

ОКСФОРД

Гриммийн
ШИДЭТ ҮЛГЭРҮҮД



Петер Картер

Гриммийн Шидэт Үлгэрүүд

Петр Гартер
ГРИММИЙН ШИДЭТ ҮЛГЭРҮҮД

Сургуулийн бага, дунд насныханд зориулав.

Орчуулагч Э.Ганболд
Хянагч Ж.Гэралмаа
Дизайнер Б.Элдэв-Очир



Хэвлэн нийтлэлийг Интерпресс ХХК

2007 он

ГРИММИЙН ШИДЭТ ҮЛГЭРҮҮД



Улаанбаатар хот
2007 он

Гарчиг

Алтан түлхүүр 7

Одой баатар жанжин 8

Муур ба хулгана 14

Амгат манжин 18

Ухаант Эльза 22

Хан хүү Мэлхий 26

Эрхийн чингээхэн Том хүү 29

Ширэнгэ ойн хаан 33

Аврага том сармаг 38

Булш сахигч хэрээнүүд 40

Зоригт бяцхан оёдолчин 46

Булшны сахиул 53

Цасан цагаан ба сарнай улаан хоёр 58

Баавгай ба ширэнгэ ойн хаан хоёрын тухай үлгэр 65

Ядуу тариачны хүү ба муур гүнж 70

Бүхнийг мэдэгч эмч 76

Нойрсогч гоо охин 80



Бремений хөгжимчид 84
Зургаан хун 87
Хулгана, Шувуу, Зайдас гурвын үлгэр 92
Улаан малгайт 94
Дуулдаг чөмөг 97
Алтан галуу 100
Алтан уулын хаан 106
Хатан зөгий 114
Ойд амьдрагч гурван одой хүний тухай үлгэр 118
Үнсгэлжин 125
Хансел Гретел хоёр 132
Цасан цагаан ба долоон одой хүн 139
Өвгөн ба нохойн идүүр 149
Эмхэтгэгчийн үг 150



Алтан түлхүүр

Цас мөс хунгарласан өвлийн нэгэн тэсгим хүйтэн өдөр нэгэн ядуу хүү түлээ түүхээр ойд очжээ. Тэр хүү уранхай муу гуталтай, ороолт малгайгүй байсан учраас осгож үхэхээ шахаад өөрийгөө дулаацуулахаар гал түлэе гэж шийдлээ.

Тэр, гал түлэх газрынхаа цасыг цэвэрлэтэл цасан дор нэгэн жижигхэн түлхүүр хэвтэж байх юм гэнэ. Түлхүүр байгаа юм чинь цоож байж л таарна хэмээн хүү бодоод газрыг гүнзгийлэн ухтал төмөр хайрцаг олджээ.

Гэтэл цоожны нүх харагдахгүй байв. Удтал хайсны эцэст модон доороос цэнхэр туяа үзэгдэх төдий сүүмэлзсэн нь цоожны нүх ажээ.

Хүү нэлээд оролдож байж түлхүүрийг цоожны нүхэнд шургуулбал яг таарлаа. Тэгээд түлхүүрийг эргүүлбэл хайрцагны таг алгуурхан онгойв.

Одоо бид нар тэр хүү тэндээс юу олсныг хамтдаа унших болно.



Одойбаатаржанжин

Эрт цагт нэгэн тээрэмчин байж гэнэ. Хэдий түүний эхнэр нь нас барсан боловч Анна гэдэг нэртэй нэгэн сайхан ухаалаг охинтой юм санж.

Мань тээрэмчин их сагсуу хүн байсан тул тааралдсан хүн бүхэнд охиныхоо хэчинэн ухаантайг яриад салдаггүй байсан учраас залхсан хөршүүд нь сүүлдээ түүнийг хаа нэгтээ явж байвал нуугддаг болчихжээ.

Нэгэн өдөр тэр улсын хаан тосгон дундуур гарч явжээ. Тээрэмчин Анна охиныг ямар ухаантайг хаан сонсолгүй явчих вий хэмээн айсандаа олны дундаас үсрэн гараад хааны морины цулбуураас зүүгдэн байж,

-Эрхэм дээдэс минь ээ! Миний охин маш их ухаантай охин шүү хэмээн хашгирчээ. Хаан морин дээрээсээ тээрэмчнийг харснаа,

-Сайхан л хэрэг байна гэчихээд морно ташуурдан цааш явж одов.

Гэтэл тээрэмчин араас нь даган гүйж замыг нь хөндөлсөөд,

-Манай охин ямар их ухаантайг хаантан та мэдэхгүй юм даа. Тэр маань бүгдийг чадна. Уншиж бичиж, тоо бодож, төгөлдөр хуур тоглож чадна. Оёж хатгаж ч чадна. Хоол хийж ч чадна хэмээн хашгирлаа.

-За за мэдлээ. Сайн байна. Сайн байна.

Хаан ингэж хэлээд олон түмэн үрүү нүд ирмэчхээд давхин одов. Цугларсан олон ч тээрэмчнийг шоолон инээлдлээ. Тээрэмчин ичсэндээ,

-Хаантан минь? Та ойлгосонгүй. Миний охин сүрлийг алт болгон нэхэж чадна хэмээн бас л хашгирлаа.

Хаан морно тогтоон эргэн харж,

-Юу гэнэ ээ. Чи юу хэлэв хө? хэмээн лавлав.

Тээрэмчин олон хүний дэргэд хэлсэн үгнээсээ буцалтай биш,

-Тийм ээ тийм, тэр сүрлийг алт болгож чадна гэж зүтгэлээ.

Хаан чихэндээ итгээгүй боловч алтанд дуртай тул тэр өдрөө охиныг ордондоо ирүүлэхийг тушаав.

Аннаг ордонд ирэхэд хаан түүнийг нэгэн жижиг өрөөнд аваачаад,

-За хө. Энд нэг боодол сүрэл, ээрүүл хоёр байгаа. Би маргааш өглөө ирнэ. Тэгэхэд чи энэ сүрлийг алт болгож чадаагүй байх юм бол үхэх болно. Өдий хүртэл хэн ч надад худлаа хэлж зүрхлээгүй юм гэгчхэд хаалгыг нь түгжчихээд яваад өгчээ.

Анна охин нэхээсний машины дэргэд суун эхэр татаж гарлаа. Намайг энэ өрөөнд бүх насаар минь хорилоо ч би ганц ширхэг сүрлийг ч алт болгож чадахгүй хэмээн тэр өөрөө өөртэйгөө яриу.

Аннаг ийнхүү уйлж байтал хананы жижиг хаалга нээгдэн нэгэн одой хүн өрөөнд үсрэн орж ирлээ. Анна тэрхүү үзэшгүй муухай царайтай одойг хараад айн дуу алдтал нөгөөх нь хуруугаа уруудлаа хүргэн,

-Зүгээр, зүгээр. Битгий ай. Би чамайг идэхгүй. Харин би хаан юу гэж хэлснийг сонслоо. Би хэрэв сүрлийг чинь алт болгочихвол чи надад юу өгөх юм бэ? гэлээ.

Анна хүзүүнийхээ зүүлтийг тайлан одой хүнд өгөөд,

-Үүнийг ав, ээжийн минь зүүлт гэлээ. Одой хүн түүнийг авч сайтар шалган аваад ээрүүдийг нь эргүүлдхэд сүрэл алтан утас болон ээрэгдлээ. Одой хүн тэгчхээд нөгөө жижиг хаалгаараа шурган ороод алга болов.

Анна юу ч хийж чадаагүй сууж байгаа гэж бодсон хаан өглөө нь зандалчнаа дагуулан иртэл алт туяарч байх нь тэр. Хаан зандалчнаа явуулаад охиноор дахин алт хийлгэхийг хүссэн тул өмнөх өдрийнхөөс арай том өрөөнд оруулан гурван боодол сүрэл өгөөд түгжиж орхив.

Тэр явахдаа,

-Чи үүнийг алт болго. Эс бөгөөс толгойг чинь авна шүү! гээд найранд суухаар явав.

Анна дахиад л уйлж суутал хананы жижиг хаалга урьдын адил нээгдэн, мөнөөх одой хүн дахиад л хүрээд иржээ.

-Хэрэв сүрлийг алт болговол чи юу өгөх юм бэ? хэмээн тэр асуулаа.

-Хайртай ээжийнхээ бөгжийг өгье хэмээн Анна хэлээд бөгжөө мулталлаа. Одой хүн уг бөгжийг үнэхээр цалин цагаан мөнгөөр хийсэн эсэхийг нь шалгаж үзсэнийхээ дараа ээрүүдийг авч сүрлийг алт болгочихоод хананыхаа жижиг хаалгаар гарч одов.

Өглөө нь хаан ирж хараад шунал нь улам хөдөлж, Аннаг асар том өрөөнд оруулбал дэлхийн бүх байшинг ч дулаалж болмоор маш их сүрэл байв.

-Чи юу хийхээ мэдэж байгаа. Хийж чадахгүй бол үхэл хүлээж байгааг санаарай! Хаан ийн хэлээд гарч одлоо. Анна мөн л уйлж суутал нөгөө одой дахин хүрч ирээд сүрлийг алт болгож болно, гэхдээ чи надад шанд нь юу өгөх

юм бэ? хэмээн асуулаа. Анна толгойгоо сэргэрэн эхэр татлаа.

-Надад одоо чамд өгөх юу ч байхгүй хэмээн тэр хэллээ.

-За яахав. Би үнэ хөлсгүй ажил хийдэггүй л дээ. Гэхдээ яахав чи хэзээ нэг цагт хатан хаан болоод анх төрүүлсэн хүүхдээ надад өгвөл наад сүрлийг чинь урьдынх шигээ алт болгож болох л юм гэж одой хүн санал тавив.

-Би хүүхдээ чамд өгөх гэж үү? Би яаж тийм юм хийх юм бэ?

-За яая гэхэв. Өөрөө л мэд. Маргааш хаан ирээд толгойг чинь цавчина даа.

Одой хүнийг ийн хэлээд жижиг хаалгаар орох зуур,

-За над шиг нэг тээрэмчний охин хатан хаан боллооо хаа байсан юм хэмээн

Анна охин бодоод,

-Хүүе хүлээгээрэй. Би чиний болзлыг зөвшөөрье гэлээ.

Одой хүн эргэн хараад,

-Сайн байна. Чи амласан шүү! гэснээ бүх сүрлийг алт болгон ээрүүлдэж орхиод урьдын адил явж одов.

Маргааш өглөө нь хаан ирээд сэтгэл нь маш хангалуун болж,

-Гайхалтай юм. Би хангалттай алттай боллоо. Анна минь чи дахиж алт хийх хэрэггүй боллоо гэлээ.

Анна охин хаанд маш их таалагдсан учраас хаан түүнийг шууд сүмд аваачин хуримаа хийжээ.

Түүнээс хойш зун, намар, өвөл ээлжлэн өнгөрсөөр хаврын улирал гарахад Анна охин төрүүллээ. Тэрээр охиндоо маш хайртай, нэг ч алхам холдож чадахгүй байсан бөгөөд аз жаргалдаа бялхсан учраас сүрлийг алт болгодог одой хүний тухай ч тэр, түүнд юу амлаж байснаа ч таг мартаж орхисон байв.

Харин одой хүн тэр тухайд огт мартаагүй байлаа. Нэг өдөр хаан шүдний эмчийн өрөөнд шүдээ авахуулж байтал хананы жижиг хаалга гэнэт онгойн, одой хүн дэвхрэн орж ирэх нь тэр.

Тэр хүүхдийг өлгийндөө байхыг нь хараад гүйн очиж тоглоомыг нь хөдөлгөөл цаадах нь нялх амьтан учраас одой хүний үзэшгүй муухайг мэдэхгүй инээн баясан байв.

-Яасан өхөөрдмөөр жаал вэ? Миний хүүхэд дээ, минийх дээ хэмээн одой хүн хэллээ.

Үүнийг нь хатан хаан сонсоод золтой л ухаан алдчихсангүй. Харин одой хүн шал дэвлэн байж,

- Чи амласан. Чи хатан хаан болбол анхны хүүхдээ надад өгнө гэж амлаа биз дээ хэмээн хашгирлаа.

Хатан хаан эхэр татан одой хүний өмнө сөгдөөд,

-Өөрийгөө хэзээ ч хатан хаан болохгүй гэж бодож байсан тул тийм амлалт өгсөн, охиныг нь л авахгүй бол хаант улсынхаа юу дуртайг өгөхөд бэлэн хэмээн гуйлаа.

Гэвч одой хүн энэхүү гуйлтыг огт тоосонгүй.

-Үгүй би хүүхдийг л авна. Амлалт бол амлалт гэж тэр хэлэв.

Хүүхдийг нь авчихвал хатан маш их ганцаардан, зовж шаналахаа тайлбарлахад одой хүн хариуд нь,

-Чи намайг бодсон уу? Ямар ч эмэгтэй надтай гэрэлзхгүй болохоор би хэзээ ч өөрийн хүүхэдтэй болохгүй. Тийм болохоор би хүүхдийг чинь л авна гэж хариуллаа.

Хатан хүүхдээ тэврэн асгартал уйлсаар байсан тул сүүлдээ одой хүн буулт хийлээ.

-За яахав. Тэгвэл би гурван шөнө дараалан чам дээр ирье. Хэрэв тэгэхэд чи миний нэрийг таахгүй бол хүүхдийг чинь авъя. Харин нэрийг минь таавал хүүхдээ өөртөө үлдээгээрэй. Одой ийн хэлээд хананы жижиг хаалгаар явж одов.

Хатан хаан хүүхдээ бүүвэйлэн жаал сууснаа ойчид болон анчдыг дуудан ирүүллээ.

-Энэ дэлхийн хаа нэгтээ нэгэн одой хүн амьдран суугаа. Би хаана байгааг нь мэдэхгүй. Харин та нар түүнийг олоод нэрийг нь мэдээд ир. Гэхдээ гурав хоногт амжуулаарай гэж гуйв.

Хатан хааны энэ гуйлт хэцүү байсан ч тэдгээр хүмүүс түүнийг маш их хүндэлдэг байсан учраас даруй хурдан морьдоо эмээллэн унаад ертөнцийн дөрвөн зүг, найман зовхист довтолгон одов.

Хатан хаан тэр өдөржингөө санаандаа орж ирсэн нэр бүхнийг бичэээр өнгөрөөв. Улмаар шөнө дунд болж, ордны цаг арван хоёр цагийн дохио өгөхөд одой хүн гарч ирээд өөрийнхөө нэрийг таасан эсэхийг лавлав.

-Матай мөн үү? гэж хатан асуулаа.

-Үгүй хэмээн одой хариулав.

-Марк уу?

-Үгүй ээ.

-Лүүк мөн үү?

-Үгүй.

-Тэгвэл Жон уу?

-Үгүй.

Одой нээд алдан хүүхдийг гижигдсэнээ жижиг хаалгаар гарч одов.

Маргааш нь хатан хаан явуулсан ойчид, анчдаа бүтэн өдөржингөө хүлээсэн боловч хэн ч эргэж ирсэнгүй. Шөнө дунд одой хүн ирж хатан хаанаас өөрийнхөө нэрийг таасан эсэхийг асуулаа.

Энэ удаа Хатан хаан санаандаа орсон хөгжилтэй нэрсүүдийг хэлж гарлаа.

-Шовгор өвдөгт үү?

-Үгүй ээ.

-Халзан толгойг уу?

-Үгүй ээ.

-Онигор нүдэт үү?

-Үгүй.

-Тэгвэл хөх хамарт мөн үү?

-Үгүй дээ, үгүй хэмээн одой хүн инээд алдан хэлээд хүүхдийг инээлгэснээ бяцхан хаалгаараа гарч одлоо.

Хатан хаан тэр шөнө огт унтаж чадсангүй, бүх нэрсийг санахыг оролдон бас явуулсан хүмүүсийг эргэж ирэхийг хүлээв. Маргааш нь олон олон хүн бараг бүгдээрээ эргэж ирсэн ч одой хүнийг олсонгүй. Тийм болохоор нэрийг нь мэдэж чадсангүй гэгцээлээ.

Хатан хаан охиноо тэврэн ордон дотуураа цааш нааш алхлан уйлж байлаа. Яагаад гэвэл тэрээр одойн нэрийг хэзээ ч таахгүй учраас хүүхдээ үүрд алдана гэж айж байв.

Шөнө болоход хатан хаан бүх зүйл өнгөрлөө хэмээн гуниглаж суулаа. Гэтэл арван хоёр цагт тавхан минут дутуу байхад морин төвөргөөн сонсогдон хамгийн сүүлчийн анчин ордны хаалгаар довтолгон орж ирэв.

Хөле тоосонд дарагдсан тэр анчин мориноосоо буун харайгаад,

-Эрхэм дээдэс минь. Одой хүнийг гурван өдөр хайгаад өнгөрсөн шөнө бөглүү ойгоос одлоо. Би харанхуйд гэрэл үзэгдэхээр нь тийшээ очтол нэгэн бяцхан байшингийн гадаа түүдэг гал дүрэлзэн, тэр галыг нэг одой хүн тойрон бүжиглэж байгааг үзлээ.

Би чоно агнах гэж байгаа юм шиг сэмхэн гэтсээр ойртон сонсвол одой хүн:

Өнөөдөр би хоол хүнсээ базаана

Харин маргааш хүүхдийг авна

Хатан хаан ч мөрийгөө алдлаа даа

Харин миний нэр Одойбаатаржанжин даа гэж дуулж байна хэмээн давхцуулан өгүүлэв.

Хатан хаан энэ яриаг сонсоод баярласандаа бүжиглэв. Тэгтэл арван хоёр цагийн дохио дуугаран одой хүн гарч ирэв.

-Сайн байна хэмээн тэрээр инээд алдаад хүүхдийн унтлагын хувцас, хүүхэлдэй авчирснаа хатан хаанд харуулан одоо ингээд хүүхдээ аваад явна даа гэлээ.

-Жаахан хүлээ. Нэрийг чинь таахыг оролдьё.

Одой алгаа ташин дэвхцэж, тэг тэг гэхдээ чи сая жил болсон ч таахгүй хэмээв.

-Гэхдээ оролдоод үзье.

-Маргин уу?

-Үгүй хэмээн одой хашгирав.

-Конрад уу?

-Үгүй

-Хенрих уу?

-Үгүй дээ, үгүй. Үгүй шүү. Одой хүн баярлан дороо дэвхцэж байлаа.

-За яахав. Би одоо ганц л нэр хэлье.

-Тэгэхдээ түргэлээрэй хатан гуай. Яагаад гэвэл арван хоёр цагийн дохио дуугараад дуусч байна шүү.

-Нээрээ тийм үү? Сонсогдохгүй байна. За байз хэн байдаг билээ... Би бодохдоо...

Хатан ийнхүү жаахан цаг нөхцөөж байснаа арван хоёр цагийн сүүлчийн дохиотой зэрэгцэн Одойжанжинбаатар хэмээн хашгирлаа.

-Арай үгүй байлгүй. Чөтгөр шулам чамд миний нэрийг хэлээ юу?

Одой хүн ийн хэлэхдээ царай нь час улайн маш их уурласан байв. Тэр уурандаа шал цөм дэвссэн бөгөөд тэр шалныхаа цөмөрхийгөөр унан алга болсон билээ. Тэр цагаас хойш хэн ч хэзээ ч тэрхүү одойг олж үзээгүй юм гэдэг.

Хатан хаан үр хүүхдээ өсгөн сайн сайхан амьдарсан юм. Харин өөрийн гэсэн үр хүүхэдтэй болж хайрлаж энхрийлье гэсэн тэр одой хүнийг бодохоор өрөвдөх сэтгэл бас төрдөг юм даа.



Муур ба хулгана

Эртний эрт цагт муур хулгана хоёр нэгэн сүмд амьдарч байжээ. Гэтэл нэгэн өдөр муур, хулганы нүхэн дээр ирээд,

-Хулгана авхай! Хоёулаа ер нь хонхны хонгилд хамт амьдарвал яасан юм бэ? Ганц хүн гал болдоггүй болохоор хоёулаа хамт амьдарвал хамаагүй хэмнэлттэй болно доо гэжээ.

Хулгана эхэндээ болгоомжлон сахлаа босгон, нүхнийхээ завсраар харвал муур туйлын эелдэг инээмсэглэн тун чиг найрсаг сайхнаар мяулан зогсож байв. Тийм болохоор хулгана, “ер нь хамт амьдарвал уг нь ч хямд л тусна даа. Болохгүй ч юм юу байх вэ дээ” хэмээн бодлоо.

-За тэгэхээр би зөвшөөрч байна. Оролдоод үзье хэмээн хулгана хэлэв.

-Сайн байна. Харин надад нэг асуулт байна. Одоо удахгүй өвөл болж, хоол хүнс хомстоно. Тэгэхээр бид хоёр идэх юмаа нөөцлөх хэрэгтэй. Хаана хадгалбал зүгээр вэ? хэмээн муур лавлав.

Ийнхүү хадгалах нь үнэхээр сайн хэрэг гэж хулгана үзсэн тул хоёул хамтран ваар дүүрэн цөцгий худалдан авчээ.

-Одоо тэгэхээр хоёул энэ нөөцөө хаана нуухаа бодъё. Хүмүүс ч хэцүү шүү дээ. Сүмээс ч хулгай хийхээс сийхгүй. Хаана нууя гэж чи бодож байна? хэмээн муурыг асуухад хулгана хаана нуухыг бодоод бодоод олсонгүй.

-За би бууж өглөө. Харин чи нэг арга бод хэмээн тэр мууранд хандлаа.

Муур нэлээд удаан нүдээ онилгон чихээ маажиж байснаа

-Надад нэг сайхан санаа төрлөө. Ерөөсөө хоёулаа дээврийн хонгилд нуучихъя. Тэнд хэн ч очихгүй гэсэн санал гаргав.

Хулгана ч уг саналыг дэмжин, хоёулаа нөгөөх цөцгийтэй ваараа дээврийн хонгилд аваачин нуулаа.

Гэхдээ хоёулаа үүнийгээ идэхгүй шүү. Өвлийн хүйтэн нойтонд л идэх юм шүү хэмээн хулгана энэ үед хэлбэл, муур гомдсон дүр үзүүлэн,

-Яалаа гэж, би юу боллоо гэж идэх юм бэ. Ийшээ ёстой зүтлэх ч үгүй гэж амлав.

Тэр явдлаас хойш тэр хоёр эв найртай амьдарсаар ганц долоо хоног дөнгөж өнгөрч байтал муур нөгөө цөцгийгөө идмээр санагдах нь тэр. Муур цөцгийн амтыг өдөр нь бодсоор, шөнө нь зүүдэлсээр сүүлдээ бүр тэсэхээ болив. Тэгээд нэг өглөө хулгана дээр явж очив.

-Хулгана авхай минь! Би чамд нэг юм ярих гэсэн юм аа. Миний зээ өнгөрсөн жил гэрлээд сая эхнэрээс нь зулзага гарчээ. Тэгсэн маш хөөрхөн зулзага гарсан байна. Тийм нэг хүрэн толботой цасан цагаан амьтан. Тэгээд миний зээ намайг уриад зулзаганыхаа загалмайлан эцэг болохгүй юу гэсэн юм. Би тэгэхээр нэг яваад ирвэл чи юм бодохгүй биз дээ? хэмээн муур их л эелдгээр ярилаа.

-Тэгэлгүй яахав, тэгэлгүй яахав. Би гэрийнхээ ажлыг амжуулж байя. Харин чи миний мэндийг зулзганд дамжуулаарай. Харин улаан дарс уухдаа намайг маргалгүй жаахныг авчраарай. Би ганц нэг балгамаар байна хэмээн хулгана харуу өгүүлэв.

-Яг тэгье. Би бас жаахан бялуу ч аваад ирье.

Муур уруулаа долоон байж ийн хэлээд хонхны хонгилоос гарч одов. Тэгэхдээ нөгөө загалмайлах ёслол уруу огтхон ч зүглэсэнгүй, харин ч эсрэгээр дээврийн хонгил уруу харайж очоод нөгөө цөцгийннийхөө дээд хэсгийг нь долоож орхив.

Дараа нь мань муур доошоо буун тосгоны байшингуудын дээвэрээр ангуучилж явсаар орой нь гэртээ харив.

-За чи цагаа сайхан өнгөрүүлэв үү? хэмээн хулгана асуув.

-Тэглээ тэглээ. Янзын сайхан байлаа гэж муур хариулав.

-Надад дарс, бялуу авчрав уу?

-Өө яана аа. Би уг нь зөндөөнийг аваад ирж байтал нэг том нохой над уруу дайраад булаагаад авчихсан шүү.

-За, зүгээр зүгээр. Тэр нохойтой ярих юм гарч байх шиг байна. За тэр ч яахав. Зээ чинь зулзгандаа ямар нэр өгч вэ дээ?

Муур энэ зуур нөгөө амтат цөцгийннийхээ тухай бодон инээмсэглэж байсан тул "Дэдэх нь байхгүй" хэмээн хэлэв.

-Үгүй мөн хачин нэр ээ. Ёстой дуулж байгаагүй юм байна гэж хулгана хэлэв.

Түүнээс хойш мөн л хэдэн өдөр өнгөрч байтал муур нөгөө цөцгийг дахин хүсэмжлэх болов. Түүний нүдэнд дээврийн хонгил доорх цэнхэр ваар, тэр вааран доторх тослог шар цөцгий үзэгдэн, унтаж ч чадахаа бараг больж галзуурах шахав. Эцэст нь муур гал тогоонд очвол хулгана аяга, тавгаа угаан завгүй байв.

-Хулгана авхай минь! Миний бас нэг зээ зулзагатай болсон юм. Тэр нь ёстой

хөөрхөн, хав хар, гэхдээ хүзүү нь цагаан. Тэгээд аав нь намайг загалмайлсан эцэг нь болооч гэж ёслолдоо уриад байна. Би яваад ирвэл яана? гэж муур асуулаа.

-Тэг тэг. Явалгүй яахав. Харин надад нэг жаахан бялуу, дарс аваад ирээрэй хэмээн хулгана зөвшөөрөв. Муур

-За, за гэж амлаад тэр дороо эргэн гарч гүйсээр дээврийн хонгилд хүрээд нөгөө нөөц цөцгийнний хагасыг нь үмхэж орхив.

Түүнийхээ дараа доош буун явсаар хотын даргын байшингийн дээвэрт авиран гарч, бүхэл өдөржингөө унтаж аваад орой нь л нэг юм гэрийн бараа харав.

Түүнийг эргэж ирэхэд,

-Хүүе, сайн байна уу? гэсээр хулгана угтаад надад чи дарс, бялуу авчрав уу? гэлээ.

-Тэгсэн тэгсэн. Үгүй тэгсэн ч гэж дээ. Нөгөө өмнө нь миний чамд ярьж байсан том нохой бас л намайг хөөгөөд дээрэмдээд авчихлаа хэмээн муур хариулав.

-За яахав. Санаа зоволтгүй. Болохгүй юм болохгүй л байдаг гэж хулгана өгүүлдэг, зулзганд ямар нэр өгснийг лавлав.

Нүдээ анин цөцгийнний тухай бодож байсан муур сандрахдаа "Хагас нь байхгүй" гэнчлээ.

-“Хагас нь байхгүй” гэнэ ээ гэж муур гайхан исгэрээд та юу хэлчэв ээ? Би ёстой амьдралдаа дуулаагүй юм байна хэмээн гайхлаа.

Муур нүдээ нээн царайгаа атируулж, чи юу гээд байгаа юм бэ? Дэлхийн бүх нэрийг мэддэг гэж өөрийгөө бодоо юу гэж асуулаа.

-Үгүй, үгүй. Зүгээр л сонин сонсогдоод л тэр хэмээн хулгана хэллээ.

Дахин долоо хоног өнгөрөхөд муур цөцгийнний тухай дахин бодож эхлэв. "Цөцгий, цөцгий. Би идмээр байна, идмээр байна. Идэх ч болно" гэж тэр боджээ.

Муур өглөө босоод хулгана дээр очлоо.

-Хулгана авхай! Миний бас нэг зээ зулзагалаад намайг загалмайлсан эцгээ болооч гэсэн юм.

-Бас дахиад л зулзага төрөө юү?

-Тийм ээ тийм. Гэхдээ маш онцгой зулзага гарсан. Цагаан тавхайтай хав хар муур. Биенд нь ганц ч цагаан үс байхгүй гээд бод доо. Тийм хөөрхөн зулзага долоон жилд ганц төрдөг гэсэн. Би явья даа. Тэгэх үү?

-Чи ч зөндөө олон зээнцэртэй боллоо доо. Эхлээд Дээдэх нь байхгүй төрсөн, дараа нь Хагас нь байхгүй гарсан. Одоо дахиад нэг зулзага төрлөө. Чи явах ёстой юм чинь явах л хэрэгтэй байхдаа.

-Баярлалаа. Би чамд бялуу, дарс авчирна аа.

Хулгана гэртээ үлдэн хоол хүнсээ төхөөрч байх зуур муур дээврийн хонгил руу гүйн очоод, нөгөө цөцгийг долоож орхиод санаа амрав.

Муурыг зургаан цагт эргэж ирэхэд нь загалмайлах ёслол хэр болсныг хулгана

сонирхлоо.

-Ёслод бүх гэр бүлийнхэн цуглаад. Би нөгөө зулзгыг тэврээд л. Ёстой хөөрхөн зулзага байна лээ. Харин чи намайг ёстой уучлаарай, би жаахан бялуу, дарс аваад явж байсан чинь...

-За цааш нь яриад яахав. Нөгөө том нохой чинь бас л тааралдаж хөөгөөд дээрэмдчихээ биз. Тэгээд саяын шинэ зулзага ямар нэртэй болов?

Муурын нүд ногоорон амтат цөцгийг санагалзан хэл нь гозолзож байснаа, тэр зулзгандаа "Бүгд байхгүй" гэдэг нэр өгсөн дөө гэв.

-Бүгд байхгүй гэнэ ээ? Энэ чинь ёстой хамгийн сонин нэр байна. Би Библийн судраас ч ийм нэр уншаагүй юм байна гээч. Сонинд ч гараагүй нэр байна хэмээн хулгана гайхширлаа.

-Энэ чинь бүүр хуучны нэр байхгүй юу. Ер нь манай орон эрх чөлөөтэй орон. Зулзагаа юу гэж нэрлэсэн ч яадаг юм. Муур ийн хэлээд саврынхаа хумсыг цухуйлгаж байв.

Хулгана муурын хумсыг үзээд толгой сэгсрэн,

-За яахав, яахав. Тэр бол чиний хэрэг гэлээ. Тэгээд хэсэгхэн ноосоор биеэ ороон унтахаар хэвтэв.

Зун өнгөрч намар болоод, намар өнгөрч өвөл боллоо. Харин муур дахин загалмайласан эцэг болсохоор уригдсангүй. Цас унан, хот тэр чигээрээ цагаан хучлагатай болон хүйтэрч хоол хүнс ч ховор живэр боллоо.

Хулгана нэгэн өглөө зоорио хараад толгой сэгсрэн, муурын дугжирч буй унтлагын өрөө үрүү очив.

-Муур аа! Бид хоол ундгүй боллоо. Гэхдээ бид хоёр бурхны авралаар идэх юмаа нөөцөлсөн нь аз боллоо. Хоёул дээврийн хонгил уруугаа очиж цөцгийнөөсөө идье хэмээн хулгана өгүүлэв.

-За хөөрхий, цаг нь болж дээ хэмээн муур бодсоор дээвэр лүү явахад хулгана араас нь гүйх ажээ.

Хулгана дээврийн хонгилд ирэн цөцгийгөө алга байхыг үзээд золтой л ухаан алдаад уначихсангүй. Тэрээр сахлаа сөрвийлгөн муур уруу ууртайгаар харж,

-Чи загалмайласан эцэг болно гэж яваад байсан. Тэгж явахдаа хулгайлаад идчихсэн байна шүү дээ. За, одоо би бүгдийг нь мэдлээ. Тэр нэрнүүд ч гэсэн. Эхлээд Дээдэх нь байхгүй, дараа нь Хагас нь байхгүй, хамгийн сүүлд

Хулганыг үгээ хэлж гүйцээгүй байтал муур уурсан хаширлаа.

-Чамайг дахиад ганц үг хэлэх л юм бол...?

Энэ үед хулганы хувьд бүх юм дэндүү оройтсон байлаа. Тэр Бүгд байхгүй гэдэг үг хэлж байхдаа аль хэдийн муурын аманд орчихсон байлаа.

Түүний хэлсэн сүүлчийнх нь энэ үг муурын амнаас дөнгөж сонсогдоод л хөөрхий золгүй хулгана муурын ходоод уруу орсон гэнэ билээ.



Амтат манжин

Далайн чанад дахь алсын алс нутагт өөрийн гэсэн үр хүүхэд хүсэмжилсэн эр эм хоёр амьдран суудаг байлаа. Тэр хоёр олон жил амьдарсан боловч үр хүүхэд төрөхгүй байсаар тэр өдрийг болоход Бурхан тэнгэр нэгэн үр заяах нь гэдгийг эхнэр нь зөнгөөрөө мэджээ.

Тэр хоёрын гэрийн цонхоор цэцэг жимс битүү дэлгэрсэн нэгэн сайхан цэцэрлэг харагддаг байж гэнэ. Уг цэцэрлэг битүү хашаагаар хүрээлэгдсэн болохоор тэр цэцэрлэг үрүү хэн ч ордоггүй байж л дээ. Гэвч хашаа нь бараг илүүц байжээ. Яагаад гэвэл тэр цэцэрлэг нь хаант улс даяар хамаг амьтныг айлгадаг, далдын нууц удистай илбэчин хүнд харьяалагддаг байсан тул хэн тийш зурхлын нэвтрэх билээ дээ.

Нэгэн өдөр эхнэр нь цонхон доороо сууж байгаад тэр цэцэрлэгт нэгэн гайхалтай сайхан манжин ургаж байхыг олж харав. Тэр манжин маш сайхан харагдсан тул тэр эмэгтэй зууш хийж идэхийг туйлын ихээр хүсэмжилжээ. Эмэгтэй манжин хэрхэн ургаж буйг өдөр болгон харах тусам идэх хүсэл нь улам оргилсоор. Гэвч илбэчин түүнийг хэзээ ч ойртуулахгүй гэдгийг тэр эмэгтэй мэдэж байсан учраас түүндээ шаналсаар цонхийн цайж, өвчинд нэрвэгджээ.

Нөхөр нь эхнэрээ ийнхүү өөрчлөгдсөнийг ажиглаад нэгэн өдөр ажлаасаа ирснийхээ дараа эмч залахаар явъя гэлээ.

Гэтэл эхнэр нь толгой сэгсэрч,

-Үгүй ээ. Надад эмч тус болохгүй.

-Яагаад тэр билээ? Эхнэр минь. Юу болоов? Чи ингээд өвдөөд байвал улам хэцүүднэ шүү. Чи яагаад өвдсөн шалтгаанаа мэдэх хэрэгтэй.

-Би мэднэ ээ. Тэр бол илбэчний цэцэрлэг дотор ургаж байгаа манжин. Би тэр манжингаас идэхгүй бол үхлээ.

Нөхөр нь эхнэрийнхээ энэ яриаг сонсоод,

-За яахав, тэр хашааг давж ороод жаахан манжин авчихад хэн л мэдэв гэж. Мэдээд толгойгоо авхуулсан ч яахав. Би эхнэрийнхээ төлөө бүтдийг хийнэ хэмээн шийдлээ.

Мань эр тэр шөнөө илбэчний хашааг давж ороод жаахан манжин зулгааж авчээ. Түүгээрээ зууш хийн эхнэртээ идүүлтэл эхнэрийнх нь хацар туяараад иржээ. Гэхдээ эхнэр нь дахиад манжин идмээр байгаагаа нөхөртөө хэлсэнгүй. Учир нь нөхрийнх нь амь насанд аюул учирч болзошгүй гэж тэр боджээ.

Гэвч нөхөр нь тэнэг хүн биш байсан учраас эхнэрийнх нь царай дахиад цонхийж эхлэхийг ажаад хэд хоногийн дараа нөгөөх хориотой цэцэрлэгт дахин орж тэвэр дүүрэн манжин авчирч идлээ. Эхнэр нь ч дээрдээд ирэв. Гэвч эмэгтэй дахин өвдсөн тул нөхөр нь гурав дахь удаагаа цэцэрлэгт очин тэвэр дүүрэн манжин автал гэнэт илбэчин эм гарч ирэн үнхэлцэг нь хагарах шахав.

-За хөөе. Та миний цэцэрлэгт орж хулгай хийнэ гэнэ ээ. Та үүнийхээ шанг хүртэх болно доо хэмээн илбэчин ширүүнээр хэлэхэд дуунаас нь хойд мөсөн далайн хүйтэн амьсгал нэвт үлээх шиг санагдав.

Нөгөө эр илбэчний өмнө өвдөг сөгдөн унаж,

-Намайг өршөө! илбэчин гуай минь. Эхнэр маань жирэмсэн юм л даа. Гэтэл энэ манжингаас идэхгүй бол үхэх гээд байна хэмээн орь дуу тавилаа.

Сарны гэрэлд илбэчний үзэшгүй муухай чөтгөр шуламынх мэт царай нэг зэвхийрэн, нэг барайн байснаа толгой дохилоо.

-За яахав. Авья гэсэн хэмжээгээрээ л ав. Харин би ч гэсэн та нараас авлагатай боллоо шүү. Хүүхэд чинь төрсний дараа би өөр дээрээ авна шүү хэмээн илбэчин эм өгүүллээ.

Ийм хүчирхэг илбэчний өмнөөс хөөрхий муу эр яах ч билээ дээ. Тэр манжингаа тэврэн гунигтайгаар явж одлоо.

Тэр явдлаас хойш манжин идэж тэнхэрсэн эхнэр нь эрүүл болж улмаар охинтой болов. Гэвч охиныг төрөөд ганц ч хоноогүй байхад илбэчин эм ирээд авч одсон бүлгээ.

Илбэчин тэр бяцхан хүүхдэд Амтат манжин гэдэг нэр өгсөн агаад тэр охин хорвоогийн хамгийн үзэсгэлэнт бүсгүй болон өслөө.

Гэвч илбэчин эм түүний энэ гоо үзэсгэлэнг хэнд ч харуулахыг хүсээгүй учраас охиныг арван хоёр настай байхад нь бөглүү ойн дундах цохир хадан цамхагт аваачин түгжиж орхижээ. Тэр цамхаг гарах хаалгагүй бөгөөд газраас дээш олон метрийн өндөрт орших бяцхан цонхноос өөр нүх сүвгүй байв.

Илбэчин эм хааяа цамхагт ирж Амтат манжинтай уулзах болохоороо доороос нь,

Амтат манжин чи

Гээгээ доош нь буулгаач хэмээн дуулна. Амтат манжин охин алтан утас мэт

баг бөх, урт сайхан гээгтэй тул гээгнийхээ нэг үзүүрийг өрөөндөө байх дэгээнд ороогоод, нөгөө үзүүрийг нь унжуулахад илбэчин эм түүгээр нь дамжин дээш авирч гардаг байв.

Зургаан жилийн дараа Амтат манжин нас бие гүйцсэн эмэгтэй болон өслөө. Тэр өдөржингөө тоглох, юм нэхэх, дуулах зэргээр цаг өнгөрөөх бүлгээ.

Нэгэн өдөр хааны хүү тэр хавиар явж байгаад охины дуулахыг олж сонсчээ. Охины дуу маш яруу тунгалаг байсан тул ханхүүд маш их таалагджээ. Гэвч тэр дуулж буй эзнийг нь олсонгүй. Улмаар ханхүү өдөр бүхэн тэр бөглүү ойд ирж, нэвтэршгүй цайзыг тойрон явж, дуу сонсдог болжээ.

Тэр энэ янзаараа хэзээ ч дууны эзнийг харахгүй байсан ч байж магад. Гэвч нэг өдөр мөн тэгж яваад хэн нэгэн:

Амтат манжин минь

Гээгээ доош нь буулгаач хэмээн дуулахыг санамсаргүй сонсов. Ханхүү модон дунд нуугдан харвал Амтат манжин гээгээ унжуулж түүгээр нь илбэчин авиран гарч байв.

-Аа, тийм бий. Одоо л учрыг нь оллоо. Би ч гэсэн азаа үзнэ дээ хэмээн ханхүү өөртөө хэллээ.

Маргааш нь ханхүү тэр газар ирээд цамхгийн дор зогсон,

Амтат манжин минь

Гээгээ доош нь буулгаач гэж дууллаа.

Манжин түүнийг нь сонсоод гээгээ унжуулахад хааны хүү ч түүгээр нь дамжин өгсөө. Түүнийг цонхон дээр очиход урьд нь илбэчнээс өөр хүний бараа бараг хараагүй Амтат манжин үхтэлээ айжээ. Гэвч ханхүү эелдэг зөөлнөөр ярих тусам түүний айдас арилан хоёр залуу бие биедээ дасч эхэлжээ. Улмаар ханхүү хайр дурлалынхаа бэлгэ тэмдэг болгон бөгжөө дурсгахад бүсгүй хүүгийн алгыг атган байж бөгжийг авчээ. Ханхүү өөрийг нь илбэчнээс илүү их хайрлана гэж тэр боджээ.

-Би тангай хамт өнөө шөнө ч хамаагүй явчихмаар л байна. Гэсэн ч хэрхэн доошоо буух билээ. Та миний гээгээр дамжаад буучихаж болно. Харин би чадахгүй. Тийм болохоор та ирэх болгондоо надад торгон утас авчирч бай. Би түүнийг чинь томж сүлжээд аргамж хиймэ. Аргамж бэлэн болмогц хоёул эндээс зугтъя гэж Амтат манжин ярилаа.

Ханхүү үүнийг зөвшөөрсөн агаад бүсгүй дээр ирэх болгондоо торгон утас авчран Амтат манжин түүгээр нь зугтах аргамжаа сүлжих бүлгээ.

Харин энэ тухай илбэчин огтхон ч мэдээгүй байлаа. Гэтэл гай газраас гэгчээр Амтат манжин үг алдаж орхив. Юу гэвэл, нэгэнтээ илбэчин эм урьдын адил авирсаар гарч ирэхэд нь та яасан уддаг юм бэ? Ханхүү бол хормын дотор гараад ирдэг юм гэгчжээ.

-Аа хаа, тийм бий. Илбэчин эм ийн дуу алдаад гараа өргөхөд нь хүмснүүд нь

тасын сарвуу мэт үзэгдэв.

-Би чамайг хорвоо дэлхийгээс нуусан гэж бодсон юмсан. Гэтэл чи ингэж байдаг байх нь гэж илбэчин эм хашгирахад гар нь үрчлээтсэн шар өнгөтэй, яг л тахианы сарвуу шиг ажээ.

Тэр Амтат манжинг самардан цохиод гээгнээс нь зулгаав. Илбэчин зүүн гараараа бүсгүйг үздэн дараад баруун гараараа хайч аван үсийг нь тас хийгтэл хяргаж орхив. Амтат манжингийн алтан шаргал гээг газарт нэлмийн уналаа.

-Ха ха ха. Одоо чам дээр ямар ч эр хүн ирж чадахгүй боллоо хэмээн илбэчин эм тас тас хөхөрч байв. Гэвч үүгээр ч зогссонгүй, хорон санаат илбэчин охиныг бүр эзгүй цөлд араатнуудын дунд хаях нь тэр.

Тэгснийхээ дараа илбэчин эм Амтат манжингийн өрөөнд түүний тайрмал гээгээр дамжин авирч гараад хулганын нүх сахисан муур мэт сууж байтал ханхүү ч доор нь ирсэн,

Амтат манжин минь

Гээгээ доош буулгаач гэж дуудлаа.

Илбэчин эм шулмын инээдээр инээмсэглэн Амтат манжингийн тайрмал гээгийг доош буулгахад ханхүү түүгээр нь авиран гараад хайртыгаа биш, харин зуун настай болов уу гэмээр хөгшин илбэчин эмийг олж харлаа.

-Ха ха ха. Чи Манжинг зорьж ирээ юу. Тэр шувуухай одоо энэ үүрэндээ байхгүй ээ. Оронд нь орж ирсэн муур одоо нүдийг чинь ухааж, нүүрийг чинь самардана даа хэмээн илбэчин эм бархирлаа.

Гэвч үүнийг сонсоод гэнэтийн уй гашууд умбасан ханхүү амиа хорлохоор шийдэн, цонхоор буцаж үсэрдээ. Гэтэл мөнөөх илбэчин сарвуугаа нүд үрүүгээ чиглүүлэн, тойрог хөдөлгөөн хийгээд галзуурсан мэт тачигнатал инээж гарав.

Илбэчин ийн илбэдсэн учраас ханхүү газарт унаж үхсэнгүй харин өргөс, шилмүүсэн дунд ойчин нүдээ сох хатгуулж орхив.

Түүнээс хойш хөөрхий ханхүү олон жилийн турш зөвхөн жимс, ургамлын үндсээр хоол хийж, ойгоор тэнүүлэн, ертөнцийн хамгийн ядуу гуйлгачнаас ч долоон дор амьдралыг туулжээ.

Тэрээр ийн явахдаа цаг үргэлж Манжин минь. Амтат манжин минь! хэмээн дуудах бүлгээ.

Тэгж тэгж, бурхан тэнгэр түүний гуйлтыг сонсон, түүнийг Амтат манжингийн хоёр ихэр хүүхэдтэйгээ амьдран буй цөлийн зүг хандуудлаа. Амтат манжин ханхүүгийн дуулахыг сонсоод гүйсээр ирсэн бөгөөд бүсгүйн нулимс ханхүүгийн нүдэн дээр тусангуут илбэч эмийн хараал арилан, хараа орсон ажгуу. Аз жаргалаар бялхсан ханхүү эхнэр хүүхдүүдээ дагуулан ордондоо эргэн ирээд насан эцэс хүртлээ баяр жаргалтай амьдарсан гэдэг.

Харин нөгөө илбэчин эм ойд чононд бариулжээ.

Тэгэхэд илбэчний хөд, гарынх нь сарвуу идүүлэлгүй үлдсэн ч шоргоолж болон



Ухаант Эльза

Нэгэнтээ Хановерийн уудам талд нэгэн талхчин, эхнэртэйгээ хамт амьдран суудаг байсан бөгөөд Эльза гэдэг нэгэн охинтой байж гэнэ.

Охиныгоо том болоход талхчин эр эхнэртээ,

-За байз, охин маань хүнтэй суух цаг боллоо доо гэжээ.

-Харин тийм ээ. Гэхдээ хэн түүнтэй гэрлэх билээ дээ гэж эхнэр нь хариулжээ.

Учир нь Эльзаг хөөрхөн гэж хэн ч хэлэхээргүй тийм бүсгүй байж л дээ. Гэвч Ханс хэмээх залуу мужаан эр нэгэн өдөр тэднийд ирээд Эльзатай гэрлэх гэж буйгаа дуулгаж гэнэ.

-Гэхдээ Эльза ухаантай бол тэр шүү дээ хэмээн Ханс болзол тавьжээ.

Эльзагийн аав хормогчныхоо гурилыг гүвэнгээ, охин минь маш ухаантай л даа... Ер нь л их ухаантай...Ухаантай, ухаантай. Би өөр юу хэлэх вэ дээ гэж бувтанажээ.

-Тэр ч үнэн шүү. Манай Эльза салхийг ч харж чадна, ялаа найтаалгахыг ч сонсож чадна. Их ухаантай даа гэж ээж нь хажуугаас нь үг нэмэрлэв.

-Үнэхээр л тийм бол болж л байна гэж Ханс хэлжээ.

Талхчин эр ирээдүйн хүргэнээ гэртээ үлдэж, хамт оройн хоол зооглохыг урилаа. Тэд ширээ тойрон суусны дараа ээж нь Эльзаг зоорин дахь торхноос шар айраг авчруулахаар явуулав.

Бүсгүй зооринд очоод торхыг эргүүлэн, цоргыг нь нээж доор нь лонхоо тослоо. Тэр лонх дүүрэхийг хүлээх зуур газар сууж байхдаа санаандгүй харвал түүний толгойн тушаа торхон дээр барилгачдын хэрэглэж байгаад орхисон сүхийг өнцөгдүүлэн тавьсан байх нь үзэгдэв.

-Ай яа. Би хэрэв Ханстай гэрлэвэл хүүхэдтэй болж таарна. Тэр хүүхдээ

том болохоор нь би агуулах уруугаа шар айрганд явуулна. Гэтэл түүний минь толгой дээр сүх унаад үхчихвэл яана аа. Ий ий. Эльза ийн бодоод эхэр татан уйлж гарав.

Дээд талд нь аав ээж нь болон Ханс Эльзаг хүлээн сууж сууж эцэст нь юу болсныг үзүүлэхээр зарц охиныг зоорь луу илгээв.

Охин доош бууж очоод Эльзаг уйлан суухыг харав.

-Хүүе Эльза. Юу болоо вэ? Аалзнаас айгаа юу хэмээн охин асуулаа.

-Үгүй ээ хэмээн Эльза мэгшээд, би хэрэв Ханстай сууж хүүхэдтэй болоод том болохоор нь зоорь луу шар айрганд явуулбал сүх толгой дээр нь унаж үхэх юм байна. Ий ий ий.

-Хөөрхий Эльза. Чи ч үнэхээрийн ухаантай юм байна шүү.

Зарц охин ийн хэлээд Эльзатай зэрэгцэн сууж бас л уйлж гарав.

Энэ үед тэднийг аав ээж, Ханс гурав баахан хүлээж цөхөөд зарц хөвгүүнийг зоорь луу илгээв. Зарц хөвгүүн доошоо шатаар гүйцээр зооринд очвол Эльза, зарц охин хоёр торх налан суугаад уйлж байх юм гэнэ.

-Хөөе та хоёрт юу тохиолдоо вэ? Хулганаас айгаа юу? гэж тэр асуулаа.

-Үгүй ээ хэмээн Эльза уйлан дуугараад, Ханстай гэрлээд хүүхэдтэй боллоо гэхэд өсөч том болохоор нь зоорь луу шар айрганд явуулна. Тэр үед түүний толгой дээр сүх унаад алчихна. Ий ий ий гэлээ.

-Би ойлголоо, ойлголоо. Эльза чи ч ухаантай юм аа. Зарц хөвгүүн ингэж хэлээд газар сууж тэр хоёртой хамтран уйлж эхлэх нь тэр.

Тэднийг ингэж байх зуур ээж аав нь Хансын хамт ширээндээ суун хүлээсээр байлаа. Сүүлдээ ээж нь тэсэхээ болиод хэлсэн нь:

-Ерөөсөө би өөрөө доошоо ороод юу болоод байгааг үзээд ирье!

Түүнийг зооринд явж ороход Эльза, зарц охин, зарц хөвгүүний хамт гурвуул мэгшин уйлж сууна гэнэ.

-Бурхан минь! Та нарыг харх айлгаа юу? хэмээн эх дуу алдлаа.

-Үгүй ээ, үгүй хэмээн Эльза гүвтнээд, би Ханстай суулаа гэхэд хүүхэдтэй болно. Тэгээд хүүхдээ том болохоор нь шар айрганд явуулна. Тэгвэл толгой дээр нь сүх унаад хүүхэд маань үхэх болно. Ий ий ий хэмээн Эльза орь дуу тавилаа.

-Нээрээ тийм байна шүү. Эльза чи ямар ухаалаг охин бэ? Ээж ийн өгүүллээд тэдэнтэй зэрэгцэн сууж, бас л уйлж гарав.

Харин аав Ханс хоёр нь гал зуухны өрөөнд, ширээний бүтээлэг гөлрөн хүлээсээр суулаа. Сүүлдээ аав нь тэвчиж чадашгүй нь гэлээ. Тэр үсрэн босоод зоорь луу харайж орвол Эльза, эхнэр хоёр нь, зарц охин, зарц хөвгүүний хамт цугаараа нус нулимсандаа хутгалдан сууцгааж байхыг хараад туйлын их гайхжээ.

-Яав аа, та нар чинь? Хий үзэгдэлтэй тулгараа юу? хэмээн аав нь

хашгирлаа.

-Үгүй ээ. Гэхдээ би Ханстай сууж хүүхэдтэй болоод түүнийгээ том болохоор нь шар айрганд явуулна. Тэгэхэд толгой дээр нь сүх унаж үхнэ. Ий ний ий хэмээн Эльза тасралтгүй уйлсаар тайлбарлав.

-Энэ бол ёстой үнэн юм байна. Эльза яасан ухаантай юм бэ?

Аав нь ингэж хэлснийхээ дараа нөгөө хэдтэйгээ зэрэгцэн суугаад мэгшүүлж эхлэв.

Ханс гал зууханд ширээний ард ганцаар суусаар байв. Ёстой сонин юм даа. Би ийм хоол байдгийг ёстой үзээгүй юм байна гэж тэр гайхан боджээ. Мөн зоориноос уухилах, мэгших, эхэр татах дуу сонсогдоход бүр ч их гайхжээ. Тэгж тэгж ерөөсөө өөрөө явж юу болоод байгаа олж мэдье хэмээн шийдлээ.

Тэр зоорины шатаар уруудан явж очтол Эльза аав ээж ба зарц охин, хүүгийн хамт бүгдээрээ торх налан суучихсан уйлж байхыг харав.

-Ээи тэнгэр минь! Та нарыг чөтгөр шулам айлгаа юу? гэж Ханс асуулаа.

-Үгүй дээ. Үгүй гэм. Гэхдээ Ханс минь. Бид хоёр гэрлээд хүүхэдтэй болно. Хүүхдээ том болохоор нь би шар айраг авчруулахаар зоорь луу явуулна. Гэтэл тэр мааь сүхэнд цохиулж үхнэ. Ий ний ий. Эльза нулимсандаа хахаж цацан байж ингэж хэлээд улам чангаар эхэр татан уйллаа.

-Ёстой доо. Чи ч үнэхээр ухаантай юм аа. Зөв л юм ярьж байна.

Ханс ингэж хэлээд Эльзатай сүмд очин гэрлэлтээ батлуудлаа.

Түүнээс хойш нэлээд хугацаа өнгөрсний дараа Ханс Эльзад хандан хэлсэн нь:

-Эхнэр минь манайх мөнгөгүй боллоо. Би явж ажил олж хийе. Харин чи яваад талх хийх эрдэнэшиш хадаад ирнэ үү гэлээ.

Ухаант Эльза дээлээ өмсөн хадуураа сугавчлаад явахад бэлтгэв. Гэхдээ явахынхаа өмнө өөртөө шөл чанаж авчээ. Тэгээд хадлангийн талбайд очсон хойноо, за байз эхлээд эрдэнэшишээ хаддаг юм бил үү, эсвэл эхлээд шөлөө иддэг юм бил үү хэмээн бодлогоширов. Тэгснээ эхлээд шөлөө идэхгүй бол хөрчих юм байна шүү. Тиймээс эхлээд хоолоо идсэн нь дээр юм байна. Би ч мөн их ухаантай хүүхэн юм даа гэж боджээ.

Эльза хоолоо идчихээд жаахан унтаж авах уу эсвэл эрдэнэшишээ хадах уу хэмээн бас л баахан бодов. Тэгж тэгж би жаахан унтаад авбал хүч тэнхээ ороод илүү их эрдэнэшиш хадах болно. Би мөн ч ухаантай хүн юм даа гэж шийдээд газар хэвтэн унтаж гарлаа.

Эльзаг ийнхүү унтаж байхад Ханс гэртээ эргэж ирлээ. Тэр галынхаа захад суун эхнэрээ эргэн ирэхийг хүлээсэн боловч гурав, дөрвөн цаг өнгөрлөө, байдаггүй. Тэгэхээр нь би ч мөн сайн эхнэртэй хүн юм аа. Тэр маань ажилдаа улайраад гэртээ ирж хоол, цайгаа ч идэж уухаа мартчихсан байна шүү дээ гэж Ханс боджээ.

Гэвч бүр үдэш болоход Хансын сэтгэл түгшин хадлангийн талбай уруу явж очлоо. Гэтэл Эльзагийн хурхирах сонсогдох бөгөөд үүргэвчинд нь юу ч байхгүй өмнө нь байсан жаахан эрдэнэ шишийн үлдэгдлийг нь элээ, хэрээ зооглосон шиг байж байх нь тэр.

Ханс маш их уурлан эхнэрээ сургахаар шийджээ. Тэр Эльзагийн дээгүүр загасны тор бүтээн, түүнд нь бяцхан хонхнууд бэхэлж орхиод гэр лүүгээ явж одов.



Хан хүү Мэлхий

Эрт урьдын цагт гурван охинтой нэгэн хаан байж гэнэ. Охид нь үзэсгэлэн гоо тоголдор агаад ялангуяа хамгийн отгон нь бүхний хайрыг булаасан, гойд сайхан охин байлаа. Алтан наран хүртэл тэр охиныг бишрэн бахдаж, ариун туяагаараа гийгүүлэх бөлгөө.

Хааны ордны ойролцоо хүлээгэр ой байх агаад тэр ой дахь хөгшин далдуу модны ёроод нэгэн худаг байх аж. Охин дулаан өдөр тэрхүү худгийн дэргэд суун алтан бөмбөгөөр наалддаг байлаа.

Нэгэн удаа гүнжийн шидсэн бөмбөг гарт нь баригдалгүй худаг уруу өнхрөөд орчихжээ. Худаг ёроол нь ч харагдахгүй гүнзгий байсан тул гүнж уйлан бархирч гарлаа. Гэтэл хэн нэгэн:

-Гүнж та яагаа вэ? Чулуу хүртэл уярмаар уйлж байна шүү, чи гэх нь сонсдов. Тэрээр ийш тийш харж хаанаас дуу гарсныг эрж хайжээ. Гэтэл нэг мэлхий үзэшгүй муухай толгойгоо уснаас цухуйлгасан харагдав.

-Учин чи байсан юм бий. Алтан бөмбөгөө худагт унагачхаад уйлж сууна даа хэмээн гүнж хэлэв.

Мэлхий хариу өгүүллүүн,

-Тайвширч үз, биттий уйл. Би нэг туслах арга хайя. Хэрэв би тоглоомыг чинь олоод өгвөл чи надад юу өгөх юм бэ?

-Эрхэм мэлхий минь, миний хувцас сувд эрдэнийн чулуу, бас миний өмсөж яваа алтан титэм аль дуртайгний чинь өгье.

Мэлхий хариулсан нь,

-Чиний хувцас, сувд эрдэнийн чулуу, алтан титэм энэ бүхэн надад хэрэггүй. Титмийг чинь авбал аав чинь дургүйцнэ. Гэхдээ чи намайг хайрлан, найз нөхрөө болгож, хамт тоглож, мөнгөн тавангаасаа идүүлж, болор хундаганаасаа уулгаж, орондоо унтуулж байх юм бол алтан бөмбөгийг чинь авч өгье. Чи зөвшөөрөх үү? гэлээ.

“Энэ муу мэлхий усан дотроо хэвтээд бусад мэлхий үрүүгээ вааглаж байвал таарна. Бас хүний найз болно гэнэ шүү” хэмээн гүнж дотроо бодсон боловч түүнийгээ ил гаргасангүй харин,

-Тэгье тэгье, алтан бөмбөгтийг минь л аваад өгвөл хүссэн болгоныг чинь гүйцэтгэнэ хэмээн өчлөө.

Мэлхий баяртайгаар вааглаад худгийн гүн үрүү шунган орж, алтан бөмбөгтийг авчран гүнжид өглөө. Гүнж баяр хоор болон, бөмбөгөө дээш нь шидлэн байснаа гэрийн зүг гүйж одов.

Мэлхий ч уснаасаа үсрэн гарч хойноос нь явсан ч түүнийг хэрхэн гүйцэх билээ, дэмий л

-Хүүе гүнж ээ, хүлээ л дээ. Би чам шиг хурдан явж чадахгүй шүү дээ гэсээр хоцров.

Маргааш өдөр нь гүнж хаан аав эгч нарынхаа хамт хоол иджээр сууж байтал шатан дээр чимээ гарах нь сонсогдов. Нэг амьтан шатаар шал, шал дуу гарган өгсөх аж. Тэгснээ хаалган дээр ирээд,

-Хайрт минь, хаалгаа нээгээч гэж нь мэлхийн дуу аж.

Гүнж хаалгаа нээж харвал мөнөөх мэлхий бүлтгэр нүдээ эргэлдүүлэн довтожон дээр суух аж. Гүнж бушуухан хаалгаа хаагаад буцаж суухад царай нь цонхийсныг хаан үзээд,

-Яав миний охин, ямар нэгэн юмнаас айгаа юу хэмээн асуулаа.

Нэг жижиг мэлхийнээс айх гэж үү? хэмээн гүнж хэлэхэд,

-Юун мэлхий байдаг билээ? Тайлбарлаад орхи хэмээн хаан хэлээ. Охин авчдаа бараг бүгдийг ярилаа. Харин өөрийнхөө амлалтын тухай л дурссангүй. Хаан түүний яриаг сонсоод ихэд уурлан, мэлхийг олж устгахыг тушаахаар шийдэн цэргүүдээ дуудахаар зэхлээ.

Яг энэ үеэр мөнөөх мэлхий хаалган дээр дахин ирж,

Гүнжсэн минь хаалгаа нээ

Хэн ирснийг харан соёрх

Далдуу модны ёроолын

Давчуу худгийн дэргэд

Өчигдөрхөн юу амласнаа

Өөрөө нэг санаач хэмээн сөөнгө хоолойгоор дуулах нь тэр.

-За хө, энэ чинь юун амлалт байдаг билээ? хэмээн хаан асуухад гүнж өчигдрийн явдлыг бүгдийг нь ярилаа.

-Тэгвэл чи амласнаа биелүүлэх ёстой. Миний улсын хамгийн ядуу тариачин ч хэлсэндээ хүрдэг байх журамтай. Тиймээс гүнж ч амласнаа биелүүлэх хэрэгтэй хэмээн хаан зарлиг болов.

Гүнж хаалгаа нээн, мэлхийг оруулж ирлээ. Бицхан хүйтэн мэлхий ширээн дээр үсрэн гарч урт хэлээ гозолзуулан,

-Хайрт минь, тавгаа дөхүүдээрэй, хоолоо хамтдаа идэжгээ хэмээн аз жаргалтайгаар хэллээ. Харин гүнжийн ой гутан, зэвхий царайлсан байлаа. Гэхдээ энэ юу ч биш байжээ. Тэр орой гүнж угаал хийлээ. Угаалгын ус хэтэрхий халуун байсан тул энэ удаа мэлхий

орсонгүй боловч гүнжийг биеэ угаагаад гарч ирэхэд нь хүлээгээд сууж байв.

-Гүнжээн минь! намайг унтлагын өрөөндөө авч ороорой. Хоёулаа хамт унтъя даа хэмээн мэлхий өгүүлдэг гүнж орь дуу тавин уйлж гарлаа. Гэтэл хаан үүнийг нь огтхон ч тоосонгүй, мэлхийг өрөөндөө авч орохыг тушаалаа. Энэ мэлхий чамд тусалсан. Одоо чи хариу барих ёстой хэмээн хэлжээ.

Гүнж мэлхийг хоёр хуруугаараа чимхэн авч өрөөндөө ороод буланд тавиад орондоо орлоо. Мэлхий шал пал хэмээн хөлөө чирэн дохсоор орон дээр үсрэн гараад, гүнжийн пансан дэрэн дээр гарч суулаа. Гүнж жонгшсэндээ мэлхийг авч чулуудахад хөөрхий мэлхий шалан дээр уналаа. Тэгэхэд нь гүнж,

-Балиар амьтан, наанаа хэвтэж бай. Маргааш муур ирж чамайг иднэ гайгүй хэмээлээ.

Мэлхийн хөл нь татавгасхийснээ, амаа хөдөлгөн нэг юм хэлэх гэсэн ч дуу гаргаж чадахгүй байлаа. Үүнийг харсан гүнж гэнэт мэлхийг өрөөдөн түүнийг гар дээрээ авч, хөөрхий мэлхий минь намайг уучлаарай гээд үнслээ.

Гэтэл юу болсон гэж санана. Харсаар байтал мэлхий өөрчлөгдөж эхэллээ гэнэ шүү. Мэлхийн ногоон арьс цагаан болон дөрвөн хөл нь гар, хөл болон уртасч нэгэн сайхан залуу болон хувирлаа. Гүнж ухаангүй айн маш чангаар хашгирлаа. Түүний хашгирах чимээнээр хаан цэргүүдийнхээ хамт гүйж ирэн мөнөөх залууг баривчлан авч гарыг нь мушгилаа.

Харин залуу огтхон ч сандарсангүй,

-Зүгээр зүгээр, та бүхэн айлтгүй. Би цонх хагалж орж ирсэн хулгайч биш харин жинхэнэ торхондоо орсон хан хүү байна. Дээр цагт хүн айлгадаг нэгэн шидтэн хаан аавд минь өширхөн намайг мэлхий болгон хувиргаж худагт хийсэн юм. Тэгээд гүнж үнэхээс нааш мэлхий чигээрээ байна гэсэн юм хэмээн өгүүллээ.

Тэгснээ гүнж үрүү эргэн харж,

-Харин та үүнийг хийлээ. Та эхлээд налад онцгүй хандсан л даа. Гэхдээ би ч үнэхээр аймшигтай муухай төрхтэй байсан. Харин дараа нь таны сайхан сэтгэл харагдлаа гэж хэлэв.

Маргааш нь хан хүү окинтойгоо гэрлүүлэхийг хаанаас гуйлаа. Хаан ч тэр, гүнж ч тэр энэ саналыг дуртайяа хүлээн авч, хуримын өдрийг товллоо.

Хан хүү уугуул нутгаа зорьж олоод, эргэж хуримандаа ирэхдээ дөрвөн цагаан морь хөллөсөн сүйх тэргээр заларлаа. Сүйх тэргийг түүний үнэнч албат Гейнрих залж явав. Тэр эзнийгээ мэлхий болон хувирахад нь "уй гунигт зүрхээ хагарна" хэмээн цээжиндээ гурван төмөр гав зүүсэн байжээ. Тэгвэл одоо Гейнрих шиг аз жаргалтай хүн алга байлаа.

Тэднийг хуримын ёслол болох сүм чиглэн давхих замд төмрийн дуу тас нясхийн сонсогдоход хан хүү сүйх тэргэ эвдрэв хэмээн бодсон ч Гейнрихийн өнөө төмөр гав тас үсрэн унахыг хараад бүгдийг ойлголоо. Одоо аз жаргалтай Гейнрихийн төмөр гав хэрэгцээгүй болж, салан унаж буй нь тэр ажээ.

Ийнхүү ханхүү Мэлхий, гүнж хоёр өнө удаан жил аз жаргалтай сайхан амьдарсан түүх эхэлсэн бүлгээ.



Эрхийн чинээхэн Том хүү

Дээр нэгэн цагт тариачин эр эхнэрийн хамт ойн захад амьдран суудаг байжээ. Тэд хүдий зав чөлөөгүй ажилладаг байсан ч жаргалтай сайхан амьдардаг байж. Тэгсэн нэг орой тариачин эр ганц тамхиа татан сууж байгаад,

-Хүүе эхнээр, манай гэр мөн ч чимээ аниргүй байх чинь вэ? хэмээн өгүүлдэхд юм нээж суусан эхнэр нь,

-Тийм ээ, хө хэмээн хариулаа.

Гэрт үнэхээр чимээгүй зөвхөн дээвэр дээр бороо дуслах, цаг цохилох л дуудах ажгуу.

Тариачин эр яриагаа үргэлжлүүлэн,

-Бидэнд үр хүүхэд байхгүй болохоор гунигтай юм даа. Бусад айлууд үр хүүхэдтэй, хэчнээн сайхан байна хэмээн хэлдээ. Эхнэр нь ч мөн гуниглан галаа ширтэж,

-Тийм шүү, эрхий хуруун чинээ хүү байсан ч бид хайраар дутаахгүй дээ хэмээн санааширлаа.

Удалгүй тэдний хүсэл биелж хүүтэй боллоо. Гэхдээ тэдний яриаг ойн савдаг сонссон болов уу гэлтэй хуруун чинээхэн хүү заяажээ. Хүү хэдий бяцхан ч гэлээ ухаалаг, овжин нүдтэй, сэргэлэн цовоо амьтан ажээ. Эж нь түүнийг гарынхаа алган дээр суулган үнэрлэж, бусад хүүхэдтэй адилхан энхрийхэн амьтан юм даа хэмээн өхөөрдөх ажгуу.

Аав ээж хоёр нь хүүдээ эрхийн чинээхэн Том хэмээх нэр хайрлажээ. Он цаг улиран өнгөрсөөр байлаа. Бяцхан Том хүү аав ээждээ туслан, халбага сэрээг нь угаах бөгөөд харин өсөч том болсонгүй, эрхийн чинээхэн хэвээрээ байлаа. Түүнийг арав орчим настай байхад нь дараах явдал тохиолджээ.

Тариачин эр өдөржин мод огтлоод, түүнийгээ морин тэргээр гэртээ авчран буцаж ой уруугаа явах гэж хамаг цагаа бардаг байлаа. Тэгээд нэг орой морин тэргийг минь араас аваачаад өгдөг хүн байдаг ч болоосой хэмээн санааширхад бяцхан Том хүү,

-Зоволтгүй ээ аав аа. Би аваад очъё гэлээ. Эцэг нь:

-Чи яаж чадах вэ. Дэндүү бага байна хэмээхүйд,

-Аав аа, би чадахдаа л чадна. Хэрэв ээж морийг маань тэргэнд хөллөөд өгөх юм бол би чихэн дотор нь суугаад, хаашаа явахыг нь хэлээд өгч чадна гэж эрхийн чинээхэн Том хариуллаа.

-Тэгвэл яахав, үзээд алд л даа хэмээн аав нь зөвшөөрлөө.

Ой уруу явах цаг болж ээж нь тэргнийг хөллөхөд Том мориньхоо чихэн дотор орж суугаад,

-Баруун тийш, зүүн тийш хэмээн хашгиран залсаар явж одов. Түүнийг нийн явж байхад нь үл таних хоёр хүн тааралдаад,

-Үгүй мөн сонин юм аа. Энэ лав албин чөтгөр биз.Тэрэг яваад байдаг, тэрэгчин нь хашгираад байгаа мөртлөө өөрөө үзэгдэхгүй юм. Дагаж яваад хаана очдогийг нь харья хэмээн хэлэлцэжээ.

Тэрэг цааш явсаар ойн гүнд ороод шуудхан мод цавчиг буй хүний дэргэд зогсов. Эрхийн чинээ хүү эцгийнхээ хараад,

-Аав аа та хар л даа. Би тэргээ аваад иртээ. Одоо намайг буулгаж ав гэж хашгирчээ.

Эцэг нь хүүгээ буулган авч буудайн ишин дээр суулгалаа. Дагаж явсан хоёр тэднийг модны араас хараад,

-Үгүй мөн сонин оо. Ийм бидхан хүүхэд байх гэж нүд бүлтгийлэн гайхлаа. Тэгснээ "Ерөөс эрхийн чинээхэн хүүг худалдаж аваад том хотод аваачиж хүмүүст үзүүлбэл их мөнгө олох юм байна" хэмээн ярилцаад аав дээр нь очиж хүүгээ зарахыг хүслээ. Харин үүнд нь эрхийн чинээхэн Томын аав ихэд уурлан,

-Би дэлхийн бүх алт байсан ч төрсөн хүүгээ зарахгүй. Дуугүй тонилгоо! хэмээн зандрлаа.

Энэ үед Том хүү эцгийнхээ мөрөн дээр авиран гараад,

-Аав аа, мөнгийг нь авчих авчих. Би буцаад ирж чадна хэмээн чихэнд нь шивэгнэлээ. Аав нь хэдий эргэлтэсэн ч хүүгийнхээ сэргэлэн цовоог мэддэг болохоор мөнгийг аваад хүүгээ өгч орхив.

Хүүг худалдаж авсан хоёр хүн,

-Чамайг хаана суулгах вэ? хэмээн хүүгээс асуухад,

-Бүрх малгайнхгаа хүрээн дээр суулгачих, чөлөөтэй сайхан байдаг юм хэмээн Том хэллээ.

Тэд цааш хэсэг явсны дараа,

-Хүүе хүн гуай, намайг буулгаатах, би бие засья хэмээн эрхийн чинээхэн Том гуйлаа. Нөгөө хүн хэсэг тоохгүй явснаа эцэст нь малгайгаа авч газарт тавилаа. Том ч бүрхний хүрээгээс үсрэн буулаа.

Тэгээд цааш гүйн замд дайралдсан хулганы нүх үрүү харайж орлоо. Тэгэхдээ,

-Баяргай залуус аа, надгүйгээр цааш явцгаа даа хэмээн хашгирлаа. Нөгөө хоёр нь яаран сандран араас нь хайсан боловч эрхийн чинээхэн хүүг олж чадсангүй, бөөн уур болсон амьтад цааш мөрөө хөөж одов.

Харанхуй ч болдоо. Том хулганы нүхнээс гаран, өвсний үндэс хөглөрсөн шавхай туулан явах зуураа, “Бурхан минь, нэг оромж олж хонохгүй бол горьгүй нь” хэмээн бодож явлаа. Ашгүй тэгтэл нэг дун дайралдсан тул түүн дотор нохойн хошууны навч чирэн оруулж ор засаад, дээр нь гарч санаа амар нойрсч эхэлтээ.

Яг энэ үеэр хоёр дээрэмчин хажууд нь ирж ярилцахыг эрхийн чинээхэн Том хүү олж сонсчээ.

-Хүүе, Билл ээ. Одоо бид нар чинь хаана очиж хулгай хийх билээ хэмээн нэг нь сөөнгөтөхөд нөгөөх нь,

-Эндхийн санваартан их баян хүн гэнэ. Зочны өрөөнд нь бөөн алт, мөнгөн тавилга байгаа гэж тогооч нь хэлсэн. Харин эргэн тойрон төмөр сараалжтай болохоор тийш нэвтрэх л хэцүү байна. Яаж тийшээ ордог билээ хэмээн яриw.

Тэдний яриаг Том хүү сонсоод,

-Яаж орохыг би хэлж өгье хэмээн хашгирлаа. Дээрэмчид түүний дуунаас үнхэлжээ хагартал айлаа. Билл нь “Энэ лав чөтгөр байхаас зайлахгүй” гэж зугтахыг завдсан ч эрхийн чинээ хүү чүдэнз зурахыг тэдэнд зөвлөw. Хулгайч нар чүдэнзний гэрэлд бяцхан хүүг олж үзэн тайвшраад,

-Гэхдээ чи ийм шавж шиг жижигхэн байж бидэнд яаж туслах хэрэг вэ гэнгээw.

-Та нар намайг сараалжны завсраар оруулчих. Би хамаг юмыг нь зөвөөд гаргая. Би их бяртай шүү хэмээн Том хэлээд булчингаа харуудлаа. Хулгайч нар ч санал нэгдэн Томын хамт цааш явсаар санваартны байшингийн цонхон дор очоод Томыг өргөн, сараалжны завсраар оруулан тавилаа.

-Хүүе та минь ээ! Энд мөнгөн халбага, сэрээ лааны алтан суурь байна. Хамаад байх хэрэг үү? хэмээн эрхийн чинээ хүү байдаг чадлаараа хашгирлаа. Гадаа байсан хулгайч нар,

-Чиши чимээгүй, хүмүүс сэрчихнэ хэмээн сандралдлаа.

Хүү тэдний үгийг огтхон ч тоосонгүй ширээн дээр гаран тогоо шанагыг нь түлхэн шалан дээр унагаж бөөн чимээ дэгдээсэн тул хажуугийн өрөөнд байсан тогооч сэртлээ.

-Эзэнтэн минь, эзэнтэн минь. Хулгайч нар гэрт ороод ирчихж. Болохоо байлаа шүү! хэмээн тэр хашгираад ухаан алдлаа. Ийнхүү хашгирахыг сонссон хоёр хулгайч хөлийн хурдаар зугтан арилж оджээ.

Том ч санаа амран байшингаас гарч малын саравчинд ороод халдсан бухал өвсөн дунд тавтайхан хэвтэж нойрлоо. Гэхдээ гай газар дороос гахай модон дотроос гэдэг шиг бас нэг гай нөмрөх нь тэр. Юу гэвэл оглөө эрт малаа тэжээхээр ирсэн малчин яг эрхийн чинээхэн Томын хэвтэж байсан тэвэр өвсийг аваад үхэртээ өгчих нь тэр. Өөрөөр хэлбэл, эрхийн чинээхэн хүү сэргэж ч амжилгүй, юу болсныг ч мэдэх завдалгүй өлсгөлөн үхрийн аманд яваад орчхов.

Хүү үхрийн аманд орсон хойноо сэргэж, шүднийг нь хараад тээрэмд орчихлоо хэмээн бодож гарахыг оролдсон ч амжсангүй, үхэр ганцхан гүдхнийгээд залгиж орчихлоо.

Хүү үхрийн ходоодонд гулсаж ортол дээрээс нь өвс нэмэгдэн орж ирсээр бүтэж үхсээ шавав. Тиймээс тэрээр одоо өвс хэрэггүй, одоо өвс хэрэггүй хэмээн хашгирч гарлаа. Энэ

үеэр тэнд байсан малчин, саальчин хоёр уг дууг сонсоод ёстой л мэл гайхан цэл хөхөрч,

-Энэ үхэр лав галзуурчихаж гэж хэлэлцээд санваартанд очиж дуулгалаа. Санваартан ч сандран ирж ариун шившлэгтэй усаар үхрээ шавшин муу чөттөр шулам минь, зайл хэмээн хэчнээн хэлэв тусыг эс олов. Эрхийн чинээ хүү гарах гэж оролдсон ч эс чадаад дэмий л хашгирсаар байв. Аргаа барсан санваартан үхрээ төхөөрөхийг зөвшөөрөөд хайртай үхэртээ харамсан уйлсаар явж одов.

Мал нядлагч ирэн хөөрхий үхрийг төхөөрсөн ч хэн нь ч ходоодыг нь нээж харахыг зүрхэлсэнгүй. Энэ хооронд ойгоос өлсгөлөн чоно гарч ирээд дотор нь эрхийн чинээхэн хүү байсаар байгаа өнөөх ходоодыг ганцхан залгиж аваад зугтан одов. Том хүү,

-За яахав, өнөөдөр миний азгүй өдөр юм байж. Хайруулын тавагнаас аврагдаад гал уруу орох нь энэ юм байж хэмээн бодсон ч сэхээ самбаагаа гээсэнгүй, арга сүвэгчилээ. Тэгээд,

-Хүүш чоно оо. Чи үнэгүй сайхан мах, хиам идэхийг хүсч байна уу? хэмээн хашгирлаа. Чоно тэр дороо зогтусан,

-Нээрээ юу, хаана байна тэр чинь хэмээн хэл амаа долоолоо.

-Тэр ойн захын айлын хоолны агуулах сараалжин тортой боловч тэр тор нь жаахан урагдчихсан байна лээ. Чи яг багтана. Дотор нь хоол хүнс пиг байгаа хэмээн эрхийн чинээхэн хүү хашгирлаа. Чоно ч тэр зүг салхи мэт хурдаллаа. Тэгээд агуулахын сараалжны завсраар шурган ороод тэнд байгаа хоолыг дэлбэртлээ идсэн тул хэтэрхий бүдүүрэн орж ирсэн газраараа буцаж гарч чадахааргүй болсон байлаа. Энэ үед Том хүү чонын дотор дэвхцэж гарлаа. Чоно ч үүнд нь өвдөн байж ядан тонгочиж гарав. Энэ чимээг дуулсан тариачин эр эхнэртээ,

-За галзуу чоно орж ирсэн байна. Би сүх авъя, чи хадуур ав хэмээгээд чоно уруу гэтэн очлоо. Тэгээд Томын аав ээж хоёр чоныг цохиж аллаа.

-Хүүе аав аа, ээж ээ. Хүү чинь байна. Чонын дотор байна шүү хэмээн эрхийн чинээхэн хүү хашгирлаа. Ээж нь яаран гүйж хайч авчран чонын гэдсийг ярвал хүү нь эв эрүүд, бүв бүтэн гарч ирж, тэд бөөн баяр хөөр боллоо.

-Ай яа, хэмээн эцэг нь санаа алдаад,

-Чи ганц өдөр шөнө л байхгүй байсан ч бид хоёр мөн ч их санаа зовлоо хэмээв.

Том цамцнаасаа хадлангийн өвс авч хаян,

-Тийм ээ аав аа. Би ч гэсэн бишгүй юм үзлээ. Бурхан минь, цэвэр агаар амьсгалах ямар сайхан юм бэ гэж дуу алдлаа.

-Хүү минь чи тэгээд хаана явж байгаад ирэв? хэмээн эх нь асуулаа.

Би хулганын нүх, үхрийн ходоод, чонын гэдсэнд байлаа. Тэгээд эцэст нь гэртээ ирж чадлаа. Бүүр хол явсан ч дахиад ирж чадна гэж эрхийн чинээхэн Том хүү өгүүлсэн бүлгээ.

Тэгээд нь,

-Үгүй үгүй, одоо дэлхийн бүх мөнгөөр ч чамайг худалдахгүй гэж ээж нь уулга алджээ.

Тэгээд Том хүү хоолоо идэж, өндөгний саванд угаал үйлдээд хүүхдийн жижиг орондоо орон уйтсан агаад дахиад хэзээ ч гэрээсээ холдоогүй гэнэ лээ.



Ширэнгэ ойн хаан

Урьд цагт хүмүүс бүгдээрээ Бурхны сургаал ёсоор амьдран, идэх талхаа хөлс дуслуулан олдог байх үед манай дэлхийн бүх юм ярьж чаддаг байж гэнэ. Тийм ээ, бүгд л ярьж ойлголцдог байсан юм гэдэг. Тухайлбал дархан хүн халуун төмөр давтахаар дошин дээрээ тавихад мөнөөх төмөр, дархан гуай, дархан гуай чанга цохиорой, чанга цохиорой хэмээн сүмийн хонх шиг хүнгэнүүлдэг байжээ.

Мужаан хүн мод зүсэх гээд ширээн дээрээ тавихад ширээ нь,

-Мужаан гуай, үүгээр хөрөөд, энүүгээр хөрөөд гэж хэлдэг байв. Тэр үед мод, харин тийм,

-Харин тийм, харин тийм яг наагуураа хөрөөд хэмээн ярьдаг ажгуу.

Тээрмийн ээнснүүд ч гэсэн бас л ярьж чаддаг байв. Тээрэм усны урсгалд эргэж эхлэхдээ,

-Бурхан минь, намайгаа авралдаа багтааж хайрла хэмээн сүм хийдийн лам нар шиг гүн сүсэглэн өгүүлэх бүлгээ. Хэрэв тээрэмчин ажлаа хийхгүй, аль эсвэл тариачдын авчирсан гурилнаас хумслаад байвал тээрэм,

-Хөөе хэн энд байна вэ? Тээрэмчин, тээрэмчин гэж дуудаж байснаа сүүлдээ маш хурднаар, ямар муухай хулгайч вэ? Ямар муухай хулгайч вэ? Атга гурилаас чимхийг нь дандаа аваад байна гэж дуржигнуулан хэлдэг байв.

Тэр үед шувууд ч бас өөрийн гэсэн хэлтэй байсан бөгөөд хүмүүс түүнийг нь ойлгодог байв. Харин харамсалтай нь одоо тэд ярих биш донгоддог, жиргэдэг, гаагалдаг, гуагалдаг төдий болсон хэрэг.

Хүмүүс хаантай, дагаж мөрдөх хуультай гэдгийг шувууд мэдэж байсан учраас тэд нар ч гэсэн хаантай болчихвол сайн сайхан болно хэмээн шийдсэн байна. Гэхдээ бүх хаан шударга сайн байдаг эсэхийг хэн ч мэдэхгүй байв.

Хаантай болох энэ шийдвэрийг бүх шувууд дэмжсэн боловч ганцхан цууцал шувуу л үл зөвшөөрөв. Цууцал бол богинохон хошуутай, ногоон алаг зүстэй, далайн эрэгт амьдардаг шувуу юм. Эрх чөлөөтэй төрсөн, эрх чөлөөтэй амьдарч байгаа бөгөөд мөн л эрх чөлөөтэй үхэхийг хүссэн тэр цууцал энэ тухай сонсоод тэр хавиар сандран нисч,

-Би одоо хаачих вэ, би одоо яана аа? гэж байснаа, алсын алс нэгэн цөөрөмд очин гав ганцаар амар жимэр аж төрөн суужээ.

Харин бусад нь хэнийг хаанаар сонгохоо шийдэхээр тавдугаар сарын нэгэн сайхан өдөр ой хөвч, тэнгис далай, уул нурууд, зүг зүгээс нисэлдэн ирж цуглав. Бүргэд, ууль, шар шувуу, хэрээ, хараачай гээд л зүсэн бүрийн бүх л жигүүртэн тэнд цугларсан байв.

Тэрч бүү хэл хэзээ ч хэнд ч үзэгддэггүй хөхөө, хөхөөнөөс дандаа өмнө ирдэг болохоороо хөхөөний цаг бүртгэгч гэж алдаршсан ацан толгойт гоёмсог өвөөлж ч иржээ. Мөн одоохондоо нэр авч амжаагүй хулганаас ч жижигхэн хүрэн бор бяцхан шувуу бас ирсэн байв.

Бүх шувуу цугласан хойно азарган тахиа, эм тахиагаа дагуулсаар нугад ирэв. Эм тахиа урьд нь энэ тухай сонсоогүй байсан учраас шувуу бүхнээс,

-Юу болоо вэ? Яав ийв? Хэмээн асууж байлаа. Азарган тахиа хайртай эхнэрээ тайвшруулан,

-Битгий сандар хайрт минь. Хаанаа сонгох том чуулган хийх гэж байгаа юм хэмээн донгодлоо.

Түүний дараа бүх шувуу цугларан хурлаа эхэллээ. Гэхдээ хурал ч гэж халуухан боллоо. Бүх шувууд хэлэх юмтай байсан учраас бие биесээсээ өрсөлдөн хашгирч байлаа. Шувууд гуагалж, гагалж, донгодож, жиргэж, хавшиж ёстой л түмэн зүйлийн дуу авиа дүнгэнэлдэн сонсогдож байв. Тэгэж тэгэж, хамгийн сүүлд шаазгай нэгэн санал дэвшүүллээ.

-Хамгийн хурдан нисдэг шувууг хаан болгоё хэмээн тэр шагширлаа.

Түүний саналыг зарим шувууд дэмжсэн боловч зарим нь хэтэрхий шударга бус байна гэж үзлээ.

-Ер нь ч тэгээд тасаас өөр хурдан нисдэг ямар шувуу байгаа юм бэ? Дэглийгээс удаан нисдэг өөр ямар шувуу байгаа юм? Тэгвэл бид нар тасыг л шууд хаан болгох юм байна л даа. Тоншуул ингэж хэлчхээд модны орой уруу нисэн очиж, мөчрийн ард нуутдлаа.

Гэтэл үг дуу цөөтэй, барагтай бол дуугардаггүй хун ам нээлээ.

-Ерөөсөө хамгийн өндөрт нисч чаддагийгаа хаанаар сонгоё гэж тэр хэллээ. Түүний саналыг олон шувуу дэмжсэн ч цацагт хяруул зөвшөөрсөнгүй.

-Би нисч ч чадахгүй гэж тэр бувтналаа.

-Чи нисч чаддаггүй юм чинь шувуу биш юм байна л даа хэмээн хэн нэг нь хажуугаас хушуу нэмэв.

Энэ үгэнд гомдсон цацагт хяруул хошуугаараа газар цавчлан толгойгоо газарт шааж орхив. Харин бусад шувуунд нэг талаар уг санал таалагдсан, нөгөө талаар бүтэн өдөржин байхыг хүсээгүй учраас шуутин исгэрэлдэж,

-Та минь ээ, хамгийн өндөрт нисдэгийгээ хаан болгоё хэмээцгээлээ.

Харин тэдний ойролцоо нэгэн мэлхий модон дор амьдардаг байсан учраас тэдний бүх яриаг сонсчээ. Тэр мэлхий бол өндөр настай, ухаантай амьтан байсан учраас хэрэв хэн өндөрт нисдэгийг үзэх тэмцээн болбол их нулимс урсана гэдгийг мэдэж байв.

-Болохгүй та минь ээ! Ёстой тэгж болохгүй гэж тэр мэлхий вааглалаа. Гэвч хэрээ хар толгойгоо хаялан,

-Зөв өө зөв. Ёстой хамгийн мэргэн шийдвэр боллоо. Бүх юм сайхан болно гэж зүтгэлээ.

Тийнхүү бүх шувуу хэн нь хамгийн өндөрт нисч чадахаа үзэхээр болов.

Шувууд тэмцээнд бэлдэн өд сөдөө цэвэрлэн, далавчаа хөвчлөн, эхлэх дохио хүлээцгээлээ. Дохио өгөх үүргийг хамгийн чанга хашгирч чаддагаар нь азарган тахианд ноогдуулжээ. Азарган тахиа хүзүүтээ хөвчлөн уушиг дүүрэн агаар залгилж аваад,

-Анхаар! Бэлдээд! Яваад! хэмээн байдаг чадлаараа хашгирлаа.

Бүх шувуу тэнгэрт хөөрлөө. Маш олон шувуу далавчаараа газар алгасан учраас шороо манан хадаж, олон шувууны өд сөд бужиганасан учраас газраас хар утаа олгойдох мэт харагдаж байв.

Шувууд өндрөөс өндөрт, эхлээд айлуудаас дээр, сүмээс дээр, модноос дээр хөөрөөд эцэстээ уулсаас ч дээгүүр хөөрөн нислээ. Хөөрөх тусам тэдний нүднээс нь нулимс гоожин, хошуу нь хавшиж байв. Удалгүй ногтруу, болжмор мэтийн жижиг шувууд эцэн буцаж, нуга дээр ирж буулаа. Харин шонхор, шар шувуу, галуу зэрэг том шувуу улам өндөрт хөөрөн, хаан титмийн төлөө тэмцэлдэж байлаа.

Бүргэд хамгаас өндөрт нисэн бусдынхаа дээрээс далавчаа дэлгэн элин халин байхдаа,

-За за, одоо дахиж дээш нисээд ч яахав. Энэ шувууд тэртэй тэргүй үүнээс өндөрт гарч чадахгүй юм байна хэмээн бодлоо. Бусад шувууд ч дороос нь,

-Хүчирхэг бүргэд минь! Танаас өндөр нисэх хэн ч алга. Та л бидний хаан болох ёстой хэмээн шуугилдлаа.

Тэгтэл ёстой сонин юм болох нь тэр. Бүргэд дээрх үгийг сонсоод толгойгоо ихэмсгээр дохиж дуусаагүй байтал нэгэн нарийхан дуу гарч,

-Би хаан, би хаан гэлээ. Харвал нөгөөх нэр устай ч болж амжаагүй бяцхан хүрэн шувуу бүргэдийн жигүүр дотор нуугдаж байснаа гараад ирэх нь тэр. Бяцхан шувуу огт нисээгүй, эцэж цуцаагүй байсан тул бүргэдээс бяцхан дээш гараад,

-Би хаан, ха ха, би жигүүртний хаан боллоо хэмээн хашгирчээ.

Гэвч бусад шувууд үүнд нь эгдүүцэн,

-Үгүй үгүй, чамайг хаанаар сонгохгүй. Дахиад өөр тэмцээн явуулья гэж хашгиралдлаа.

Энэ удаа шувууд газарт хамгийн гүнзгий шигдсэнийгээ хаан болгохоор шийдлээ. Шувууд ч газарт хамгийн гүн шигдэхийг хичээн уралдаж гарлаа. Галуу том далавчаараа газар алгадан тоос манаруулж, эм тахиа өөрийн нөхөр азарган тахиандаа нүх ухаж өгөв. Харин хамгийн өрөвдөлтэй нь нугас байв. Хөөрхий муу нугас далбагар сарвуутай нарийхан хөлөөрөө газар дэвсэлж байгаад хөлөө гэмтээж орхиод,

-Энэ бол луйвар, шударга бус байна гэж үглэсээр цөөрөм үрүүгээ хазганан явж одов.

Тэгтэл нэгэн хачирхалтай чимээ гарлаа. Тэгсэн чинь нөгөө бяцхан хүрэн шувуу хулганы нүхэнд орчихсон дуугарч байх нь тэр.

-Би бүхнээс илүү доошоо орсон. Би хаан. Би хаан боллоо гэж тэр цангиууллаа.

Үүнд нь бусад шувууд маш их уурласан байна.

-Юу гэнэ ээ хө? Тэгж ярихгүй шүү! Чамайг сая жил болсон ч хаан болгохгүй. Биднийг хууран мэхэлнэ гэнэ ээ хэмээн шувууд хашгиралдаад хулганы нүхэн дээр шавж,

-Гараад ир чи! Чамайг шийтгээд өгье хэмээн уурслаа.

Бяцхан шувуу тэднээс ихэд айсан учраас гарч ирсэнгүй, улам цааш зүтгэлээ.

-Хохь чинь тэр. Тэгвэл чи наанаа үхэн үхтлээ байх болно доо. Чамайг хоригдол болголоо гэж тэд хэлэв.

Орой болж, шувууд ядран үүрэндээ очих болсон учраас тарахаар болж харин мөнөөх хулганы нүхийг сахиж байх үүргийг шар шувуунд өглөө.

-Тэр муу шувууг гаргаж болохгүй шүү! Гаргаж алдал толгойтой чинь ярина шүү хэмээн бусад нь шар шувуунд хэлээд тاران одлоо.

Шар шувуу том шар нүдээ бүлтгийлэн нүхийг ширтэн суулаа. Гэвч тэр бас л ядарчээ. Яагаад гэвэл тэр урьд өмнө энэ өдрийнх шиг өндөрт хэзээ ч нисч байгаагүй юм санжээ.

-Ерөөсөө би нэг нүдээ аньчихъя. Нөгөө нүдээрээ энэ муу шувууг хараад байж болно. Хэрэв гарч зугтвал миний хүчирхэг сарвуунаас мултрахгүй нь лав хэмээн шар шувуу бодлоо.

Түүнийг зүүн нүдээ анигуут нөгөө жижиг шувуу нүхнээс гарч ирлээ. Шар шувуу ч ухаххийтэл буцаад нүх үрүү шургаж амжив. Шар шувуу дараа нь баруун нүдээ аниад зүүн нүдээ нээлээ. Ийм маягаар шар шувуу арван минут тутамд нэг нүдээ нээж нөгөөг нь аньж, ээлжлэн харж байв. Гэвч сүүлдээ нэг

нүдээ нээхээ мартаад өөрөөр хэлбэл, хоёр нүдээ хоёуланг нь аниад нойрондоо автжээ. Нөгөө бяцхан шувуу ч шар шувууны хурхирахыг сонсоод нүхнээсээ гаран арилж өгөв.

Тийнхүү тэр үеэс хойш хөөрхий шар шувуу өдөр бусдад харагдахаа больсон юм гэнэлээ. Яагаад гэвэл, ийм алдаа хийсэн тул бусад шувууд түүнийг тоншиж самардан, элэг доог хийх болжээ. Тиймээс шар шувуу шөнө, сарны гэрэлд чимээгүйхэн нисч, нүх ухаж амьдардаг, хулгана зурам ангуучлах болсон байна.

Бяцхан шувуу ч гэсэн ширэнгэ ойн гүнд нуугдан амьдрах болжээ. Хэрэв түүнийг бусад шувуу барьж авбал хуурч мэхэлснийх нь төлөө яахыг мэдэж байгаа тул ийн нуугдах ажээ. Гэхдээ тэр шувуу ширэнгэ ойн гүнд очоод хэн ч сонсохооргүй газар,

-Би хаан байна. Тийм ээ. Би жигүүртний хаан байна хэмээн өөрөө өөртөө чангаар хэлдэг зантай гэнэ.

Шувууд түүнийг дооглон “Ширэнгэ ойн хаан” гэж нэрлэх болсон түүхтэй ажээ.

Гэхдээ шувууд хаангүйгээр аз жаргалтай сайхан амьдарсаар ирсэн бөгөөд тэднээс хамгийн баясгалантай нь болжмор шувуу гэнэ.

Тэр бяцхан хөөрхөн шувуу наран мандахад хорвоо дэлхийн дээгүүр нисэн, “Яасан сайхан дэлхий ертөнц вэ?” хэмээн шулганан жиргэдэг билээ.

Та нар хөдөө очвол болжморын жиргээг ч, “Ширэнгэ ойн Хаан”-ы үглэхийг ч, шар шувуу өөрийн дайсан хулганатай хөөцөлдөхийг ч харж, сонсч болно шүү дээ.



Аврага том сармаг

Ах дүү хоёр хамтдаа долоон жил цэргийн алба хаажээ. Том ах нь харэгдсан бүхнээ хулгайлан цааш нь нөөцөлж байсан бол харин бага дүү нь чин шударгаар албандаа зүтгэж, цэргийн үүргээ нэр төртэй биелүүлж явжээ.

Тэднийг цэргээс халагдахад дарга нь бага дүүг нь албаа сайн хаасан хэмээн талархаад харин ахыг нь маш муу цэрэг байсан гэж хэлжээ. Энэ үед ах нь маш баян болсон байсан бол дүү нь сүмийн хулганаас ч ядуу зүдүү байв.

Ах нь том сайхан байшин худалдан аваад тэндээ ханхүү мэт чинээлэг амьдарч эхэлсэн бол дүү нь алгын чинээхэн газар түрээсэлж аваад түүн дээрээ жаахан ногоо будаахан тариалж, арай чамай амь зогоох ажээ.

Тийн байтал бороо цас холилдон хүйтэн шамрага шуурсан өдөр нэгэн гуйлгачин эмгэн хазганаж доголсоор ирж гэнэ. Тэр эмгэн эхлээд баян ахынх нь хаалгыг тогшин идэх хоол, унтах ор гуйтал цаадах нь түргэн зайлахыг тушаагаад хэрэв зайлахгүй бол нохдоо суллан тавьж уруулна шүү хэмээн занажээ. Дараа нь эмгэн ядуу дүүгээс тусламж гуйхад дүү нөгөө эмгэнийг өчүүхэн муу овоохойдоо оруулан, хамаг байдгаараа дайлан хонуулжээ. Мөнөөх гуйлгачин эмгэн өглөө нь тэднийхээс явахдаа тариалангийн талбай уруу нь заагаад,

-Сармаг тариарай! гэгчхээд яваад өгч гэнэ.

Хавар болж, тариалангийн цаг эхлэхэд ядуу тариачин дүү дээрх үгийг санаад жаахан талбайгаа хагалж борнойдоод сармагийн үр тариалж орхив. Хэдэн долоо хоног өнгөрөхөд сармаг ургаж эхэлсэн агаад ялангуяа талбайн голын нэг сармаг онцгой томорч, хөл бөмбөгийн бөмбөг чинээтэй болов. Тэгснээ ядуу тариачин дүүг харсаар байтал улам томорсоор сармагийн хаан гэж нэрлэсэн ч болохоор урьд хожид үзэгдэж дуудлаагүй асар томрон ургалаа гэнэ.

Ийнхүү талбайнхаа голд асар том сармагтай болсон ядуу тариачин яахаа

мэдэхээ байж, мэл гайхан цэл хөхөрч суутал хөрш нь нэгэн санаа гаргажээ.

-Энэ чинь сармагийн хаан юм болохоор чи срөөсөө хаантанд өөрт нь аваачиж өгвөл зүгээр юм байна. Тэр худалдаад авчхаж ч магадгүй. Ямар ч байсан оролдоод үз. Өөр хүн худалдаж авахгүй байлгүй хэмээн тэр хүн зөвлөжээ.

Ядуу тариачин энэ зөвлөгөө ёсоор өнөө том сармагаа үхэр тэргэнд ачаад хааны ордонг зүтгэжээ. Тэр тэргийг нь найман хайнагийн шар чирч явсан гээд бодохоор үнэхээр л том сармаг байлаа. Тэгсээр хааны ордонд очиход хаан маш их баярлан хөөрчээ.

-Яасан гайхалтай юм бэ? Би ийм мангар том сармаг амьд яваа насандаа хараагүй юм байна хэмээн хаан уулга алдлаа.

Тэрээр хатан хаан болон хүүхдүүдээ дуудуулан ирүүлэхэд цаадуул нь мөнөөх сармагийг үзээд баярлалдан дэвхцэж, алга ташин хөөрч байв.

-За хө. Чи чинь хэн билээ? Бодвол азтай яваа биз хэмээн хаан ядуу тариачнаас шалгаалаа.

-Үгүй ээ. Эрхэм дээдэс минь. Би нэг муу халагдсан ядуу цэрэг байна. Надад сохор зоос ч байхгүй. Харин ах минь баян тарган учраас хүн бүхэн түүнийг мэддэг юм. Харин намайг бол харж хайхардаг хүн байхгүй дээ гэж ядуу тариачин хаанд өчлөө.

-За тэгвэл энэ талаар санаа тавих хэрэгтэй юм байна даа.

Хаан ингэж хэлээд ядуу тариачинд тариалангийн газар, үхэр сүрэг, мөнгө санга хангалттай өгч гэнэ. Мань тариачин ийнхүү маш их бэлжиж нөгөө баян ахаасаа ч илүү чинээлэг болжээ.

Баян ах нь энэ тухай олж сонсоод ихэд атаархан хэрхэн улам баяжиж болох арга сүвэгчлэв. Тэгээд нэгэн зальг арга сэдэв гэнэ. Мань хүн нэгэн тэрэг авч түүн дээрээ бүх юмаа ачаалжээ. Бүх юмаа шүү. Алт, мөнгө, сандал ширээ, ор дэр, хувцас хунараас өгсүүлээд халбага, сэрээгээ хүртэл авчээ. Тэгээд л хааны ордныг зорин хөдөлж дээ. Дүү маань ганц сармаг аваачиж өгөхөд тийм их баялаг авсан юм чинь би ийм их юм аваачиж өгөхөд хаан ч гар татахгүй их юм хариуд нь өгнө гэж тэр хүн тооцоолсон хэрэг.

Баян ах явсаар хааны ордонд хүрээд хаантай уулзлаа. Тэрээр:

-Эрхэм дээдэс минь! Би таныг маш их хүндлэн хайрладаг болохоор энэ их бэлгийг өгөхөөр ирлээ. Болгоох ажаамуу гээд мэхийн ёслолоо.

-Баярлалаа. Та их сайхан зүйл сэдсэн байна. Таны энэ их бэлэгний хариуд би ч гэсэн бэлэг өгөх ёстой болж байна. Гэхдээ та маш их баян хүн юм байна. Тийм биш бол ийм их бэлгийг хэрхэн надад өгч чадах билээ дээ хэмээн хаан хэллээ.

Тэгснээ хаан сахлаа имрэн жаахан бодол болж сууснаа, би оллоо. Ёстой жинхэнэ гоё бэлэг хэмээн дуу алдлаа.

Тэгээд хаан түүнд мөнөөх том сармагийг бэлэг болгон өгчээ.



Були сахигч хэрээнүүд

Нэгэн цагт ядуу хөвгүүн амьдран суудаг байжээ. Тэр ажил төрөлгүй, ядуу учраас цэрэгт алба хаах болжээ. Тэр үед цэрэгт зарим нэгэн бүтэлгүй хүмүүс байдаг байсан бөгөөд мөрийгтэй тоглоом тоглон, зугаа цэнгээний газраар дэмий тэнэн цагийг бардаг байв. Ажил төрөлгүй ядуучуудаас өөр хэн ийм газар очиж, хоосон байранд түрүүч нарт дээрэлхүүдэн байхыг хүсэх билээ дээ.

Гэвч тэнд бас чиг гэж цөөн тооны сайн хүн байсны нэг нь дээрх хөвгүүн ажгуу. Тэрээр биеэ зөв авч яван, оногдсон үүргээ биелүүлж, зугаа цэнгээний газраар бараг явдаггүй байв. Хөвгүүн цэргийн албаны цалингаа цуглуулан дэлгүүртэй болж, эхнэр аван амьдрахыг мөрөөддөг байв.

Түүний салаанд хоёр үл бүтэх хүн хамт алба хаадаг байсан агаад бас их зальтай улс байжээ. Тэд хөвгүүнийг мөнгө хуримтлуулж байгааг мэдээд түүнийг нь авахыг санаархав.

Тиймээс тэр хоёр цэрэг эрийг эргүүлдэн,

-Хөөш найз аа жаахан уучихъя эсвэл сайхан хيام байна идээч гэжгээх бүлгээ.

Үнэхээрийн зальтай луйварчид!

Цаг хугацаа өнгөрөхөд тэр гурав найз нөхөд болцгоож хөвгүүн нөгөө хоёрыгоо сайн хүмүүс гэж шийдэв.

Удалгүй нөгөө хоёр луйварчин цэргээс халагдах тухайгаа ярих боллоо. Тэд нар,

-Бид мөнгөгүй болохоор халагдаад ч хаачих билээ. Харин чи хурандаад хадгалуулсан мөнгөө аваад цэргээс халагдвал дээрсэн. Энд ингэж гинжтэй нохой шиг байгаад хэрэггүй хэмээн хөвгүүнийг ятгах боллоо.

Цэрэг хөвгүүн энэ тухай бодож бодож, нэг өдөр шийдвэрээ гаргав.

-Би эндээс халагдлаа. Дараа долоо хоног гэхэд явах минь гэлээ.

Хоёр луйварчин ч баярлан хөвгүүний далыг алгадан байж,

-Яг зөв. Гэхдээ мөнгөө авахаа мартав даа хэмээцгээв.

Дараа долоо хоног болоход хөвгүүн үүргэвчээ бэлдэн, мөнгөө аваад даргадаа сүүлийн удаа ёслоод цэргийн хуарангаасаа гарч алхлаа.

Гэтэл нөгөө хоёр нь түүнийг үүдэнд хүлээж байжээ.

-Бид хоёр чамайг ийш нь жаахан дөхүүлж өгье хэмээн тэр хоёр саймширлаа.

Мань гурав алхсаар нэгэн замын уулзварт иртэл тэнд нэгэн хүнийг дүүжилсэн байв.

-Яагаад хүний амь хөнөөсөн хэрэгтнийг замын уулзварт дүүжилдэг юм бол доо гэж хөвгүүн асуулаа.

-Дүүжлүүлсэн хүний сүнс дүүжилсэн хүнийг олж өшөөгөө авахаас төөрүүлж ингэдэг юм гэж нөгөө хоёрынх нь нэг хариулав.

-За, тийм байдаг байж. Бид сүнс биш болохоор хаашаа явж байгаагаа мэдэх юм хойно зүүн тийш эргэе дээ гэж цэрэг өгүүлэв.

-Үгүй ээ. Бид нар баруун тийш эргэнэ гэж луйварчид мэлзэв.

Цэрэг тэдний хэлсэн баруун зүг харвал зам нь зэрлэг чоно, баавгай дүүрэн бөглүү ой руу чиглэсэн байх ажээ.

-Үгүй. Ийшээ яваад хэрэггүй хэмээн цэрэг хэлэв.

Гэтэл луйварчдын нэг нь,

-Чи биднийг худалч гэлээ хэмээн цэрэг рүү давшлав.

-Яалаа гэж. Би тэгж хэлээгүй хэмээн цэргийг хэлж дуусаагүй байтал луйварчид түүн үрүү дайрлаа. Цэрэг эр тэдний нэгийг нь цохин унагааж чадсан боловч хоёр дахь луйварчин араас нь гэнэдүүлэн модоор цохилоо. Цэрэг газарт унав. Хоёр луйварчин түүнийг хайр найргүй өшгичин зодоод үхчихлээ гэж боджээ. Тэр хоёр, цэргийн хамаг мөнгийг нь хамж аваад тосгон уруу зүглэн, зугаа цэнгээний газруудаар орон, наргиж гарчээ.

Гэвч цэрэг эр хүдэр чийрэг хүн байсан учраас хараахан үхээгүй байв. Тэр ойд өдөржин шөнөжин, дөнгөн данган амьд байсаар байв. Гэхдээ тэр нарыг ч, сарыг ч, оддыг ч харж чадахгүй байлаа.

-Ээж ээ! Хөөрхий цэрэг ийн дуудах боловч цуурайнаас өөр юу ч үл сонсогдох бүлгээ.

Цэрэг эр сохорсноо мэдлээ. Тэр дэмий л бурхнаас өршөөл гуйж байлаа.

Цэрэг эр толгой, нүднээсээ цус гоожуулан шавар шавхайн дундуур мөлхсөөр мөнөөх дүүжлүүрт хүрэв.

Цэрэг эр дүүжлүүрт авиран гараад гараа алдлан хэрээсэлсэн модноос зуурлаа.

-Бурхан надтай хамт байгаа юм байна. Бурхны хүү шиг би хамаг амь насаа ядуу хүмүүст зориулан цовдлогдлоо хэмээн цэрэг эр болсоор ухаан алджээ.

Өглөө болж үүр цайлаа. Чононууд улилдан, шар шувуу том нүдээ нээж, хүмүүс гал хөсөө асааж байхад булш эргэгч хэрээнүд хаа нэгтээгээс нисэн ирээд дүүжлүүрийн дээгүүр элэн халин нисэж, улмаар дүүжлүүрийн хөндлөвч дээр ирж суулаа.

Хэрээнүүд хурц нүдээр эргэн тойрноо шинжин, идэх юм хайн өлбөлзөж байсан тул доор нь цусаа гоожуулан хэвтэж буй цэрэг эрийг хараагүй байлаа.

Хэрээнүүд шөвгөр хошуугаараа өд сөдөө цэвэрлэн, амарч суухад нар мандаж, ойн амьтдын түрүүч үүрнээсээ гарлаа.

Гуаг гуаг хэмээн эхний хэрээ гуагчаад та нар өнөөдөр их л хол нисэж яваад ирлээ. Ямар сайхан мэдээтэй ирэв? хэмээн асуулаа.

Хоёр дахь хэрээ аймшигт хар хошуугаа шөвөлзүүлээд,

-Гуаг гуаг. Эгч дүү хэрээнүүд минь. Би өнөөдөр тосгон дээгүүр нисч яваад ирлээ. Гэтэл тэнд ус байхгүйгээс хүмүүс цангаж үхэж байна. Тэнд байгаа захын талбайд чулуу, чулууны дор хана байгаа юм. Тэр хана арван мянган хүнд ч хүрэлцэх усны судлыг хаагаад байж байгаа юм. Хүмүүс үүнийг мэдэхгүй байхад бид мэдэж байгаа биз дээ. Ха ха ха хэмээн бархирав.

Хэрээнүүд инээлдэн хошуугаа билүүдэж, хөндөл модон дээгүүр гүйлдэж байхдаа доороо хэвтэж буй цэргийг харахгүй л байлаа.

Ингэж байтал гурав дахь хэрээ хоолойгоо засан байж ярьж эхэллээ.

-Гуаг гуаг. Хүмүүс гэж ёстой юу ч мэддэггүй усан тэнгүүд байх юм. Хөгшин хааны охин өвдөөд үхэх гэж байна. Хэрэв түүнийг эмчлэх хүн гарвал хаан тэр хүнийг угсаа залгамжлуулж, охинтойгоо гэрлүүлнэ гэж ам гарсан гэнэлээ. Гэвч гүнжийг яаж аврахаа хэн ч мэдэхгүй байгаа юм даа. Уг нь тэнд нэг намаг бий. Тэр намагт байгаа мэлхийг шатаагаад үнсийг нь гүнжид аваачиж өгвөл эдгэрэх ёстой юм. Гэвч хэн ч үүнийг мэдэхгүй болохоор гүнж үхэх л болж дээ.

Дараа нь эхний ярьсан хэрээ яриагаа дахин эхэллээ.

-Хүмүүс ч өөрсдийгөө их ухаантай гэж дэмий бодох юм даа хөөрхийс. Тэд нар нарны нууцыг тайлж, газар дэлхийг танин мэдэж чаддаг мөртлөө ус хаана байгааг ч хааны охиныг хэрхэн эмчлэхийг ч мэдэхгүй юм даа. Би өнөөдөр нэг сохор хүн ой уруу мөлхөж ороод алга болохыг харсан. Тэр лав өдний амьтны идэш болчихсон байгаа даа гэж тэр хэрээ өгүүллээ.

Бусад хэрээ энэ үгийг сонсоод баясан инээлдэж далавчаа дэвэн хошуугаа билүүдэн ангалзаж байв.

-Хэрэв тэр сохор хүн өнөө шөнө диваажингаас энэ дүүжлүүрийн дор дуссан шүүдрийн усанд нүүрээ угаавал сохорсон нүдэнд нь хараа орох юм. Тэр үүнийг яаж мэдэх вэ дээ гэж эхний хэрээ яриагаа үргэлжлүүллээ.

Хоёр дахь хэрээ толгой дохиж,

-Тийм ээ, хүмүүс өөрсдийгөө ухаантай гэж боддог ч гүнж өвдөн, хүмүүс цангаж үхэн, хэн нэг нь хараагүй болж байна. Маргааш хэдүүлээ цох хорхой идэхээр явах учраас одоо унтаж амарья. Хүмүүс дайсныг нь идэж устгадаг бидэнд юунд дайсангана вэ хэмээн ярилаа.

Хэрээнүүд ийнхүү ярилцаад хошуугаа өд сөндөдөө нуун, дугжирч гарав.

Хэрээнүүдийг ийнхүү унтаж байх зуур цэрэг эр доошоо бууж дүүжлүүрийн дор байх шүүдрийг цуглуулан нүдээ арчлаа. Тэгээд тэнгэр өөд харвал одод ярайн харагдаж байв.

Өглөө нь тэр намагт очин аль дивангалавын үеэс хойш тэнд амьдарсан мэлхийг агнан, шатааж үнс болгоод, хааны ордон уруу яаравчлан очиж хаантай уулзлаа.

-Эрхэм дээдэс минь. Би нэг муу азгүй цэрэг эр байна. Гэхдээ та миний авчирсан энэ үнсийг гүнжид өгвөл эдгэрэх болно хэмээн хэлэв.

Хаан мэлхийн үнсийг охиндоо идүүлэх дургүй байсан ч хатан нь тогоочоо дуудуулан шөл болтгүүллээ. Гүнж ярвайн байж мөнөөх үнс хольсон шөлийг уутал хэрээний ярьснаар тэр дороо эдгэлээ.

Харин хөвгүүний гадаад байдал хаанд таалагдсангүй. Цэрэг эрийн хувцас хунар нь уранхай ноорхой, гутал нь майжиг, нүүр царай нь шарх сорвиор дүүрэн, гуйлгачин шиг харагдаж байв.

Ийм тэнүүдчтэй охиноо суулгахгүй хэмээн тэр боджээ. Гэхдээ хэрэв хэлснээсээ буцах юм бол ард түмэн нь уурлан эсэргүүцэж, ширээнээс нь ховхолж хаяна гэдгийг мэдэж байсан учраас хэсэг бодолхийллээ.

-Чи охинтой минь гэрлэж болно. Гэхдээ манай тосгоны хүмүүс цангаж үхэж байгаа учраас тэдэнд ус олж өгч чадвал шүү дээ хэмээн хаан хэлэв.

Хаан, цэргийг хэзээ ч ус олж чадахгүй гэж боджээ. Гэвч хэрээний яриаг тодхон санаж байсан цэрэг хотын захын талбайд очин тэнд байсан чулууг авч хаяад, доор нь байсан ханыг зайлуулахад арван мянган хүний ч цангааг тайлах ус оргилон гарчээ.

Хаан аргагүйн эрхэнд цэрэг эрийг охинтойгоо гэрлүүллээ. Цэрэг эр ч эхнэрийн хамт өөрийн тусгай ордондоо аз жаргалтай амьдран, хүмүүст хүндлэгдэх боллоо.

Түүнээс хойш нэг их удалгүй цэрэг эр зуны нэгэн сайхан өглөө ойд ан хийж яваад дээр цагийн танил, мөнгийг нь дээрэмдсэн нөгөө хоёр луйварчинтай дайралдав гэнэ.

Тэр хоёр усан тэнэгүүд байсан тул цэргээс хөөгдсөн бөгөөд ажил төрөл ч олдохгүй ойд хоргодон жимс идэн, халгайн шүүс ууж амь зогоож явдаг болсон байж гэнэ.

Цэрэг эр үзэмжтэй сайхан хувцас өмсөн, омголон морь унасан байсан тул тэр хоёр түүнийг таньсангүй. Харин цэрэг эр таньжээ.

Тэднийг морин дээрээс харж байхдаа дүүжлүүрт аваачин дүүжиле хэмээн бодлоо.

Гэвч тэдний уранхай ноорхой байдлыг хараад өрөвджээ. Тэгээд мөнөөх хоёрыг хооллож ундлаад өөрийгөө хэн болохыг хэлэв. Тэгээд өгүүлрүүн:

-Та хоёр намайг орхисон ч бурхан намайг мартаагүй. Дүүжлүүрийн модон дор би хэвтэж байхдаа гурван хэрээний ярианаас хорвоогийн нууцыг сонссон юм. Тийм учраас би хааны гүнжтэй гэрлэн ханхүү болсон. Одоо би гоё хувцас өмсч, сайн морь унадаг, өөрийн ордондоо амьдардаг хүн болсон. Надад тушаал болгоныг минь биелүүлдэг зарц, цэргүүд байна. Үнэхээр бурхан, чөтгөр шулмаас өмнө авардаг юм байна гэлээ.

Хоёр луйварчин цэргийн өмнө өвдөг сөгдөн талархал илэрхийллээ. Гэвч тэдний хилэнцэт зүрх атаархал, хорслоор дүүрч байв. Иймээс тэдний нэг нь мөн тэр оройдоо нөгөөдөө хандан,

-Яагаад ганц тэр цэрэг л азтай байх ёстой гэж. Хоёулаа тэр дүүжлүүрийн мод уруу очиж хэрээнүүдийн яриаг чагнаж аваад бас баян, хүч нөлөөтэй болшооё гэлээ.

-Харин тийм ээ, тэгье. Хоёр баян болоод тэр муу цэргийг алж орхиё гэж хоёр дахь нь хэллээ.

Нөгөө луйварчин нь ч зөвшөөрөх нь тэр. Тэдний зүрх сэтгэл өс хонзонгоор оволлож байв.

Наран жаргаж шөнийн эрвээхий нисэлдэж эхлэх үеэр дүүжлүүрийн модонд очин, доор нь хэвтэцгээлээ. Гэхдээ тэр хоёр тэнгэр бурханд ч залбирсангүй, нүгэл хилэнцээ ч наманчилсангүй. Харин архи ууж ууж, унтаад өгөв.

Ойн шувууд ч жиргэхээ больсон шөнө гурван хэрээ дүүжлүүр дээр нисэн ирж суугаад гуагачин хашгиралдаж, эргэн тойрноо хурц хараагаар ажиглан байснаа ярилцаж эхлэв.

-Би өнөөдөр их хол нисч их зүйл сонсч, их зүйл харлаа. Хэн нэгэн ус тагласан байсан ханыг нэчихсэн байна. Одоо тосгон хангалттай устай болчихжээ хэмээн эхний хэрээ шогширлоо.

Хоёр дахь хэрээ маш их уурлан, хошуугаа тэнгэр лүү чиглүүлэн шөвөлзөөд, хөгшин хааны гүнж эдгэрчихсэн гээд та нар бод доо. Хэн нэгэн нөгөө намагт байсан мэлхийг олоод гүнжид өгсөн байна гэлээ.

Хэрээнүүд маш их уурсан, хошуугаа тачигнуулан шовширч, жигүүрээ дэлгэж байлаа.

-Тэр бүү хэл нөгөө сохор эр хардаг болчихсон байна гэж гурав дахь хэрээ аахиллаа. Тэд хумсаараа дүүжлүүрийн модыг самардан байв.

-Хэн нэгэн биднийг сэм чагнаж байсан байх. Түүнээс хүмүүс тийм нууц зүйлийг хэрхэн мэдэх билээ. Ерөөсөө шалгаж үзэх хэрэгтэй. Хэрвээ тийм хүн олддог л юм бол би ёстой....

Хэрээнүүдийн нэг нь ийн хэлж дуусаагүй байтал дор унтсан хоёрын нэгнийх нь согтуугаар хурхирах дуу сонсогдох нь тэр.

Хэрээнүүд ясан хошуугаа чинжаал хутга мэт хурцлан доош өнгийж харвал хоёр луйварчин байж байх нь тэр.

-Нөгөө муу туршуулууд чинь байна. Биднээс хорвоогийн нууцыг сэм мэдсэн туршуулууд хэмээн тэд бархиралдлаа.

Хэрээнүүд доош шунган, луйварчдыг хүчирхэг далавчаараа шавхуурдан, хумсаараа самардан, хошуугаараа нүдийг нь ухан алж орхилоо.

Маргааш нь цэрэг-ханхүү тэр хавиар агсам морио унан давхиж яваад тэдний цогцсыг олсон бөгөөд тэднийг хүний ёсоор оршуулахыг тушаажээ.

Хоёр луйварчинг мөнөөх дүүжлүүрийн модон доор нутаглуулсан ажээ.

Үнэхээр бурхан тэнгэр гэгч муу үйлтнийг шийтгэж, сайн үйлтнийг авардаг нь энэ үлгэрээс харагддаг ажгуу.



Зоригт бяцхан оёдолчин

Хамелин гэдэг алдар түүхт хотод нэгэн оёдолчин амьдран суудаг байжээ. Тэр хэдий бие хаагаар бяцхан боловч туйлын эелдэг, баяр баясгалантай хүн байсан гэнэ.

Намрын нэгэн налгар өдөр тэрбээр цонхныхоо дэргэд суун үйл урлаж байтал тариачны эхнэр гудамжаар жимсний сайхан чанамал зарж явах нь үзэгдэв.

-За энэ чанамал ч мөн амттайхан даа хэмээн оёдолчин өөртөө хэлээд тариачны эхнэрийг дуудан, гэртээ оруулж сонголтоо хийж эхэллээ. Мань оёдолчин савтай чанамал болгоныг үнэрлэн амталж үзлээ. Тэгэж тэгэж, гүзээлзгэний чанамалыг заан хамгийн гоё нь энэ байна хэмээн өгүүллээ. Ингэж их удаан сонгосон хүн лавтайяа хоёр килограммыг авна гэж тариачин эхнэр боджээ. Гэтэл оёдолчин ердөө зуухан граммыг хүслээ. Тариачин эхнэр тэгэхэд нь нөгөө жаахан чанамалыг нь тасалж өгөн,

-Бүгдийг нь нэг дор идээд пологтчихов доо хэмээн ёжлоод гарч одлоо.

Оёдолчин шүүгээнээс хар талх гарган зүсээд дээр нь нөгөө чанамалаа түрхэн шүлсээ залгилаа. Мань эр чихэрлэг зүйлд ухаангүй дуртай нэгэн байв. Гэхдээ эхлээд хүрмээ оёод дуусгачихъя. Дараа нь идвэл бүр амттай гэж бодоод зүсэм талхаа хойш нь тавиад оёдлоо хийж эхлэв.

Чанамал түрхсэн талхаа идэх гэж яарсан тул хол хол харайлган өөж байлаа. Энэ хооронд амтат чанамалын үнэр авсан нэг ялаа, хоёр ялаа, арван ялаа халуунд нээлттэй байсан цонхоор нисэн орж ирээд талхан дээр шавлаа. Сүүлдээ бүүр хэдэн зуун ялаа шавсааралдах нь тэр.

Ялаа дүнгэнэлдэхийг сонссон оёдолчин эргэн хараад,

-Хүүе, та нарыг хэн дуудсан юм бэ?, одоохон зайлцгаа хэмээн хашгирлаа. Гэвч хүний хэл мэддэг ялаа гэж байхгүй тул тэд талхан дээр шавсаар л байв.

Үүнд цухалдсан оёдолчин,

-За яахав, би та нарт үзүүлдэд өгье хэмээгээд ялааны цохиур аван ширвэлээ. Тэгтэл лав л долоон ялаа цохиурт өртөн газарт үхтэхийн унах нь тэр. Үүнийг харсан оёдолчин туйлаас баярлан толины өмнө цэжээ түхийлгэн зогсож,

-Би нэг цохилтоор бүхэл бүтэн долоон амьтан цааш харууллаа. Бүх хот даяар үүнийг мэдэх ёстой хэмээн омгорхлоо. Тэгснээ ширээний ард суун нэгэн хантаазан дээр:

“НЭГЭН ЦОХИЛТООР ДОЛООГ ЦААШ ХАРУУЛАВ” хэмээн томоос том бичив. Тэгээд мөнөөх бичигт хантаазаа өмсөн толинд өөрийгөө харан, жижиг биетэй боловч агуу эр юм даа би. Нэг цохилтоор долоог цааш нь харуулсан гавьяаг минь манай ганц хот битгий хэл, дэлхий даяар мэдэх ёстой гэж өөртөө хэллээ. Түүний зүрхэнд омгорхол, бардамнал халгиж байлаа.

Тэгээд хаалгаа цоожлон хувь заяагаа бэдрэхээр гарч одлоо. Гарахынхаа өмнө өрөөнөөсөө хэрэг болох юм хайсан боловч төдийлөн базаалтай зүйл олсонгүй нэгэн бяслаг бас нэг дууч бязлуухай байсныг халаасалжээ.

Оёдолчин хөл хөнгөн, сэтгэл сэргэлэн алхсаар ууланд хүрч очвол нэгэн аварга том хүн эргэн тойрноо харан, тавлаг нь аргагүй сууж байх юм гэнэ.

Оёдолчин түүн үрүү очин үг өдөж,

-Нөхөр минь, сайн байна уу? Өргөн удам хорвоог харж сууна уу? Би азаа үзэх гэж явна. Чи хамт явна биз дээ гэлээ. Хариуд нь аврага том хүн түүнийг хайхрамжгүйхэн хараад,

-Хөөрхий муу тэнүүлчин гэжээ.

Оёдолчин тэгэхэд нь хүрмээ тайлан хантаазаа ил гаргаж үзүүлдэд,

-Би ямар хүн байна уншиж үз л дээ гэлээ.

Аварга хүн “НЭГ ЦОХИЛТООР ДОЛООГ ЦААШ ХАРУУЛАВ” хэмээсэн бичгийг уншаад оёдолчинг ялихгүй хүндэтгэх сэтгэл төрөв. Тэгэхдээ мань аварга хүн долоо гэдгийг долоон ялаа бус долоон хүн гэж ойлгосон ажээ.

Гэлээ ч түүнийг сорихоор шийдэн нэг чулуу аван ус гартал атгав. Чи тийм бяртай юм бол миний хийснийг хий гэж аварга хүний өгүүлдэхэд оёдолчин халааснаасаа бяслаг гарган шүүснийг нь гоожтол атгажээ. Тэгснээ тэр,

-Чамаас илүү байгаа биз дээ? гэв.

Аврага хүнд хэлэх үг оллоогүй боловч ийм жаахан амьтан тэгж чадна гэдэгт эргэлзэн, нэг чулуу аван шидэхэд үзэгдэхгүй болтлоо хөөрснөө гэртээ хол очин газарт унав.

Бяцхан оёдолчин хамраа маажсанаа,

-Чиний чулуу эргээд газарт унаж байгаа бол миний шидсэн чулуу бүүр эргэж унахааргүй хол явна гэж хэнэг ч үгүй хэлээд халааснаасаа мөнөөх дууч бязлуухайгаа гарган дээш шидвэл шувуу нисэн алга болов.

Аварга хүн харсандаа итгэхээс өөр аргагүй болов. Чи ч сайн шиддэг юм

байна хэмээн тэр бувтнаад аянганд ниргүүлэн газарт унасан аварга том царсны дэргэд очин, за чи тийм их бяртай юм бол үүнийг надтай дамжлалц гэлээ.

-Тэгье л дээ. Чи их биеийг нь өргөөд яв. Би мөчрөөс нь өргөө. Яагаад гэвэл тэр тал нь хүнд байдаг юм хэмээн оёдолчин хэллээ.

Аварга хүн модыг мөрөн дээрээ тавиад эргэж харж чадахгүй байсан тул оёдолчин нэг мөчир дээр нь суун ачаан дээр нь ачаа болон хөдөллөө.

Оёдолчин, “Хаврын нарлаг өглөө гурван шилдэг оёдолчин

Хотоос гаран замдаа шуударлаа”

хэмээн дуулсан шиг модон дээр сууж явахад нөгөө аварга хүн сүүлдээ ачаагаа даахаа байж,

-Хөөе би модоо хаялаа шүү гэлээ.

Тэр хооронд оёдолчин газар үсрэн буугаад модны нэг үзүүрийг өргөсөн байдал харуулан зогсоод,

-Чи ийм том байж энүүхэн модыг даахгүй юм даа гэж хэлэв гэнэ.

Тэд хамт цаашлан аварга том интоорын модны дэргэд ирээд аварга хүн хамгийн их жимстэй оройн мөчрийг тахийлган жимсийг нь идүүлэх гэж оёдолчинд атгуулав. Гэтэл оёдолчин маань хариугүй жижигхэн тул аварга хүнийг гараа авангуут тэнийсэн мөчирт таягдуулан, модон дээгүүр шидүүлэн цаад талд нь уначхаж гэнэ. Гэхдээ азаар гэмтэж бэртсэнгүй.

-Яаж байна? Иймхэн мөчрийг тогтоох тэнхэл алга уу? хэмээн аварга хүнийг асуухад мань оёдолчин,

-Юу гэнэ ээ, нэг цохилтоор долоог цааш харуулсан хүн нэг мөчир дийлэхгүй гэж бодоо юу чи. Би зүгээр л энэ модон дээгүүр үсэрч дасгал хийсэн юм. Чи бас оролдоод үз хэмээн өчлөө.

Аварга хүн хэчнээн хичээсэн ч модон дээгүүр үсэрч гарч чадсангүй тул модонд авиран гарч жимс түүж өгчээ. Тэгээд аварга хүн,

-За чи үнэхээр шилдэг эр байна. Манайд очиж хоноё гэлээ. Хөндий өгсөн явсаар нэгэн том бараан жалганд хүрч очвол бас нэгэн аварга хүн бүхэл бүтэн тугал идэн суух нь харагдах агаад оёдолчны бараг долоо хоногийн хүнс болмоор том мах тасдан авч өглөө. Оёдолчин ч юм хэлсэнгүй, мах шарж гарлаа.

Шөнө болоход нэг аварга хүн нь ор зааж өгөхөд оёдолчин түүн дээр нь авиран гарсан боловч унтаж чадсангүй. Учир нь аварга хүмүүст зориулсан тэр ор дэндүү томоос гадна хөнжил нь хүнд гэж жигтэйхэн, дарж алахаар байв. Иймд оёдолчин орноос бууж буланд унтахаар хэвтлээ.

Тэр нь бөөн аз байжээ. Учир нь түүнд ялагдсандаа атаархсан өдрийн аварга хүн шөнө ор луу гэтэж ирээд асар том төмөр бороохойгоор маш хүчтэй дэлсэж аваад, оёдолчныг үхэв хэмээн боджээ.

Хоёр аварга хүн үүр тэмдгэрэх төдий гарч одсон агаад оёдолчин нэлээд хожуу сэргэж, босоод шүдээ угааж, жаахан зутан идэж аваад замд гарав.

Гэтэл ойд жимс түүж байсан мөнөөх хоёр аварга хүн түүний барааг хармагцаа өшөөгөө авч, өөрсдийг нь алахаар ирлээ хэмээн үнхэлцгээ хагартал айн, ор мөргүй зугтаж одов. Оёдолчин тэднийг ийн зугтсанд гайхан араас нь хэд харайсан ч хэрхэн гүйцэх билээ. Харин ч нөгөө хоёрыг улам айлгасан хэрэг болов.

Энэ хэрэг явдалд гайхсан оёдолчин цааш явсаар хэдэн цагийн дараа хааны ордонд хүрч очоод цэцэрлэгт нь түрүүлгээ харан унтаж орхив.

Энэ үеэр түүн дээр ирсэн хааны албатууд хантааз дээрх

“НЭГЭН ЦОХИЛТООР ДОЛООГ ЦААШ НЬ ХАРУУЛАВ” хэмээх бичгийг уншаад,

-За энэ лав ерийн хүн биш болж таарлаа гэлцээд энэ тухай хаандаа очин айлтгав. Хаан ч оёдолчныг дуудууллаа. Тэгээд,

-Чи харваас баатар хүн шиг байна. Миний цэрэгт алба хаах уу? хэмээн асуулаа. Оёдолчин мөнөөх,

“НЭГЭН ЦОХИЛТООР ДОЛООГ ЦААШ ХАРУУЛАВ” хэмээх бичгээ зааж,

-Тийм ээ, дайсан байвал заагаад өг. Би учрыг нь олъё. Ингэх ч гэж би ирсэн юм хэмээн өчлөө.

Хаан ийм зоригт эрийг албандаа туйлын дуртай авсан агаад түүнд генерал цол олгон, том сайхан байшинд суулгалаа.

“Хорвоо дэлхий уудам гэж үнэн юм даа. Би саяхан л оёдолчин байсан. Одоо тэгвэл генерал болчихлоо” хэмээн оёдолчин аз жаргалтайаа бодож явдаг боллоо.

Харин хааны бусад генералууд энэ явдалд төдийлөн баярласангүй. “Хэрэв дайн болбол энэ хүн нэг цохилтоор долоон дайсанг устгах учраас хаан биднийг тоохгүй болно. Ерөөс учрыг нь олж хужрыг нь тунгаах нь зүй” хэмээн тэд ярилцаад хаандаа очин,

-За хаан минь, нэг бол энэ хүнтэйгээ үлд, нэг бол биднийг чөлөөлж явуулж аль хэмээн хэллээ.

Хаан гайхан духаа маажлаа. Нэг талаас нэг цохилтоор долоон хүн алдаг баатартай баймаар байсан ч нөгөө талаар өөрийн үнэнч генералуудаа явуулчихвал энэ баатар миний эсрэг босвол хэцүүднэ хэмээн бодов.

Тэгэж тэгэж, нэг арга зохиогоод оёдолчинг дуудан ирүүлж,

-За чи миний төлөө нэг зүйл хийж чадах уу хэмээн асууваас,

-Тэгэлгүй яхав, эрхэм дээдэс минь, айх юмгүй хэл хэл хэмээн цаадах нь өчнөв.

Хаан баярласандаа суудлаасаа үсрэн босч ирээд,

-Их ойд хоёр аварга амьтан үүрлэн эзэнт гүрнийг минь түйвээгээд байна. Тэр хоёрыг устгавал би чамд охиноо, хаант улсынхаа хагастай өгье хэмээн

уулга алдлаа.

-Тэр хоёрыг би мэднэ. Ядах юм байхгүй хэмээн оёдолчинг өгүүлэхэд хаан,

-Би чамд зуун морьт цэрэг өгье гэлээ. Оёдолчин үүнд ихэд инээн,

-Үгүй дээ, хаан минь тэгэх шаардлагагүй хэмээгээд,

“НЭГЭН ЦОХИЛТООР ДОЛООГ ЦААШ ХАРУУЛАВ” гэдэг бичгээ үзүүлэн,

-Би яг одоо замдаа гарлаа гэлээ.

Ийнхүү оёдолчин маань их ойн зүг дуртай дуугаа аяланхан алхсаар гүнд нь орж явчлав. Тэгтэл асар их хүржигнэх мэт чимээ сонсогдов. Тэр зүг явж очвол хоёр аварга амьтан унтан, хурхирч буй нь тэр ажээ. Тэр хоёрыг хурхирахад шуурга дэгдэх мэт болж, модод шуугих аж. Оёдолчин газраас чулуу түүн, халаасаандаа дүүргэж аваад тэр хоёрын унтаж буй модны оройд авиран гарлаа.

Тэгээд нэг аварга амьтных нь хамар луу чулуу шидлээ.

Оночихлоо. Гэвч аварга амьтан сэрсэнгүй. Дахин хэд хэд шидээний дараа мөнөөх амьтан сэрэн ийш тийш ууртайгаар харснаа нөгөөхөө сэрээн,

-Чи яагаад намайг цохиод байна? хэмээн асуулаа.

-Үгүй үгүй, би цохиогүй, чи хар дарж зүүдэлжээ хэмээн хоёр дахь аварга амьтан хэлээд тэр хоёр үргэлжлүүлэн унтлаа. Оёдолчин дахиад л чулуу шидэн хамрыг нь оносон тул эхний аварга амьтан уурлан бархирч хоёр дахь уруугаа агсарлаа. Хоёр дахь нь энэ удаа мөн л аргадан хоёул дахин унтаж эхэллээ. Харин гурав дахь удаагаа оёдолчин маань хоёр дахь аварга амьтны хамрыг чулуугаар цохиж онолоо. Гэтэл тэр амьтан туйлаас уурлан,

-Чи намайг цохилоо хэмээн нөгөөх үрүүгээ дайран зодолдож эхэллээ. Тэр хоёр аймшинтайгаа тулалдан биесээ өшиглөн, сахлаа зулгаалцан ноцолдлоо. Эцэстээ хоёул аварга том модод суга татан авч биенийгээ цохин, хоёул амиа алдан уналаа.

Оёдолчин ч модноосоо бууж, сэлмээ сугалан хоёр аварга амьтны арьснаас дурсгал болгон огтолж аваад буцлаа.

Түүнийг ордонд очиход хаан нүдэндээ итгэхгүй байлаа.

-За чи нөгөө хоёрыг үнэхээр устгачлав уу? хэмээн гайхан лавлав. Оёдолчин харилуу нь,

-Тийм ээ, гэхдээ амаргүй байлаа шүү. Тэр хоёр мод суга татан бариад над уруу дайрсан шүү. Гэхдээ л хэмээн яриад хүрмээ яран,

“НЭГЭН ЦОХИЛТООР ДОЛООГ ЦААШ ХАРУУЛАВ”

хэмээх бичгээ харуулаад,

-Ийм байхад тэд яаж ч намайг дийлэхэв дээ. Би яг ингэсэн гээд сэлмээ сугалан цавчих хөдөлгөөн харуулахад, Хаан:

-За яахав яахав, ордныг минь цавчаад хуваачихна гэж сандарлаа.

Оёдолчинд төдий л итгээгүй хаан ой уруу морьт цэргээ илгээн шалгуулахаар

явуулбал, хоёр аварга амьтан үнэхээр үхсэн байна гэж тэд ярьсаар буцаж иржээ.

-За, хаантан минь таны охинтой гэрлэж болно биз дээ хэмээн оёдолчин асуухад хаан хөмсгөө атируулан түгдэрлээ. Учир нь хаан нэгд, охиноо ийм доод язгуурын хүнтэй гэрлүүлэх, хоёрт, хаант улсынхаа хагасыг өгөх хүсэлгүй байжээ. Тэгээд бас нэг арга бодож олоод оёдолчинд хандан хэлсэн нь:

-Чиний захирах ёстой тэр газарт нэг өрөөсөн эвэрт амьтан байна. Тэр хамаг амьтныг айлган үймүүлж байна гэлээ.

-Тэгье тэгье. Би алаад орхие хэмээн оёдолчин хашгирлаа.

Харин хаан,

-Үгүй үгүй, түүнийг алчихвал аз харьчихдаг юм. Амьдаар нь аваад ир хэмээн хэллээ.

-Зовох хэрэггүй, ганц эвэртийг амьдаар нь барьж ирээд гүнжтэй гэрлэх юм байна гэж оёдолчин өгүүлээд хүрмээ сөхөх гэтэл хаан гараараа занган болиулж,

-Мэднэ мэднэ, “НЭГЭН ЦОХИЛТООР ДОЛООГ ЦААШ НЬ ХАРУУЛАВ” гэж байгаа биз дээ гэлээ.

Оёдолчин хүлэг хийхээр урт оле базааж аваад ганц эвэртийн байгаа ой руу очлоо. Ганц эвэрт оёдолчинг харангуутаа эврээ духайлган галт тэрэг мэт бараантан давхиж ирэв.

Оёдолчин аварга том царс модыг хуруугаараа налан зогсож байгаад ганц эвэртийг тулаад ирэнгүүт циркийн акробатчин шиг дээш үсрэн бултаж амжлаа. Нэгэнт ойрхон ирсэн ганц эвэрт биеэ татаж чадсангүй эврээ царсанд зоон гацааж орхив.

Оёдолчин ч түүнд тайван дөхөж очоод хүзүүгээр нь оосорлоод эврийг нь модноос салгаад хөтөлж буцлаа. Оёдолчныг эргэж ирэхийг харсан хаан хэсэг сандарснаа дахин нэг арга бодож оллоо.

-За би чамд эзэнт улсынхаа баруун хэсгийг биш зүүн хэсгийг өгье. Яагаад гэвэл тэр нь хамгийн сайн газар байгаа юм. Гэхдээ тэнд нэг галзуу зэрлэг бодон бий дээ хэмээхэд оёдолчин хааныг хориглохоос өмнө амжин хантаазаа гаргаж,

“НЭГЭН ЦОХИЛТООР ДОЛООГ ЦААШ ХАРУУЛАВ” хэмээх бичгээ ил гарган заагаад,

-Тэгье тэгье, тэр муу амьтныг болгоод өгье хэмээн хашгирлаа.

Оёдолчин өглөөний цайгаа уугаад замд гарлаа. Хаан түүнтэй хамт анчдыг илгээжээ. Анчид ч гэсэн нөгөө зэрлэг бодонтой тооцоотой юм санж. Учир нь тэр амьтан олон анчныг барьж идсэн байжээ.

Оёдолчин анчдыг ойн захад үлдэхийг тушаагаад, ганцаараа ойн гүн үрүү явж ортол мөнөөх зэрлэг бодон соёгоо гялалзуулан, хөөс сахруулсаар түүнийг чиглэн дайрч ирэх нь тэр. Мань оёдолчин ч хөлийн хурдаар зугтсаар арайхийн

нэгэн сүм үрүү харайж ороход бодон ч араас нь мөшгөв. Энэ зуур оёдолчин самбаачлан цонхоор үсрэн гарчээ. Харин бүдүүн том бодон хэрхэн цонхоор багтах билээ. Энэ хооронд оёдолчин сүмийн хаалгыг ч хааж амжсан бөгөөд сүмийн тоостой номнуудыг ховдоглон идсэн бодон ч удалгүй үхжээ.

Оёдолчин үхсэн бодонг аван буцаж ирэхэд хаан яаж ч чадсангүй зөв харж инээн, буруу харж үйлсаар охиноо эзэнт улсынхаа хагастай өгчээ.

Оёдолчин туйлын аз жаргалтай байлаа. “Хорвоо дэлхий уудам юм даа. Ямар азаар тэр өдөр чанамал худалдаж аваад нэгэн цохилтоор долоогийн долоон амьтныг цааш нь харуулав аа” хэмээн сэтгэл хангалуун бодох бүлгээ.

Гэтэл хожим нэгэн шөнө мань оёдолчин зүүдэндээ,

-Тийм ээ, ноёнтоон нэг өмд, бүсний хамт шүү. Тийм ээ ноёнтоон энэ долоо хоногт утасдаарай. Би энэ хотын хамгийн хямд оёдолчин шүү хэмээн ярихыг гүнж сонсчихжээ.

Гүнж энэ тухай аавдаа хэлбэл хаан ихэд гутран, миний охин нэг муу оёдолчинтой суучихжээ.

-Гэхдээ чи өнөөдөр унтлагын өрөөнийхөө хаалгыг нээлттэй орхиорой. Би арав, үгүй ээ тавин цэрэг явуулаад яг тэр зүүдэн дунд нь барьж аваад ертөнцийн хязгаарт цөлж орхиё. Бидний нүдэнд хэзээ ч харагдахгүй болгоё хэмээн ярилаа.

Үүнийг сонссон үйлчлэгч хүү энэ тухай оёдолчинд дуулгалаа. Учир нь тэр хүүд оёдолчин их сайн ханддаг байж л дээ.

-Баярлалаа, чамд хэмээн оёдолчин хэлээд хүрмээ ярж,

“НЭГЭН ЦОХИЛТООР ДОЛООГ ЦААШ ХАРУУЛАВ” хэмээх бичгээ үзүүлээд,

-Намайг хэн ч дийлэхгүй гэлээ.

Тэр шөнө оёдолчин унтсан дүр үзүүлэн нүдээ анин хэвтэж байгаад,

-Тийм ээ бүс, өмд хоёр. Би хоёр аварга амьтныг бас заан шиг том бодонг алж, ганц эвэртгийг барьсан хүн шүү. Одоо миний өрөөний гадаа байгаа цэргүүдээс ч айхгүй хэмээн зүүдэлсэн мэт хашгирахад гадаа нь отож байсан цэргүүд чөтгөрт хөөгдсөн мэт пижигнэтэл зугтаж оджээ.

Тэр цагаас хойш зоригт бяцхан оёдолчны эсрэг хэн ч юу ч хэлж чадахаа байсан бөгөөд оёдолчин ч хаант улсын хагасыг ухаалагаар удирдан захирах болжээ. Мөнөөх хүүг тэр гүнгийн зэрэгт дэвшүүлсэн бөгөөд эцэгт нь ч хэргэм зэрэг олгожээ.

Тэрээр ордныхоо ханан дээр алтан үсгээр,

“НЭГЭН ЦОХИЛТООР ДОЛООГ ЦААШ ХАРУУЛАВ” хэмээх эрхэм үгээ өөрийн гараар сийлсэн гэнэ билээ.



Бушины сахиул

Нэгэн өдөр баян тариачин тариалангийн талбай, цэцэрлэгээ харан зогсож байв гэнэ. Түүний тарьсан эрдэнэ шиш сайхан ургаж, наран дор алтран шаргалтаад л интоорын модных нь мөчрүүд жимсээ дааж ядан байхыг мань хүн үзээд туйлын сэтгэл хангалуун болов. Тэрээр өнгөрсөн жилийн ургацаас ниг дүүрэн нөөцөлсөн агуулахаа өнгөрөөд малынхаа хашаанд очив.

Тарган морьд нь өнгөлөг гялалзаж, хайнаг, шарууд нь тэжээл хивэн, үнээдээс нь саасан сүү хувин хувингаар мэлтэлээж байлаа.

Тариачин эр замдаа дайралдсан галуу, нугасыг хөөсөөр буцаж гэртээ орон том өрөөндөө очлоо. Тэрээр нууц газраас нэгэн хүнд төмөр хайрцаг гаргаж ирэн, нээв. Түүн дотор алт, мөнгө, үнэт цаас дүүрэн байх ажээ.

Тариачин энэ баялгаа хараад туйлын баяртайгаар маасайн нийэмсэглэлээ. Гэтэл яг энэ үед зүрх нь ёгхийх шиг боллоо. Тэгсэн чинь энэ бол зүрх сэтгэлийнх нь хаалга дуугарсан нь тэр байжээ.

Хорвоогийн бүх хүний сэтгэл зүрх хаалгатай байдаг юм гэдэг. Ихэнх хүний тэр хаалга үргэлж нээлттэй энэрэл, хайр, нигүүсэл түүгээр нь цутгаж байдаг бол манай үлгэрийн баатар баян тариачин эр шиг зарим нэг хүний тэр хаалга нам цоожтой, дотор нь атаархал, хорсол буцалж байдаг гэнэ ээ.

Тэгсэн баян тариачны сэтгэл зүрхний хаалгыг хүн чанар ирж тогшоод хэлж байх юм гэнэ.

-Тариачин гуай минь! Та хэрэгцээнээсээ зуу дахин илүү эд баялаг хуримтлуулжээ. Гэвч та энэхүү баялгаа бусадтай хуваалцсан бил үү? Гэр бүлээ асарч, ядуусыг тэтгэсэн үү? Талхаа өлссөн хүмүүст, дарсаа цангасан олонд хүртээж байсан уу? Та ийм их эд хөрөнгөндөө сэтгэл хангалуун байна уу, аль эсвэл дахиад л илүү ихийг хүсч байна уу? хариулаач гэж мөнөөх хүн чанар

асуулаа.

-Тийм ээ. Би хэнийг ч өрөвдөж, хайрлаж байгаагүй. Гэр бүлийнхэндээ ч харамч нарийн хандаж ирсэн. Ядуу гуйлгачин ирэхэд нь хөөж нохдоороо уруулдаг хүн. Бурхны тухай ч бодож явсангүй, зөвхөн хар амиа л хичээж явлаа. Эд баялаг маань тэнгэр тултал овоорсон ч сэтгэл минь ханахгүй дэг хэмээн тариачин эрийн зүрх сэтгэл хариулжээ.

Тариачин эр зүрх сэтгэлийнхээ энэхүү яриаг сонсоод царай нь цонхийн ухаан алдах шахан мэгдлээ.

Гэтэл яг энэ үеэр байшингийнх нь хаалгыг нэгэн хүн тогшив гэнэ.

-За ор ор! гэж тариачныг дуугарахад нэгэн хүн орж ирсэн нь хөрш нь байжээ.

Тэр хөрш болбоос туйлын ядуу зүдүү амьтан бөгөөд өнөр өтгөн гэр бүлээ тэжээх гэж алгын чинээхэн үржил шимгүй газарт тариа тарин, үйлээ үзэн амьдардаг байжээ. Тэр жаахан олсон мөнгөө газрын түрээсэнд өгөөд таардаг байв. Тэрээр малгайгаа аван баян тариачинд мэхийн ёслол.

-Та хүнд юу ч өгдөггүйг би мэднэ. Гэхдээ аргагүйн эрхэнд нэг юм гуйхаар ирлээ. Гэр бүл маань турж үхэх гэж байна. Та дараагийн ургац хүртэл дөрвөн шуудай гурил зээлүүднэ үү хэмээн хөрш нь хэллээ.

Баян тариачин түүнийг харан бодол боллоо. Ганц цагийн өмнөсөн бол тэр ядуу хөршөө үг дуугүй хөөж явуулах байлаа. Гэвч тэр зүрхнийхээ дуудлагыг сонссон учраас сэтгэлийнх нь хатуу мөс наранд гарсан мэт хайлж байлаа.

-Би ч их харамч байсан л даа. Тэгээд одоо бол... Юу ч гэмээр юм бэ дээ... Ер нь бол би чамд дөрвөн шуудай гурил зээлүүлэх биш харин найман шуудайг бэлэглэе. Гэхдээ нэг болзолтойгоор шүү!

-Хүүе, энэ хүн яасан их өөрчлөгдчихөв өө хэмээн хөрш өөрөө өөртөө хэлээд, та ямар болзол тавьж байгаа юм бэ дээ? хэмээн асуулаа.

-Чи намайг үхэхээр миний булшийг гурван шөнө манаж хоноорой хэмээн баян тариачин хэллээ.

Ядуу хөршид энэ болзол төдийлөн таалагдаагүй ч аргагүйн эрхэнд зөвшөөрч найман шуудай гурил аваад явж одов.

Хэдий хачирхалтай мэт боловч баян тариачин ирээдүйгээ харсан мэт долоо ч хоноогүй нас баржээ. Яагаад нас барсныг нь хэн ч сонирхосонгүй, тэгээд ч түүнийг нас барлаа гээд хэн ч харамссангүй. Харин түүнийг оршуулсны дараа ядуу хөрш нь хэлсэн үгийг нь эргэн саналаа.

Талийгаач ямар ч гэсэн надад сайн үйл хийсэн. Гэр бүлийг минь өлсгөлөнгөөс аварсан ачтан болохоор би хүсэлтийг нь биелүүлж, амласандаа хүрэх ёстой гэж хөрш боджээ.

Тэр шөнө хөрш дулаахан хувцаслаад, бүдүүн бороохойгоор зэвсэглэн баян тариачны булшин дээр очжээ. Тэр шөнө нам гүмхэн шөнө байлаа. Зөвхөн шар

шувууд л тэс модон дээр суун үүг үүг хэмээн дуугарч, сарьсан багваахайнууд сарны гэрэл дор сүлжилдэн нисэх ажээ. Хөрш ийнхүү эхний шөнийн үүргээ гүйцэтгээд үүр цайхад гэртээ харьлаа.

Хоёр дахь шөнө ч гэсэн урьдын адил амар тайван өнгөрсөн бөгөөд харин сүүлчийн гурав дахь шөнө хөрш зөн билгээрээ ямар нэгэн юм болохыг мэдэн, сэтгэл нь түгшиж эхэллээ.

Түүнийг булшны дэргэд ганц нэг цаг сууж ахуйд шар шувууд урьд урьдынхаасаа аймшигтай хашгиралдаж, сарьсан багваахайнууд бараантан нисэлдэх нь чөтгөр шулмын хий үзэгдлийг санагдуулах ажгуу.

Сүмийн хонх шөнийн арван нэгэн цагийг зарлан дуугарч байх тэр мөчид хөрш тэртээ сүмийн буланд нэгэн зүйл бараантан сүүтэгнэхийг олж үзлээ.

-Хэн бэ? Юун хүн бэ? хэмээн тэр асуулаа.

Хариулт байхгүй байсан тул хөрш бороохойгоо барин урагшиллаа. Гэхдээ тэр туйлын их айж, хөл мэдэн зугтах хүслээ арайхний барьж байв. Гэтэл нэгэн хүн тэс модны сүүдрээс гаран түүн үрүү дөхлөө. Харвал тэр хүн шовгор оройтой малгай духдуулан, асар урт нөмрөг өмсөн захыг нь босгосон байх ажээ.

Хөөрхий хөрш үүнийг хараад бараг ухаан алдгалаа айсан боловч бороохойгоо далайж, хэн бэ чи? Хариулахгүй бол толгойг чинь хага цохилоо шүү гэлээ. Гэхдээ мань эрийн хоолой чичрэн, хөгшин чавганцных шиг сөөнгөтөж байсан хэрэг.

Нөгөө хүн нь үүнийг сонсоод хүйтнээр инээн, дөхөж ирээд хөршийг хариугүй ухаан алдан унахын өмнө малгайгаа аван нүүрээ харуудлаа. Тэгсэн тэр бол ширүүн дориун харцтай, нүүрэндээ шарх сорвитой, залуу ч биш, хөгшин ч биш дунд насны хүн байх ажээ.

-Та хэн бэ? Энэ оршуулгын газар юугаа хийж яваа юм? Надаас айхгүй байна уу? хэмээн хөрш асуув.

-Би юу ч хайгаагүй. Бас юунаас ч айдаггүй хүн. Нэгэн хөвгүүн айхыг сурах гэж яваад гүнжтэй гэрлэдэг үлгэр шиг л юм. Би албанаасаа халагдсан нэг муу ядуу цэрэг эр байна. Буудалд төлөх мөнгөгүй болохоор энд ирж хоног төөрүүлье гэж явна хэмээн нөгөөх шовгор малгайт өгүүлэв.

Хөрш эр үүнийг сонсоод сэтгэл нь тайвширч,

-За тэгвэл сайн байна. Чи надтай хамт манаач хий. Өнөө шөнө ямар нэгэн юм болж магадгүй гэлээ.

-Тэгье, тэгье. Манаа хийнэ гэдэг цэрэг хүний ажил. Чамтай хамт байя л даа. Би ч бас нэг юм болох нь л гэж бодоод байгаа юм.

-Юу гэнэ ээ. Яагаад чи бас ингэж бодох болов?

-Яагаад гэж үү?

Цэрэг эрийн хэлээд пальтогоороо биеэ худлан тухалж, шар шувуу дуугарахаа больж, сарьсан багваахайнууд алга балсон байгаа биз дээ. Сарыг үүл халхлаад

эргэн тойрон түнэр харанхуйд умбасан байна даа гэж ярилаа.

Хөрш тариачин айсандаа чичирсээр зэрэгцэн суулаа. Гэхдээ дэргэд нь юунаас ч айдаггүй хүн байсан ч ийн чичирсээр л байсан хэрэг.

Түүнээс хойш нэг цаг өнгөрөн арван хоёр цагийн хонх дуугарч сүүлчийнх нь дохио цохих тэр мөчид агаарт их бууны сум шунгинах мэт илгэрсэн чимээ гаран хүхэр үнэртсээр шулам авхай өөрийн биеэр морилон ирэх нь тэр. Шулам гоё ганган хувцас өмсөн, малгайндаа улаан өд хатган дэгжирхжээ.

-Аа хаа хэмээн шулам хашгираад, зайлцгаа та нар эндээс. Тэгэхгүй бол та хоёрыг би тамын тогоо уруу аваачаад хийчихнэ шүү. Наана чинь байгаа хүний сүнснийг би авах ёстой юм. Зайлахгүй бол хүзүүг чинь хута татна гэж мэдээрэй хэмээн сүржигнэлээ.

-Мөн тэгнэ байхаа хө. Чи ямар миний дарга хурандаа юм уу. Тийм болохоор чамаар ч тушаалгахгүй дээ.

Цэрэг эр ийн өгүүлээд булшны шороог нуруугаараа налан ганас тамхиа асаалаа.

Үүнд нь шулам мэл гайхан, хөшиж орхив.

-Чи надаас айхгүй байгаа юм уу? хэмээн тэр лавлав.

-Би нэг муу хүхрийн үнэр, улаан шувууны өд төдийхнөөс айдаг нь биш хэмээн цэрэг эр инээд алдаад, харин одоо чи өөрөө эндээс зайл. Уурыг минь хүргэж орхивол хохь чинь шүү гэж тушаалаа.

Шулам шанаагаа тулан бодолд автлаа. "За байз энэ хоёр ч надаас айхгүй улс байна. Мөнгө өгч л аргалахаас өөр мэхгүй боллоо" хэмээн тэр боджээ.

-Би наад булшинд чинь байгаа тариачны сүнснийг авах гэсэн юм. Тийм болохоор би та хоёрт шуудай дүүрэн мөнгө өгье. Та хоёр тэгвэл явна биз дээ гэж шулам өгүүллээ.

-Ганц шуудай мөнгө ч хангалтгүй л байна даа. Чи яахав миний шаахайг дүүргэх алт авчирвал болох л юм гэж цэрэг хариуллаа.

Шулам цэрэг эрийн шаахайг харж байснаа, надад тийм их алт байхгүй. Гэхдээ энэ тосгоны баянаас зээлээд ирье. Надад лав өгнө хэмээн хэлээд явж одов.

Цэрэг эр ч шаахайгаа тайлаад,

-За хө, энэ муу шуламд хоёулаа молиго үмхүүлнэ ээ. Хутга байна уу? гэлээ.

Цэрэг хөрш тариачны өгсөн хутгаар шаахайныхаа уланд нүх гаргаад, бас газар ухан өвсөөр хучиж түүн дээр мөнөөх цоорхой шаахайгаа тавьлаа.

-За тэр муу яндан хөөлөгчийг яахыг харъя гэж тэр хэллээ.

Удсан ч үгүй шулам шуудай алт тэвэрсээр ирэв.

-Тэр шаахай уруу хий. Харахад наад алт чинь миний гутлыг дүүргэхгүй л юм байна даа хэмээн цэрэг эр хэв нэг хэлэхэд, шулам шаахай уруу алтаа асгав.

Гэвч алт нь улны цоорхойгоор гоожин газарт ухсан нүх үрүү юүлэгдэн шаахай урьдын адил хоосон харагдаж байв.

-Тэнэг хөгшин шулам минь. Би хангалтгүй гэж хэлээ биз дээ. Дахиад явж олж ир хэмээн цэрэг хэлэв.

Шулам гайхаш тасран чихээ маажиж байснаа явж одоод тосгоны баянаас дахиад илүү том шуудайтай алт эзэлж авчрав. Түүнийгээ шаахай уруу хийгэл мөн л урьдын явдал давтагдав. Шулам час улаан нүдээрээ шаахай уруу тонгойж хараад, чи ч их том хөлтэй юм аа даа гэж бувтналаа.

-Юу гэнэ ээ чи. Намайг өөр шигээ шувуун хөлтэй гэж бодоо юу? Явж дахиж алт авчир хэмээн цэрэг эр уурсан хашгираа.

Шулам энэ удаа мөн л буцан явснаа маш том шуудай алтыг дааж ядан аахилж уухилан майжиганаж ирэв. Тэр алтаа шаахай уруу асгахад мөн л улны цоорхойгоор гоожин нүхэнд орлоо. Гэвч үүнд шулмын тэвчээр барагдан уур нь хүрчээ.

-Намайг та нар мэхлээд байна уу? хэмээн тэр уурсан хашгираад шаахайг шүүрэн авч харлаа. Гэтэл яг энэ мөчид нарны эхний туяа зүрхнийн туссан тул шулам тамынхаа тогоо уруу яаран буцахаас аргагүй болон арилж өглөө. Ийнхүү баян тариачны сүнс аврагдах нь тэр.

Ядуу хөрш асар их алт мөнгийг хараад нүдэндээ ч итгэхгүй байв. Тэгээд алтаа хувааж авахыг цэрэг эрд санал болгов.

-Үгүй ээ. Миний хувийг ядууст өгөөрэй. Үлдсэн нь бид хоёрт хангалттай. Би эргэж ирээд чамтай цуг амьдаръя. Бурхан ивээвэл амар жимэр амьдрахад хүрэлцээтэй баян боллоо бид нар гэж цэрэг эр хэлжээ.

Тийнхүү тариачин, цэрэг хоёр он удаан жил нэгэн тосгонд эв найртай, аз жаргалтай амьдарсан юм гэнэлээ.



Цасан цагаан ба Сарнай улаан хоёр

Нэгэн ядуу бэлэвсэн эхнэр хязгаар бөглүү нутагт амьдран суудаг байжээ.

Тэр эмэгтэйн цэцэрлэгт сарнайн хоёр бут ургадаг байсны нэгээс нь цагаан цэцэг, хоёр дахиаас нь улаан цэцэг дэлгэрдэг байлаа. Мөнөөх эмэгтэй басхүү хоёр дагавар охинтой юм санж. Нэг охин нь цагаан царайтай тул Цасан цагаан гэдэг нэртэй, нөгөөх нь улаахан хацартай тул Сарнай улаан гэдэг нэртэй байв.

Тэд нялх багынхаа аз жаргалд умбасан, зан ааш, хүмүүжил сайтай баяр баясгалантай охид ажээ. Цасан цагаан охин ноомой зөөлхөн ааштай, гэртээ байж ээждээ туслах дуртай бол Сарнай улаан нь хурц идэрмэг ааштай агаад хээр талаар гүйж, араатан жигүүртнийг сонирхон харах дуртай бүлгээ.

Хэдий охид ийм өөр өөр зан ааштай боловч хоорондоо туйлын найрсаг, эвтэй амьдрах бөгөөд хэзээ ч хагацан салахгүй, баяр зовлон алиныг ч хамтдаа туулах андгай тангарагтай байлаа.

Тэд хүн амьтангүй бөглүү хязгаарт амьдардаг боловч хэзээ ч уйдаж байсангүй. Охидыг ойн гүнд гүзээлзгэнэ жимс түүн явахад ямар ч амьтан айлгаж очоодоггүй бүлгээ.

Тэдний өмнө бяцхан бүжингүүд дэгдэн ирж, гараас нь өвс ногоо идэж, хандгай бута хажууд нь харайн наадаж, шувууд жиргэн баясдаг байв. Цасан цагаан, Сарнай улаан хоёр ойд оройтвол навчсаар биесээ хучаад хөвдөн дээр унтаж орхидог байв. Ингэхэд нь хэн ч тэднийг айлгаж ичээдэггүй байсан тул ээж нь ч санаа амар байдаг байлаа.

Охид гэр орноо ч гял цал сайхан байлгадаг байв. Цасан цагаан нь зуны цагт гэрийнхээ ажлыг хийн, өглөө бүр сарнай цэцгийн баглаа бэлтгэн ээжийнхээ

орны дэргэд тавьдаг бол Сарнай Улаан охин өвлийн улиралд гэр орноо арчлан, гялалзуулдаг заншилтай байлаа.

Үдэш нь ээж нь охиддоо тэдний сонсох дуртай “Зоригт бяцхан оёдолчин”, “Хан хүү Мэлхий”, “Нойрсөгч гоо охин” зэрэг үлгэрүүдийг уншиж өгдөг байлаа. Гэхдээ хоёр охины хамгийн дуртай үлгэр нь “Цасан цагаан ба долоон одой хүн” байв.

Ээжийг нь ийнхүү үлгэр уншиж байхад галын дэргэд ишиг хэвтэн, цагаан тагтаа хошуугаа жигүүрэн доороо шургуулан задгай зуухны хажууд тухлах ажгуу. Тэд хэдий нэг их баян цагталан биш боловч ийнхүү туйлын эв найртай сайхан амьдардаг байсан учраас илүү эд хөрөнгөний ч хэрэггүй байв.

Өвлийн нэгэн шөнө тэдний нутагт аймшигт цасан шуурга боллоо. Салхи яндангаар хүнгэнэн ой, нуга цасанд даруулжээ. Харин байшин дотор тохилог, дулахан байх агаад ээж нь охиддоо үлгэр уншин, ишиг тугал хоёр унтаж зөвхөн цагийн дохио өгөн хашгирагч азарган тахиа л дахин зуны найртай улирал болно гэдгийг сануулан дуугарч байв.

Тэгтэл гэнэт тэдний хаалгыг аймшигтай чангаар тогших нь сонсогдлоо.

Хүүхдүүд нь нүдээ дүрлийлгэн ээжийгээ харвал ээж нь нүдний шилээ авч уншиж байсан номоо хойш тавиад тайвнаар,

- Энэ замд төрсөн хөөрхий аянчид байхаас зайлахгүй. Сарнай улаан аа, миний охин хаалгаа нээж өг хэмээн хэлэв.

Сарнай Улаан хаалганы түгжээсийг мулталбал салхи исгэрэн, цас манарч тэдний байшинд асар том хар баавгай нэвсийн орж ирэх нь тэр. Сарнай улаан айсандаа дуу алдаж, ишиг өөр өрөө үрүү зугтан, тагтаа гал зуухны шүүгээ үрүү зүтгэн, цагны азарган тахиа хүртэл дохиогоо өгөхөө умартан жижиг хайрцгандаа шургалаа. Харин Цасан цагаан ээжийнхээ сандлын араар нуугдлаа.

Ээж нь галын шилээврээ шүүрэн авбал мөнөөх баавгай шар собоогоо гарган, данхар толгойгоо сэжиж,

-Сайн санаат хүн гуай минь, намайг битгий цохиорой. Би цасан шуурганд төрсөн баавгай байна. Галын бараа харж дулаацахгүй бол ичээндээ хэзээ ч очиж чадахгүй, хөлдөж үхэх юм байна гэж бодоод ирсэн минь энэ хэмээн баргил хоолойгоор өгүүллээ.

- Хөөрхий муу баавгай хэмээн ээж нь дуу алдаж баавгайн толгойг илж,

- Тэгээгүй яхав, чи манайд байж дулаацаж ав. Харин галд үсээ хуйхалчхав, болгоомжтой байгаарай. Цасан цагаан, Сарнай улаан хоёр минь наашаа ирцээ. Энэ баавгай та хоёрыг яах ч үгүй хэмээн хэллээ.

Хоёр охин, ишиг, тагтаа бүгдээр гарч ирцгээн цагны азарган тахиа найман цаг болсныг зарлан донгодлоо.

Баавгай газар, задгай зуухны дэргэд сөхрөн хэвтээд санаа амран аахиллаа. Түүний биед цас, мөсөн бүрхүүд тогтсон байсныг нь хүүхдүүд шүүрдэн арилгалаа.

Баавгай гүнзгий амьсгаа аван хажуугаараа задгай зуух налан хэвтээд,
- Баярлалаа, хүүхдүүд минь. Ээж танд баярлалаа. Хүн бүхэн гэртээ баавгай оруулаад байдаггүй юм хэмээн талархан хэлэв.

Ээж нь баавгайд лонх сүү, зөгийн балтай өглөө. Энэ үед хүүхдүүд тэдний үсэрхэг зочин болох баавгайнаас айхаа аль хэдийн больсон байлаа. Улмаар тэд бишүүрхээ больж баавгайн үсийг илбэх, сүүлнээс нь татах, дээр нь мордох зэргээр түүнгэй тоглож эхлэв.

Хүүхдүүд түүнийг шилбүүрээр ороолгон тоглоход баавгай уурласан дүр үзүүлэн хүржигнэх бөгөөд тийн шилбүүрдэх нь баавгайд үлээх төдий ч мэдрэгдэхгүй байсан ба хүүхдүүдийн дээр нь мордох ганц ялаа суусан төдий санагдаж байсан ажээ.

Орой унтах цаг болоход хүүхдүүд баавгайд сайхан нойрсохыг ерөөн өрөө үрүүгээ орцгоов. Баавгай ч явахаар зэхэн босоход нь ээж түүнд хандан,

-Эрхэм баавгай минь. Яваад хэрэггүй. Манайд дулаан галын дэргэд хоночих хэмээн хэлэв.

Баавгай түүнд талархан бүхэл шөнийн турш задгай зуухны дэргэд нам унтсан бөгөөд харин өглөө болж, хүүхдүүд хаалга нээгдэж байшингаас гарч цасан дундуур явж одов.

Хүүхдүүд болон эх, баавгайг ийнхүү явуулсандаа тун гонсгор байсан агаад баавгайн хүлгээр бараа байхгүй болохоор гэр орон нь ч эл хуль оргих мэт санагдаж байв. Гэвч мөн тэр үдэш тэд гэр бүлээрээ галаа тойрон сууцгааж байтал хаалга тогших чимээ сонсогдон Сарнай улаан хаалгаа нээгээд баавгайн данхар том толгой цаанаас нь цухуйлаа.

- Хүүе, баавгай юу даа? Чи чинь дахиад төөрчихөө юү хэмээн эх асуулаа.

Баавгай хий ханиалган түгдчиж байснаа,

- Би ч уг нь яг ч төөрөөгүй л дээ. Зүгээр л. Юу л гэж. Би урьд шөнө их сайхан хоносон болохоор дахиад ирмээр санагдаад. Та нарыг төвөгшөөхгүй байх гэж санаад хэмээн ичингүйрэн өгүүллэв.

Тэр өдөөс хойш баавгай тэдний байшинд үдэш бүрийн найман цагт ирж хүүхдүүдтэй тоглоод дараа нь баавгайнуудын амьдралын тухай сонин түүхийг хүүрнэн, задгай зуухны дэргэд унтдаг болов.

Өвөл өнгөрч, хавар болдгоороо боллоо. Хэдий цас хайлж хараахан дуусаагүй байсан ч модод гөлөглөн, бутны цагаан цэцэг соёолж байсан цаг.

Нэгэн өдөр баавгай ердийнхөөсөө арай эрт ирлээ.

-Би явах боллоо. Зун, намар ирэхгүй. Та нартайгаа дараа өвөл л ирж уулзъя хэмээн баавгай хэлэх нь тэр.

Ээж хүүхдүүд үүнд тун гунигтай байв.

-Чи яагаад явж байгаа юм бэ? Эрхэм баавгай минь хэмээн тэд нэгэн дуугаар лавлав.

Баавгай хүндээр санаа алдах бөгөөд нэг зүйлд санаа зовон түгшсэн шинжтэй харагдаж байв. Би ичээндээ нэлээд их алт эрдэнэстэй юм л даа. Харин ойд амьдардаг муу санаатай одой хүмүүс тэр алт эрдэнэст минь шунан, хулгайлах гээд байгаа юм. Тэд нар аль эртнээс газар доогуур хонгил ухан миний ичээн доороос нэвтрэн, алт эрдэнэсийг минь хулгайлахаар оролдсоор ирсэн юм.

Харин өвөл бол миний баялаг аюулгүй байдалд байдаг. Учир нь газар хөлдөн хад мэт хатуу болдог болохоор одой нар миний ичээнд хүрч чаддаггүй юм. Харин одоо бол хавар болж, газар гэсэн зөөлөрсөн учраас одой нар газар доогуур хөндийлөн ичээнд минь хүрэх боломжтой болсон. Тэд одоо өдөр шөнөгүй газар ухаж байгаа байх. Хэрэв тэд миний алт эрдэнэсийг олбол даах хэмжээгээрээ хулгай хийж аваад уулын жалганд булчихна. Тэгвэл дахиж олоход маш хэцүү. Та нар минь үүнийг зөв ойлгоорой хэмээн баавгай ярих.

-За яахав, тэгвэл чи яв даа. Гэхдээ бид чамд санаа зовох болно хэмээн ээж хэлэв.

-Та нар минь намайг уучлаарай! хэмээн баавгай хэлээд хоншоорыг нь даган урсах нулимсаа арчаад хаалгаар гарч цааш хурдан давхисаар ой модон дунд орон, бараа тасрав. Гэвч баавгай маш хурдан давхисан тул биеэ нэгэн модны яранд огло татан хэсэг ноос үлдээгээд бие нь хэсэгхэн газар шалбарсан нь ил харагдаж байв. Цасан цагаан үүнийг нь хальт харсан бөгөөд биеийнх нь тэр хэсэг шаргал өнгөтэй харагджээ. Гэхдээ энэ бүхэн маш хурдан болсон тул Цасан цагаан харсандаа төдийлөн итгээгүй ч гайхсаар үлдэв.

Тэр цагаас хойш хэсэгхэн хугацааны дараа зуны сайхан улирал болж шувуудын жиргээ уянгалах болсон цагаар ээж нь хоёр охиноо мөөг түүлгэхээр явуулав. Охид гэрээсээ гараад холдоогүй байхдаа нэгэн сонин зүйлтэй учирсан нь аяганд ниргүүлэн газар унасан нэгэн модны хажууд нэг зүйл бөртөгөнөн сүүдэлзэх ажээ. Ойртон очвол гурван алд урт сахалтай, барзгар бараан царайтай нэгэн одой хүн байсанд хүүхдүүд нүдэндээ ч итгээснийгүй. Сахлынх нь нэг үзүүр модны мөчрийн угт хавчуулагдсан байх агаад тэр одой хүн хэдийгээр гинжтэй нохой мэт цовхчих боловч сахлаа мулталж авч хэрхэвч чадахгүй байв.

Одой хүн мухар хуруут гараа охид уруу гозолзуулан, ууртай улаан нүдээрээ хялайн харж,

-Тэнд битгий зогсоод бай л даа. Наашаа ирцгээ! хэмээн хашгирав.

-Юу болоо вэ? хэмээн Сарнай улаан асуулаа.

-Юу болоо вэ гэнэ шүү. Тэнэг мулгуу галуунууд минь. Харахгүй байна уу? Би аяга хоолоо чанаж идэх жаахан түлээ түүх гэсэн юм. Би ямар та нар мэтийн заваан том хүмүүс шиг хоолоо хийх гэж бүхэл бүтэн ой огтолдог биш. Тэгэх гэж мод огтолж яваад сахлаа модны салаанд хавчуулж орхилоо байна. Тэнэг царайлсан хоёр хүний оронцгууд минь та нар намайг шоолж байхаар туслаад өгөөч хэмээх мөнөөх одой хүн чарлав.

Цасан цагаан, Сарнай улаан хоёр одой хүнийг суллах гэж байдгаараа оролдлоо. Тэр хоёр түүний хүзүү, толгойноос нь барин татаж, өргөж үзсэн боловч сахлыг нь модноос салгаж дөнгөсөнгүй. Сүүлдээ аргаа барсан Сарнай улаан явж хэн нэгнийг олж ирэхээр шийдээд түүнийгээ одой хүнд дуулгав.

-Хагархай тогоонууд минь, хэмээн одой хүн хашгичаад өөр хүмүүс ирлээ гээд өөдтэй юм болохгүй. Та нар ч хониноос тэнэг амьтад юм байна хэмээн одой хүн бухимдан орилов.

Цасан цагаан одой хүн эгчтэй нь ийн ярилцахыг сонсоод,

-За яахав тийм байж. Хүн гуай, та хэрэв суларья л гэж байгаа бол сулар л даа хэмээн хэлээд хайчаа гарган одой хүний сахлын үзүүрийг хайчлав.

Одой хүн сахлыг нь тайрангуут хүчиндээ гэдрэг савж унаснаа түргэхэн босон харайж, модны ёроолд нуусан алттай үүргэвчээ шүүрч аваад охилод баяртай ч гэж хэлэлгүй явж одов. Тэгснээ нэлээд хол очоод,

-Тэнэг охидууд, та нар миний сайхан сахлыг хайчилна гэнэ ээ. За яахав сайхан мэдээрэй хэмээн хуруугаараа чичин хашгирав.

Түүнээс хойш бүр намар болсон хойно Цасан цагаан, Сарнай улаан хоёр нэгэн сайхан өдөр загасчилж яваад голын эрэг дээр нэгэн амьтан дэвхрэг шиг дэвхэрч байхыг олж үзэв. Гэтэл хэн байсан гэж та нар бодно, нөгөөх одой хүн дүрээрээ байх нь тэр.

-Хүүе ээ! Та болгоомжтой байгаарай, усанд унах нь байна шүү хэмээн Цасан цагаан анхаарууллаа.

Одой хүн гэдэн үрүү хялалзан,

-Аа өнөөх ясан толгойтууд уу? Миний яаж байгааг харахгүй байна уу, та нар. Би загасчилж явтал дэгээнд нэг том загас орчихлоо. Гэтэл загасны дэгээний утас сахалд минь орооцолдчихоод загас ус уруу намайг татаад живүүлж алах нь. Туслаарай! хэмээн хашгичав.

Хоёр охин одой хүнийг түшин авсан ч утас сахалд нь даамай орооцолдсон учраас яавч салгаж дөнгөхгүй байлаа. Ийм болохоор Цасан Цагаан хайчаа гарган сахлынх нь үзүүрээс тайран авч, одой хүнийг усанд живэхээс аварлаа. Үүний төлөө тэр хүүхдүүдэд талархал илэрхийлсэн гэж та нар бодож байгаа биз. Тэгвэл харин ч үгүй шүү. Одой хүн уурлан газар дэвсэлж,

-Муу сармагчингууд. Та нар эхлээд сахалны минь хугасыг тайрсан. Одоо бүр илүү тайрлаа. Дараагийн удаа та нарын сүнсийг чөтгөр авсан байх болтугай хэмээн орилов.

Тэгснээ модны дор нуусан сувдтай уутаа шүүрэн аваад харааж зүхсээр арилж өгөв.

Намрын алтан өдрүүд ирлээ. Алим жимс боловсроон усны шувууд дулаан орноо нисэн одлоо. Тосгонд намрын баяр болох байсан учраас ээж нь охидоо тэр баяр уруу утас зүү, тууз зүүлт худалдан авхуулахаар илгээв. Тэр тосгон

уруу явахад том том хадан цохион дундуур өнгөрдөг байв. Хоёр охиныг тэнд явж байгал нэгэн шувуу хашгирах чимээ сонсогдов. Хартал хадан цохионы ард нэгэн том бүргэд нэгэн зүйл үрүү шунган тоншиж байх нь үзэгдэв. Тэндээс хэн нэгэн айн сандарсан хоолойгоор орилох нь дуулдахад охидууд яаран гүйж очвол мөн л өмнө нь тааралдаж байсан нөгөөх одой хүн байж байх ажээ.

Бүргэд түүнийг хүчирхэг сарвуугаараа шүүрэн аваад хариугүй нисэх гэж байв. Агаарт дөнгөж хөөрч эхэлж байхад нь охидууд амжин очиж Сарнай улаан сахлынх нь үзүүрээс, харин Цасан цагаан хүрэмнийх нь хормойноос зууран барьж авахад бүргэд хэдий бүх хүчээ гаргасан ч тэднийг хараахан даасангүй, эцэстээ орхин нисэч одов.

Одой хүн газарт унан, амьсгаагаа дарсан хойноо газар дэвслэн байж,

-Муу хоёр галуу. Ахиад л та нар уу? Миний шинэ хүрмийг урж таслаад хаячихлаа та нар хэмээн сүржигнэлээ. Тэгсэнээ эрүүгээ барьж үзээд,

-Гайтай хоёр новш. Миний сахлын үлдэснийг тас татсан байна шүү дээ. Та хоёрын хүзүү хугараг хэмээн аймшигтайгаар бархирлаа.

Тэгээд ганц ч талархлын үг хэлсэнгүй, газраас алмас эрдэнэ дүүрэн чихээстэй цүнхээ шүүрч аваад хадны дундах нүхэн оромж уруугаа шургаад алга болов.

Түүнээс хойш өдөр хоног улиран улирсаар өвлийн сэрүүн амьсгал орсон үеэр Цасан цагаан, Сарнай улаан хоёр түлээ түүхээр ойд явж байгаад мөнөөх одой хүн үнэт эрдэнэсээ хараад сууж байхыг санаандгүй олж үзлээ.

Одой хүн алт, сувд, алмас эрдэнийг газарт асган түүнийгээ шүлэнгэтэн ширтэж суух нь модлын завсраар харагдав. Алт нар шиг шижиртэн, сувд саран адил туяарч, харин алмас эрдэнэ солонгорон гялалзахыг охид сонирхон харж зогсол мөнөөх одой тэднийг олоод үзчихэв. Түүний царай час улаан болон уурслаа.

-Аа та хоёр дахиад л намайг мөрдөж явна уу? Юугаа хараав? Та хоёр намайг юу гэж бодоов? Одой хүн ийн хашгираад бүснээсээ сүх мултлан авч тэдэн үрүү чиглүүлэн далайлаа. Охид ч туйлын их айлаа. Гэтэл ойн зүгээс асар их чимээ гарч замдаа дайралдсан модны мөчрийг тас няххийлэн хугалсаар баавгай дүүлэн гарч ирэх нь тэр.

Баавгайн завжаар нь хөөс сахран нүд нь улаанаар эргэлдэх агаад хойт хоёр хөл дээрээ зогслоо.

-Намайг өршөөгөөч дээ, баавгай минь! Би чамд бүх алт эрдэнэсийг өгье хэмээн одой аймхай дуугаар гонгиноход баавгайн архиралт улам ширүүслээ.

Одой хүн хоёр охины араар гүйн орсноо,

-Баавгай минь. Би ийм жижигхэн юм чинь чамд хоол болох ч үгүй. Тэгээд ч над шиг хөгшин амьтны зовлогоор та яах вэ? Харин энэ хоёр охин ёстой амттай байгаа даа. Энэ хоёрыг идчих хэмээн хашгирлаа.

Тэгсэнэ хоёр охиныг урагш нь түлхээд зугтлаа. Гэвч түүнийг нүх үрүүгээ шургаххаас өмнө баавгай базан авч хумин шидэхэд одой хүн хамхуул мэт бөөвийсөн бөөрөнхий юм болоод газрын уруу бөмбөрөн одов.

Энэ явдлаас айж цочирдсон хоёр охин ч эргэн гүйлээ. Гэтэл араас нь,

-Хүүе, Цасан Цагаан, Сарнай Улаан хоёр оо! Битгий ай л даа, би та хоёрыг яах ч үгүй хэмээн баавгай хашгирлаа. Тэр хоёр ч найз баавгайнхаа дуут танилаа.

Гэтэл эргээд хартал хамгийн гайхалтай үзэгдэл болох нь тэр. Юу гэвэл баавгайн арьс нь гэнэт хуулран унаж, савар нь мултран хувирсаар нэгэн сайхан залуу болж орхилоо.

Тэгээд тэр залуу хоёр охиныг дагуулан гэрт нь очоод ээжийнх нь хамт гал тойрон суугаад, дараах түүхийг хүүрнэжээ.

-Би бол хааны хүү байгаа юм хэмээн тэр яриагаа эхлээд, тэр одойг хов жив ярьсных нь төлөө би шийтгэсэн юм. Гэтэл тэр надад хараал хийн баавгай болгосон учраас би ойд амьдрахаас аргагүй болсон юм. Гэхдээ одоо хариугаа ч авсан. Хараал нь ч хүчгүй болсон хэмээн яриw.

Охид алга ташлаа. Харин ээж нь нэлээд гунигтайгаар,

-Тэгвэл чи одоо ордондоо очих болох нь. Бид ч дахиад уулзалдахгүй биз дээ хэмээлээ.

Хан хүү гал уруу ширтэн тойлгой эсгэсэрч,

-Үгүй ээ, би ордонд очихгүй. Тэнд уйтгартай, ёсорхуу, ганцаардмал амьдрал байдаг. Би танай энэ бяцхан байшинд ирээд л хүн энгийн мөртлөө аз жаргалтай амьдардгийг мэдсэн. Би энд сууж бүх эрдэнэсээ ядуу хүмүүст тарааж өгнө гэлээ.

Түүнийг сонсч байсан гэр бүлийнхэн хэчнээн их баярласан гээч... Цасан цагаан, Сарнай улаан хоёр инээлдэн дуу дуулж, бяцхан ишиг, тагтаа хоёр дэвхцэн, цагны азарган тахиа баярлан хашгирсаар хоолой нь сөөсөн гээд бод доо та нар.

Залуу Хан хүү Цасан цагаантай гэрлэсэн бөгөөд хан хүүгийн ах мөн тэнд амьдрахаар ирээд Сарнай улааныг эхнэрээ болгож, бүгд он удаан жил аз жаргалтай сайхан амьдарсан бүлгээ.

Тэдний цэцэрлэгт сарнайн бут урьдын адил урган, цагаан ба улаан цэцэгс дэлгэрсээр байгаа гэнэ билээ.

Харин өнөөх санаа муутай одой одоо хүртэл хамхуул болоод л салхинд хийсээд бөмбөрч яваа гэсэн шүү. Та нар дайралдвал модоор нэг хатгаад хашраагаад авахад гэмгүй л байх.



Баавгай ба ширэнгэ ойн хаан хоёрын тухай үлгэр

Байгаль дэлхий баясан мишээсэн тавдугаар сарын нэгэн өглөө хөвчийн хүрэн баавгай нойрноосоо сэрэн ичээнээс гарч зөгийн бал олж идэхээр ой дундуур бэдэрч явжээ.

Тэгж яваад нүшэн модны дэргэд чонотой тааралдаж гэнэ. Тэр хоёр эрт цагийн андууд байсан учраас зам нийлэн, залуу нарсны сайхан үнэрээр амьсгалсан шиг цааш алхжээ.

Тэр хоёрыг ийнхүү ой дундуур явж байтал шувууд шувуудаас чанга дуутай нэг шувуу жиргэж байх юм гэнэ.

-Хүүе чоно найз аа! Ингэж чанга дуугардаг чинь одоо ямар шувуу байна аа? хэмээн баавгай асуулаа.

-Аа энэ үү? Бялзуухай л байна. Ширэнгэ ойн хаан гэдэг юм даа хэмээн чоно хариуллаа.

Баавгай урт хар хумсаараа хамраа маажаснаа, чоно найз аа! Би тэгвэл энэ бялзуухайн ордонг үзмээр байна. Би ерөөсөө хааны ордонг хараагүй юм гэж гуйлаа.

-За яахав. Тэгье л дээ. Гэхдээ ширэнгэ ойн хаан гэртээ эргэж ирэхийг нь хүлээж байгаад ордон нь хаана байгааг мэдэх хэрэгтэй дээ хэмээн чоно хэллээ.

Тэр хоёр ингэж ярилцаад нэгэн модны ард нуугдан сууж байтал хошуундаа дүүрэн чийгийн улаан өт зуусан ээж бялзуухай нисч ирлээ.

-Энэ бол ширэнгэ ойн хатан хаан гэж чоно хэлэв.

Удсангүй бас нэгэн бялзуухай бас л өт зуусаар нисч ирлээ.

-Нөгөө ширэнгэ ойн хаан чинь энэ дээ хэмээн чоно ярихад, баавгай ордонг

нь үзэхээр ухасхийлээ. Тэгтэл чоно түүний сүүднээс хурц шүдээрээ хазан зогсоож, ярах хэрэггүй баавгай найз минь! Хаан, хатан хоёрыг явсны дараа больё хэмээв.

Баавгайг тэсч ядан хүлээж байх зуур хаан, хатан хоёр бялзуухай авчирсан өтнүүдээ үүрэндээ орхиод дахин хоол төхөөрөхөөр нисэн одоцгоов.

-За одоо л хааны ордонг харна даа гэж баавгай хэлэв. Тэгээд сүүдээ чонын амнаас угзран аваад мод өөд авиран данхар том толгойгоо навчис, өргөс дундуур шургуулан байж харвал нэг жижигхэн үүрэнд зургаан бяцхан ангаахай байж байх нь тэр.

-Үгүй ер өө. Энэ хааны ордон байхдаа яахав дээ. Би энэ үүрийг хамрын дор байсан ч олж харахааргүй өчүүхэн юм байна гэж баавгай уулга алдлаа.

Тэр том толгойгоо сэжин инээд алдаж, улаанаар эргэлдсэн нүдээр мөнөөх ангаахайнуудыг хараад, энэ өчүүхэн амьтад хааны хүүхдүүд гэж үү? Та нар чинь яг л эсгийнний өөдөс шиг амьтад байна шүү дээ гэлээ.

Ангайхайнууд гэтэл сүрхий хор шартай амьтад байжээ. Тэд нар өрөвлөгтэй шар хүзүүгээ гүрднийлгэн хэрүүл хийж гарлаа.

-Бид тийм амьтад биш ээ. Бид нар сайн шувууд. Аав ээж минь ч нэртэй төртэй амьтад. Чи биднийг ингэж хэлсэндээ харамсах болно доо, баавгай. Аавыг иртэл байж бай. Бид нар чиний яаж доромжилсныг хэлиэ дээ. Аав бол ширэнгэ ойн хаан шүү хэмээн тэд ам өрсөн шагшралдав.

Баавгай, чоно хоёр үүнийг сонсоод ихэд айж зугтан үүр, ичээндээ шургацгаасан бөгөөд нөгөө ангаахайнууд үүрэн дээрээ гаран уурсан хашгиралдаж байв.

Эцэг бялзуухай, эх бялзуухайн хамт баахан хоол олж эргэн иртэл хүүхдүүд нь идэхгүй байлаа. Бүр хамгийн амттай эрвээхийний авгалдайд ч ам хүрэхгүй байсан гээд бод.

-Бид хоол идэхийг хүсэхгүй байна. Баавгай бид нарыг эсгийнний өөдөс гэж хэлснийхээ төлөө уучлал гуйхгүй юм бол өлсөж үхнэ хэмээн тэд бархиралдлаа.

Аав бялзуухай сүүдээ шарван, өд сөдөө сэгсэрч, эрвээхийн авгалдайг өөрөө залгиж орхиод,

-Тайвширцаа! хүүхдүүд минь. Би тэр баавгайг заавал уучлалт гуйлгана хэмээн амлав.

Тэгээд шууд ниссээр баавгайн ичээн дээр очлоо. Тэр ичээний хонхыг даран баавгайг дуудлаа.

-За муу хөгшин ясан толгойт минь! Чи хүүхдүүдийг минь доромжилсон байна. Би чамайг энд байгааг мэдэж байна шүү. Гарч ирж уучлал гуй гэж Ширэнгэ ойн хаан хашгирлаа.

Гэвч баавгай ичээнийхээ мухарт улам шигдэн гарч ирсэнгүй.

Үүнд нь дургүйцсэн бялзуухай далавчаа дэвэн байж,

-За яахав, тэгвэл би чиний эсрэг цуст дайн зарлалаа гэгчхэд нисэн одов.

Ийнхүү баавгайн эсрэг цуст дайн зарласан тул мань баавгай хорвоогийн бүх дөрвөн хөлт найз нараа дуудан цуглуулж дайнд бэлдлээ. Шар үхэр, морь, буга, чоно, нохой, муур гээд л дөрвөн хөлт амьтад бүгд ирлээ.

Бялзуухай ч гэсэн агаараар нисдэг бүгдийг ирүүллээ. Тэнд зөвхөн шувууд төдийгүй нисдэг шавьжууд ч цугларлаа. Зөгий, ялаа, шумуул, дэлэнч хүртэл иржээ.

Тэгээд Ширэнгэ ойн хаан хамгийн жижигхэн бөгөөд зальтайгаар нь шумуулыг тагнуулд явууллаа. Тэнд хамаг дөрвөн хөлтнүүд байх бөгөөд данхар эвэрт буга ба үхэр, хурц шар соёот чоно, тэр бүү хэл хурц хумст муур хүртэл байж байв. Шумуул царсны навчин доор нуугдан сууж харвал баавгай хоёр хөл дээрээ босон суугаад юм ярьж байв.

-Бүх амьтан миний ах дүү нар билээ хэмээн баавгай хүнгэнээд,

-Бид нар хүчирхэг армитай боловч тулалдаанд удирдах жанжин хэрэгтэй байна. Үнэг хаа байна? гэж асуулаа.

Үнэг олны дундаас сугаран гарч ирэв.

-Үнэг минь! Чи хамгийн аргатай амьтан тул жанжин болж биднийгээ удирдана уу хэмээн баавгай санал болгоход бусад амьтад ч нэгэн дуугаар зөвшөөрснөө илэрхийлэн мөөрөлдөж, хуцаж, улж, мяулж байлаа.

-За сайн байна. Бид дайнд ямар тугтай орох вэ үнэг ээ? гэж баавгай асуулаа.

Үнэг хөлөө маажсанаа зальт нүдээрээ бусдыгаа ширтэж

-Ерөөсөө ингэе та минь. Би улаан өдөн баглаа шиг урт сайхан сүүлтэй болохоор тулалдаанд орохоороо сүүлээ өргөө хэмээгээд урт сүүлээ өндөрт өргөн харуулав. Тэгснээ,

-Миний сүүл ийм өндөрт байгаад байвал бид ялж байна гэж бодоорой. Харин би сүүлээ буулгаад хоёр хөлийн завсар хавчуулбал ялагдлаа гэж бодоод та нар зугтах хэрэгтэй шүү. Тэгэхгүй бол шувуунуудад алуулж мэднэ шүү гэж яриу.

Үнэгний энэ яриаг бүх амьтан бас шумуул ч ойлгосон бөгөөд шумуул буцан ниссээр энэ тухай бялзуухайд ирж дуулгав. Бялзуухай түүнд талархал илэрхийлээд салааны даргаар томиллоо.

Маргааш өглөө нь мандахын улаан нарнаар илжигний чангаар орилон дохио өгөх чимээнээр бүх амьтад илжигхэн хөдөллөө. Тэдний энэ чимээ асар сүртэй байсан бөгөөд газар хөдлөн, далай тэнгисийн ус цалгиж байсан гээд бод доо.

Жигүүртнүүд ч гэсэн азарган тахианы хашгирах дохиогоор хөдөлж бялзуухай армиа дагуулан нислээ. Тэд нар жиргэж, донгодож, гагалж,

гуагалж, исгэрч, жигүүрээ дэлдэж байсан тул тэнгэр доргиж, үүлс сарниж байв.

Бялзуухай ухаалаг амьтан учраас бөхөгнө зөгийг дуудан ирүүлээд тушаал буулгалаа.

-Зөгий минь! Чи нисч очоод үнэгний сүүлэн дор бөгснөөс нь нэг сайн хатгаад ав. Тэгвэл үнэг сүүлээ буулган амьтад ялагдлаа гэж бодоод тарж зугтаана хэмээн тэр хэллээ.

Зөгий маш түргэн нисч үнэгийг олж очоод сүүлнийх нь доод талд бөгснөөс нь хатгалаа. Үнэгэнд хэдий хэцүү байсан ч нэг хөлөөрөө догонцон сүүлээ өргөсөөр амьтдаа дагуулан урагшилж байв.

Зөгий дахин хатгахад үнэг өвдсөндөө ярвайн нулимс нь гоожсон ч тэссээр, сүүлээ өргөсөөр урагш давшив.

-За яхав. Тэгвэл одоо ёстой үзүүлээд өгье.

Зөгий хурц хэлээ хурцлан байж ингэж хэлээд үнэгийг сүүлчийн удаа хамаг чадлаараа шунган дайрч хатгалаа.

Энэ хатгалт час халуун зүү шаасан мэт байсан тул үнэг энэ удаа үнэхээр тэвчсэнгүй. Тэр өвдсөндөө нулимсаа гоожуулан ёлоод сүүлээ буулган хоёр хөлийнхөө завсар хавчлаа.

Үнэгний сүүл ийнхүү буухыг харсан амьтад ялагдлаа гэж ойлгоод үүр, ичээ, хашаа саравч, уул тал гээд хаана амьдардаг вэ, тэр газар болгон уруугаа хөл мэдэн зугтаж одох нь тэр.

Үүнийг харсан жигүүртнүүд цуст дайнд ялсан баяраа тэмдэглэн шулганан баяслаа.

Ялалтандаа сэтгэл ханасан бялзуухай эхнэрийн хамт чийгийн улаан хорхой зуусаар үүрэндээ эргэн ирчгээлээ. Аав бялзуухай ангахайнуудаа бардмаар харж,

-Бяцхан хүүхдүүд минь. Өт идэцгээ. Яагаад гэвэл бид нар дөрвөн хөлт амьтдын эсрэг цуст дайнд ялалт байгууллаа хэмээн омог бардам өгүүллээ.

Гэвч бяцхан бялзуухайнууд хоол идэхээс урьдын адил татгалзан үүрний мухарт шигдэн нүдээ аныггаалаа.

-Баавгай энд ирж биднийг сайн шувууд. Жинхэнэ хааны гүнж, ханхүү нар гэж хэлэхээс нааш хоол идэхгүй хэмээн тэд орилолдоо.

-Тийм ээ. Тэд нарын маань зөв. Чи дахиж яваад баавгайг энд ирүүлж уучлал гуйлга гэж эхнэр бялзуухай нь хэлэв.

Эцэг бялзуухай ниссээр баавгайн ичээнд очин хонх дарлаа.

-Хөгшин чалчигч минь! Гараад ир гэж тэр дуудлаа.

Хөөрхий баавгай айн чичирсээр ичээнээсээ цухуйхад бялзуухай чихэн дээр нь очиж суугаад,

-Чи миний ордонд одоохон очиж хүүхдүүдээс минь уучлал гуй. Эс тэгвэл

би цэргээ хөдөлгөн чамайг үхтэл чинь тоншуулж орхино шүү хэмээн омоглоо. Тэгснээ хэлсэн үгээ батлан баавгайн чихийг нэг сайн тоншоод авав.

Баавгай энэ удаа аргагүй зөвшөөрч, бялзуухайн үүрэнд толгой унжуулан явж очоод уучлалт гуйлаа. Түүний дараа залуу бялзуухайнууд баясан дуу орж, шар шувуунаас бусад нь унтчихаад байхад ч шөнө дөлөөр идэж уусаар байв.

Гуньж гутарсан баавгай ч толгойгоо ганзагалан ичээндээ буцаж очоод шургав.

Гэхдээ л Бялзуухайны ангаахайнууд яг л эсгийнний өөдөс шиг хариугүй амьтад хэмээн баавгай одоо хүртэл дотроо бодсоор байгаа гэнэлээ шүү.



Ядуу тариачны хүү ба муур гүнж

Эхнэр ч үгүй, хүүхэд ч үгүй гон бие нэгэн хөгшин тээрэмчин байжээ. Тэр хүн нэг сайхан усан тээрэмтэй бас Карл, Жоан, Ханс гэдэг гурван шавьтай юм санжээ!

Тэднээс Карл, Жоан хоёр нь өөрсдийгөө их ухаантай гэж боддог байсан бол Ханс нь тэр тухай боддог ч үгүй агаад сайхан сэтгэлтэй хөвгүүн ажгуу. Тээрэмчин тариагаа хулганаас хамгаалахын тулд тээрмийнхээ байранд гурван муур байлгадаг байсан бөгөөд Ханс тэдэнд их л дотно хандан шөнө бүр өөрийнхөө сүүт тэдэнд өгдөг байжээ.

Тэгж байтал нэгэн орой бүгдээр хоолоо идэж суугаад хөгшин тээрэмчин хэлж гэнэ.

-Би ямар мөнх амьдрах биш дээ. Тэгээд ч надад өөрийн гэсэн эхнэр, хүүхэд байхгүй тул би тээрмээ та гурвын хэн нэгэнд гэрээслэн үлдээх гэсэн юм. Гэвч хэнд чинь гэдгээ шийдэж чадахгүй байна гэж тэр ярилаа.

Тийм ээ. Үнэхээр хэцүү шийдвэр байна гэж гурван шавь нь дор бүрдээ бодлоо.

За хүүхдүүд минь. Та гурав гурвуулаа л сайн шавь байсан. Тийм болохоор тээрмээ хэнд чинь үлдээхээ шийдэхийн тулд би нэг болзол тавьж байна. Сайн сонсогдоо! хэмээв.

Мэдээж гурван шавь ихэд хичээнгүйлэн сонслоо. Их хичээснээс тэдний чих нь дэлдгэнэн хөдөлж байсан гэнэ ээ бүр.

-Би та нарыг гадагш нь явууллаа. Та нар надад морь авчирч өгцгөө. Хамгийн сайхан морь олж ирсэнд чинь би тээрмээ өгнө. Болж байна уу? хэмээн тээрэмчин хэллээ.

Энэ санал Карлд маш их таалагдав. Учир нь тэр өөрийгөө хамгаас ухаантай

гэж боддог тул хамгийн сайн морийг олж чадна гэдэгтээ итгэлтэй байв.

Уг санал Жоанд ч сайхан санагдав. Тэр өөрийгөө хамгийн ухаалгт тооцдог тул хамгийн сайн морийг ядах юмгүй олоод ирчихнэ гэж бодож л дээ.

Харин Ханс чимээгүйхэн инээмсэглээд өөрт ноогдсон загаснаасаа муурнуудад өгч суув.

Маргааш өглөө нь шавь нар тээрэмчинд баяртай гэж хэлээд их замд гарч одлоо. Өдөр нь тэд явсаар нэгэн тосгоны зочид буудалд ирж талх, бяслаг идэхээр дотогш оров. Хооллосны дараа Карл Хансад хандан,

-За бид нар ингээд гадагшаа гарлаа. Чи бараг энд үлдээд аяга таваг угааж өл залгуулсан нь дээр биз дээ. Чам шиг усан тэнэг хүн насаараа яваад ч морь олохгүй дээ гэж гэнэ.

Гэвч Ханс юу ч болоогүй мэт инээмсэглэн тэнд байсан муурын зулзагыг тэжээсэн шиг байв гэнэ.

Карл Жоан хоёр буудлаас гаран тосгоны гудамжаар өнгөрч ойн зах уруу орлоо. Тэр хоёрыг эргэж харах бүрд Ханс инээмсэглэсэн чигээрээ дагасаар яваа харагдаж байв.

Тэднийг ойгоос гарч амжаагүй байтал шөнө болж унтах газар хэрэгтэй болов. Гэтэл өнөөх ухаантай биш гэгддэг Ханс нэгэн хуурай ганга олж гэнэ.

Энэ л тохиромжтой газар байна гэж өгүүлдээд унтахаар хэвтлээ. Нөгөө хоёр нь ч мөн хэвтсэн боловч худлаа унтсан дүр үзүүлэн хэвтэж байв.

Төд удалгүй Карл Жоаныхаа хажуугаас нударан,

Хөөе явъя. Наад Ханс чинь үргэлж араас дагаад юу л хийнэ гөлрөөд хэцүү юм. Одоо наадахыг чинь орхиод сэм явцгаая гэж хэлэв гэнэ.

Жоан ч үүнтэй санал нэгдсэнээр хоёр хөвгүүн сар гийсэн хөндий уруудан явахдаа “Ёстой ухаантай хэрэг хийж байна даа” хэмээн баясалдаж явав. Гэвч ингэснийхээ хариуг авах л байх даа.

Шөнө өнгөрөн өглөө болж шувууд жиргэж эхлэхэд Ханс сэрлээ. Сэрээд тэр нүдэндээ ч итгэсэнгүй босон харайлаа. Учир нь тэрбээр маш өндөр хананы дунд хэвтэж байх агаад тэнгэр тэртээ дээр л харагдах ажээ.

-Би хаана байна? Хүн байна уу? Юу болчихов оо? Хансыг ийн хашгирвал түүний хэлсэн үгний цуурай л сонсогдох нь тэр.

Ханс хэдий айсан ч гэлээ өөрийгөө зоригжуулан дээшээ авирч гарахаар шийдлээ. Хэрэв энд байгаад байвал өлбөрч үхэх байх. Тэгж байснаас авираад үзье хэмээн тэр шийджээ.

Тийнхүү Ханс дээш авирч гарлаа. Тэгэхдээ ийн авирах нь, ямар хэцүү байсан яана. Тэр лав хоёр ч удаа хөл халтиран доошоо нисч үхэх шахав. Гэвч тэр авиран авирсаар хананы дээд ирмэгт хүрээд хамгийн эцсийн хүчээ шавхан байж биеэ татан дээш гарвал битүү балар ой өмнөөс нь угтах нь тэр.

-За хөөрхий. Би энэ харанхуй ойд төөрчихсөн болохоор нөгөө сайхан морь

олно гэдэг худал боллоо. Амьд үлдвэл их юм боллоо хэмээн Ханс боджээ.

Гэвч суусан цэцнээс явсан тэнэг гэдэг болохоор Ханс хүү цааш алхлаа. Хэсэг яваад нэгэн нарийхан жим олон ямар нэгэн айлд очих магад хэмээн дагаж алхлаа. Гэвч нөгөө зөрөг зам айл уруу чиглэсэнгүй, харин ч ойн гүн үрүү хөтөлсөөр сүүлдээ бүр шигүү балар хөвчид орж явчих нь тэр. Иймд Ханс ихэд айн сүрдлээ.

-Энэ ч ёстой нэг харанхуй ширэнгэ байна даа. Хэрэв унтах газар олохгүй бол энүүгээр дүүрэн байгаа чононд идүүлэх юм байна хэмээн тэр өөрөө өөртэйгөө ярих.

Тэр цааш яаран эхлээд алхаж, дараа нь шогшиж, бүр гүйсээр явсан ч эцэстээ ядран амьсгаадаж жаал амрахаар шийдэв. Тэрээр унасан мод сандайлан суугаад нүдээ анин амсхийлээ. Тэгээд нүдээ нээвэл өмнө нь нэгэн муур савраараа нүүрээ угаан суух нь үзэгдлээ.

Муур ногоон нүдээ эргэлдүүлэн байснаа Хансыг илбэчин мэт ширтлээ. Тэгснээ амаа ангайлгахад ягаан хэл, арзгар шүд нь харгагдаж байв.

-Ханс! Чи энд юу хийж яваа юм? хэмээн муур асуулаа. Ханс гайхсандаа эг маг хийн хөшиж орхив. Ярьдаг муур! Ханс өмнө нь ийм юм үзээгүй, дуулаагүй байв.

-Муур минь! Чи надад тус болж чадахгүй биз дээ хэмээн Ханс хэллээ.

Муур ногоон нүдээрээ түүнийг ширтэн байснаа,

-Ханс! Би чамайг сайхан сэтгэлтэй гэдгийг мэднэ. Бас чухам юу хүсээд байгааг чинь ч мэднэ. Чи манайд очиж долоон жил миний зарц хийвэл би чамд дэлхийд байхгүй хосгүй сайн морь олж өгье. Хамгийн баян хаанд ч тийм хүлэг байхгүй гэж мэд гэж муур ярих.

За яахав. Энэ муур ярьж чаддаг болохоор лав энэ их ойн эзэн савдаг биз. Тэгээд ч мууртай хамт явахгүй бол чононд бариулах юм байна гэж Ханс бодлоо. Ханс ийн бясалгаад,

-За за муур аа. Би зөвшөөрч байна гэлээ. Муур сүүлээ гозойлгон зөрөг замаар орон шогшиход Ханс ч даган алхсаар гэрт нь хүрлээ.

-Ханс! Чи энд долоон жил алба хаана даа гэж муур хэллээ.

Муур гурван зулзагатай агаад нэг нь цагаан, нөгөөх нь бор гурав дахь нь улбар шар зүстэй ажээ. Хоолны ширээн дээр сүү болон хулганы махаар хийсэн хиам тавьсан байв. Ханс хиамнаас татгалзаад сүү, талхыг дуртайяа идэж орхив.

Тэднийг ийнхүү хоолож байхад нөгөө гурван зулзага концерт тоглож эхлэв. Нэг нь морин хийл бархируулан нөгөөх нь хийл чахруулж, улбар шар зүст нь бөмбөр нүдэн чихний хэнгэрэг хагалах дөхлөө. Тэднийг концертоо дуусгахад муур Ханстай бүжиглэхийг хүслээ.

-Үгүй, үгүй хэмээн Ханс татгалзаад би хэзээ ч мууртай бүжиглэж байгаагүй

хэмээн учирлалаа.

-За тэгвэл одоо яая гэхэв хэмээн муур хэлээд агаарт дэгдэн эргэж өөрөө өөртэйгээ бүжилжэж гарлаа.

Хансыг унтах болоход зулзаганууд түүнд туслан нэг нь гуталнаас нь чангааж, хоёр дахь нь ор засан, гурав дахь нь гэрэл унтрааж өгөв. Өглөө нь тэд дахин ирж нүүрийг нь угаан сүүлээрээ арчиж өгөөд гутлынх нь үдээсийг үдэж өгөв.

Өглөөний цайны дараа муур Ханст хандан, түлээ бэлдэн цэцэрлэгийг арчлах ёстойг хэлээд энэ нь долоон жилийн турш хийх ёстой ажил гэдгийг сануулав. Муурын байшингийн бүх тавилга ба багаж хэрэгслүүд алт мөнгө агаад Ханс хоол унд сайтай байв. Хэдийгээр муур, хулганы махтай хиаманд дуртай ч тэрийг ид хэмээн хэзээ ч Хансад албадаагүй ажгуу. Энэ бүх хугацаанд Ханс ганц ч хүний бараа хараагүй бөлгөө.

Он цаг нүд ирмэх мэт хурдан өнгөрч Ханс нэг өдөр мууранд хандлаа.

-Эрхэм муур авхай минь! Би долоон жилийн турш танд үнэнчээр зүтгэж, хэлсэн болгоныг чинь хийсээр ирлээ гэж Ханс хэлжээ.

-Тийм ээ, чи сайн үнэнч зарц байлаа. Гэхдээ чи зургаан жил л болж байна, Ханс аа. Одоо дахиад нэг жил ажиллах хэрэгтэй. Харин энэ хооронд хулгана элбэгтэй голын хөвөөнд надад нэг зуны сууц барьж өг хэмээн муур хариулав.

Ханс голын хөвөөнд хулгана элбэгтэй нугын захад сайхан байшин барьж дуусгаад мууранд очиж хэлсэн үүргийг нь ёсчлон биелүүлснээ илтгэлээ. Муур ч байшинг очиж үзэхээр болов гэнэ.

-Маш сайн байна, Ханс аа хэмээн муур хүржигнээд, үнэхээр сайхан байшин болжээ. Чи бүтэн долоон жил надад үнэнчээр зүтгэлээ. Би одоо хэлсэн үгэндээ хүрнэ. Чи одоо энэ хорвоо дээр надаас өөр хэний ч олж үзээгүйг харах болно гэж муур хэлэв.

Муур урт сүүлээ гурвантаа шарваж, ногоон нүдээ гурвантаа анивчаад, одоо миний байшинг онгойлгоод орхи гэлээ.

Ханс байшингийн хаалгыг онгойлговол дотор нь арван гурван сайхан морьд байж байх нь тэр. Тэдгээр морьдын арьс нь хүрэл мэт үзэгдэх агаад шүд нь мөнгөрөн, нүд нь алтран гялалзах нь хараад хараад ханашгүй гоо үзэсгэлэнтэй байв.

- Энэ бол дэлхийн хамгийн сайхан морьд. Чи долоон жил надад үнэнчээр ажилласан ба зулзган муурнуудыг байнга халамжилж байсан учраас эднээс нэгийг нь авч болно гэж муур хэлээ.

Гэхдээ би морийг чинь гурван өдрийн дараа дөхүүлж өгөх болно хэмээн муур өгүүлээд сүүлээ шарвалзуулангуут Ханс нам унтаж орхив.

Тэгээд сэртэл анх нөгөө хоёр ухаант шавьтай хоноглосон гангандаа хэвтэж байх нь тэр.

“За байз би зүүдэлсэн юм болов уу” хэмээн Ханс бодсон ч хувцас нь уранхай цоорхой байхыг үзээд тийм биш юм байна гэж эргэлзлээ. Учир нь өнгөрсөн долоон жилд муур түүнд ямар ч хувцас өгөөгүй тул ийн салбайсан юм санж.

Тийм болохоор, “За байз, ямар ч гэсэн гэртээ дөхөж ирсэн юм байна. Карл, Жоан хоёр морьд авчирсан даа. Хэнийх нь илүү бол” гэж Ханс бодлоо.

Ханс буцан уул хөндийг өгссөөр мөнөөх зочид буудалтай тосгонд ирэхэд сүү худалдаж авч уулгаж байсан тэр нэг муурын зулзага түүнийг танин мяулж байв.

Удсан ч үгүй Ханс явсаар тээрэм дээрээ ирэхэд тээрэм нь урьдын адил эргэлдэн, гурван муур нь түүнийг таниад гүйлдэн ирж сүүлээ шарван хөлийг нь ороон самардаж, эрхэлж байв гэнэ.

Карл Жоан хоёр ч морьд аваад ирчихсэн байв. Гэхдээ нэг их сайн морьд биш байв. Учир нь Карлын морь сохор харин Жоаны морь доголлон аж.

Тэр хоёр Хансын гар хоосон ирэхийг хараад,

-Өө муу усан тэнэг ээ, тэнэг хэвээрээ л байх шив дээ гэж хашгиралдлаа. Харин Ханс юу ч хэлсэнгүй дуугайхан инээмсэглэж байлаа.

-Миний морь гурав хоногийн дараа ирнэ. Тэр бол дэлхийн хамгийн сайхан морь байх болно хэмээн Хансыг хэлэхэд нөгөө хоёр нь инээд алдлаа.

-Чамайг морь авчрах юм бол муур хүний хэлээр ярих байлгүй хэмээн тэд шоолоход Ханс үл хайхран доош сууж муурнуудыг эрхлүүлж байв.

Гурван хөвгүүн хоол идэхээр ширээний ард суухад хөгшин тээрэмчин Хансад хандан, хэрэв хэн нэгэн хүн ирэх юм бол чиний наад уранхай хувцас намайг шившиглэх юм байна. Тиймээс эндээс гар хэмээн хэллээ.

Ханс аргагүйн эрхэнд гадаа морьдын жүчээнд хооллосон төдийгүй нөгөө хоёр нь унтлагын өрөөнд оруулаагүй учраас тахианы байранд хонов.

Ийм маягаар гурав хоног өнгөрч, дөрөв дэх өдрийн өглөө болоход муурнууд хөөрөлдөн гүйлдэж, сүүлээ шарван дэвхцэж эхлэх нь тэр.

Тэд нар маш их догдолсон болохоор өглөөнийхөө сүүг ч уусангүй гэнэ.

Хөгшин тээрэмчин Жоан, Карл гурав юу болоод байгааг үзэхээр гарч ирвэл арван хоёр морь хөллөсөн сүйх тэрэг байж байх нь тэр. Сүйх тэрэг нь шижир алт, цалин цагаан мөнгөөр бүтээгдсэн үнэхээрийн гоёмсог эд байсныг хэлэх үү. Тэгсэн морьдын хөтөч нь улбар шар үст хүү байх агаад сүйх тэргэнд заларч яваа гүнж нь мөнөөх Карлын долоон жил ажлыг нь хийсэн тэр муур байх ажээ.

Гүнж хөгшин тээрэмчинд хандан,

-Ханс гэдэг хөвгүүн хаана байна? гэж асуулаа. Чихэндээ итгэж ядсан тээрэмчин хариуд нь,

-Ханс гэнэ ээ? Тан шиг ийм сайхан гүнж Ханстай уулзах гэж үү? хэмээн лавлав.

Гүнж үүнд нь ундууцан, та чинь дүлий юм уу? Ханс, Хансыг дуудаад орхи

гэхэд,

Тэр тахианы байранд байгаа хэмээн цаадах нь түгдчив.

-Яагаад үнэнч Ханс минь тахианы байранд байж байдаг билээ?

-Уранхай ноорхой хувцастай болохоороо л тэр.

-Хурдан Хансыг авчир.

Гүнжийн зарц Хансыг тахианы байрнаас олж ирээд голд оруулан угааж сайхан хувцас өмсүүлбэл яг л ханхүү мэт гоёмсог харагдаж байв. Дараа нь гүнжийг шаардсанаар Карл Жоан хоёрын авчирсан морьдыг хөтөлж ирэв. Гүнж тэдгээр морьдыг хараад инээд алдаж, наадуул чинь морьд биш эвдэрч хэмхэрсэн илжигнүүд байна гэв.

Гүнж сүйх тэрэгний хамгийн эхэнд хөллөсөн морийг зарцаараа урагш хөтлөн гаргаж хөгшин тээрэмчинд үзүүлэхэд, тэр морийг урьд хожид үзэгдэж дуудлаагүй дэлхийн хамгийн сайхан хүлэг мөн хэмээн тэрээр зөвшөөрлөө.

Ийнхүү сайхан морь харсан хөгшин тээрэмчин өөрийнхөө тээрмийг Хансад өвлүүлэх болно гэдгээ хэлбэл гүнж дахин инээд алдаад,

-Зүгээр зүгээр. Ханс арай илүү юмтай болно гэж хэлжээ.

Тэр Хансыг нөгөө өөрийнх нь барьсан байшинд авчраад илбийн хүчээр өөрчлөн алт, мөнгө, хүрэл дүүрэн орд харш болгон хувиргалаа.

Дараа нь гүнж Ханс хоёр гэрлэн хуримаа хийхдээ нөгөө буудлын зулган муур, тээрэмчний гурван муур тэргүүтнийг ч урихаа мартсангүй. Тэд нар нь ч Хансын харшны хажуугийн нугад ирж аз жаргалтай амьдрах болсон билээ.

Хулганууд энэ үлгэрт дургүй байдаг боловч харин бүх муур дуртай байдаг билээ. Хэрэв та нар хоёр гурван муур гал тойрон сууж, нүдээ анивчин байхыг үзвэл тэд лав тээрэмчний шавь ядуу хавгүүн ба муур гүнжийн тухай хууч хөөрч байгаа байх шүү.



Бүхнийг мэдэгч эмч

Наймаалж хэмээх нэртэй нэгэн эр амьдран суудаг байлаа. Уг нь тэр тариачин боловч үржил шимгүй алгын чинээхэн газартай тул ургац ч авсан юм байхгүй, турж үхэх шахан амь зогоодог байж.

Наймаалж нэгэн бороотой өдөр ойд очин мод огтлоод түүнээ хоёр шаранд хөлдсөн тэргэнд ачиж аваад ойролцоох тосгонд очиж зарахаар явлаа.

Тэр тосгоны шавар шавхай болсон гудамжаар өдөржингөө өөдөө соөргөө холхин, “Түлээ аваарай, түлээ аваарай! Сайхан түлээ хямдхан зарж байна шүү” хэмээн хашгирсан ч хэн ч түүнийг сонирхсонгүй.

Тийн байсаар бараг орой болж байхад тосгоны эмч мод авах болж гэнэ. Хэдий тэр эмч хоёрхон тэвэр түлээ авсан нь чамлалтай ч өргүйгээс охинтой хэмээн Наймаалж боджээ.

Наймаалж түлээгээ эмчийн хашаанд буулгаад мөнгөө авахаар гэр лүү нь дөхөж очтол цонхоор нь оройн хоол зассан ширээ нь харагдаж байв гэнэ. Тэнд шарсан үхрийн мах, төмсний нухаш, цөцгий, лонх дарс гээд элдвийн сайхан амттан цасан цагаан бүтээлэгтэй ширээн дээр өрөөстэй байх нь үзэгдэв гэнэ.

-Бурхан минь хэмээн Наймаалж дуу алдаад,

-Би өнөө оройн хоолондоо ганц аяга сармагийн шөл л ууна даа гэж өөрөө өөртэйгээ ярив.

Эмчийг цонхондоо дөхөж ирэхэд нь ямар сайхан хувцастайг нь Наймаалж харав гэнэ. Эмч сайхан цэмбэн пальто эгэлдрэглэн, зөөлхөн савхин гутал өшиглөсөн байжээ. “Би нэг муу таар өмсөөд явж байдаг гэж Наймаалж бодсоноо би ер нь эмч болоод ингэж амьдарч болдоггүй юм байх даа гэж саналаа.

Эмч гарч ирэн хоёр зоос өгөхөд Наймаалж хамраа нухлан,

-Уучлаарай эмч ээ. Би ер нь эмч болж чадах болов уу? хэмээн асуулаа.

Эмч бороон дор зогсоо уранхай ноорхой тариачныг хараад,
-За бас нэг солиотой амьтан байна гэж бодлоо. Гэвч Наймаалжийг цаашлуулмаар санагджээ.

-Тэгэлгүй яхав. Чи эмч болж чадна, чадна. Их амархан л даа. Эхлээд чи цагаан толгойн ном худалдаж ав. Манай тосгонд байгаа. Тэгээд дараа нь наад тэргээ хоёр шартайгаа зараад тэр мөнгөөрөө сайхан хувцас худалдаж авах хэрэгтэй. Урт цагаан нөмрөг, чагнуур хоёр худалдаж авахаа мартав. Тэгээд “ Би бол бүхнийг мэдэгч эмч” гэсэн хаяг гэрийнхээ үүдэнд нааж орхи хэмээн эмч хэлжээ.

Эмч ийн хэлээд цонхоо хааж хооллохоор суухдаа Наймаалжийн тухай санан, инээд нь хүрч байв.

Харин мань Наймаалж яг эмчийн хэлсэн ёсоор бүгдийг хийсэн агаад ер нь ч бараг эмч болохоо шахав. Учир нь жинхэнэ эмчид төлөх мөнгөгүй ядуус түүн дээр очдог боллоо.

“Бүхнийг мэдэгч эмч” буюу Наймаалж тэднийг хүлээн аваад урт цагаан нөмрөгөө нөмрөн чагнуураараа чагнах боловч ёстой юу ч мэдэхгүй байв. Бас тэр мөнөөх цагаан толгойгоо дэмий харах боловч бичиг үсэгт тайлагдаагүй тул ганц ч үг гаргахгүй байв. Тэгж тэгж, мань эмч тэдэнд жаахан буцалсан ус уулгах бөгөөд нөгөөдүүл нь ч Наймаалж эелдэг зантай, маш бага төлбөр авдаг тул түүнд талархаад явж одох бүлгээ.

Тэгсэн тэр улсын нөгөө хязгаарт маш баян чинээлэг нэгэн гүн амьдардаг байж гэнэ. Гэтэл гүнгийн маш их мөнгө хулгайд алдагдсан тул цагдаагийнхан түргэн авч, хайгаад хайгаад уг мөнгийг ч хулгайчийг нь ч олсонгүй ажээ. Гүн тэгэхээр нь хувийн мөрдөгчид хөлсөлсөн боловч мөн л бүтэлтэй юм болсонгүйд ихэд цухалдах болжээ.

Гэтэл нэгэн өдөр зарц нь түүнд бүхнийг мэдэгч эмчийн тухай дуулгаж дээ.
-Бүхнийг мэдэгч эмч гэнэ ээ? Гэртээ хэзээ байдаг хүн бэ тэр? хэмээн гүнг асуухад зарц нь:

Тэр бүхнийг мэддэг хүн гэж хариуллаа.

-Тэгвэл түүнийг одоохон олж ир. Ирээд хулгайч хэн болохыг хэлж өгөг гэж гүн зарлиг буулгалаа.

Зарц тэр дороо морь тэрэг хөллөн довтолгосоор Наймаалжийнд очин гүнгийн хүсэлтийг дуулгалаа.

-За яхав. Би очиж болох юм. Гэхдээ би эхнэр Гретатайгаа л очих болно хэмээн Бүхнийг мэдэгч эмч өгүүллээ.

Зарц ч дээрх болзлыг зөвшөөрөн эр эм хоёрыг гүнгийн ордонд авчирлаа. Тэр хоёрыг ирээд хоолонд оруулах болов. Нэгэн зарц шөл барьсаар орж ирэхэд Бүхнийг мэдэгч эхнэрийнхээ хажуугаас нудран

-За тэр, нэгдэх нь энэ дээ гэж хэлэв.

Уг нь Бүхнийг мэдэгч эмч маань нэгдүгээр хоол л гэсэн ухаантай юм байж. Гэтэл нөгөө хоол зөөгч зарц өөрийгөө мэдчихлээ гэж боджээ. Тэр бол үнэхээр эхний хулгайч байсан хэрэг.

Мань зарц гал зууханд гүйж орон бусдадаа,

-Ай яа, одоо яана аа? Бүхнийг мэдэгч эмч намайг хараад чи бол нэгдүгээр хулгайч байна гэж яг хэлж байна хэмээн орь дуу тавилаа.

Хоёр дахь зарц маш их айсан тул хоол зөөхөөс зугтаасан ч гүн хонх цохин дуудсан тул аргагүйн эрхэнд тавагтай загас барьсаар зоогийн өрөөнд явж орлоо. Түүнийг явж ороход Бүхнийг мэдэгч бас л эхнэрээ нудран,

-Энэ бол хоёр дахь нь байна хэмээв. Тэгэхдээ хоёрдугаар хоол л гэсэн санаа илэрхийлжээ. Тэгсэн тэр зарц яг хоёр дахь хулгайч байж таарч, өөрийгөө илчлэгдэв хэмээн сүнс нь зайлах шахав. Гурав дахь зарцыг орж ирэхэд бас л дээрх явдал давтагдав. Тэр зарц ч бас хулгайч байсан хэрэг.

Харин дөрөв дэх зарц орж ирэхдээ хоолоо бүтээсэн байв.

-За энэ эмч манайд ирээд хоолыг минь идээд эхнэрээ хажуугаас нь ёвчоод л суугаад байх юм. Туршиж үздэг хэрэг хэмээн гүн шийдлээ.

Гүн урагш тонгойн Бүхнийг мэдэгч эмчид хандаж,

-За хө, чи бүгдийг мэддэг хүн гэсэн. Тэгвэл энэ тавганд юу байгааг мэдээд орхи гэлээ.

Бүхнийг мэдэгч бүтээлгэн дор юу байгааг тааж ч чадахгүй байв. Тэр өөрийгөө хаашдаа баригдлаа гэж бодоод ташуурдуулна гэж санахаас хөлс нь цутгаж ирэв. Мань эр ийнхүү бодон урсах хөлсөө алчуураар арчин байж, хөөрхий муу Наймаалжны үйл нь ирээд үхэх цаг нь болж дээ гэлээ.

Гүн тавагны бүтээлгийг автал дор нь шарсан наймаалж байх нь тэр.

-Гайхалтай. Үнэхээр гайхалтай хэмээн гүн бахдан хашгираад, энэ хүн бол ёстой Бүхнийг мэдэгч байна. Миний мөнгийг хэн хулгайлсаныг ч мэдэж байгаа юм байна хэмээн чангаар өгүүлэв.

Тэгтэл дөрөв дэх зарц хоолойгоо засан Наймаалжийг гал зуух уруу сэм дохив. Наймаалж түүнийг даган гал зуух уруу очиход гурван хулгайч зарц орь дуу тавин нүглээ нанамчилж, хулгайлсан мөнгөө хаа байгааг зааж өгье гэцгээв.

-Тэр мөнгө хоолны өрөөний зуухны ард байгаа. Гэхдээ та биднийг гүнд битгий хэлээрэй. Биднийг дүүжилж орхино гэж тэд сөгдөн гуйлаа.

-За яахав би та нарыг дүүжлүүлэхийг бодохгүй байна. Дахиад та нар хулгай хийсэн байв даа.

Бүхнийг мэдэгч ийн хэлээд буцаж хоолны өрөөнд орлоо.

-Гүнтэн! Одоо мөнгө чинь хаана байгааг хэлж өгье гэж тэр хэлээд цагаан толгойн номоо амч уншсан дүр эсгэлээ. Тэр номноос азарган тахианы зураг олоод гүнд харуулж, хэлсэн үгээ улам үнэмшилтэй болгоё гэж тэр шийдсэн

байж.

Гэтэл нөгөө азарган тахианы зураг олддоггүй гэнэ шүү. Тэгэхээр нь Бүхнийг мэдэгч аргаа барахдаа,

-Би хаана байгааг чинь мэднэ шүү! хэмээн чангаар хэллээ. Тэгэхдээ нөгөө азарган тахианы зургийг хэлсэн хэрэг. Гэтэл юу болсон гэж санана.

Наймаалжийг дахин нэг сорихоор зуухны ард нуусан байсан тав дахь зарц үсрэн гарч ирээд,

-Бүхнийг мэдэгч эмч үнэхээр л бүхнийг мэддэг юм байна гэж уулга алдлаа.

Үүний дараа Бүхнийг мэдэгч гүнд мөнгө байгаа газрыг зааж өгсөн бөгөөд харин хэн хулгайлсан байсныг хэлсэнгүй.

Маш их баярласан гүн түүнд их шагнал өгсөн ба нөгөө хулгайч зарц нар ч бас мөнгө өгсөн байна.

Ингээд ихээхэн мөнгөтэй болсон Бүхнийг мэдэгч эмч эхнэрийн хамт гэртээ харьж аз жаргалтай, элбэг хангалуун амьдарсан юм гэдэг.



Нойрсогч гоо охин

Эрт урьд цагт хаан хатан хоёр ханилан суудаг байжээ. Тэр хоёр дутагдах гачигдах зүйлгүй амар тайван амьдардаг байсан ч ганцхан үр хүүхэдгүй байсан тул үртэй болохыг мөрөөдөн байдаг байж гэнэ. Тэгж тэгж, тэртээ олон жил өнгөрсний хойно хатан нь нуурын усанд орж байтал нэгэн мэлхий уснаас үсрэн гарч ирээд, таны хүсэл биелж жил бололгүй охинтой болох юм байна хэмээн том нүдээ эргэлдүүлэн хэлж гэнэ ээ.

Үнэхээр ч мэлхийн хэлсэн ёсоор хатантан зул сарын баяраар хачин хөөрхөн охинтой болж, хаан эцэг нь ч магнай тэнийн хавь орчныг донсолгосон нижтэр найр наадам хийжээ. Найрандаа садан төрөл, найз нөхөд, танил талаа уриад зогсохгүй охиныхоо ашдын аз заяаг болож үзмэрч эхнэрүүдийг ч басхүү урьжээ.

Тэр улсад арван гурван үзмэрч эхнэр байдаг агаад тэд нар там болоод диваажингийн хамаг нууцыг мэддэг, араатан, жигүүртнийг захирдаг арга шидтэй улс ажээ. Гэвч тэдэнд хоол хийж барих хааны алтан тавагны тоо арван хоёрхон байсан тул аргагүй нэг үзмэрчийг нь урилгүй орхисон ажээ.

Дуутай, бүжигтэй, дуурьтай, балеттай, галын наадамтай урьд хожид болоогүй хөлтэй найр өндөрлөхөд хүмүүс бяцхан охинд бэлгээ өгч эхэлжээ. Үзмэрч эхнэрүүд ч өлгийннийх нь дэргэд зогсон шидэт бэлгээ гардуулжээ.

Нэг нь сайхан сэтгэл, нөгөөх нь гоо үзэсгэлэн, гурав дахь нь эд баялаг гээд л хорвоогийн хүн болгоны хүсэл мөрөөдлийг бэлэглэж дээ. Арван нэгэн үзмэрч эхнэр бэлгээ өгөөд байтал гэнэт аймшигт дуу чимээ гаран ордны хаалга цонхоор Хойд мөсөн далайгаас үлээсэн гэмээр хүйтэн салхи сэвэлзэн, хүн бүхэн дааран дагжиж байхуй, мөнөөх найранд уригдаагүй арван гурав дахь үзмэрч эхнэр гэнэт үзэгдэх нь тэр.

Түүний ясан цагаан царай зэвхийрэн, хоёр нүд нь оюу мэт ногоорон байснаа, урьдлаггүй юм бол өөрөө ирж чадаж байгаа биз дээ. Энэ гүнж чинь арван таван насандаа ээрүүлийн голд сүлбүүлж үхнэ дээ хэмээн өгүүлдэг ирсэн шигээ гэнэт алга болов гэнэ.

Бэлгээ хараахан өгч амжаагүй байсан арван хоёр дахь үзмэрч эмэгтэй босч ирээд энэхүү айхтар хараалыг хариулж дийлэхгүй, харин сааруулж л чадна. Тийм болохоор гай тохиолдвол гүнж үхэхгүй боловч зуун жил унтах болно хэмээн айлдсан ажээ.

Түүний дараа хаан охиноо золгүй явдалд өртүүлэхгүй гэж эзэнт улсынхаа бүх ээрүүлүүдийг шатаан устгах тушаал гаргажээ.

Үзмэрч эхнэрүүдийн хайрласан бэлэг эзэндээ сайхан тогтож гүнж үзэсгэлэн гоо, цэцэн билэгт, эелдэг сайхан, харсан хүний хайрыг булаасан охин болон өсч торнижээ.

Яг түүнийг арван таван нас хүрдэг өдөр хаан хатан хоёр эзгүй, охин ганцаархнаа шилтгээнд үлдсэн байжээ. Тэрээр шилтгээн дундуур баахан зугаалаад, эцэст нь эртний нэгэн цамхгийн дэргэд очин, давчуу нарийн шатаар өгсөн явбал нэгэн жижигхэн хаалганд тулжээ. Хаалганд буй зэвтэй түлхүүрийг эргүүлбэл хаалга онгойлоо. Дотор нь нэгэн эмгэн сууж ээрүүл барин утас ээрэн завгүй суух аж. Эмгэн туйлын өндөр настай, харалган хүн байх бөгөөд эрт балрын цаг хугацаа босч ирээд сууж байна уу гэлтэй санагдахаар ажээ.

-Эмээ сайн байна уу? Юу хийж байгаа юм бэ? хэмээн охин асуулаа.

-Утас ээрч байна аа.

- Тийм үү. Ямар сонин юм бэ? Та яах гэж утас ээрч байгаа юм бэ?

- Хөнжил нэхэж байна аа охин минь.

-Яасан сонин эргэлддэг юм бэ?

Охин ийн хэлээд ээрэх санаатай ээрүүлийг авбал шившлэг тарнийн хүчээр охины гар цоо хатгадлаа. Гүнж эгшин зуур гүн нойронд автан тэнд байсан орон дээр хэвтээд нам унтлаа. Гүнжийг ийнхүү унтангуут хаан хатан хоёр тэдний бүх албат нам унтлаа. Бас тагтаанууд үүрэндээ, үхэрнүүд хашаандаа унтаж эмээлтэй морьд, гинжтэй ноход хүртэл гүн нойронд автав.

Зарц хүүгийн үсийг самнаж байсан тогооч хүүхэн ч тэр, зарц хөвгүүн ч тэр ялгаагүй нойрондоо автлаа. Хогон дээр шавж байсан ялаанууд нүдээ анин, нутаг сүрэлжж явсан зөгийд нойрсон тэр бүү хэл гал дүрэлзэхээ байж зөвхөн ув улаан цог л сүүмэлзэх болов. Салхи ч гэсэн зүүрмэглэсэнээс модны навчис ч унагаах тэнхэлгүй болсон байлаа. Хаант улсын бүх цаг зогсон, зүү нь гацаж орхилоо.

Тэр цагаас хойш сар жил улиран одсоор зөвхөн ордны хажуугийн сарнай цэцэг л урган ургасаар байлаа. Тэрхүү цэцэг ургасаар байгаад хааны ордон, тэр бүү хэл хамгийн өндөр цамхаг хүртэл цэцгэн дунд умбан алга болж, юу ч

харагдахгүй боллоо.

Хэдий ордон болоод хаант улс зүүдний мэт уусан сураггүй болсон ч гэлээ ийм явдал болсон тухай чимээ шуугиан бүх дэлхийгээр тархсан байлаа.

Олон сайхан хан хөвгүүд нойрсочг гоо охины тухай дуулаад, түүнийг олохоор замд гарцгаасан ч битүү цэцгэн саадыг давж чадахгүй л байлаа.

Ширэнгэн ойд өргөст нохойн хошуу биесээ ороон шигүү ургасан тул тэдгээр хан хүү нарыг өргөсөндөө дэгээдэн ороож гарцгүй болгон үхүүлдэг ажээ. Тэдгээр хөөрхий хөвгүүдийн араг яс хэзээ хойно өвлийн бүүдгэр наран дор гялалзан харагдааг ажгуу.

Олон олон жил өнгөрсний хойно нэгэн хан хүү тэр хавийн нэгэн цайны газарт цайлж суугаад энүүхэн ойрхонд нь ширэнгэн ой байдаг тэр ойд хааны ордон байдаг бас тэнд нэгэн гоо сайхан гүнж мөнх нойрсож буй тухай домгийг сонсчээ.

-Юу гэнэ ээ? Ширэнгэ бол ширэнгэ. Би түүнийг туулж гараад гүнжийг сэрээх л болно хэмээн мөнөөх хан хүү ам гарлаа.

Үүнийг сонссон настай хөгшин:

-Үгүй, үгүй хэмээн уулга алдаад, олон олон хөвгүүн тэр ширэнгэнд хүлэгдэн амь насаа алдсан гэж өвөг аав ээж минь ярьж байсан. Чи тэдэн шиг болохыг хүсээ юу? Хүү минь, чи аав ээжийгээ бод. Тэд чинь чиний араас уй гашууд автаасай гэж чи хүсэхгүй биз дээ гэлээ.

Гэвч халуун цустай залуу хүү өвгөнд талархал илэрхийлээд маргааш өдөр нь ширэнгэн ойг зорин хөдөллөө.

Илдээ сугалан авч өргөст моддыг цавчиж гарлаа. Өргөст модод ч хариу шавхуурдан байснаас орой хэрд хөвгүүний хамаг нүүр царай нь шархдан цус болсон байв. Ойин гүнд амь насаа алдсан урьдын талийгаачдын араг яс цайран үзэгдэх боловч хөвгүүн шантарсангүй урагшилсаар байлаа. Тэр шөнөжин явсаар өглөө болохын хэрд ширэнгэн ойн өргөс нь зөөлөрч, шигүү нь багасч иржээ.

Тийнхүү явсаар тэрээр мөн өдрийнхөө орой наран баруун зүгт шингэн жаргахын алдад хааны ордонд хүрч очив.

Тэр нүүрнийхээ цусыг арчин эргэн тойрноо ажиглахуй, гинжтэй ноход, эмээлтэй морьд болон үхрүүд унтаж байхыг үзэв. Бас тагтаанууд хошуугаа далавчин дороо нуун нойрсоч, ялаанууд ч ялгаагүй нойрсоч байхыг харлаа. Тогооч эмэгтэй зарц хүүгийн үсийг бариастай чигээрээ байх бөгөөд ув улаанаар туяаран царцсан гал дээр хав хар тахианы мах дүүжлэгдсэн хэвээр байх ажээ.

Хан хүү ордны их танхимд очвол хаан хатан хоёр болон ордны бусад бүх албат баримал хөшөө мэт унтацгаах бөгөөд нэгэн албат хаандаа мөргөсөн чигээрээ хөшин нойрсон харагдав.

Хан хүү ордныг тойрон, чимээгүй явсаар хамгийн сүүлд дээврийн хэсэгт

байх эртний цамхаг уруу явж очлоо. Тэнд гадагш гарсан хонгил байх агаад тэр хонгилд хулгана, аалз хэвтэн нойрсож буй нь харагдав. Гэтэл цонх ч үгүй, чийдэн ч үгүй мөртлөө дотроо гэрэлтэй нэгэн хачин өрөө цаана нь харагдах нь тэр.

Тийш явж орвол тэртээ дээр нэгэн цагт мөнөөх настай эмгэний нэхэж байсан хөнжлийг нөмөрсөн гоо охин хэвтэж байсан нь нойрсогч гоо бүсгүй чухам л мөн байлаа.

Хан хүү нойрсогч гүнжийн хөнжлийг хуулан нүүрийг нь харлаа.

-Хөөе, гүнжхэн минь хэмээн тэр шивгэнээд,

-Хэрэв чи сэргэж босох юм бол би чамтай гэрлэнэ шүү хэмээгээд хацар дээр нь үнслээ. Ийнхүү үнсэх мөчид хаа нэгтээ цаг цохих нь дуулдахад "Яасан хачин юм бэ" хэмээн хан хүү бодлоо. Ийнхүү цаг цохих чимээнээр гүнжийн аньсага чичирхийлснээ уруул нь хөдөллөө. Цагийн дохио үргэлжлэн дуугарсаар ес дэх удаагаа цохиход аниргүй унтаа байдал алга боллоо.

Гүнж болон түүнтэй хамт бүх албат сэрлээ. Хулгана нүх үрүүгээ гүйж, аалзнууд шүлсэн тороо нэхэж гарлаа. Ноход хуцан сүүлээ шарваж морьд янцгааж, тагтаанууд тэнгэрт нисэлдэн, ялаанууд дүнгэнэлдэж эхэллээ. Тогооч хүүхэн зарц хөвгүүнд үүрэг даалгавар өгч, гал дүрэлзэн, ширэнгэн ой урьдын адил сарнай цэцгийн төгөл болон хувирлаа.

Хан хүү гүнжийг эртний цамхагас гарган дагуулсаар их танхимд очвол хаан хатан хоёр сэргихсэн эвшээлгэн суниацагаж байх бөгөөд хан хүүг явж ормогц "Төрсөн өдрийн мэнд хүргэе!" хэмээн чанга дуугаар хашгиралдлаа. Энэ өдөр бол үнэхээр шинээр мэндэлсэн, төрсөн өдөр байлаа.

Нойрсогч гоо бүсгүйд ийм л явдал тохиолдсон юм даа. Тэр гүнж 21 нас хүрээд Хан хүүтэйгээ гэрлэн, хожим нь хатан болж жаргалтай амьдарч үр хүүхэдтэй болсон билээ.

Урьдын нойрсогч гоо бүсгүй, одоогийн тэр хатан хаан их сайхан найрсаг, зочломттой хүн юм гэдэг шүү.



Бремений хөгжимчид

Бар гэдэг амьтан цоохор болоогүй байсан балар эртийн цагт Герман оронд нэгэн илжиг эзэндээ зүтгэж байжээ. Илжиг олон жил зүтгэсээр эцэстээ тэнхээ тамир нь дордоод, эзэн нь өөрийг нь нэг л гунигтай хардаг болоод байхаар нь “За хөөрхий, эзэн надаар тогоо тослох нь. Ерөөс оргож одье” хэмээн шийдэж гэнэ дээ.

Тэгээд хашаагаа зад дайран гараад цаашид яахаа бодон хээр нэг хоноод, ер нь Бремен хотод очиж хөгжимчин болдог хэрэг гэж шийдээд зам шулууджээ. Тэр үед Бремен хот хөгжимчдөөрөө цуутай байсан ажээ.

За тэгээд мань илжиг зам даган гэлдэрч явтал хэлээ унжуулан аахилсан нэгэн нохой хэвтэж байна гэнэ.

-Хав хав минь. Юу болоов хэмээн илжгийг асуухад. Хав хав:

-Би өтөлж хөгшрөөд буга гүйцэхээ больсон тул эзэн маань алах гээд зугтаад явж байна. Цаашид яаж хоолоо олж идэх билээ хэмээн хариу зовлон тоочжээ.

-Би Бремен үрүү явж байна. Тэнд очоод хөгжимчин болно. Надтай хамт явж бас хөгжимчин бол. Би бөмбөр дэлдье, харин чи пийпаа дар хэмээн илжиг санал болголоо.

Нохой үүнийг нь зөвшөөрөн цааш хамт явлаа. Удаа ч үгүй царайд нь гуниг зовлон хуралдсан нэгэн муур, замын хажууд суухыг тэр хоёр үзэв.

-Сахалт минь, юу болоов хэмээн илжиг шалгаалаа.

-Аминд минь аюул учраад байхад надад юуных нь сайхан байхав дээ. Нас өндөр болоод хулгана гүйцэхээ байж пийшин бараадахаас өөрцгүй боллоо гээд,

-Эзэгтэй маань усанд живүүлж алах гээд арайхнийг зугтааж гарлаа. Цаашид яаж хоолоо залгуулна даа хэмээн муур гасаллаа.

-Зүгээр зүгээр, энэ нохой бид гурав яг адилхан юм байна. Гурвуулаа Бремен орж хөгжимчин болцгооё. Чи шөнө дуугарахдаа мундаг юм чинь яг болно хэмээн илжиг хэллээ.

Мөнөөх муур уг саналыг баяртайгаар шүүрэн авч,

-Гялайлаа хэмээн өгүүлдэд нүүрээ угааж аваад тэр хоёрыг дагалаа.

Ийнхүү нутаг уснаасаа дайжсан зовлон нэгт гурав цааш жаал явж байгаад нэг хашааны дэргэдүүр өнгөрөхдөө хаалган дээр суун хашгирагч азарган тахиаг олж үзэв.

-Чи яагаад ингэж хашгираад байгаа юм бэ? хэмээн илжиг асуулаа.

-Маргааш ням гаригт манайд зочин ирэхээр миний толгойг тасалж шөл хийж дайлах гэнэ. Хатуу сэтгэлт эзэн минь ингэж шийдсэн байна. Тэгээд би сүүлдний удаа хашгирч байгаа минь энэ хэмээн тахиа очлоо.

-Улаан залаат минь, тэгж ярихгүй. Бидэнтэй хамт Бремен орж хөгжимчин бол. Сайхан дуулдаг тул чи яг тохирно хэмээн илжиг найр тавилаа.

Азарган тахиа энэ саналыг зөвшөөрөн хамтарлаа. Тэр дөрөв өдөртөө Бремен орж амжсангүй тул ойд хоноглох болжээ. Илжиг нохой хоёр модон дор хэвтэж, муур тахиа хоёр мөчирт авиран гарч, харин тахиа хамгийн тайван газар болох модны оройд нисэн гарч тухаллаа. Азарган тахиа унтахынхаа өмнө ийш тийш харснаа тэртээд галын очис гялазахыг хараад,

Хүүе нөхөд өө! тэнд очис үсрээд байна. Лав байшин байгаа даг аа хэмээлээ.

-Тэгвэл босч тэнд очиж хоноё. Энд тохь тух ч алга хэмээн илжиг дуугарлаа. "Тэнд сайхан шүүстэй ясны хэлтэрхий ч байж мэднэ хэмээн нохой бодсон бол муур аяга сүүний тухай, харин тахиа тариа будаа, илжиг хэдэн лууван идэхсэн хэмээн дор дороо мөрөөдлөө.

Тэгээд мөнөөх газар луу явцгаалаа. Төд удалгүй гэрэл тодорсоор тэр хэд хурц гэрэлтэй дээрэмчдийн байшингийн дэргэд хүрч очигцоолоо. Илжиг хамгийн өндрөөрөө цонхны дэргэд очин дотогш шагайж харахад,

-За саарал минь, юу харагдана? хэмээн азарган тахиа адгалаа.

-Надад юу харагдаж байна гэж үү? Дээрэмчид сайхан зассан ширээ тойрч суугаад идэж уухыг ч үзүүлж байна даа.

-Бидэнд хувь хүртдэг ч болоосой доо хэмээн азарган тахиа санааширлаа.

Тэгээд тэр дөрөв дээрэмчдийг хэрхэн зайлуулах тухай удтал зөвлөлдөөд нэгэн арга сүвэгчиллээ. Илжиг цонхны тавцан дээр хөлөө тавиад нуруун дээрээ нохойг гаргалаа. Харин муур нохойны дээр зогсон хамгийн дээр азарган тахиа үсрэн гараад цөмөөрөө нэгэн зэрэг хөгжимдөхөөр тохирцгоолоо.

-За муусайн дээрэмчид! Бремений хөгжимчдийн яадгийг үз хэмээн азарган тахиа хашгирлаа. Тэгээд орчин тойрныг түйвэйтэл дуу гаргаж эхэллээ. Илжиг орлон, нохой хуцаж, муур мяулан, тахиа донгодсон хэрэг. Тэгээд мань дөрвөн

амьтан цонхоор үсрэн ороод чухам л тамын ноход л ийм байдаг болов уу гэмээр аймшигтайга хяхтнан орилолдож гарлаа. Дээрэмчид тэднийг чөтгөр шулам хэмээн бодож байшингаасаа ум хумгүй арилж одлоо. Нөгөө хэд ч санаа амран, хамаг юмыг нь шавайгаа ханатал идэж ууж аваад унтахаар хэвтэцгээлээ.

Илжиг өвсөн бухлын оройд, муур пийшингийн бүлээн үнсэн дээр хэвтсэн бол нохой хаалганы ард, харин азарган тахиа хонуур дээр тухаллаа.

Энэ үеэр шөнө дунд болж сүмийн цаг дохилоо. Мөнөөх зугтсан дээрэмчид ойд цуглаад толгойлогч нь нөгөөдүүлдээ хандан,

-За та минь, бидний ингэснийг дуулбал бусад дээрэмчид охин хүүхдүүд гэж шоолно шүү. Одоо нэг нь явж тэнд хэн байгааг мэдээд ир хэмээн хэлээд нэгэн хамгийн унхиагүй дээрэмчнийг байшин уруу илгээлээ.

Мөнөөх дээрэмчин байшинд ороод анир чимээгүй байсан тул санаа амран харанхуйд цог мэт гялалзах муурын нүдийг хараад гараа явуулбал цаадах нь нүүр лүү нь үсрэн ноцож самардлаа. Дээрэмчин үнхэлцээ хагартал айн, ухаан жолоогүй зугтсаар арын хаалгаар гүйн гарахад нь тэнд хэвтэж байсан нохой ухасхийн хөлийг нь хазлаа. Дээрэмчин цааш гүйсээр өвсөн бухлын дэргэдүүр өнгөрөхдөө илжгэнд нэг сайн тангаруулж авлаа. Энэ шуугианаар сэрсэн азарган тахиа муухай орилон сүрийг үзүүлсэн төдийгүй дээрэмчний толгой дээр шунган бууж чихнийг нь лавтайга арваад удаа тоншиж орхилоо.

Хөөрхий дээрэмчин хөлийн хурдаар гүйсээр толгойлогчдоо очин,

-Ай яа яа, байшин дотор аймшигтай эм шулам өөдөөс үлээн урт хумсаараа нүүр амыг минь урж, үүдэнд нэгэн этгээд хөл үрүү минь хутга шааж, хашаан дотор хэвтэж байсан нэг аймшигт амьтан бороохойгоор балбаснаар барахгүй дээвэр дээр сууж байсан шүүгч "Хүүе, тэр хулгайчийг бариад аваарай" гэж хашгирлаа. Би арай гэж амь голтой зугтаж гарч ирлээ хэмээн орь дуу тавилаа.

Энэ яриаг сонссон дээрэмчид ум хумгүй сүүдээ хавчин арилж, бараа сураггүй болсон агаад харин мөнөөх амьтад тэр байшиндаа сэтгэл амар амьдран суух болжээ. Тэд нар хэзээ ч Бремен рүү явж, хөгжимчин болоогүй гэдэг. Бремен хот ч гэсэн тийм хөгжимчдөөр яхав дээ.

Энэ үлгэрийг надад дөнгөж эргүүдхэн нэг хүн ярьж өгсөн юм шүү.



Зургаан хун

Алсын нутгийн нэгэн хаан ан гөрөө хийж яваад аглаг их ойд замаа алдан төөрчээ. Тэгж яваад үдэш болохын хэрд нэгэн эмгэгтэй дайралдаад түүнээс зам зааж өгөхийг хүсчээ.

Эмгэн хааны ордон хүрэх замыг мэднэ гэвч хэрэв хаан охинтой нь гэрлэх аваас тэрхүү замыг зааж өгнө хэмээн болзол тулгажээ. Харин тийн гэрлэхгүй бол балар ойд тэр чигтээ үлдэх болно гэдгийг ч хаанд дуулгаж дээ.

Балар их хөвчөөс ганцаар хэзээ ч гарч чадахгүйгээ ойлгосон хаан аргагүйн эрхэнд зөвшөөрлөө.

-Сайн байна. Та гэхдээ харамсахгүй дээ. Миний охин залуухан бас гоо үзэсгэлэнтэй бүсгүй шүү гэж эмгэн хэллээ.

Тэр ойн гүн үрүү шурган орж алга болсноо удалгүй охиноо дагуулан буцаж ирэв. Охин нь эмгэний хэлсэнчлэн үнэхээр залуухан, царайлаг боловч хаанд нэг л зэвүүн санагджээ. Учир нь охины хар нүдэнд нэгэн сонин оч гялбалзан улаан уруулд нь жигтэй инээмсэглэл зүрхнийхийг хаан ажиглаж л дээ.

Гэвч Хаан аргагүйн эрхэнд эмгэнээр зам заалган ордондоо очсоныхоо дараагаар эргэн ирж охиныг нь аваачин хурим хийснээр тэр бүсгүй Хатан хаан болов.

Харин Хаан өмнө нь гэрлэж байсан агаад зургаан хүү, нэг охинтой юм санжээ. Гэхдээ Хатан хааны хачин харц, жигтэй инээмсэглэлийг бодоод хүүхдүүдэд минь хор хүргэж магадгүй хэмээн болгоомжилсон тул хүүхдүүдийнхээ тухай шинэ хатандаа хэлсэнгүй, харин ч тэднийгээ ойн гүнд байх цайзад аваачаад нууж орхижээ. Тэр цайзад нь зөвхөн хаан л очиж чаддаг байв.

Гэхдээ бас учиртай. Хаанд талтай нэгэн илбэчин эмэгтэй түүнд нэгэн ноосон бөмбөлөг өгсөн аж. Хэрэв тэр бөмбөлгийг газарт шидвэл урагш бөмбөрөн явж

хүүхдүүдийн байгаа цайзад хүрэх замыг заадаг учиртай юм санжээ. Түүнээс биш тэр бөмбөлөггүй бол Хаан өөрөө ч цайзад очиж чахлаагүй байв.

Хаан хүүхдүүддээ маш их хайртай байсан тул түүнээс хойш бараг өдөр болгон цайз руу явах болов.

Хаан ийнхүү ордондоо төдийлөн байхгүй байгаад Хатан хаан дурамжхан байлаа. Тэр Хааныг үргэлж ан хийж явдаг гэдэгт итгэхгүй байсан учраас хэд хэдэн удаа Хааныг сэм дагасан ч замдаа төөрөн буцаж иржээ. Хатан хаан ийн дагах бүрд нүдэнд нь мөнөөх зэвүүн очис гялалзан, жигтэй нинээмсэглэл уруулд нь зүрххийх бүлгээ.

Хааны итгэлт түшмэдийн нэг нь урвагч байхыг Хатан хаан олж мэдээд түүнд мөнгө атгуулан Хаан яагаад байнга ой руу явдгийг асуулаа.

-Яагаад гэвэл хаан хүүхдүүдээ ойд нуучхаад тэднийгээ байнга эргэдэг юм гэж мөнөөх түшмэл хэлжээ.

-Хүүхэд ий? Хаан хүүхдүүдтэй гэж үү? Хатан хаан ийн хэлэхэд сайхан царай нь гэнэт зэвхийрэн хөгширч эмгэн шулмын үрчгэр нүүр үзэгдэх шиг боллоо.

-Тийм тийм хэмээн мөнөөх урвагч түшмэл хэлээд нэг аяга дарс залгилан амаа гараараа шударсанаа,

-Та надад алт өгвөл тэдний тухай хэлж өгье гэж гэнэ.

Хатан хаан түүнд хүүдий алт өгвөл тэрээр, мөнөөх ид шидтэй бөмбөлгийн тухай ярьжээ.

-Тэр бөмбөлөгийг аваад өг. Би чамд юу хүссэнийг чинь өгөмз гэж Хатан Хаан шавдуулснаар урвагч түшмэл бөмбөлгийг хулгайлан авчирч өгчээ.

Хатан Хаан тэр шөнөдөө долоон жижигхэн цамц оён, түүнийгээ шидэт тарниар шившлээ. Хаан анх уулзахдаа зөнгөөрөө мэдэрсэнчлэн тэр эмэгтэй бол гоо үзэсгэлэнтэй хэдий ч хүйтэн сэтгэлтэй, чулуун зүрхтэй хүн байсан юм байжээ.

Маргааш өглөө хааныг анд явсан хойгуур Хатан хаан нөгөө бөмбөлөгийг газарт хаясанд ойн гүн рүү хөтөлсөөр хүүхдүүдийн байгаа цайзад аваачжээ. Түүнийг цайзад дөхөж очиход зургаан хөвгүүн хашаан дотор тоглож харин ганц эгч нь өрөөндөө ном уншиж суужээ. Хөвгүүд аавыгаа ирлээ хэмээн баярлалдан гүйж ирээд Хатан хаан байхыг үзээд буцан зугтаахыг оролдсон ч хэтэрхий хожимдсон байлаа. Хатан хаан тэдэн үрүү шидэт цамцнуудыг шидэхэд хааны хөвгүүд хун болон хувираад нисэч одох нь тэр.

Дагавар хүүхдүүдгүй болж, хаанд өөрөөс нь өөр хайрлах хүнгүй боллоо хэмээн Хатан хаан баясан нинээгээд буцаж явсаар ордондоо ирлээ. Гэхдээ тэр бяцхан охины тухай мэдээгүй ажээ.

Хаан маргааш нь цайз уруу очив. Тэрээр охиныхоо ярьсанд огтхон ч итгээгүй боловч дүү нар нь хун болон нисэхдээ тэнгэрээс унагаасан өднүүдийг хүртэл харуулсанд арай чамай итгэлээ.

Гэхдээ Хатан хаан тийм муухай зүйл хийсэн гэдэгт Хаан итгэхгүй байсан бөгөөд өөр хэн нэгэн илбэч эм ийм хэрэг хийж гэж бодсон учраас охиноо ордондоо аваачихаар шийдлээ.

Гэвч бяцхан гүнж дүү нарыгаа эргэж иртэл эндээ байж байя хэмээн нулимс асгаруулан гуйсан тул Хаан түүнийг ганц хоног цайзад үлдэхийг зөвшөөрлөө. Хаан ордон уруугаа буцахдаа охиноо дараагийн өдөр ирж авахаа амлаад юу ч болсон хаашаа ч гарч болохгүй гэж захилаа.

Бяцхан гүнж маргааш нь өдөржингөө дүү нараа харуулсан ч хэн ч эргэж ирээгүй тул орой нь балар хөвч ой уруу гарч явлаа. Тэр дүү нартаа туйлын хайртай байсан тул шөнөжингөө өдөржингөө тэднийхээ нэрийг дуудан харанхуй ойд явсаар байв. Гэвч бөглүү ойд баавгай архирах, чоно улихаас өөр чимээ алга л байлаа.

Тэгсээр хоёр дахь өдрийн орой гүнж дуугарч ч чадахгүй шахам болсон хойноо ойн бяцхан чөлөөнд нэгэн жижигхэн байшин байхыг олж очоод дотор нь явж орвол зургаан жижигхэн ор байх ажээ. Бяцхан гүнж орон дээр унтаж арай зүрхэлсэнгүй тул доогуур нь орж хэвтээд юу болдог бол гэж бодсоор нүдээ анилаа.

Өглөө наран мандахын өмнөхөн хашгирч гагалах хачин чимээ гарснаа тэртээгээс зургаан хун нисэн ирж газардах нь тэр. Тэдгээр хун бие биенийхээ өд сөдийг үлээцгээтэл тэр өд сөд нь гуужин унаж ах дүү зургаан ханхүүд хувилав.

Гүнж орон дороосоо үсрэн гарч ирэхэд дүү нар нь түүнийг тэврэн баярын нулимс урсгалаа. Гэвч тэд охиныг энд үлдэж болохгүй хэмээн шавдууллаа.

-Энэ бол дээрэмчдийн үүр. Тэд эргэж ирээд чамайг олбол алах болно гэж хэллээ.

-Гэхдээ та нар намайг хамгаална биз дээ гэж гүнжийн хэлэхэд, ах дүү нар нь нэгэн дуугаар, үгүй ээ эгч минь, бид арван тавхан минут л хүн байдаг юм. Тэгээд буцаад шувуу болдог юм даа гэгцээлээ.

Тэгээд би та нарт тусалж чадахгүй гэж үү гэж гүнж нулимс асгарууллаа.

-Тийм ээ. Гэхдээ энэ маш хэцүү учраас танд хэлэх хэрэггүй байх гэж дүү нар нь өгүүлэхэд хорвоогийн хамгийн хатууг ч давах болно хэмээн гүнж андгайллаа.

-За тэгвэл яахав. Танд юу хийхийг чинь хэлье. Энэ ойд одон цэцэг гэдэг маш жижигхэн нэгэн цэцэг бий. Түүгээр бидэнд зургаан цамц нэхэх хэрэгтэй. Тэгэхдээ тэр цэцэг маш жижигхэн учраас ийн нэхэхэд зургаан жил хэрэгтэй. Гэхдээ хамгийн хэцүү нь чи энэ хугацаанд чи нэг ч үг дуугарч болохгүй. Чи нэг л үг амнаасаа унагаах буюу ингэвэл бид нар үүрд мөнх хун хэвээрээ үлдэх болно хэмээн дүү нар нь түүнд ярилаа.

-Би бүхнийг хийнэ хэмээн гүнжийг харуулж дуусаагүй байтал дүү нар

нь дахиад л хун болон хувираад умар зүгт гаслантайгаар ганганасаар нисэн одлоо.

Бяцхан гүнж дээрэмчдийн байшингаас гарч гүйн ойг чиглэлээ. Тэр шөнөжингөө одон цэцэг түүгээд өглөө нь нэгэн модон дээр авиран гарч суугаад эхнийхээ цамцыг чимээгүйхэн нэхж эхлээ. Тэр шөнөжингөө цэцэг түүж түүнийгээ өдөржин нэхээр хэдэн сар ойд амьдарчээ. Энэ хугацаанд түүний амнаас нэг ч авиа гарсангүй билээ.

Хэсэг хугацааны дараа нэгэн анчны хамт тэр хавиар гөрөөлж яваад охиныг модон дээр юм нэхэн суухыг үзээд нэн их гайхсан нь мэдээж.

-Чи хэн бэ? Энд юу хийж байгаа юм бэ? хэмээн тэр асуулаа.

Охин анчныг явчихаж магадгүй хэмээн бодоод алтан зүүлтээ, дараа нь дээлээ, эцэст нь малгайгаа газарт шидсэн ч тус болсонгүй.

-Энэ бол хааны нутаг. Тийм болохоор чи хаанд л тайлангаа тавьж дээ хэмээн анчин толгой сэргэн хэлжээ.

Тэд нар гүжижийг модноос буулган хаандаа хүргэж өглөө. Хаан ийм хөөрхөн охин байсанд маш их гайхан, хаанаас ирсэн, хэн гэдгийг нь машид сонирхон шалгаасан ч нөгөөх нь ганц ч үг газар унагасангүй, чулуу шиг чимээгүй байв.

Хаанд охин маш их таалагдсан тул түүнийг ордондоо авчран гэрлэлээ. Энэ хугацаанд охин нэг ч үг дуугарахгүй л байжээ.

Харин түүнд хааны ээж маш дургүй байв.

-Хэн гээч нь хаанаас гараад ирэв ээ? Цэцэг түүж юм нэхж суугааг нь харахад энэ лав илбэч эм байж таарна. Нэг л муу муухай юмаа нуугаад байгаа хэрэг. Тэр ч Хатан хаан байх учиргүй амьтан даа гэж тэр эмгэн байнга янших бүлгээ.

Гэсэн хэдий ч Хаан тэрхүү этгээд сонин эхнэртээ их хайртай агаад тэд нар улмаар хөөрхөн хүүтэй болж, хаан хүүдээ ухаангүй хайртай байв. Гэвч хааны ээж туйлын хорон санаатай хүн байсан тул нэгэн шөнө хүүг өлгийнөөс нь хулгайлан авч түлээчинд өгчээ. Тэгээд тахиа алан цусыг нь хатан хааны аманд түрхээд түүнийг шулмас байсан тул өөрийн үр хүүхдээ идчихлээ гэж Хаан хүүдээ хэлж гэнэ.

Гэвч Хаан үүнд нь итгэсэнгүй.

-Үгүй. Тийм байх ёсгүй. Хэн нэгэн атаатан хүүг минь хулгайлчихаад л гэмийг нь хатанд минь тохох гэж байна хэмээн тэр хашгирчээ. Энэ хооронд Хатан хаан урьдын адил цэцэг цуглуулан цамцаа нэхэж, чив чимээгүй суусаар л байх ажээ.

Хэсэг хугацааны дараа Хатан хаан хөөрхөн охин төрүүлснийг нь хааны ээж бас л хулгайлан авч түлээчинд өгөөд, тахианы цусаар Хатан хааны амыг бялдан хүүхдээ өөрөө идчихлээ гэж гүтгэсэн ч Хаан бас л итгэсэнгүй. Хатан Хаан ч цамцаа нэхээр байсан ажгуу.

Тэгсээр Хатан хаан гуравдахь хүүхдээ гаргахад урьдын явдал гурав дахиа давтагдлаа. Хаан хатнаа дуудан ирүүлээд,

-Хайрт минь үгүй гэдэг ганц үг л хэлчих. Тэгвэл л чиний гэм буруугүйн бүрэн баталгаа болно хэмээн гуйлаа.

Гэвч гүнж ганц ч үг хэлэлгүй, цамцаа нэхсээр суусанд Хаан уурлан нударгаа зангидан цухалдлаа. Хатан хаан мөн л ганц үг хэлсэнгүй. Тийм болохоор түүнийг буруутай гэж тогтоогоод түүдэг гал дээр шатааж алах зарлиг гаргажээ.

Хатан хааныг могой, хилэнцэт хорхой дүүрэн нүхэн зооринд хорьсон агаад түүнийг шатаах өдөр нь цамцнуудаа нэхэж дуусах зургаан жилийн хамгийн сүүлчийн өдөр байж таарчээ. Хатан хаан тун шаргуу ажилласаар таван цамцаа болон болгоод зургаа дахийг нь хариугүй дуусгах гэж байв. Түүнийг зургаа дахь цамцныхаа үлдсэн ганц зүүн ханцуйг нь нэхэж эхэлтэл зоорины хаалга онгойж, нүүрэндээ баг өмссөн зандалчин орж ирэн хуруугаараа занган дуудлаа.

Хатан хаан цаазын талбай уруу ч цамцаа нэхсээр л явлаа. Хаан түүнээс,

-Гэм буруугүй гэдэг ганц үг хэлээч. Тэгвэл өршөөлөө хэмээн гуйлаа. Хатан хааны нүднээс нулимс асгаран байвч бас л ганц ч үг амнаасаа унагасангүй цамцаа нэхсээр л.

Зандалчин хүртэл түүнийг өрөвдөж байв. Гэвч тэр гүнжийг хураасан түлээн дээр гарган гал асаахаар чүдэнз зуртал юу болсон гэж санана.

Зургаан хүн гэнэт тэнгэрээс ганганасаар бууж ирэхэд Хатан хаан нэг гараа хүлэгнээ мултлан цамцнуудаа шидэхэд хунгууд дүү нар нь болон хувирлаа. Харин хамгийн отгон дүү нь дутуу нэхсэн цамц өмссөн тул зүүн гарынхаа оронд хунгийн мөнгөн жигүүртэй хоцорсон ажээ.

Улмаар дүү нар нь Хатан хааныг суллахад, тэр ч ярих боломжтой болов. Хатан хаан хүүхдүүдийг нь хааны ээж хулгайлсан тухай хэлэхэд хаан түлээчин үрүү хүн явуулж, хүүхдүүдээ авчруулахад тэд нь эрүүл саруул өсч бойжиж байжээ.

Харин хааны ээжийг нөгөөх түүдэг галд шатаан хороосон байна.

Ийнхүү нэг ч үгийн солиогүй анир чимээгүй зургаан жил өнгөрч Хатан хаан, Хаан, тэдний гурван хүүхэд, зургаан ах дүү нар хамтаараа олон жил эвтэй сайхан аж төрсөн билээ.



Хулгана Шувуу Зайдас гурвын үлгэр

Шувууд хаанаа сонгохын өмнөхөн болжмор хулгана зайдас гурав нөхөрлөн хамтдаа амьдрахаар шийдэж гэнэ.

Гэхдээ гурвуулаа гэрийнхээ ажлыг тэнцүүхэн хийдэг байж л дээ. Өглөөд болжмор ой уруу нисэн гал асаах зомгол цуглуулж, хулгана ус зөөж, харин зайдас хоол хийдэг байлаа. Тийнхүү тэд эвтэй сайхан амьдарч байв.

Нэгэн өглөө болжмор уран жиргээтэй тааралдаад ямар сайхан жаргалтай амьдарч буйгаа сайрхан ярьж гэнэ. Гэтэл цаадах нь атаархуу амьтан байж л дээ. Тэрээр хошуугаа хавшин, шар нүднийхээ булангаар болжморыг харж байснаа хэлэв гэнэ.

-Чи юунд тийм их баярлаад байгааг мэдэхгүй юм. Гэхдээ чи хамгийн муу ажлыг нь л хийж байгаа юм шиг надад санагдлаа. Хулгана гэхэд усанд явахад газар нь ойрхон тул дорхноо авчирчаад нүхэндээ ороод унтаад өгч байна. Харин Зайдас хоолоо тогоондоо хийгээд сайн хутгаж орхиод амарч хэвтэхээс өөр ажилгүй байна. Харин чи. Би чиний санааг нэг их зовоох гэсэн юм биш л дээ. Гэхдээ юу л даа. Юу гэвэл чи тэр хол ойгоос тийм хүнд зомгол авчирна гэдэг хэцүү л харагдах юм. Хошуу чинь мултраад уначихвал яана. Хулгана зайдас хоёр ч чамайг шоолж л суугаа даа. Бүх шувууд л миний ярьсныг ярьж байгаа шүү хэмээн уран жиргээ хөврүүлэв.

Тэгж хэлчихээд уран жиргээ нисэн одлоо.

Болжмор уран жиргээгийн хэлснийг бүхэл шөнөжин эргэж хөрвөн бодсоор өглөө нь нөгөө хоёртоо түлээнд явахгүй гэдгээ хэлэв.

-Хэдүүлээ одоо ажлаа солих хэрэгтэй боллоо. Би дахиад түлээнд хэзээ ч явахгүй. Та хоёрын нэг нь яв хэмээн тэр шулганалаа.

Хулгана зайдас хоёр түүнээс бодлоо өөрчлөхийг өчнөөн гуйсан ч болжмор

хөдөлсөнгүй, өөрийнхөөрөө зүтгэв. Ийнхүү тэдний ятгаад байгаа нь уран жиргээгийн хэлснийг нотолж байна хэмээн болжмор болсон хэрэг.

Эцэстээ болжморын болзлыг нөгөө хоёр нь зөвшөөрлөө. Гэхдээ шударга байхын үүднээс сугалаа сугалахаар боллоо. Тэд нар хуудасны өдөснүүд дээр өөрсдийнхөө нэрийг болон хийх ажлаа бичээд зайдасны малгайд хийн сэгсэрлээ. Үүнийхээ дараа хэдүүл нүдээ анин байж сугалбал зайдас түлээ түүх, хулгана тогооч болох, болжмор усанд явахаар таарсан байв.

Маргааш өглөө нь бяцхан Зайдас түлээ түүхээр ой чиглэн өнхөрч, болжмор гол уруу нисэч, хулгана гал зууханд үлдлээ.

Үдэш болоход Зайдас эргэж ирсэнгүй тул болжмор түүнийг хайхаар ой уруу явав. Тэгээд бүр шөнө болсон хойно оллоо.

Болжмор ойд нэгэн том нохой байхыг үзээд түүнээс асуулаа.

-Нохой гуай? Та үүгээр нэг Зайдас өнгөрч явахыг хараагүй биз?

-Харсан харсан.

-Та хаана байгааг нь хэлээд өгөхгүй юу?

Нохой гэдсээ зааж,

-Энд байгаа хэмээн эвшээлгэн хэлэх нь тэр.

Болжмор бараг ухаан алдах шахав. Нохой том толгойгоо данхалзуулснаа, чамайг ч гэсэн гээд харахад шувуу аль хэдийн нисч одсон байв.

Болжмор гэртээ ирээд золгүй найз зайдасны талаар хулганадаа хэлж хоёр хамтдаа гашуудан баахан уйллаа. Гэвч амьдрал үргэлжилсээр байгаа тул тэр хоёр тус тусынхаа ажлыг хийж эхлэв.

Маргааш нь болжмор ус, түлээндээ явж, хулгана хоол хийх болов. Хулгана шөлөө буцалган ногоогоо хийчхээд зайдас тогооны ирмэгээр бөмбөрөн хутгадгийг санаад түүн дээр үсрэн гартал, хальтраад буцалсан усан дотор унаж орхив.

Гаднаас орж ирсэн болжмор найддаа туслахаар ухасхийсэн ч хожимдсон байлаа. Хожимдох төдийгүй болжмор сандрахдаа тогоотой тостой шөлийг гал уруу татаж асгасан тул түймэр дэгдэх нь тэр. Золгүй шувуу галаас зугтаж гарч бас чадсангүй. Ийнхүү хоёр найзын нэг нь халуун шөлөнд, нөгөөх нь галд өртөн үхэх нь тэр.

Ийнхүү хулгана зайдас болжмор гурвын амьдрал харамсалтайгаар дууссан юм гэнэ билээ.



Улаан малгайт

Урьд нэг хөөрхөн бяцхан охин байжээ. Түүнийг харсан хүн бүхэн хайрлан өхөөрдөх бөгөөд эмээ нь бүүр амь, өгөх юмаа олж цөхнө. Нэг удаа эмээ нь улаан малгай бэлэглэхэд зохисон гэдэг нь хачин тул өөр малгай өмсөхөө больж, тэр малгайнаас салахаа байсан учир бүгд л түүнийг “Улаан малгайт” гэх болжээ.

Эх нь нэг өдөр түүнд хэлсэн нь,

-Наашаа хүрээд ир, Улаан малгайт аа! Энэ бин, лонх дарс хоёрыг эмээдээ хүргэж өг. Эмээ чинь өвчтэй, бие нь ядруу байгаа. Үүнийг идэж уугаад тэнхэл авч илааршиг даа. Халуу шатаагүй дээр явж үз. Томоотой яваарай. Замаасаа хазайв даа. Хальтарч унаад лонхоо хагалчихвал эмээдээ өгөх юмгүй болно шүү. Байшинд нь очоод “Өглөөний амгаланг айлтгая” гэж хэлэхээ мартав. Ийш тийшээ сэртэгнээд байж болохгүй шүү гэжээ.

-Би бүгдийг таны хэлсэн ёсоор хийнэ гэж Улаан малгайт өгүүлдээ ээжтэйгээ гар бариад замдаа гарлаа.

Эмээ нь тосгоноос хагас цаг явах газар ойд амьдардаг байжээ.

Улаан малгайт ойд явж байгаад чонотой тааралдах нь тэр. Тэрээр чоныг догшин араатан гэдгийг мэддэггүй байсан тул огтхон ч айсангүй гэнэ.

-Өглөөний мэнд хүргэе! Бяцхан Улаан малгайт минь хэмээн чонын өгүүлдээд,

-Их баярлалаа гэж охин хариуллаа.

-Бяцхан Улаан малгайт аа! Чи нийм эрт хаа хүрэх гэж яваа юм бэ дээ хө?

-Эмээгийнх үрүүгээ л явж байна.

-Наад хормогчинд чинь юу байгаа юм?

-Бин, дарс байгаа юм. Өчигдөрхөн хайрсан бин. Эмээгийн бие тааруу байгаа

болохоор түүнд өгч тамир тэнхээг нь сайжруулах гэж байгаа юм л даа.

-Хүүе хүүе, Улаан малгайт аа. Эмээ нь хаана амьдардаг юм бэ?

-Ойд амьдардаг юм. Эндээс хэдхэн минут яваад хүрнэ. Байшин нь гурван том царс модны нөмөрт, хушгын модон шивээ хашааны хажууд байдаг юм. Та гэхдээ мэднэ биз дээ.

“Энэ булбарай охины зөөлхөн мах эмгэнийхээс ч амттай даг аа. Яаж ийгээд хоёуланг нь үмхчих юм сан” хэмээн чоно санаашран бодоод, арга сийлж эхэллээ. Тэгээд,

-Бяцхан Улаан малгайт минь, эргэн тойрны гоёхон цэцэгсийг хар даа. Чи яагаад тоохгүй байгаа юм бэ? Бас шувуудын жиргээг ч чи хайхрахгүй байх шиг санагдаад байна. Чи сургууль уруугаа явж байгаа юм шиг ганцхан замаар явж байгаа болохоороо ойд ямар их хөгжилтэй байдгийг ер мэдэхгүй байна даа хэмээн ярилаа.

Нарны туяа моддын сиймхийгээр булгалзан гялбалзаад л үзэсгэлэнт цэцэгс сагсайлдан ургасныг Улаан малгайт нүдээ дүрлийлгэн харлаа.

“Хэрэв би эмээдээ баглаа цэцэг аваачиж өгвөл их баярлана даа. Цаг эрт байгаа юм чинь амжиж л таараан хэмээн охин бодоод замаасаа гарч, цэцэг хайж эхэллээ. Тэр нэг цэцэг тасдаж аваад цааш харахад бүүр ч гоё цэцэг байхаар түүн үрүү дэгдэж очсоор байгаад замаасаа холдон холдсоор ойн гүн үрүү орж явчихлаа.

Тэр хойгуур чоно эмээгийнх нь байшинд явж очоод үүдийг нь тогшиход эмээ,

-Хэн бэ? гэж асуулаа.

-Улаан малгайт байна аа. Танд бин, дарс авчирлаа. Үүдээ онгойлгооч.

-Чи наад бариулаа эргүүл. Надад босох ч тэнхэл алга гэж эмгэн хашгирлаа.

Чоно хэлснээр нь бариулыг эргүүлэн байшинд харайн оржээ. Тэгээд эмгэнийг үмхээд, түүний малгай хувцсыг өмсөн орон дотор нь орж, өмнөх хөшгийг нь хаан хэвтлээ.

Энэ үед Улаан Малгайт ийш тийшээ гүйсээр байж даагдахгүй их цэцэг түүсэн хойноо л сэхээ орж, эмээгээ саналаа. Тэрээр замдаа орж эмээгийнх үрүүгээ алхлаа. Очиход үүд нь онгорхой байсан тул маш их гайхав. Орж очвол байшин нэг л хачин мэдрэмж төрүүлж байлаа. “Тэнгэр минь, би өнөөдөр яагаад ийм бухимдуу байдаг билээ? Өмнө нь эмээгийнх ирэхэд баяр баясгалан төрдөг сөн” гэж охин бодоод,

-Эмээ, таны өглөөний амгаланг айлтгая гэлээ. Гэтэл ямар ч хариу алга, таг чиг байв. Улаан малгайт үүнд их л гайхан орны хөшгийг сөхөн харвал эмээ нь малгайгаараа нүүрээ хаан, нэг л хачин янзтай хэвтэж байхыг олж үзэв.

-Эмээ өнөөдөр таны чих яагаад ийм том болчихсон юм бэ?

-Чиний ярихыг улам сайн сонсох л гэж.

-Эмээ эмээ, тэгвэл нүд чинь яагаад ийм том болчихсон юм бэ?

-Чамайг улам сайн харах гэж л тэр.

-Гар чинь бас их том болчихжээ.

-Чамайг барьж авахад амар гэж тэр шүү дээ.

-Эмээ, таны ам чинь бас аймаар том болчихжээ.

-Аа, тэгвэл чамайг үмхэхэд хялбар байдаг болохоор тэр дээ хө. Чоно ийн хэлээд орноосоо харайн босч ирээд хөөрхий Улаан малгайтыг ганцхан үмхэж орхилоо.

Гэдэс нь цадаж, сэтгэл нь ханасан чоно гуай орон дээр гаран хавь орчныг сэртэл дүнгэнэтэл хурхирч гарлаа. Энэ үеэр байшингаас холгүй явж байсан нэгэн анчин эр, “За байз, юун сонин чимээ байдаг билээ? Эмгэн гуай зүгээр л байдаг байгаа даа” хэмээн бодоод байшинд орж очвол мань чоно байж байлгүй хаачих вэ.

-Муу нүгэлтэн, би чамайг хэчнээн эрэв? Энд байдаг вий. Өст хүн өлийн даваан дээр гэдэг энэ дээ хэмээн анчин эр өгүүлээд буугаа мөрнөөсөө мулталснаа чонын гэдсэнд нэг юм хөдөлж байх шиг байхыг үзээд “Нээрээ, эмгэнийг залгичихсан бол аварч болох юм” хэмээн бодоод чонын гэдсийг хайчаар хайчиллаа. Хэд хайчилтал Улаан Малгайт үзэгдлээ. Дахин хэд хайчилтал охин,

-Ёо ёо, үхтлээ айлаа. Чонын гэдэс ямар харанхуй байдаг юм бэ? гэсээр үсрэн гарч ирлээ. Араас нь эмээгий нь ч гаргаж ирлээ. Харин энэ хооронд анчин эр хүнд чулуу авчран чонын гэдсэнд хийгээд буцааж оёж амжлаа.

Чоно сэрээд, байшингийн цонхоор үсрэн гарч зугтсан боловч гэдсэн дэх чулуугаа даалгүй гол уруу шурган унаад амьсгал хураажээ.

Эмээ охин анчин гурав бөөн баяр хөөр болж, анчин чонын арьсыг өвчиж авчээ. Харин эмээ охиныхоо авчирсан бинг идэж, сайхан дарс уугаад тамир тэнхээ орон гялалзаж эхэлжээ.

“Үүнээс хойш юманд явбал хэзээ ч замаасаа гарахгүй, бас хаа хамаагүй танихгүй амьтан хүнтэй юм ярихгүй юм шүү” хэмээн Улаан малгайт охин гэртээ харих замдаа бодож явлаа.

Одоо тэр ойд чоно лав байхгүй биз. Гэхдээ тэр хавиар явбал Улаан малгайтын энэ түүх лав санагдах байх даа.



Дуулдаг чөмөг

Алс холын нэгэн нутагт нэгэн аюумшигтай бодон гахай байж тэр хавийгаа түйвээн сүйтгээд уджээ. Тэр бодон туйлын зэрлэг хэргий агаад хүмүүсийг барьж иддэг байсан тул хавийн амьтан дүрвэж зугтан хадлан тарианы газар хувхайрч идэх хоолгүй, өмсөх хувцасгүй болцгоожээ.

Ийн хоёр, гурван жил болоход хүмүүсийн түрүүч өлсгөлөнд нэрвүүлэн үхэж эхэлсэн гэнэ. Хүүхдүүд, эцэг эхчүүд турж үхэж байв. Хадан цохион дээрх ордондоо амьдардаг улсын хаан ард түмэндээ хайртай, нөгөөтэйгүүр тэднээс алба гувчуур авахаа байсан тул нэгэнтээ зарлагуудаа орон даяар томилон явууллаа.

Ногоон дээл, алтан хантаазаа өмсөн агсам морь хөлөглөсөн хааны элч нар хот, тосгон бүрд очин хэнгэргээ дэлдэн байж эзнийхээ зарлигийг чангаар хашгиран сонсож явав.

-Хаан эзний нэрийн өмнөөс зарлан тунхаглах нь. Бодон гахайг алсан хүн хааны охинтой гэрлэж, ханхүү болох болно хэмээн тэд зарлаж байв.

Энэхүү зар том хотуудаас эхлээд захын жижиг тосгод, мөнөөх бодонгийн үүрлэсэн ойн захад ч хүрчээ.

Тэр ойгоос холгүй амьдардаг ах дүү хоёр болох Карл, Фриц хоёр энэ мэдээг сонсоод хоёул бодонг алан хааны охинтой гэрлэхийг хүсэх боллоо. Харин ах Карл нь муу санаатай, зальтай хөвгүүн байсан бол дүү Фриц нь даруухан, сайхан сэтгэлтэй хүн байв. Ядуу гуйлгачин тэднийд ирэхэд ах Карл нь тоох ч үгүй хөөж нохойгоороо уруулдаг бол харин дүү нь яг эсрэгээр тэдгээр гуйлгачдын араас очин гац ч болов зоос өгөн, өөрөө өлсгөлөн байсан ч хамаагүй байгаа тал бяслагаа хуваалцах бөлгөө.

Хааны зарыг энэ ах дүү хоёр сонссон даруйдаа шуудхан бодонгийн үүрэнд

довтлон устгаж, хааны охинтой гэрлэхийг хүсэмжлэв. Гэхдээ Карл нь зөвхөн гүнжтэй гэрлэхийн тулд нийм зүйл хийх гэсэн бол Фриц нь юуны өмнө хүмүүсийг өрөвдсөндөө бодон гахайг устгахаар зориг шулууджээ. Фриц нь нийм л сайхан сэтгэлтэй хөвгүүн ажээ.

Ах дүү хоёр хааны зарыг олж сонссоныхоо маргааш өглөө ой уруу явлаа. Гэхдээ эхлээд Карл нь давхар бариултай сэлэм агсан битүү ойг чиглэсэн бол харин Фриц нум сум агсан өөр замаар мөн ой уруу зүглэв.

Фрицийг тийн явсаар үд дунд болон нар шарж, шувууд ч жиргэхээ больсон үед гэнэт ойгоос сүр сархийх чимээ дуулдан, улмаар мод бут хөдөлж эхлэв.

Нөгөө бодон гахай айсуу гэж бодсон Фриц нумаа эвшээлгэн, сумаа хөвчлөн хараачилж байтал модон дотроос бодон гахай биш, харин хар өнгийн жад барьсан жижигхэн хүн үсрэн гарч ирэх нь тэр. Фриц нумаа онилохоо болин буулгаж тэр хүнийг харахад нөгөөх нь ч түүнийг гайхан ширтлээ.

Тэгснээ тэр хүн,

-За Фриц чамтай тааралддаг минь сайн хэрэг боллоо. Чи сайхан сэтгэлтэй хүү учраас би чамд энэ жадыг өгье хэмээгээд хар жадаа газарт хатгав.

-Үүнийг ав. Тэгсэн байхад айх юм байхгүй. Үүгээр тэр зэрлэг бодонг устгаж хааны гүнжтэй гэрлээрэй. Сайхан сэтгэлтэй хүнийг дандаа аз дайрдаг гэж бурхны номонд бичсэн байдаг юм.

Бяцхан эр нийн хэлээд ойн гүн үрүү шурган алга болов.

Фриц жадыг аван ойн гүн үрүү цааш алхлаа. Нэлээд явж байтал гэнэт газар тэнгэр нийлэх мэт их чимээ гаран, хавийн модод чичрэн доргилсоор завжаар нь хурц соёо ёрдойсон улаан нүдтэй бодон харайн гарч ирээд түүн үрүү дайрлаа.

Фриц эхлээд модонд авирч гарьюу гэж бодсоноо зоригтой хүү байсан учраас биеэ барин зогсоч байгаад гахайг довтлон ирэхэд нь жадаа цээжинд нь зоолоо. Бодон гурван удаа аймшигтайгаар дуугараад газарт нам унан үхэв. Фрицийн гар хөл догдолсондоо чичирсээр байсан бөгөөд тэр гараараа хөлсөө шударснаа бодон гахайн хөлийг холбон үүрч, гэдрэг буцжээ.

Түүнийг ирэхэд Карл гэртээ байж байлаа. Яагаад гэвэл тэр бодонтой тааралдахаас айж, эрт эргэж ирсэн байж. Тэр айдсаа дарах гэж ирэнгүүтээ архи уусаар шал согтчихсон байж байлаа.

Гэхдээ Фрицийг үхсэн гахайг үүрсээр ирэхэд тэр маш их агаархан хорслоо. Гэвч тэрээр зальтай, муу санаатай хүн байсан учраас худлаа инээмсэглэн дүүгээ утлаа.

-Зэрлэг гахайг алж чадсан чинь ямар сайн хэрэг вэ? Чи их ядраа байлгүй. Наашаа сууж дарс ууж амар хэмээн тэр ярилаа.

Харин дүү Фриц нь дэндүү цайлган сэтгэлтэй нэгэн байсан тул ахдаа хэрхэн бяцхан одой хүнтэй учран, түүнээс жад авсан, дараа нь яаж гахайг агнаснаа нэгд нэгэнгүй хүүрнэн, өдрийнхөө амжилтыг хамтран тэмдэглэжээ.

Орой болохын хирд Фриц хот уруу явах боллоо. Тэр алсан бодон гахайгаа үүрэн хаанд үзүүлж, гүнжтэй гэрэлхээр замд гарав. Гэтэл Карл түүнийг сэм дагаж яваад гүүрэн дээр дүүтээ бороохойгоор цохиж хөнөөгөөд гүүрийн доорх горхины хөвөөнд оршуулж орхив. Түүнийхээ дараа бодонг аван хаанд аваачиж өгөөд өөрийгөө уг амьтныг агнасан гэж ярьжээ. Ийнхүү Карл хааны гүнжтэй гэрлэж язгууртны амьдралаар баян тансаг амьдрах болов.

Гэвч булавч бултайна, даравч дардайна гэдэгчлэн бузар муу үйл хэзээ нэгэн цагт заавал илэрдэг жамтай билээ.

Дээрх хэргээс хойш долоон жилийн дараа нэгэн малчин хөвгүүн гүүрэн дээгүүр явж байгаад загас хайн ус руу тонгойн харвал горхины ёроолд усанд угаагдан цас шиг цагаан болсон яс харагджээ.

-Ашгүй дээ. Лимбэнийхээ амсрыг хийхэд яг таарах юм оллоо хэмээн тэр хүү өөрөө өөртөө хэлээд горхи руу очин мөнөөх ясыг үзвэл нэгэн чөмөгний яс байх бөгөөд түүнийг аван засач янзлаад лимбэнийхээ амсар болгов.

Тэгээд гүүрэн дээр суун лимбээ үлээтэл энгийн нэг дуу биш шал өөр авиаг мөнөөх чөмөг гаргаж байх нь тэр.

“Малчин бяцхан хөвгүүн чи,
Чөмөгний минь ясыг үлээж байна даа
Агнасан бодонг минь аваад
Хааны гүнжтэй гэрлэх гэсэн
Ах минь намайг гүүрийн дор
Хороогоод булсан юм даа” хэмээн лимбэ нь исгэрч байх юм гэнэ.

Малчин хүү тэр дороо хааны ордонд гүйж хүрээд лимбээ тоглож үзүүлбэл цаг үргэлжид л дээрх гунигт аялгуу цуурайтаад байжээ. Хаан цэргүүдээ явуулж гүүрийн доорх газрыг малтаж үзвэл хөөрхий муу Фрицийн араг яс гарч иржээ. Карлыг хаан ордноос чирч ирээд араг ясыг үзүүлэн, лимбэний дууг сонгоход урьдын гэмт үйлээ зөвшөөрөн улайсан агаад түүний хүзүүнд чулуу дүүжлэн голд живүүлэн цаазалжээ. Харин Фрицийн араг ясыг хүндэтгэлтэйгээр оршуулсан гэнэ билээ.



Алтан галуу

Эрт цагт гурван хүүтэй нэгэн хүн амьдран суудаг байжээ. Түүний хамгийн бага хүү нь хөдөө хээр сэлгүүцэн, шувууд, цэцэгсийг сонирхон инээмсэглэж явдаг зантай байсан тул хүмүүс үүнийг жаахан гажигтай гэж үзээд тэнэг хэмээн нэрлэсэн ажээ.

Нэгэн өдөр түүний ууган ах нь ойд мод огтлохоор явах болж гэнэ. Ээж нь ахмад хөвгүүнийхээ үдийн цайнд зориулан гүзээлзгэнэтэй бялуу, сайн чанарын дарс өгчээ.

Тэр ойд явж очоод ажлаа эхлэхийн өмнө цайлахаар суулаа. Тэгтэл нэгэн буурал үстэй навтгар хүн бутны цаанаас түүнийг харж байх юм гэнэ.

-Чи юугаа хараав? Хэмээн ахмад хөвгүүн ууртайгаар асуувал нөгөөх навтгар эр дөхөж ирснээ,

-Намайг өршөөгөөрэй. Би олон хоног хэлэн дээрээ юм тавьсангүй. Тэр бялуунаасаа жаахан өгчихгүй юу гэж гуйж гэнэ.

-Юу гэнэ ээ? Чамд өгчих юм бол би юугаа идэх болж байна. Зайл, чи! Тэгэхгүй бол нүдийг чинь таглаж орхино шүү хэмээн ахмад хөвгүүн ширүүллээ.

Навтгар эр мөрөө хавчаад ойн гүн үрүү явж одов гэнэ. Түүнийг явсны хойно ахмад хөвгүүн сүхээ аваад мод цавчтал сүх нь хальтран гараа гэмтээж орхижээ. Хөвгүүний гараас цус гоожин арай чамай гэртээ харьжээ.

Маргааш нь дунд хөвгүүн нь мөн л ой уруу явах болж, ээж нь хүүдээ интоортой бялуу, лонх шар айраг өгч явуулжээ. Дунд хөвгүүн ойд очоод ажлаа эхлэхийн өмнө цайлахаар суутал мөнөөх навтгар эр бутны араас гарч ирээд зүсэм бялуу гуйжээ.

-Юу ярьж байгаа юм чи? Чамд өгчихвөл би цадахгүй. Яв чи, өөр юм хөөцөлд хэмээн дунд хүү хэдэрлэлээ.

-За яахав. Толгойгоо алдчихав! Навтгар эр ийн өгүүлээд явж одлоо.

Дунд хөвгүүн сүхээ аван мод цавчтал сүх нь эргэж ойн толгойг нь цохиж, золтой л тархийг нь зад татчихсангүй. Түүнийг хүмүүс олж дамнуур дээр тавин гэрт нь хүргэжээ.

Гурав дахь өдөр болоход хамгийн бага тэнэг хүү нь ой уруу модонд явуулахыг эцгээсээ гуйлаа. Тэгсэн эцэг нь хүүг гайхан харж байснаа дооглон инээд алдаж,

-Чи юу дээ, одоо чи ой уруу явах гэж үү тэнэг минь. Чи ой хаана байдгийг ч мэдэхгүй байж яаж модонд явах юм? Ах нар чинь гэмтэж бэртээд ирсэн юм чинь чи өөрийгөө алах байлгүй. Дуугүй байж үз хэмээлээ.

Гэвч тэнэг хүү шантарсангүй, эцгийгээ ажилдаа явахад нь даган гуйсаар байсанд эцэг нь эшгэсгээ залхан хэлсэн нь:

-За, яришиг яришиг. Тэр ой уруугаа яв. Харин гэмтэж бэртвэл намайг битгий буруутгаад байгаарай.

Тэнэг хүү сүх мөрөвчлөн ээжээсээ үдийн цайнд идэх юмаа авлаа. Гэхдээ ээж нь түүнд зөвхөн үнсэнд булж болгосон бин, ганц лонх ус л өгчээ. Харин үүнд нь тэнэг хөвгүүн ер гомдсонгүй, сүхээ мөрөвчлөн, бин, усаа халааслаад ойн зүг явж одов.

Бага хөвгүүн ойд очин тухалж үдийн цайгаа ууж эхэлтэл мөнөөх навтгар эр гарч ирээд, идэх юм гуйлаа.

-Тэгэлгүй яахав. Наашаа суугаад цай уу. Гэхдээ надад үнсэнд булж болгосон бин, лонх ус л байгаа шүү хэмээн тэнэг хөвгүүн найрсгаар хэлэв.

Навтгар эрийг хажууд нь зэрэгцэн суусны хойно хөвгүүн цүнхээ уудалтал юу байсан гэж санана. Цүнхэнд нь бин, ус хоёр биш харин амттайхан давтсан мах, шарсан элэг, лонх оргилуун дарс байсан гээд бод доо.

Тэр хоёр идэж уусны хойно нөгөө навтгар эр,

-Тэнэг хүү минь баярлаллаа. Чи сайхан сэтгэлтэй хүн байна. Тийм болохоор чамайг үргэлж аз дайрч байх болно. Чи тэр хөгшин модыг харж байна уу? гэж гэнэ.

Хөвгүүн заасан зүгт нь харвал нэгэн саглагар хөгшин мод дүнхийн байжээ.

-Чи тэр модыг тайрвал ёроолд нь чамд таалагдах сайхан юм байгаа хэмээн навтгар эр өгүүлээд замаа хөөн, ойн гүн үрүү явж одлоо.

Тэнэг хүү сүхээрээ модыг цавчвал өнөөх мод бяслаг мэт зөөлхөн байх юм гэнэ. Түүнийг ганцхан цохисны дараа мод газарт унан, ёроолд нь нэгэн алтан өдөг галуу байх нь үзэгдэв.

Тэнэг хүү нүдэндээ ч итгэсэнгүй. Гэвч галууг гартаа барьж үзвэл үнэхээр л өд сөд нь шижир алт байлаа.

-Өнөөдөр ч миний азтай өдөр байна даа хэмээн тэнэг хүү өөртөө өгүүлээд

галуугаа сугавчлан алхаж гарав. Тийн хэсэг алхсанаа гэнэт,

-Би ер нь юугаа хийж гэртээ очих билээ? Ах нар галуут минь булаагаад авчихна. Аав хашгирч загнаад тэнэг мулгуугаар минь дуудна. Би ер нь алтан галуутай юм чинь хэзээ ч өлсөхгүй. Тийм болохоор өргөн хорвоог үзэж танья байз хэмээн шийдлээ.

Тэнэг хүү өдөржин явсаар орой болохын хэрд нэгэн буурчийн газар ирээд галуугаа хөлсөлж авсан өрөөнийхөө орон дээр орхиод юм уухаар гарч явлаа.

Тэгсэн тэр буурчийн газрын эзэн гурван охинтой юм санж. Тэд нар тэнэг хүүг алтан галуу авч ирэхийг нь харсан байжээ. Тэдний хамгийн ууган охин нь,

-Энэ ямар гайхамшигтай сайхан шувуу вэ? Өрөөнд нь сэмхэн ороод ганц өд хулгайлчихъя байз. Хэн ч мэдэхгүй хэмээн сэтгэв. Тэгээд өрөөнд сэмхэн гэтэж ороод,

-Ганцхан, ганцхан нарийхан өд хэмээн бувтнаад галууны сүүл үрүү гараа явуулан бариад автал өд сугарсангүй гэнэ.

Галуу эргэж харан гаагалбал, охины гар галууны өдөнд бүрмөсөн наалдчих нь тэр.

Энэ явдлаас ганц хоёрхон минутын дараа буурчийн газрын эзний дунд охин бас л ганц өд авчих санаатай ирээд гараа наалдуулж орхиж.

Гараа наалдуулсан хоёр охин орь дуу тавин үйлж гартал бас л нэг өд авчих санаатай хамгийн отгон дүү нь хүрээд ирэх нь тэр.

-Хүүе, чи хойшоо бай. Боль, боль хэмээн эгч нар нь хашгирсан ч отгон дүү нь зөрүүдлэн,

-Үгүй ер өө, та хоёр өд аваад байхад би яагаад болдоггүй юм? хэмээн зүтгэсээр эгч нарынхаа биенд хүртэл галуу ч гаагалан гар нь ч бас наалдаж орхилоо.

Маргааш өглөө нь Тэнэг хүү галуугаа сугандаа хавчуулан өргөн уудам хорвоог үзэхээр цааш гарч одов. Нөгөө гурван охин галуунд наалдаастай тул түүнийг даган санжганалдах аж. Тэнэг хүү хаа ч явсан, өгссөн ч, уруудсан ч, намаг шалбааг, ой ширэнгэ, шат гишгүүрээр явсан ч тэд мөн л дагаастай, яагаад ч суларч чадахгүй байлаа.

Тэгж явсаар нэгэн хөндийг гатлан гарч явтал тэдэнтэй санваартан дайралдлаа. Мань санваартан тэдний ийн хэлхэлдэн явахыг хараад мэл гайхаж нүд нь бүлтрэх шахаж,

-Зогсоого, больгоо! та нар. Ийм охид эр хүн хөөцөлдөөд ингэж явна гэж байх уу? Яасан ичих нүүрэндээ илэг наасан охид вэ хэмээн хашгирлаа.

Санваартан улмаар хамгийн отгон охины гараас татгал галуу ч гаагалан бусадтайгаа бас л гагнагдаж орхих нь тэр дээ. Тэнэг хүү ч цааш явж, гурван охин, санваартан нар дагалдан явж байтал оройн хоолонд уригдаж очоод гэртээ

харьж явсан нэгэн ширээт лам дайралдав.

Ламтны царай минчийн хүрээнтээд,

-Мөн дөө хө, санваартан гуай та юу хийж яваа чинь энэ вэ? Сахил санваараа мартаад ингэж явдаг вий хэмээн дуу алдаад санваартны ханцуйнаас татгал галуу ч гагалан гар нь ч наалдаж орхилоо. Ламтан хэдий тарган бүдүүн биетийн дээр шарсан үхрийн мах тэврээстэй явсан ч аргагүйн эрхэнд тэдэнтэй хэлхэлдэн урагшлахаас аргагүй боллоо.

Тэнэг хөвгүүн галуугаа сугадан алхаж, араас нь эгч дүү гурав, санваартан, ламтан тав таваргасаар явтал газар ухаж буй нэгэн ажилчин хүн тохиолдлоо.

Түүнийг харсан ламтан,

-Хүүе, хүн гуай туслаарай, биднийг салгаж аваарай хэмээн хашгирлаа. Ажилчин хүн ч туслах гээд бас л наалдсан нь мэдээж.

Гэтэл бас болоогүй ээ. Нөгөө ажилчин хүний халаасанд шарсан зайлас байсан юм байж. Тэр зайдсыг идэх гээд нэг нохой замын хажууд сахиад байж л дээ. Тэр нохой ажилчин хүнийг наалдангуут ухасхийгээд нөгөө зайдсыг үмхдэгийн даваан дээр галуу гагалж орхитол нохой бас л наалдан пад болчих нь тэр дээ.

Тэд ийнхүү наалдаастай урт цуваа болж аваад цааш явсаар арван хоёр цаг болж байхад хотын зах уруу орж ирэв. Тэгсэн тэр хотын хааны охин маш гунигтай, насаараа инээж үзээгүй хүн юм санжээ. Үүнд нь санаа нь маш их зовсон хаан “Хэрэв хэн нэгэн хүн охиныг нь инээлгэж чадах юм бол тэр хүнийг хан хүү болгон охинтойгоо суулгана” гэсэн зар тараасан байлаа. Тэр хавийн илбэчин жилбэчин, инээдэмчин алиалагчид, циркчид жонглёрчид гээд хамаг амьтан охиныг инээлгэх гэж оролдоод эдүгээ хүртэл амжилт олоогүй ажээ.

Тэгтэл тэнэг хүү галуугаа сугавчилчихсан, тэнд нь эгч дүү гурав наалдчихсан, дээрээс нь бас горзгор туранхай санваартан, голигор бүдүүн ламтан, зайлас үмхээд залгагдчихсан нохойтой тэр цувааг хараад хааны охин тэсгэлгүй инээд алдаж гэнэ. Инээд алдахаар барахгүй элгээ хөштөл хөхөрч гэнэ. Тэнэг хүү ч бас л инээд алдлаа.

Тэгсэн хаанд өөр бодол төржээ. “Энэ миний охинтой гэрлэх эр биш дэг ээ” хэмээн тэр тэнэг хүүг голоод арга зохиож эхэллээ. Тэгээд тэнэг хүү охиныг нь эхнэрээ болгохыг хүсэхэд олсон аргаа хэлжээ. Тэр нь юу вэ гэвэл, зoorь дүүрэн дарс ууж чадах хүн олж ирэхийг хүслээ.

Тэнэг хүү үүнд нь төдийлөн шимтсэнийгүй. Зoorь дүүрэн дарсыг заан ч ууж барахгүй биз. Тийм хүн олно гэсэнээ гэрийн зүг гэлдэрье байз гэж бодсоноо ер нь юмыг яаж мэдэх вэ, оролдоод үзье гэж шийдээд ой уруу явж одлоо.

Тэгтэл ойн гүнд нэгэн саглагар модны дэргэд бяцхан эр сууж байх юм гэнэ. Тэр хүний царай уйтай гэж жигтэйхэн, барайсан л юм байв гэнэ.

“Энэ хүн надад тус болж магадгүй. Асуугаад үзье байз” хэмээн хүү шийдээд,

түүнээс юу нь болохоо байсныг лавлав.

-Цангаа. Би дандаа л цангаж байдаг хүн хэмээн нөгөө хүн буйтнаад ус уугаад нэмэр алга. Бүтэн торх шар айраг уусан ч халуун зуухан дээр борооны ганц дусал унахын төдий болох юм хэмээн учирлав.

Тэгвэл найз минь надтай яв. Чиний наад зовлон чинь одоохон дуусгавар болно хэмээлээ.

Тийнхүү хүү нөгөө эрийг дагуулсаар хааны дарсны зооринд хүрч очиход тэр хүн томоос том торхтой дарсыг ховх залгилан хийлсэн мэт бүдүүрсээр дор нь шавхаж барав.

Гэтэл хаан охиноо өгөх дургүй л байлаа.

“Энэ тэнэг хүүд охиноо өгчихвөл дэлхийн бүх хаад намайг шоолж, ингээдэх байх даа хэмээн тэр боджээ. Тэгээд бас нэг арга зохион, хотын бүх талхыг ганцаараа идэж чадах хүн олж ирэхийг хүүд тушаалаа. Харин тэгсний дараа охиноо түүнтэй гэрлүүлдэг хэмээн амлалаа.

Тэнэг хүү гайхшаа баран, хуйхаа маажлаа. Энэ ч ятгүй хэрэг байна даа гэж тэр зүрхшээсэн ч юутай ч ойд очвол нөгөө бяцхан хүн тусалж юуны магад гэж бодлоо.

Түүнийг ойд очвол мөнөөх саглагар модны дэргэд бас нэг өөр бяцхан эр суух ажээ. Царай зүс нь аймшигтай зэвхийрэн, зогсон, эвшээх агаад гэдэсндээ бүсэлсэн савхин бүсээ самардан оролдож суух ажээ.

-Юу тохиолдоо вэ, хүн гуай? хэмээн хүү лавлахад нөгөөх нь, Өлсгөлөн, өлсгөлөн гэдэг юм хэцүү байна. Би дөнгөж сая арван хүүдий төмс идсэн ч аймшигтайяа өлссөн хэвээр л байна. Ямар сайндаа өлсгөлөнгөө зогсоох санаатай гэдээ маажиж сууна гэж ярилаа.

Тэнэг хүү гараа баяртайгаар өргөөд, санаа алдаад хэрэггүй найз минь. Намайг дагаад яв хэмээн хэллээ.

Тэр хүн тэнэг хүүгийн хамт хотод ирээд бүх дэлгүүр гуанзны хамаг талх төдийгүй махыг хүртэл хуу хамж барлаа. Хотод талхны хэлтэрхий ч үлдсэнгүй.

Тэнэг хүү галууныхаа алтан өднөөс сугалан авч дэлгүүр, гуанзны эздэд төлбөр болгон өгөөд хааны ордонд очлоо.

Гэвч хаан энэ удаа бас л нэг нөхцөл тулгалаа. Тэрбээр далайд ч хуурай газарт ч явдаг хөлөг онгоц олж ирэхийг хүүтээс хүслээ. “Ингэвэл хүү яаж ч чадахгүй. Тэнэг хүү хоосон гуяа ганзагалаад буцаад ирэхээр нь би алтан галууг нь авчихна. Хаанг улс маань ч миний эзэмшилд үлдэнэ” гэж хаан бодсон хэрэг.

-Усанд ч, газар дээр ч явдаг хөлөг онгоц гэж ёстой хэзээ ч дуулаагүй, сонсоогүй юм байна. Хаанд ч байхгүй биз дээ. Гэхдээ яахав, ойд очоод үзвэл учир нь олдож магадгүй хэмээн тэнэг хүү бодлоо.

Хүүг ойд явж очиход хамгийн анх уулзсан навтгар эр модны дэргэд сууж байх нь тэр. Мөнөөх эр хааны шаардлагыг сонсоод гайхан исгэргээ.

Тэгснээ,

-За яахав, чи надад сайн сайхнаар хандсаныг чинь би мартахгүй. Тэр хөлөг онгоцыг чинь олж өгнө гэххэд туулайн нүх үрүү ороод алга болчихов.

Тэнэг хүү ойгоос гарч, хөндийд бууж ирвэл мөнөөх хаа сайгүй явагч хөлөг онгоц зогсож байх нь тэр. Хүү хөлөг онгоцон дээр гарвал уг онгоц тал хөндийгөөр хурдлан гол тааралдвал хөвөн явсаар хотын гудамжаар давхин хааны ордны үүдэнд ирж зогслоо.

Энэ удаа хаан хэлсэн амандаа хүрэхээс аргагүй болж хуримын товыг товлов. Дараагийн долоо хоногт тэнэг хүүг гүнжтэй гэрлэхэд нь маш олон шувуу байсан бөгөөд тэр хоёр ч туйлын аз жаргалтай байв.

Хожим хааныг нас барахад тэнэг хүү хаан болсон бөгөөд хэдий олон юм ярихгүй ч эзэнт улсаа он удаан жилийн турш ухаалгаар удирдан залж суугаа билээ.

Хэрэв та нар хэзээ нэгэн цагт тэр хотод очих юм бол хотын гол хаалган дээр тэнэг хүүгийн сүлд сийлээстэй байгааг харж болно.

Тэр сүлдэн дээр алтан галуун дээр суусан навтгар эрийг дүрсэлсэн байдаг бөгөөд доод талд нь Өршөөл, Энэрэл, Эв нэгдэл ба Хайр хэмээх үгсийг бичсэн байдаг билээ.



Алтан уулын хаан

Конрад гэдэг хүүтэй нэгэн худалдаачин байжээ. Хүү балчир нялх, дөнгөж мөлхдөг байсан цаг юм санж. Худалдаачин хоёр хөлөг онгоцтой байсан бөгөөд нэгэнтээ тэдгээр онгоцондоо бүх эд бараагаа ачаад Энэтхэг үрүү илгээжээ. Мань хүн түүнийгээ зараад их ашиг олж, урь урьдынхаасаа илүү баян болно гэж тооцоолсон юм байж.

Тийн тооцоолсон худалдаачин тосгоны гудамжаар ихэмсгээр алхдаг байж л дээ.

Гэвч гурван сарын хойно нөгөө онгоцууд нь далайн дээрэмчдийн гарт орон сураггүй болсон муу мэдээ ирэв гэнэ.

Ийнхүү худалдаачин маань баяжих бүү хэл хоосроод, ядуугийн эгнээнд орж гунигтайхан амьдрах болжээ.

Тэрээр тосгоны захад нэг бяцхан тариалангийн талбайтай байв. Наанадаж гуниг зовлонгоо мартаж, цаанадаж өөрийг нь хүмүүс шоололдож буй хэмээн боддог тул тэднээс зугтаан тэр талбайдаа очиж бага боловч ногоо ургуулахыг оролдох бүлгээ. Нэгэнтээ тэр тарьж байгаа байцаагаа арчилж явтал ногоон зүс царайтай нэгэн бяцхан жижигхэн хүн чулуун дээр суучихсан гаанс тамхи уугиулан сууж байх юм гэнэ.

Худалдаачныг түүн үрүү дөхөн очиход нөгөөх одой эр,

-Юу болоов найз минь? Царай зүс чинь тааруухан харагдаж байх чинь. Яг л нөгөө үлгэрт гардаг Ухаант Элза шиг л байна гэж хэрэгт дурлав.

-Чи хэрэв миний оронд байсан бол бас л өөдтэй царайлахгүй л байсан байх даа гэж худалдаачин өгүүлэв.

-Ямар асуудал гарав вэ? гэж ногоон хүн лавлав.

-Хэрэв чи тусалж чаддагсан бол ярмаар л байна санж.

-Тусалж чадаж ч болох юм. Чадахгүй ч байж болох юм. Гэхдээ чамайг яасныг мэдэхгүй байж тэр тухай би юу хэлэх вэ дээ.

-За яахав хэлье.

Худалдаачин одой хүнтэй зэрэгцэн сууж юу болсныг нэгд нэгэнгүй тайлбарлав.

Гэтэл одой хүн, тэгвэл би тусалж болох л юм гэжээ.

Худалдаачны сэтгэлд өнгөрсөн олон сарын дотор анх удаагаа л найдварын оч зурсхийв.

-Би чамайг хүрэлцээтэй алттай болгож өгье. Гэхдээ ганцхан болзолтойгоор шүү гэж бяцхан хүн өгүүллээ.

-Ямар болзол гэж?

-Үүнээс хойш яг арван хоёр жилийн дараа чи яг эндээ ирж надад бэлэг өгөх ёстой.

-Чухам ямар бэлэг гэж?

-Өнөөдөр чамайг гэртээ харихад чинь эхэлж хөлөнд чинь хүрсэн тэр зүйлийг л чи надад авчрах ёстой.

Худалдаачин энэ болзлыг сонсоод, чамайг өнөөдөр гэртээ харихад урьдын адил нохой маань л хөлнөөс зуурна биз гэж бодоод дуртайяа зөвшөөрөв.

Хоёр эр тохиролцон гараа барилцаад бяцхан эр ойн зүг, худалдаачин гэрийн зүг хандаагаав. Худалдаачин гэртээ ортол түүний хөлнөөс нохой нь биш харин шалан дээр мөлхөж явсан Конрад хүү нь зуураад авчээ.

Мань эр гэнэт өдрийн тохиролцоогоо санаад айсан боловч ямар нэгэн юм тохиолдолгүй долоо хоноход, бяцхан хүн тоглож байсан байх хэмээн сэтгэлээ тайвшрууллаа. Гэвч худалдаачин тарьсан байцааныхаа дороос их хэмжээний алт, мөнгө гэнэт одлоо. Тэрээр маш их баяртай байсан боловч нууцхан түгшүүрийг сэтгэлдээ хадгалсаар байв.

Арван хоёр жил өнгөрөхөд Конрад хүү ухаалаг, гярхай хүн болон өслөө. Тэр аавыгаа нэг л гунигтай байгааг ажиглан учир шалтгааныг нь асуулаа.

Аав нь үрчлээ болсон магнайгаа арчаад санаа алдсанаа, арван хоёр жилийн өмнө юу болсон, хүүг өгөх өдөр хариугүй дөхснийг бүгдийг ярьж өгөв.

Харин тэр яриаг Конрад хүү сонсоод огтхон ч тоосонгүй.

-Тайван бай аав минь. Би тэр одойн хүү болно гэж байхгүй. Харж л бай та хэмээн тэр итгэлтэй хэллээ.

Хүү арван хоёр нас хүрснийхээ өглөө сүмд очин адис тавиулаад ногооныхоо талбай уруу очив. Тэр өөрийгөө тойруулан газар дээр шидэт тойрог татан түүн дотроо таван хошуу зураад дотор нь аавыгаа оруулан зогсоов.

Үдээс хойш нь сүмийн хонх гурван цагийг зарлан дохиолж дуусахад бяцхан хүн яран хүрч ирлээ. Гэвч шидэт тойргийг үзээд цухалдан зогслоо.

-Энэ чинь юу болж байгаа хэрэг вэ? Чи яагаад шидэт тойрог зурав? Алив

хүүхдийг өгөөдөх гэж тэр шаардлаа.

-Та юу хүсээ вэ? хэмээн Конрад хүү аваасаа өрсөн чангаар асуулаа.

-Дуу чи хэмээн одой эр хяхтнаад, би чамтай ярихгүй. Аавтай чинь ярих гэж ирсэн юм гэлээ.

-Гэхдээ та надтай л ярих болно доо хэмээн Конрадыг зүтгэхэд одой хүн уурсан, урагшаа ухасхийсэн ч шидэт тойрог дотор хэрхэн орж чадах билээ.

-Би хэлснээ биелүүлсэн. Одоо чиний биелүүлэх ээлж гэж түүнийг өгүүлэхэд, үгүй ээ та миний аавыг хуурсан гэж Конрад хариулав.

-Тийм биш ээ. Би эрхээ эдэлж байна хэмээн одой хүн зөрүүдэллээ.

Конрад тэр хоёр ийнхүү удтал маргалдсан ч хэн нь ч хэнийгээ давсангүй тул эцэстээ нэгэн тохиролцоонд хүрлээ. Юу гэвэл Конрад одойн хүүхэд болно, харин одой хүн түүнийг аавын хүү хэвээр үлдэнэ гэдгийг яагаад ч зөвшөөрөхгүй байсан тул ерөөсөө Конрадыг сэлүүргүй завинд суулгаад далайд гаргая, хувь заяа нь шийдэг хэмээн тэд тохиролцсон ажгуу.

Тийнхүү тэд далайн эрэгт хүрч очоод Конрад хүү сэлүүргүй завинд суун аав нь хүүтэйгээ ганц ч болов хором байх гэж эргээс нэлээд хол завийг нь түрж өгөөд хоцров. Гэвч завь нэг их хол явсангүй усны долгионд цохиулан хөмрөх нь тэр. Аав нь далайн эргийн дагуу хашгирч гуагчин зөндөө гүйсэн боловч Конрадын бараа ч гарсангүй хөмөрсөн завь л урсан алга болсон тул мань хүн гуниг зовлонд шаналсаар гэртээ харьжээ.

Гэсэн ч Конрад амьд байлаа. Хэдий завь хөмөрсөн ч хүү завины суудлаас зүүгдэн амь гарчээ. Гэхдээ хөмөрсөн завь толгойг нь далдалж байсан тул аавдаа харагдаагүй юм байжээ.

Завь салхи шуурганд туугдсаар нэгэн аралд хүрэв. Конрад эрэг дээр авирч гараад харвал ууланд алт, мөнгөн оройтой үзэсгэлэнт сайхан цайз байх бөгөөд тэрхүү цайзын дотор ганц ч цэрэг, албат үзэгдэхгүй нь хачирхмаар ажээ.

Конрад өрөө болгоныг шагайж харсан ч хулгана ч гүйхгүй хов хоосон байв. Харин хамгийн мухрын өрөөнд шалан дээрх гинжнээс аргамжаатай шар цоохор могой байж байв. Конрад тэнд байсан сандлыг шүүрэн авч могойг алахаар далайтал могой гэнэт гинжнээсээ сулран үзэсгэлэнт бүсгүй болон хувирав.

-Ай яа хэмээн бүсгүй шүүрс алдаад, би чамайг хүлээн бүтэн арван хоёр жилийн турш энд гинжлээтэй байлаа. Харин одоо чи намайг чөлөөлбөл цайз ид шиднээс ангижирна гэлээ.

-Тэгээд одоо яах вэ? гэж Конрад лавлав.

-Өнөө шөнө арван хоёр мангас цайзад ирнэ. Тэд чамайг тамлан зовоож, галд шарах болно. Харин чи нэг ч үг дуугарахгүй байх хэрэгтэй. Тэд нар яг шөнө дунд там уруугаа буцна. Тэгээд маргааш шөнө хорин дөрвөн мангас, нөгөөдөр шөнө гучин зургаан мангас дахин ирээд чамайг тамлан зовоож, улмаар толгойг чинь тасдана. Гэвч та нэг чиг дуугарч болохгүй. Тэгвэл би аврагдаад тан дээр

ирж шидийн хүчээр чамд амь оруулна.Чи ингэж чадах уу? хэмээн бүсгүй асуулаа.

Бүх юм бүсгүйн хэлснээр болов. Эхний арван хоёр мангас ирж Конрадыг тамлахад тэр нэг ч үг хэлсэнгүй. Дараа нь хорин дөрөв, маргааш нь гучин зургаан мангас ч ирж тамласан байна. Гэхдээ хүү нэг ч үг амнаасаа унагасангүй тэсч байв. Эцэстээ мангасууд түүний толгойг тасдан хаяад шөнө арван хоёр цагт там уруугаа буцан одлоо. Тэднийг ийн алга болмогц могой гинжнээсээ мултран гүнж болон хувираад Конрадад ид шидийн хүчээр амь орууллаа. Гүнж Конрадтай гэрлэснээр мань хүн Алтан уулын хаан болов.

Конрад эхнэртэйгээ жаргалтай сайхан амьдарсаар хэсэг хугацааны дараа хүүтэй болцгоожээ. Харин түүнээс хойш найм, есөн жил өнгөрсний хойно Конрад эцэг эхээ дурсан санаж тэдэн дээрээ очихыг мөрөөдөх болов.Түүнийг ийм зорилгоор хаант улсаасаа гарч явна гэхэд гүнж сонсохыг ч хүсэхгүй байлаа.

-Чи тэгвэл хэзээ ч эргэж ирэхгүй хэмээн гүнж хэлсэн ажгуу.

-Би эргэж ирнэ. Чөтгөр шулам саад хийсэн ч заавал ирнэ хэмээн Конрад ам өчгөө өглөө. Конрад энэ тухай байнга шаардсаар эцэстээ гүнж түүний явахыг арайхний зөвшөөрлөө.

-Энэ ч сайн хэрэг биш дээ. Гэхдээ чи энэ бөгжийг ав. Энэ бол шидэт бөгж. Чиний хүссэн газарт чинь хүргэж өгнө. Гэхдээ чи нэг л зүйл амла. Намайг энэ хаант улсаасаа гарч явах хүсэлтийг л чи энэ бөгжинд хэлж болохгүй хэмээн гүнж хэллээ.

Конрад амлалт өгөн бөгжийг хуруундаа зүүгээд нутагтаа очих хүсэлтээ шивнэлээ. Тэнгэр харанхуйлан аянга цахисны дараа Конрад нүдээ нээвэл төрсөн хотынхоо хаалган дор зогсож байх нь тэр.Тэр хотын хаалгаар орж гэртээ очих гэсэн боловч хэтэрхий этгээд чамин хувцастай байсан тул хаалгач цэрэг түүнийг дотогш нэвтрүүлсэнгүй.

Тэрээр цэрэгт мөнгө өгөхийг оролдоод ч тусыг эс олсон тул дэмий л энэ тэрүүгээр сэлгүүцэн явж байгаад нэгэн малчин хөвгүүнтэй тааралдав. Хоёул хувцсаа солилцон Конрад малчин хүүгийн бүдүүн бараг дээлийг өмсөн очиход харуулын цэрэг түүнийг дотогш нь орууллаа.

Тэр төрсөн гэрийнхээ хаалгыг тогшин, аяга ус гуйлаа. Зарц түүнийг гэрт оруулахад аав нь сайхан сэтгэлтэй хүн учраас түүнийг суулгаж хоол, цай өгчээ.

Конрад хоол идэх зуураа аав, ээж хоёроосоо хүүхэдтэй байсан эсэхийг нь асуулаа.

-Тийм ээ. Бид хүүтэй байснаа олон жилийн өмнө алдчихсан юм аа гэж аав нь гашуудалтайгаар өгүүлэв.

Конрад халбагаа хойш тавьж, тэгвэл одоо гуних хэрэггүй ээ. Би хүү чинь

байна хэмээв. Аав ээж хоёр нь түүнийг хүзүүдэн авч, сүйд майд болох байх гэж Конрад бодсон ч тэгсэнгүй харин ч тэд уурслаа.

-Бид элдэв заль мэхнээс залхлаа. Олон хүн бидий мөнгийг салгах гэж яг ийм зүйл хэлдэг юм. Чи хурдан эндээс яв. Эс бол нохойгоо тавилаа шүү гэж тэд хэлжээ.

-Та нар хүүгээ таних ямар нэгэн содон тэмдэг мэдэх үү? хэмээн Конрадыг инээмсэглэн асуухад, хүү минь гаран дээрээ эрвээхий мэт мэнгэгтэй юм сан гэж ээж нь хэлэв гэнэ.

Конрад цамшихаа ханцуйг сөхөөд эрвээхийн чинээ мэнгээ харуулав. Ээж нь ч ухасхийн түүнийг тэврэн авч, миний хүү мөн байна хэмээн мэгшлээ.

Аав нь лонх дарс задлан хүүгээ эргэж ирсэний баярыг тэмдэглэлээ.

-Чи энэ олон жил хаана байж байгаад ирэв? гэж аав нь асуулаа.

Конрад хэрхэн амь гарч арал дээр очсон болон тэнд гүнжтэй гэрлэсэн, Алтан уулын хаан болсон, долоон настай хүүтэй зэргээ нэг бүрчлэн хүүрнэлээ.

Түүнийг яриагаа өндөрлөхөд аав нь инээмсэглэн байж, миний хүү мөрөөдөлгүй яахав. Гэхдээ ийм үлгэр яриад яахав гэлээ.

-Энэ чинь юу гэсэн үг вэ? хэмээн Конрадыг шалгаахад чи өвгөн малчин шиг ийм хувцастай байж хаан гэж ярьдаг чинь нэг их үнэмшилгүй л байна. Гэхдээ аав ээж нь чамдаа хайртай шүү гэж хэлэв.

Конрадын уур хүрчээ. Тэр өөрийн түүхийг дахиад хоёр ч удаа давтсан боловч аав нь огтхон ч үнэмшсэнгүйд тэрээр босон харайлаа.

Тэгээд би тэгвэл нотлоод өгье хэмээн хашгираад хуруун дахь бөгжиндөө хандан, миний эхнэр хүүхдийг энд аваад ир хэмээн хэллээ.

Тэгтэл тэнгэр харанхуйлан, цахилгаан цахиснаа дахин гэгээ ороход Конрадын эхнэр, хүүхэд хоёр аль хэдийн өрөөн дотор зогсож байх нь тэр.

-Хүүе Конрад аа. Чи арай ч дээ. Намайг эх нутгаас минь холдуулахгүй гэж чи амлаа биз дээ хэмээн Хатан хаан хашгирлаа.

Конрад түүний гарыг атган өршөөл гуйж, энэ тухай санасангүй мартсанаа хүлээв.

Хатан хаан ч жаахан уйлж байгаад тайвширсан тул Конрад өөрийг нь өршөөв хэмээн боджээ.

-Одоо би та хоёрт миний анх завийг хөмрүүлэн адал явдлаа эхэлсэн газраа үзүүлье гэж Конрад эхнэр хүүхэддээ хэлэв.

Тэгээд Хатан хааны хамт далай эрэг үрүү явлаа. Төд удалгүй тэр нойрондоо дийлдэн эхнэрийнхээ гарыг дэрлэн унтахад Хатан хаан бөгжийг нь хуруунаас нь сэм сугалан авлаа.

-Хуурамчхан амьтан минь. Одоо төрсөн газраа амьдар. Чи одоо Алтан уулын хаан байхаа больсон гэж гүнж хэлээд, бөгжиндөө гэртээ очих хүслээ хэлэн хүүхдийн хамт алга болж одов. Гэхдээ Конрадын гарт өрөөсөн шаахайгаа

орхин оджээ.

Орой болж далайн түрлэг эхлэхэд, Конрадын хөл усанд норсноос тэр нойрноос сэвлээ. Харвал хуруун дахь бөгж нь үгүй, хажууд нь хэн ч байхгүй хоосон эрэг дээр хэвтэж байсан тул эхнэр хүүхэд нь өөрийг нь үүрд орхин одсонг ойлголоо. Тэр чулуу сандайлан суугаад баахан уйлж аваад эцэстээ зөвсөн шаналсандаа шанаа тулан далайн бараан усыг ширтэн удтал суусан бүлгээ.

Тэгж тэгж бослоо. Хэрэв намайг гэртээ очвол хүмүүс эхнэр, хүүхдийг минь харахыг хүснэ. Тэгээд эцэстээ намайг худал ярьсан хэргээр шийтгэх болно. Тиймээс гэртээ харилгүй, Алтан уулын улсаа олъё хэмээн тэр шийджээ.

Эр уул өгсөн алхаж гарав. Тэгж явсаар оройхон нь уулын хэцэд гурван аварга том хүн маргалдан байхтай тааралдав гэнэ. Тэд Конрадыг хараад дуудахад, тэр өөрийг нь идэх нь гэж айжээ. Гэвч тэдний ахмад нь түүнийг тайвшрууллаа.

-Бид нар ах дүүс юм л даа. Аав маань өнгөрсөн долоо хоногт нас барахдаа бидэнд өмч гэрээслэн үлдээсэн юм. Гэтэл бид нар тэр өмчийг яаж хуваахаа мэдэхгүй маргалдаж байна. Жирийн хүмүүс та нар ухаантай байдаг тул чи бидэнд зөвлөгөө өгөөч хэмээн ахмад аврага хүн түүнд хандлаа.

-За тэгье л дээ. Ямар өв өвөлсөн улс вэ дээ? Гэж Конград асуув.

Аварга хүмүүс газар уруу дохихыг нь үзвэл тэнд нь сэлэм, дээл, гутал гурав харагдав гэнэ.

-Энэ чинь нэг их маргалдаад байхаар сүрхий эд юмс биш л байна шүү дээ гэж Конрадыг мөрөө хавчин хэлбэл, аварга хүмүүс толгой сэгсэргээлээ.

-Чи ойлгосонгүй. Эд бол шидэт зүйлс. Чи хэрэв дээлийг өмсвөл харагдахгүй болж хувирна, харин гутлыг углавал хэнд ч гүйцэгдэхгүй. Сэлмийг бариад "минийхээс бусад толгой тасартугай" гэж хэлэхэд бусад бүх хүн үхнэ. Ийм л шидтэй зүйлс дээ гэж тэд яриу.

-За явахав. Тэгвэл би наадуул чинь үнэхээр шаардлага хангаж байгаа эсэхийг шалгаатхая. Дээлээ өгчих гэж Конрадыг хэлэхэд аварга хүмүүс толгой сэгсэрлээ.

-Чи үүнийг өмсөөд зугтаачихвал үзэгдэхгүй болчих учраас бид нар чамайг олохгүй болчихно гэж тэд тайлбарлалаа.

-За тэгвэл маргацгааж л бай даа гэж Конрад хэлээд явахаар зэхэнд аварга хүмүүс шийдвэрээ өөрчиллөө. Тэдний өгсөн дээлийг Конрад өмсөөд харагдахгүй болоход аварга хүмүүс сандралдсан ч хүү дээлийг тайлан дахин харагдахад аварга хүмүүс түүнд бага зэрэг итгэж эхэллээ.

Одоо сэлмийг чинь шалгая гэж дараа нь Конрад өгүүлэв.

Гэтэл хамгийн отгон аварга хүн хүзүүтээ барилан, чи биднийг хүзүүт хяргачихвал яана гэж болгоомжиллоо. Гэвч эцэстээ тэд Конрадад сэлмээ гардуулан зөвхөн модон дээр шалгах хэрэгтэйг сануудлаа. Конрад сэлмийг

аван бүдүүн гэгчийн царс модыг цавчвал нөгөө мод хадууранд өртсөн ширхэг өвс мэт уналаа.

-Дажгүй сэлэм байна. Одоо гутлыг нь үзье гэж Конрад хэлэв.

Аварга хүмүүс дахиад л толгой сэгсэрлээ.

-Чи гутлыг өмсөөд энэ дэлхийн хүссэн газраа очих боломжтой. Чамайг алдчихавал яана гэж аварга хүмүүс ярих.

-Би тэгэхгүй дээ. Би бол нэр төртэй хүн шүү гэж Конрад тайлбарлалаа. Аварга хүмүүс ч гутлаа өгчээ.

Конрад гутлыг өмсөнгүүт, дээлийг ч мөн эгэлдэрэгтээд, сэлмийг шүүрэн авснаар маш хүчтэй, үл үзэгдэгч, санасан газраа хүрдэг хүн болж хувирлаа. Хэдий тэр аварга хүмүүст ам өгсөн ч тэд нарыг харсаар байтал, намайг Алтан ууланд аваачтугай хэмээн ганц хашгираад гялехийн алга болов.

Ийнхүү ганцхан хормын дараа аварга хүмүүсийн шидэт гутлын тусламжтайгаар Конрад Алтан уулын хаант улсад эргэн ирсэн байлаа.

Тэрээр шидэт дээлийг тайлан ордноо чиглэн алхлаа. Хэдий харуй бүрий болж байсан ч ордны бүх цонхиуд гэрэлтэн, дуу хуур сонсогдох авай. Үүнд гайхсан Конрад гахай маллагчийг зогсоон юу болоод байгааг лавлав.

-Хатан хааны хурим болж байна аа. Түүний хуучин нөхөр түүнийг мэхэлсэн бөгөөд одоо нас барсан тул Хатан хаан өөр хүнтэй гэрлэж байгаа юм гэж гахай маллагч хөвгүүн тайлбарлалаа.

Конрад үүнийг сонсоод мөс шиг хөшиж орхилоо.

-Би түүнийг мэхэлсэн гэж үү? Үгүй ээ. Харин тэр намайг мэхлэн унтуулж орхиод зугтан зайлсан. Тэгээд бас одоо өөр хүнтэй сууж байна гэнэ. За яахав та нарт үзүүлдэд өгье л дөө хэмээн тэр цухалдан хашгираа.

Тэр шидэт дээлийг нөмрөн үзэгдэхгүй болоод хурим хийж байгаа танхимд явж орвол идээ будаа дүүрэн ширээний ард гоёмсог ягаан дээл өмсөн хааны титэм духдуулсан Хатан хаан сууж байв. Түүнтэй зэрэгцэн алт, мөнгөөр гоёсон нэгэн хүн байх нь Хатан хаантай гэрлэх гэж буй ноёнтон ажээ.

Конрад сэмхэн гэтсээр гүнжийн яг ард нь очиж зогслоо. Тэгээд гүнжийн ширээн дээр хоол ирэнгүүт нь түүнийг нь авч идээд, дарс ирэнгүүт нь уугаад байлаа. Ингэсээр байтал ирсэн бүх зочид цагалан байхад Хатан хаан өлсгөлөн сэтгэл гонсгор үлдлээ.

Сэтгэл нь тавгүйрхсэн Хатан хаан гарч явахад Конрад ч араас нь даган гарлаа. Нөгөө долоон жилийн өмнө байсан мангасууд эргээд ирэв үү, яв. Намайг аварсан тэр хүн ирсэн юм болов уу гэж Хатан хаан хэлээд мэгшин үйлж байв.

Конрад Хатныг гэнэт алгадан, тийм ээ. Бүтэн гурван шөнө мангасуудын тамлалыг даван чамайг аварсан тэр аврагч чинь би байна. Чи надаас урвасан гэнэ ээ. Би чамайг арай ч ингэхгүй байх гэж бодсон юм хэмээн тэр хашгираа.

Конрад шидэт дээлээ тайлан үзэгдэх болоод хуримын өрөө үрүү гүйн очоод сэлмээрээ аяга тавгийг нураалаа.

-Хурим дууссан. Жинхэнэ Хаан эргэж ирлээ. Тарцгаа хэмээн тэр хашгирлаа.

Гэвч зочид тарсангүй түүнийг шоолон инээлдэв. Хатантай гэрлэж буй ноёнтон түүн үрүү бүр дарсны, шавхруу цэцэн тохуурхахад Конрад улам уурсан, та нар тарах улс уу, үгүй юу? хэмээн дахин хашгирлаа.

Тэгтэл зочид уурлан бүгд сэлмээ сугалан Конрад руу дайрахад,

-Болгоомжтой бай хэмээн Конрад гурвантаа хашгирсан ч хэн ч хайхрахгүй байсан тул, минийхээс бусад толгой тасартугай гэж хашгирлаа.

Ийн хашгиртал тэнд байсан бүх хүмүүсийн толгой тасран уналаа. Хатан Хааны толгой ч бөмбөрөн унаж Конрадын хөлд ойчив.

Ийнхүү Конрад ганцаар ялагч, ганцаар Хаан болсон бөгөөд Алтан уулсын хаант улсын цорын ганц оршин суугч болсон түүхтэй ажээ.



Хатан зөгий

Та нарын эцэг эх, эмээ өвөө, тэд нарын элэнц, хуланц, элэн, хулан ч төрөөгүй аль эргийн цагт гурван хүүтэй нэгэн хаан байжээ. Хүссэн болгоныг нь өгөөд байдаг болохоор ч тэр юмуу хоёр ахмад хөвгүүн нь харамч, ууртай, хэрүүлч бөгөөд харгис хэрцгий хүмүүс болон өсчээ.

Хэдий Хаан хүүхдүүдээ улс орноо удирдах ажилд оролцуулах хүсэлтэй байдаг ч тэр хоёр нь зугаа цэнгээний газар хэсэн, архи ууж, мөрийтэй тоглон сар жилээр хулжиж алга болон, гэртээ ховор үзэгддэг байв.

Гэгэл нэгэнтээ цагаан цайлган сэтгэлтэй, гэнэн санаатайн улмаас Тэнэгхэн гэж нэрлэдэг бага хүү нь гадуур гарч, хоёр ахыгаа хаан аавдаа олж ирье гэж ярьсанд хаан төдийлөн дуртай байсангүй гэнэ.

Хүмүүс түүнийг элэглэн,

-Ха ха ха. Чи мөн ах нарыгаа олно байх даа. Өмссөн малгайгаа олж чадахгүй амьтан байж хэмээн инээлдэх ажээ.

Гэвч Тэнэгхэн хүү түүнийг хайхарсангүй замд гарч олон хоног бэдэрсний эцэст дэлхийн хамгийн захад хоёр ах нь мөрийтэй тоглоомны газар байж байхыг арайхийн олов гэнэ. Гэгэл тэр хоёр нь мөн л бусад хүмүүсийн адил дүүгээ тохуурхаж эхлэв.

Чи юугаа хийж энд яваа юм? Чи үхвэл таарна. Бид залуу байгаа дээрээ жаргаж цэнгэж авах гэж байна хэмээн тэд хэлэв.

Хоёр ах нь ингэж хэлээд цааш тэнүүчлэн одоход Тэнэгхэн тэднээс сөөм ч хочрохгүй олон хоногийг турш дагасаар байлаа.

Тэгж яваад хоёр ах нь талд байсан шоргоолжны үүрийг олоод мод аван нөгөөх үүрийг сэндийлж гарсанд Тэнэгхэн дүү нь тэднийг хориглов.

-Хөөрхий шавжнуудыг зүгээр орхи. Та хоёрт гэм хийгээгүй биз дээ хэмээн

тэр ах нартаа хэллээ. Тэр хэдий тэнэг хочтой ч хүч чадалтай хөвгүүн байсан тул ах нарыгаа шоргоолны үүр сүйтгэхийг болиулж чаджээ.

Тэгээд цааш явж байтал нэгэн гол дайралдав гэнэ. Тэр голд эх нугас, эр нугасны хамт ангаахайнууддаа үүр засан амьдарч байв гэнэ. Гэтэл ах нар нь энэ муу ангаахайнуудыг алаад орхиё. Нугаснууд яахыг нь үзье гэж хашгиралдлаа.

Тэгтэл Тэнэгхэн уурсаж, хэрэв ангаахайнуудыг алах юм бол би та хоёрыг ална шүү. Намайг байгаа цагт наадуул чинь усандаа тайван шумбах болно гэж хатуу сануулжээ.

Хоёр ах нь хэдий маш дургүй байсан ч Тэнэгхэн бяр тэнхээтэй тул дэмий л амандаа хараал тавин цааш явцгаалаа.

Ойд орж очтол нэгэн зогийний үүр тааралдав. Үүрэнд дүүрэн бал байх бөгөөд модноос урсан хорхой хүргэм ажээ. Хоёр ах нь гал шатаан зогийнүүдийг алж балыг нь идье хэмээсэн ч энэ удаа Тэнэгхэн бас л зогсоолоо.

-Энэ балыг зогийнүүд зулзганууддаа өгдөг юм. Зулзаганууд амьдрах ёстой. Бидэнтэй адилхан амьд амьтад шүү дээ гэж Тэнэгхэн хэлсэнд ах нар нь аргагүйн эрхэнд бууж өгчээ.

Тэр орой ах дүү гурав нэгэн цайзад хүрч очлоо. Тэд цайзанд дөхөн очвол гадаа нь чулуун цэргүүд зогсох аж. Малынх нь хашаанд орвол тэнд байгаа бүх мал амьтад чулуу төдийгүй ордон доорх бүх хүн ч чулуу байв. Тэнд чулуун хаан, хатан, зарц, шивэгчин тэр бүү хэл чулуун элчин сайд хүртэл байсан гээд бод доо.

Ах дүү нар чулуун шатаар өгсөн дээш гарвал ор дэр, тавилга хогшдууд нь ч чулуу байв. Харин тэд цайзны мухрын нэгэн өрөө гурван давхар цоожтой байхыг үзээд түүн дээр очин цоожны нүхээр нь шагайвал нэгэн хүн тэр өрөөн дотор чулуун орон дээр хэвтэж байх юм гэнэ.

Ах дүү нар түүнийг дуудахад нөгөөх эр сонссонгүй. Хоёр дахь удаагаа ч мөн л дуулсангүй. Тэгж тэгж гурав дахиа дуудуулан байж аажуухан өндийгөөд хаалга руу хүндээр, удаан, хөшүүн алхсаар дөхөж ирэв. Харвал тэр хүний нүүр царай нь хувхай цайвар, харц нь барималынх мэт царцанги ажгуу.

Энэхүү хачирхалтай хүн ах дүү гурвыг нэг ч үг хэлэлгүй өрөөнд дагуулан ороход хоол унд пиг өрөөстэй ширээ харагдлаа. Гэвч тэрхүү хоол унд бас л чулуу байх юм гэнэ. Ах дүү нар үүнийг гайхан толгой сэгсрэн зогссон бөгөөд эцэстэй нөгөө хүний заасан унтлагын өрөөнүүдэд орж унтацгаажээ. Гэхдээ төдийлөн сайн унтаж чадсангүй. Учир нь ор, дэр нь ч бас чулуу юм чинь.

Маргааш өглөө нь нөгөө хүн хамгийн ахмад хөвгүүнийг булшин дээр аваачив. Булшин дээр гурван өгүүлбэр сийлсэн байх агаад эхний өгүүлбэр нь:

Ойн гүн дэх хөвдөн дор мянган ширхэг сувд буй. Хэн нэгэн хүн тэр сувдыг олвоос энэ ордын илбийн хүч арилах бөгөөд тэрхүү сувд ологч хүн Хааны гүнжтэй гэрлэх болно. Гэхдээ сувдыг нар жаргахаас өмнө олохгүй бол тэр

хайгч хүн ч гэсэн чулуу болон хувирах болно гэсэн байв.

Ахмад хөвгүүн тэр дороо ой руу гүйсэн боловч нар жаргахад зөвхөн нэг зуухан сувд олсон тул чулуу болон хувирлаа.

Маргааш нь хоёр дахь ах мөн л азаа үзсэн боловч хоёр зуухныг л цуглуулж чадсан тул бас л чулуу боллоо.

Гуравдахь өдөр Тэнэгхэний ээлж ирлээ. Тэр ой уруу очин хөвдөн доогуур хайсаар орой болохын хирд зөвхөн гурван зуухан сувд л олжээ. Тэр толгой унжуулан сууж чулуу болон хөшсөн ах нараа гунигтайгаар ширтлээ. Гэтэл гэнэт шажиганан шужиганан чимээ сонсоод толгой өргөн харвал шоргоолжны хаан ах нарынх нь гараас аврагдсан шоргоолжин армия дагуулан нүүгэлтэн нүүдэллэж явах нь тэр. Шоргоолжнууд хөвдөн доогуур шурган ороод нар жаргахан өмнө мянган сувдыг нэгд нэгэнгүй түүн Тэнэгхэнд авчирч өгөв.

Тэнэгхэн нөгөө цайзан дахь хүнд мянган сувдыг авчиртал тэрээр түүнийг оршуулан дээр дахин аваачихад булшин дээр бас нэгэн бичээс байв. Тэнд:

Гурван гүнж ордон дотор түгжээтэй байгаа бөгөөд түлхүүр нь хаант улсын хамгийн том нуурын ёроолд бий. Хэрэв тэр түлхүүрийг олохгүй аваас гүнж нар тэндээ үүрд үлдэх болно гэжээ.

Тэнэгхэн нуур уруу гүйж очин шумбалаа. Гэвч нуурын ёроол шавар шавхай болон замгаар бүрхэгдсэн тул түлхүүрийг олох ямар ч найдваргүй харагдаж байв. Тэрээр ийн бодож байтал гуагалах чимээ дуудлан мянга мянган нугас ангахайнуудыг нь аюулаас аварсан нугасны Хатан хаанаар удирдуулан нисэч ирээд нуурын усыг бүрхэн буужээ.

Нугаснууд ус уруу шунган ороод ёроолыг нь нэгжиж, нар жаргахаас өмнө түлхүүрийг Тэнэгхэнд авчирч өглөө. Тэрээр ордон уруу буцан, түлхүүрийг нөгөө хүнд өгсөн боловч түүний үүрэг үүгээр дуусаагүй байжээ. Учир нь маргааш өглөө нь булшин дээр дахин очвол бас нэгэн өгүүлбэр байв.

Гүнжүүд өрөөндөө бий. Чи гэднээс хамгийн залуухан, хамгийн үзэсгэлэнтэйг нь олж үнсэх ёстой. Хэрэв андуурвал чи чулуу болон хувирна гэж тэнд бичсэн байх ажээ.

Тэнэгхэн ордон уруу гүйж хүрээд түлхүүрээр хаалгыг онгойлгон орлоо. Уг нь тэр хамгийн залуу үзэсгэлэнт гүнжийг дор нь олно гэж бодож байж. Гэвч энэ бол амаргүй даваа гэдгийг тэр ойлгов. Учир нь гурван чулуун гүнжийн нүүр царай ялгагдах юмгүй адилхан байх нь тэр.

Тэнэгхэн бүгдийнх нь дээрээс тонгойсон боловч хэнийг нь үнсэж зүрхэлсэнгүй.

Хэрэв би бурууг нь үнсчихвэл чулуу болох биз хэмээн тэр өөрөө өөртөө хэлж байв.


Орой хариугүй харанхуй болохын өмнөхөн сүргийг нь Тэнэгхэн аварсныг мартаагүй Зөгийн Хатан хаан цонхоор нисэн орж ирлээ.

Тэр зөгий эгч дүү гурвын уруулыг үнэртлээ. Учир нь эгч дүү гурван гүнж чулуу болохынхоо өмнө амттан идсэн байж. Тэгэхэд хамгийн ахмад нь элсэн чихэр, хоёр дахь гүнж амтаг ундаа ууж харин хамгийн отгон нь бал идсэн ажээ.

Ийм учраас зөгий тэдний үнэрээр нь бал идсэн хамгийн отгон гүнжийг танилаа. Тэнэгхэн тонгойн гүнжийг үнсвэл тэр гүнж болон бусад бүх хүмүүс, хатан, ноён гээд хамаг бүгдээрээ амь орлоо.

Ийнхүү үлгэр амар сайхан жаргаж байна. Мэдээж Тэнэгхэн хайртай гүнжтэйгээ гэрлэн эрх мэдэлтэй хаан болсон байна. Харин нөгөө хоёр ах нь хоёр эгч гүнжтэй гэрлэцгээсэн боловч тэд нар нь тун удалгүй ааштай бүдүүн авгай нар болон хувирч хөөрхий хоёрыг насаар нь зовоосон гэдэг.

Сайн санааны үзүүрт шар тос гэдэг үнэхээр үнэн билээ.



Ойд амьдрагч гурван одой хүний тухай үлгэр

Ширэнгэ хар ойн захад эхнэр нь нас барсан нэгэн эр амьдарч байв. Мөн түүнээс халгүйхэн нөхөр нь талийгаач болсон нэгэн эмэгтэй бас суудаг байж гэнэ. Эрэгтэй нь Фреда, эмэгтэй нь Элза гэдэг охинтой юм санж. Элза, Фреда хоёр уулзаж учирсаар улмаар найз нөхөд болцгоожээ.

Тэр хоёр нэгэн өдөр бэлэвсэн эхнэрийн гэрт тоглож байтал мөнөөх эхнэр хэлжээ.

-Хонгорхон Фреда минь! Чи аавдаа очиж намайг өөртэй нь амьдран суух хүсэлтэй байгааг минь дамжуулж өг. Хэрэв би аавын чинь эхнэр болох юм бол чамайг сүүнд оруулж, сайн дарс уулгана. Харин миний өөрийн охин хүйтэн усанд биеэ угааж шар айраг уух болно гэдгийг ч бас хэлээрэй.

Бэлэвсэн эхнэр ийн яриад Фредагийн үсийг илбэн бялуу өгчээ. Тэр эхнэр хүнийг яаж уяраахаа мэддэг хүн байв.

Фреда гэртээ хариад энэ тухай аавдаа хэлбэл аав нь гал ширтэн удтал дуугүй суулаа.

Гэрлэнэ гэдэг хараал ч байж мэднэ, ерөөл ч байж мэднэ. Уг нь надад эхнэр, чамд ээж хэрэгтэй л дээ гээд тэр чимээгүй болов.

Мань эр шөнөжин бодол болж нойргүй хоноод өглөө нь охиндоо,

-За чи энэ гутлыг авч яваад улыг нь хадаасаар шоол. Тэгээд модноос өлгөж байгаад ус хийж үзээрэй. Хэрэв ус гутал дотор тогтвол би тэр эхнэртэй гэрлэнэ, харин ус хадаасны нүхээр гоожвол гэрлэхгүй гэж хэлж гэнэ.

Фреда гадагш хашаан дотроо очоод гутлын улыг цоолон дотор нь ус хийжээ. Гэхдээ гутлыг хойш нь хазайлгасан тул ус улны цоорхойгоор гоожсонгүй харин өсгийн хэсэгт тогтжээ. Фреда ингээд үүнийгээ аавдаа харуулжээ.

-За яахав. Тэгвэл ингэж л шийдье хэмээн эцэг нь дуугарлаа.

Эр, эм хоёр гурван долоо хоногийн дараа хуримаа хийв. Хурим хийсний дараа охидууд биеэ угаахаар очиход Фредагийн саванд сүү, Элзагийн саванд хүйтэн ус байж. Хооллох болоход Фредад сайхан дарс, Элзад муухан шар айраг оногджээ. Ийн хоёрхон хоноод байдал эсрэгээр эргэв. Юу гэвэл гурав дахь өдрөөс хойш Фреда хүйтэн усанд орж, муу шар айраг уух боллоо. Харин эмэгтэйн охин Элза сүүнд булхан, амттаныг зооглох ажээ.

Эмэгтэй хоёр охинд ийн маш ялгаатай хандаж эхлэв. Хөөрхий Фреда хойд эхийн заавраар хамаг хүнд ажлыг хийн борви бохисхийлгүй ажиллаж, хоолны шавхруугаар гол зогоож байхад, харгис эмэгтэйн төрсөн охин Элза үд хүртэл орондоо бялуу идэн хэвтэх бүлгээ.

Аав нь охиноо хамгаалахыг оролдсон ч хахир хатуу эхнэр түүнтэй өдөржин шөнөжин хэрэлдэж, үглэж янших тул Фредагийн аав сүүлдээ залхаад гэрээсээ аль болох хол хөндий байх болов.

Намар өнгөрч байхад ээж, охин хоёр Фредаг улам ихээр үзэн ядах болов. Учир нь Фреда өдөр ирэх тусам үзэсгэлэнтэй хөөрхөн бүсгүй болон өсөж байв. Фреда сайхан сэтгэлтэй царайлаг, харин Эльза үзэмжгүй, муухай ааштай нэгэн болон өсч байв.

Өвөл боллоо. Тэр өвөл хахир хатуу, маш хүйтэн, цас ихтэй байсан бөгөөд мод, бутнаас мөсөн цацаг унжих бүлгээ. Гэтэл нэгэн өдөр хойд эх нь Фредад цаасан дээл өмсгөөд хэлж байх юм гэнэ.

-Ой уруу явж зэрлэг гүзээлгэнэ түүж ир. Би хавьд идсэнгүй гэж л дээ.

-Зэрлэг гүзээлгэнэ гэнэ ээ? Хэмээн Фреда гайхаад, одоо өвөл гүзээлгэнэ хөлдөөд төмөр шиг хатуу болчихсон байгаа. Тэгээд ч цаасан хувцастай явбал модонд онгилогдоод салхинд хийсээд би хөлдөж үхнэ гэж учирлалаа.

-Юу гэнэ ээ чи? Миний өмнөөс эсэргүүцнэ гэнэ ээ.

Хойт эх нь ийн хашгираад охиныг алгадан түлхэж Миний хэлснээр хурдан яв. Эс тэгвэл чамайг бүр хөл нүцгэн явуулна шүү. Гүзээлгэнэ олж ирэхгүй бол хохь чинь шүү хэмээн тачигнав.

Тэр Фредаг хаалгаар түлхэн гаргаад араас нь хатсан талх шидэж, энэ хоол чинь шүү гэлээ.

Хойт эх өөрийн охинтойгоо, Фредаг ийн хөөж явуулчихаад элгээ эвхэн, галд дулаацан халуун гэртээ үлдлээ. Фреда хөлдөөд үхэхээр бид хоёр энэ гэрийн бүх юмны эзэн болно гэж тэд ярилцан суулаа.

Харин хөөрхий Фреда хүйтэн ойд хөр цас туулан алхах ажээ. Маш хүйтэн байсан учраас чоно хүртэл үүрнээсээ хоншоороо цухуйлгаж чалахгүй байв. Охины өмссөн цаасан дээл модны мөчирт урагдан түүгээр нь хүйтэн салхи сийгэн амь алдахад ойрхон болов. Гэсэн ч азаар замд нь нэгэн бяцхан байшин харагдан, тэр байшингийн цонхоор гурван одой хүн түүнийг ширтэж байхтай

охин тааралдлаа.

Фреда хаалгыг нь тогшин орвол нөгөөх эрчүүд,

-Охин минь ор ор, зуухны дэргэд сууж дулаац хэмээн хашгиралдлаа.

Фреда гараа дулаацуулаад хатсан талхаа гарган идэхээр зэхлээ. Бяцхан эрчүүд түүнийг харж байснаа нэг нь,

-Охин минь, бид нар хоолгүй болчихсон юм л даа. Бидэнд талхнаасаа жаахан өгөхгүй юу гэж гуйлаа.

-Тэгэлгүй яахав, тэгэлгүй яахав. Уулаасаа бага л юм. Хуваагаад идэжгээ хэмээн Фреда хэлээд талхаа хуваан одой нарт өгөхөд тэд дуртайяа идэжгээх ажээ.

Тэгж байснаа тэдний хамгийн ахмад нь урагш бөхийж,

-Жаахан охин минь! Чи энэ хар хүйтэнд цаасан дээлтэй юугаа хийж явдаг байна? гэж асуулаа.

-Би зэрлэг гүзээлзгэнэ түүхээр явж байна аа.

-Гүзээлзгэнэ ий? Энэ хар өвлөөр үү?

-Хэрэв би гүзээлзгэнэ олохгүй бол гэртээ орж чадахгүй юм аа.

Одой хүмүүс бие бие үрүүгээ харсны дараа хамгийн отгон нь,

-Хонгор минь, чи гараад хашааны цасыг цэвэрлээд өгөхгүй юу гэлээ.

Фреда хормойноосоо талхны үртсийг сэгсэрч орхиод босон шүүр авч гадагш гарахад, хамгийн ахмад одой эхлэн ам нээлээ.

-Энэ бол их сайн охин байна. Тэр хэдий өөрт нь хүрэлцэхгүй байсан ч талхаа бидэнтэнтэй хуваалцлаа. Бас цасыг маань цэвэрлэж өгч байна. Тийм болохоор бид түүнд бэлэг өгөх хэрэгтэй. Би охиныг өдөр ирэх тугуам улам үзэсгэлэнтэй болох бэлэг өгч байна хэмээн тэр өгүүллээ.

-Миний бэлэг бол тэр хаантай гэрлэг гэж хоёр дахь бяцхан хүн хэлэхэд, хамгийн отгон нь түүнийг үг хэлэх болгонд амнаас нь алт унах болно. Энэ нь миний бэлэг юм гэлээ.

Бяцхан эрчүүдийг тийн ярилцаж байхад Фреда хашааны цасыг арилгаж байгаад цасан дор ув улаахан зэрлэг гүзээлзгэнэ ургасан байхыг олоод түүнийг түүж авлаа. Дараа нь тэр гурван бяцхан хүнд талархал илэрхийлэн тэднийг үнсээд гэр лүүгээ яарлаа.

Фреда гэртээ оронгуутаа,

-Оройн мэнд! хэмээтэл амнаас нь алтны ширхэг унах нь тэр. Тэр хойд эх, Эльза хоёрт юу тохиолдсоныг бүгдийг ярьж өглөө. Тийнхүү ярихад үг болгоных нь дараа алт амнаас нь унах аж. Эльза түүнд атаархан,

-Зүгээр байж байгаад л мөнгө унаад байна шүү дээ, энүүнээс. Хурдан зайл чи тарган муур минь хэмээн шал дэвслэн хашгирчээ.

Фреда байшингийн дээвэрт орших орондоо орж унтахаар явж, ээж охин хоёр үлдлээ.

-Би маргааш ой уруу явлаа. Эргэж ирэхэд минь амнаас алт унадаг болсон байна даа гэж Эльза өгүүллээ. Харин гадаа дэндүү хүйтэн байгаа тул яваад хэрэг байна уу даа, остгох юм биш үү хэмээн ээж нь хориглолоо.

Гэвч Эльза бодлоосоо буцсангүй,

-Би явна, заавал явна хэмээн бархирсан бүлгээ.

Маргааш нь ээж нь Эльзад ангийн үсэн дээл, өвлийн гутал, малгай, гутал өмсүүлэн томоос том бялуу, боов, өндөг, дарс өгч явууллаа.

Эльза их хувцсандаа түүртсээр ой уруу явж одлоо. Тэрээр явсаар мөнөөх байшинд очиход гурван бяцхан эр цонхоор харан зогсох нь үзэгдэв. Эльза хаалгыг нь ч тогшонгүй давхиж орон зуухны дэргэд суугаад хоолоо идэж гарав.

Одой нар түүнийг хэсэг харж байснаа ахмад нь ам нээж,

-Охин минь, бидэнтэй идэх юмнаасаа хуваалцаач гэлээ.

-Үгүй ер өө. Надад өөрт ч хүрэхгүй байна. Та нар өөрсдийнхөө хоолыг идэхгүй юу хэмээн Эльза толгой хялан хэлээд тэр их хоолыг ганцаараа хахаж цацан идэж дуусгав.

Тэгтэл отгон одой урагш бөхийж,

-Хонгор минь. Цас их орсон тул бид хүчрэхгүй юм. Чи манай хашааны цасыг цэвэрлээд өгнө үү гэлээ.

Эльза өнөөх одой хүн үрүү дээрэлхүү гэгч нь ширтэж, би чиний хонгор юм уу. Тэгээд ч би ямар зарц биш. Та нар цасаа өөрснөө цэвэрлэнэ биз. Намайг хатагтай гэж дуудвал зохино гэж тачигналаа.

Тэгснээ гүзээлзгэнэ олохоор гадагш гарахад гурван одой хүн биенийгээ ээлжлэн харлаа.

-Яасан муухай биеэ тоосон өөдгүй охин бэ. Бид түүнд ч бас бэлэг өгье л дөө. Энэ охин өдөр бүр улам муухай царайтай болох болно хэмээн ахмад одой яриу.

-Би ч гэсэн бэлэг өглөө.Тэр адгийн муугаар үхэх болно хэмээн хоёр дахь нь үргэлжлүүдэхэд, гурав дахь нь ам нээж, энэ охин үг хэлэх болгонд цадиггүй амнаас нь мэлхий унана гэж амлалаа.

Эльза байшингийн гадуур гүзээлзгэнэ хайж баахан явсан ч юу ч олдсонгүй. Гэхдээ үүндээ ч гутарсангүй нөгөө хүмүүст баяртай ч гэж хэлэлгүй гэр лүүгээ зүглэв. Гэртээ ирээд ам нээтэл амнаас нь мэлхий үсрэн гарч ирэх нь тэр.

Тэр өдрөөс хойш Эльза улам царай муутай болсоор, үг хэлэх болгонд амнаас нь мэлхий унадаг болсон тул хүн болгон түүнээс зугтах болжээ. Харин ээж нь улам гоё болсоор буй Фредад өшин хорсож байлаа. Тэгсээр өвлийн эцсээр Фредаг хороох аргыг тэр эхнэр бодож олсон байна.

Маргааш нь тэр том саванд ус буцалган дотор нь хувцас хунар хийгээд Фредаг дуудлаа.

-Энэ савтай усыг гол уруу аваад яв. Тэгээд хувцсыг сайн угаахын тулд голын дунд нь очиж ширүүн урсгалд нь сайн булхуул гэж тэр тушаалаа.

-Болохгүй шүү дээ. Одоо голын ус нимгэн байгаа юм чинь дунд нь очвол ус цөмөрч би живж үхэх байх хэмээн Фреда болгоомжиллоо. Гэвч хойт эх нь уурсан хашгирлаа.

-Тэнэг минь! Чи өмнө нь зөндөө яваа биз дээ. Явахгүй бол чам уруу буцламгай ус цацлаа шүү гэхэд Фреда халуун устай савыг барин гол уруу одлоо.

Харин Фредаг гол дээр очиход халуун устай саванд голын мөс гэсэн цөмөрч, охин живж үхэх нь баараггүй гэж бодсон хойт эх баярлан инээд алдаж байв.

Фреда голын зах уруу орж явтал голын эргээр нэгэн сүйх тэрэг довтолгож явсан нь хаан заларч явсан юм байжээ.

Хаан үзэсгэлэнтэй сайхан охин голын нимгэн мөсөн дээгүүр явахыг хараад түүнийг зогсоож өөр дээрээ авчрахыг хөтөчдөө тушаав.Түүнийг авчрахад хаан ийм хүйтэн өдөр юу хийж яваг нь лавлаад түүнээс эхнэрээ болохыг хүсэв. Фреда хэднй ичингүйрэн улайсан ч зөвшөөрсөн агаад Хааны хурим нижгэр сайхан болж өнгөрчээ.

Нэг жилийн хойно шинэ Хатан хаан хүүхэд төрүүллэв. Хойт эх нь энэ тухай сураг сонсоод улам их атаархлаа. Тэр нэгэн өдөр хамаг өнгөтэй өөдтэйгөө өмсөн, охин Эльзагаа мөн тэгж хувцаслаад хааны ордонд очлоо.

-Өнгөрсөн юм өнгөрснөөрөө болог. Би чамд гомдох юм байхгүй гэж тэр зальт авгай Фредад хэллээ.

Фреда үүнд нь баярлалаа хэмээн инээмсэглэн хариулжээ.

Тэр хоёр түүнээс хойш Фредаг хорлох гэж өдөр шөнөгүй бодож байсан ч боломж олдохгүй л байлаа. Учир нь Хаан үргэлж түүнтэй хамт байх ажээ. Гэвч Хаан өөр улсын хаантай уулзахаар явахад хоёр эмэгтэй муухай санаагаа гүйцэлдүүллээ.Тэр хоёр Хатан хааны өрөө үрүү сэмхэн гэтэж очоод Фредаг хөл толгойноос нь дамжлан цонхоор гаргаж ордон тойрсон устай шуудуу уруу чулууджээ.

-Муу хогоос арайхийн саллаа хэмээн хойд эх энэ үеэр баярлан хашгирчээ.

Тэгээд Эльзагийн хувцсыг тайлан Хааны оронд хэвтүүлээд хаан ирвэл нэг ч үг дуугарч болохгүй шүү гэж захилаа. Хаан шөнө дунд гэртээ ирээд эхнэртэйгээ ярих гэсэн боловч цаадах нь дуугарсангүй.

Энэ үеэр хойд эх түүнд хандан, өнөөдөр Хатан хаан ядарсан байх. Жаахан амраа түүнийг гэж хэлэхэд Хаан үгэнд нь үнэмшин албан өрөө үрүүгээ явж олов.

Гэвч маргааш өглөө нь эхнэрээ гэж бодсон хүнтэй ярилцав. Эльзаа нүүрнийхээ гивлүүрийг сөхөлгүйгээр түүнтэй ярилцахад мэлхийнүүд үсрэн гарч орны бүтээлэг дээр унах ажээ.

Хаан үүнд гайхан цочирдсон ч хойт эх түүнийг хойш нь татаж, өнгөрсөн шөнө Хатан Хаан өвчилсөн. Энэ мэлхийнүүд өвчний улмаас ингэж байгаа юм гэж тайлбарласанд хаан үнэмшин албан өрөө үрүүгээ явлаа.

Эх охин хоёр ард нь инээлддээр хоцров.

Маргааш өглөө нь тогооч хөвгүүн ордон тойрсон устай шуудуунд хөвөх нугасыг олж үзлээ. Тэр нугас шар хушуугаа ангайлган түүн рүү гаагалаад

-Гаага, гаага, гаага бяцхан тогооч хөвгүүн минь. Хаантан одоо юу хийж байна? Унтаж байна уу? Сэрүүн байна уу? гэлээ.

Мэл гайхсан тогооч хөвгүүн үг ч дуугарч чадалгүй зогсож байтал мөнөөх нугас дахин дуугарч байна гэнэ.

-Гаага, гаага, гаага бяцхан тогооч хөвгүүн минь, зочид одоо юу хийж байна? Унтаж байна уу? сэрүүн байна уу? гэх юм гэнэ.

Тогооч хөвгүүн доош тонгойж,

Бяцхан нугасхан минь, нугас минь. Тэд одоо унтаж байна гэж хариулахад нугас өмнөөс нь толгойгоо шомболзуулан

-Гаага, гаага, гаага, бяцхан тогооч хөвгүүн минь. Зочид одоо юу хийж байна? Унтаж байна уу? сэрүүн байна уу? гэлээ.

Тогооч хөвгүүн нугасанд талхны үйрмэг хаяж өгөөд,

Бяцхан нугасхан минь, нугас минь

Тэр өлгийдөө унтаж байна хэмээн хариуллаа.

Нугас цааш хөвөн одсон боловч шөнө нь хүүхдийн өрөөнд эргэж ирлээ. Тэр хүүхдийг угжин, ор дэрийг нь хуурайлаад шуудуу уруугаа буцан нислээ. Дараа шөнө нь дахин ирж мөн л тэгсэн боловч харин гурав дахь шөнөө тогооч хөвгүүнийг дуудан, хааныг сэлэмтэй нь авч ирүүлэхийг хүслээ.

Хааныг ирэхэд нугас түүнээс хүзүүг нь сэлмээрээ гурван удаа цавчихыг хүслээ. Хаан хэлснээр нь хийтэл нугас гэнэт Хатан хаан болон хувирлаа.

Фреда юу болсныг Хаанд хэлсэн бөгөөд түр зуур ордон дотор нуугдсан байна.

Хаан хэд хоногийн дараа хойд эх, Эльза хоёрыг дуудан ирүүлээд асуулаа.

-Би нэг хэрэг шүүх болоод байна. Хоёр гэмт этгээд гэмгүй эмэгтэйг гол уруу живүүлж алсан байна. Тэднийг яаж шийтгэх вэ? гэж Хаан асуув.

Хойд эх дарс залгилснаа, тэднийг шийтгэх шийтгэл тодорхой. Тэдний хүзүүнээс төмөр дөнгө зүүгээд уулнаас доош өнхрүүлэх хэрэгтэй гэж хэллээ.

-Тэднийг өршөөх хэрэг байна уу? хэмээн Хаан лавлахад эх, охин хоёр ялааа гэж, ёстой өршөөж болохгүй хэмээн нэгэн дуугаар хэлцгээв.

-За тэгвэл та хоёр өөрсдийнхөө ялыг өөрсдөө тогтоолоо гэж Хаан эцэст нь хэллээ.

Түүний тушаасан ёсоор эх, охин хоёрын хүзүүнд төмөр дөнгө зүүгээд уулын уруу гол уруу өнхрүүлэн живүүлж цаазалжээ.

Ийнхүү мөнөөх гурван одойн хэлсэн үг бүрэн биелэгдлээ. Фреда Хаантай гэрлэсэн бол Эльза гутамшигтайгаар үхлээ.

Фреда одой эрчүүдийг ордондоо ирж амьдрахыг гуйсан ч тэд ойн бяцхан байшингаасаа холдохыг хүссэнгүй. Харин нөгөө тогооч хөвгүүн гүн цолтой болсон ба хожим Хатан хаан Фредагийн охин гүнжтэй гэрлэн Хаан болсон байна.

Тэр хаан гүнжийгээ нугасны дэгдээхий гэж дууддаг байсан юм гэнэ билээ.



Үнсгэлжин

Уул, тал хоёр хэзээ ч уулзахгүй гэж хуучны үгэнд байдаг нь ядуус ба баячууд хэзээ ч нэгдэхгүй гэсэн утгатай билээ. Гэхдээ энэ үлгэрээс хуучны тэр үг хуудуутай байдаг нь харагддаг билээ.

Нэгэн баян чинээлэг эр эхнэрийн хамт амьдардаг байж. Тэд олон жил хамт амьдарсны эцэст эхнэр нь хүнд өвчинд нэрвэгдэн хариугүй нас барах болж. Тэгээд нас барахынхаа өмнөхөн хайртай ганц охиноо дуудан ирүүлжээ.

-Хонгор үр минь! Бид хоёр энэ хорвоод дахин хамт байх аргагүй боллоо. Гэвч чи сайхан сэтгэлтэй байх юм бол бурхан чамайг хамгаалж, би чамайг тэнгэрээс харж явах болно гэж ээж нь хэлээд талийгаач болжээ.

Охин өдөр бүхэн ээжийнхээ булшийг эргэн гашуудан уйлдаг ч ээжийнхээ захиснаар хүмүүст сайн сайхан ханддаг байлаа.

Өвөл болж, булш цасан бүтээлэгтэй болоод дараа нь хавар ирж цас хайлахад аав нь өөр эхнэр авлаа.

Шинэ эхнэр хоёр охинтой байв. Тэд ээжийгээ дуурайсан царайлаг боловч муу санаатай, муухай ааштай охид байсан бөгөөд хойд дүү нь сайхан сэтгэлтэй, өгөөмөр, нинжин байсан учраас түүнийг үзэн ядаж эхэлжээ. Атаархал хадыг ч хайлуулах хор гаргадаг гэхчлэн тэд охинд дайсагнаж байв.

-Энэ бидэнтэй хамт том өрөөнд амьдраад байхдаа яахав дээ. Явж тэр гал зуухны аяга таваг угаадаг өрөөнд оч хэмээн тэд шаардах аж. Тэр хоёр мөн түүний хувцсыг нь булаан авч оронд нь ноорхой дээл, модон ултай майжгийг шаахай өмсүүлдэд шоолон инээлдэж,

-Ямар хөөрхөн гүнж вэ? Ямар хувцас өмсчихсөн байна аа? хэмээн хөхрөлдөж байв. Тэд хэдий өөрсдөө хуруугаа ч хөдөлгөдөггүй боловч, охинд,

-Гал зууханд очиж төмс арилгахгүй бол хоол өгөхгүй шүү хэмээн сүрдүүлэх

бүлгээ.

Сүүлдээ охин хамаг хүнд хүчир ажлыг ганцаар хийх боллоо. Тэрээр ус зөөж, түүдээ бэлтгэж, хоол хүнс төхөөрөн, гэр орноо цэвэрлэн борви бохисхийлгүй хөдөлмөрлөх авай.

Тэгдээ ч гэсэн эгч дүү хоёрын сэтгэл ханахгүй түүнийг улам хорлон тохуурахах нь даанч хэцүү. Жишээлбэл тэр хоёр түүний цэвэрлэсэн шалан дээгүүр шавхайтай гутлаараа зориуд туучих буюу гал зуухны хогийн савыг хөмрөн доторхыг нь тараан асгах мэтээр аашилна.

Гэд түүнийг өөрийн гэсэн ортой байхыг ч зөвшөөрөөгүй тул охин аргагүйн эрхэнд зуухны өмнөх үнс нурам болсон талбайд унтах болов. Охин шөнөд нь ээжийгээ зүүдлэн уйлахад нулимс нь үнс нурманд даруулсан нүүрийг нь даган урсаж өглөө нь халтайсан амьтан босч ирдэг байв. Үүнийг үзсэн эгч дүү хоёр шоолон инээлдэж,

-Чи муур шиг харагдаж байна. Яг л нүүр цоохор муур гэсэн үг гэгцгээх агаад охины үс үнсэнд байнга дарагдсан байдаг тул түүнийг Үнсгэлжин гэж хочлох боллоо.

Нэг өдөр аав нь зах уруу явахдаа хоёр дагавар охиноосоо юу захихыг асуулаа.

-Өө. Надад шинэ дээл хийх гоё торго авчраарай. Би хуучин хувцаснаасаа бүр уйдаж гүйцээд байна гэж хамгийн ахмад охин дээл нь бараг шинэ байсаар байхад хэлсэн бол дүү нь толинд цагаан хүзүүгээ харан эргэлдэнээ,

-Надад хүзүүний зүүлт хэрэгтэй байна гэж урваганалаа. Гэхдээ тэр хааны төлөөсөнд өгсөн ч болохоор их гоёлтой байсан гэдгийг бас хэлье.

-Харин чи юу захих вэ? гэж аав нь Үнсгэлжингээс лавлав.

Шал зүлгэж байсан Үнсгэлжин сая л толгой өндийлгөж,

-Аав аа та, гэртээ ирэх замдаа малгайд чинь тээглэсэн хамгийн эхний модны мөчрийг аваад ирээрэй гэлээ.

Аав нь зах орж торго, хүзүүний сувдан зүүлт худалдаж авлаа. Буцаж явах замдаа ойн зөргөөр морьтой явж байтал нэгэн самрын мод малгайд нь шүргэхэд Үнсгэлжингийн захиа санан нэгэн мөчир авч харив. Эгч нар нь унтлагынхаа өрөөнд гүйж орон дээлийг өмсөн, зүүлтийг зүүж өөрсдийнхөө гоё сайхныг гайхан толны өмнө эргэлдэж эхлэв. Харин Үнсгэлжин ээжийнхээ булшин дээр очин самрын модны мөчрийг суулгаад урсах нулимсаараа усалж байв.

Зовлонгоос жаргал ч үүсч болдог болохоор мөнөөх самрын модны мөчир сайхан ургаж саглагар өтгөн мод болон дэлгэрчээ. Тэрхүү модон дээр нэгэн бяцхан цагаан шувуу ирж суугаад охинд дуулж өгдөг болжээ.

Зун нь улсын хаан хаан ширээнд суусныхаа тавин жилийн ойг тэмдэглэн гурав хоногийн баяр тэмдэглэх шийдвэр гаргалаа.

Хааны хүү эхнэрээ сонгох тул эзэнт улсын бүх охидууд баярын бүжгэнд

оролцох ёстой хэмээн Хаан зарлиг болжээ.

Энэ тухай сонссон эгч дүүс туйлгүй баясан догдолжээ.

-Ямар сайхан юм бэ? Бүжиг, бүжиг болох нь байна шүү дээ гэж тэд уулга алдацгаах агаад Үнсгэлжинг гал зуухнаас авчран гутлаа өнгөлүүллэн, хувцсаа индүүдүүлээ.

-Олигтойхон янзлаарай чи. Ханхүү бид хоёрын нэгийг л сонгоно гэж тэд хямгсанаад хөөрхий Үнсгэлжингийн хамрыг няслан чихнээс нь татаж дээрэлхэв.

Үнсгэлжин ч гэсэн бүжгэнд очихыг хүсч байлаа. Тэгээд тэр тухайгаа хойд эхдээ хэлбэл цаадах нь түүнийг галзуурчихав уу гэсэн мэт нүдээ том болгон харж,

-Чи юу даа. Чи Хааны бүжгэнд очих гэж үү? Чам шиг ийм заваан амьтан ийм уранхай ноорхой таар өмсөөд бүжиглэх гэж үү? Өөрийгөө сайн хар хэмээн доогтойгоор нээгээд түүнийг алгадлаа. Гэвч Үнсгэлжин бууж өгсөнгүй, харин хаант улсын бүх охид бүжгэнд очих ёстойг санууллаа.

-За тэгвэл одоо тийм байж хэмээн хойд эх нь бувтнаснаа,

Яахав чи бүжгэнд очиж болох л юм. Гэхдээ гэснээ сагстай вандуй авч цэцэрлэгт очин тоос шороотой холилдсон бухал өвс үрүү түүнийгээ асгаад, чи нэг цагийн дотор бүх вандуйг түүж аван сайн муугаар нь ялгаж чадах юм бол бүжгэнд яваарай хэмээн шилбэлзлээ.

Хойд эхийг явмагц Үнсгэлжин сөхрөн сууж вандуйг ялгаж гарлаа. Гэвч тэр вандуйнууд өчүүхэн жижигхэн байсан тул бараг цаг болоход хоёр атгыг л ялгаж дөнгөв.

-Би ч үүнийг барахгүй нь дээ. Хааны бүжгэнд явах минь ч өнгөрлөө хэмээн тэр шүүрс алдлаа. Гэтэл гэнэт шар шурхийх чимээ гарлаа. Үнсгэлжин толгой өндийн харвал ээжийнх нь булшны модон дээр амьдардаг жижигхэн цагаан шувуу цонхоор нисэн орж ирэх нь тэр.

Шувуу шулаганан жиргэсэнээ, Үнсгэлжин минь, тусламж гуй. Бүх шувуу гуй хэмээн хэлэв.

Үнсгэлжин гараа алдан тэнгэрт хандаж,

-Туслаач шувууд минь. Бүх шувууд аа надад туслаач гэж хэллээ.

Гэтэл болжмор, бялуухай, тагтаа гээд олон олон шувууд нисэлдэн ирлээ. Эхлээд тагтаанууд вандуйг түүн тонголзлоо. Дараа нь бусад бүх шувууд хөдлөн вандуйг сайн, муугаар нь дор нь ялгаж орхиод нисэн одоцгоов.

Үнсгэлжин вандуйгаа аван байшинд ороход хойг эх, эгч нар нь хөмсөг зангидлаа. Тэгсэнээ эгч нар нь, чи өөдтэй хувцас өмсөч очвол оч. Бидний нэрийг битгий гутаачих гэгчхэд бүжгэнд яран явж одлоо. Тэд Үнсгэлжинг сайхан хувцас хэзээ ч олж өмсөж чадахгүй гэж бодсон байжээ.

Үнсгэлжин гал зууханд суун гутарсандаа мэгшиж байтал тогших чимээ

гарлаа. Харвал мөнөөх жижигхэн цагаан шувуу хошуугаараа цонх тогшин, толгойгоо гилжийлгэн намайг дагаад яв гэсэн дохио өгөөд нисч одов.

Үнсгэлжин ээжийнхээ булшин дээрх өнөө шувуу үүрлэсэн самрын модон дор очин сөхрөн суугаад,

Навчсаа сэгсэр, самрын мод минь

Надад тэгээд алт мөнгө өгөөрэй хэмээн хэлэв.

Модны мөчрүүд дайвалзан чичирхийлж, салхи гарсан мэт шуугин шидэт үгсийг хэлэх шиг болоход модны оройгоос цагаан шувуу буун алт мөнгөн хувцас, алт мөнгөн шаахайг Үнсгэлжинд авчирч өглөө.

Үнсгэлжин гэр лүүгээ гүйж хүрээд шинэ ганган хувцсаа өмсөөд бүжгэн дээр явж очлоо. Түүний хойт эх, эгч нар нь гурван алтан гургалдай шиг амьтад бүжгэн дээр сэтэгтгэн алхлах агаад Үнсгэлжингээс өөр сайхан хувцастай гоёмсог охин тэнд байхгүй байгааг атаархан харж байв. Гэхдээ мөнөөх үнс, шороонд хутгалдаж явдаг Үнсгэлжинг тэд яасан ч танихгүй байлаа.

Үнсгэлжин тэр үдшийн хамгийн сайхан бүсгүй байсан тул ханхүү зөвхөн түүнтэй бүжиглэн, өөр хэнийг ч түүнд ойртуулсангүй. Бүжиг шөнө дунд дуусахад ханхүү сүйх тэргээ дуудан түүнийг хүргэж өгөхөөр явлаа. Гэвч Үнсгэлжин гэрийнхээ дэргэд ирмэгцээ цэцэрлэг үрүүгээ зугтан ороод тагтааны үүрэнд нуугдаж орхив.

Ханхүү Үнсгэлжингийн аавыг иртэл хүлээж байгаад, нэрийг нь үл мэдэх охин тагтааны үүрэнд нуугдчихлаа гэж хэлэв.

-Хэн юм бол доо? Лав л Үнсгэлжин биш дэг хэмээн эцэг нь хэллээ.

Тэгээд зарцаа явуулан үзүүлбэл тагтааны үүрэнд хэн ч байхгүй байв. Тэд нар хамтдаа гэрт орвол үнс нурманд даруулсан Үнсгэлжин унтаж байх аж. Тэгтэл энэ хооронд Үнсгэлжин булшин дээр гүйж очоод алт мөнгөн хувцас, шаахайгаа тайлж өгөн бяцхан цагаан шувуунд өгчхөөд хуучин муу дээлээ нөмөрч амжсан байжээ.

Ханхүү Үнсгэлжинг ганц хяламхийн хараад, энэ охин лав биш гэхдээ ордон уруугаа толгой сэгсрэн буцлаа.

Маргааш орой нь хоёр дахь өдрийн бүжиг эхлэн гэрийнхэн нь тийшээ явсан хойно Үнсгэлжин самрын модон дор сөхрөн суугаад

Навчсаа сэгсэр самрын мод минь

Надад тэгээд алт мөнгө өгөөрэй гэлээ.

Модны мөчир урьдын адил чичирхийлэн, навчис нь сэргитгэн байснаа бяцхан цагаан шувуу алт, суудан хувцас, шаахай буулгаж өглөө.

Үнсгэлжин хувцас, гутлаа солиод бүжгэнд очив. Зочид түүний ааш зан, үзэсгэлэн гоог шагшин магтаж байсан агаад ханхүү ганцхан түүнтэй л бүжиглэлээ. Харин бүжиг дууссаны дараа тэр охиныг гэрт нь хүргэж өгсөнгүй харин араас нь сэмхэн дагав.

-Энэ удаа ч надаас зугтааж чадахгүй дээ. Энэ охины хэн болохыг олж мэдээд түүнтэй гэрлэнэ дээ гэж ханхүү боджээ.

Тэр Үнсгэлжинг хотын тахир гудамжаар даган явж байтал охин гэнэт цэцэрлэг дотор гүйж ороод лийрийн модон дотор нуугдаж орхих нь тэр.

Удалгүй Үнсгэлжингийн аавыг гэртээ ирэхэд нь хорвоогийн хамгийн сайхан бүсгүй лийрийн модон дотор нуугдчихлаа гэж ханхүү түүнд хэллээ.

-Хачин юм даа. Манайд Үнсгэлжин гэж ганц охин л гэртээ байгаа даа. Гэхдээ хорвоогийн хамгийн сайхан бүсгүй л лав биш хэмээн аав нь хэлээд зарцаа явуулан лийрийн модны бүх мөчрийг тайруулсан ч тэнд хэн ч байсангүй. Үнсгэлжин аль хэдийн хувцас хунараа шувуунд өгч амжаад байдгаараа байж байв.

Маргааш нь баярын хамгийн сүүлчийн шөнө болж хамгийн сүүлчийн бүжиг боллоо.

Үнсгэлжин эхийнхээ булшин дээр очвол самрын модноос алмас эрдэнэ алтаар хийсэн дашинз, болор шаахай бууж ирлээ. Түүнийг бүжгэн дээр очиход гоо үзэсгэлэнг нь бахадсан зочид амаа ангайлган, нүдээ эргэлдүүлж энэ хэн бэ? хэмээн биенээсээ асууцгаах ажээ. Гэвч хэн ч түүнийг таньсангүй.

Ханхүү бүхэл шөнөжин Үнсгэлжинтэй бүжиглэхдээ нэр усыг нь шалгаасан боловч охин тэр тухай огт ярьсангүй байсаар бүжиг дуусахад гэр лүүгээ зугтаж одлоо.

Гэвч энэ удаа ханхүү бэлэн байжээ. Тэр зарцгаа шатан дээр охиныг саатуулахаар зогсоосон боловч зарц нь Үнсгэлжинг саатуулж амжсангүй. Харин Үнсгэлжингийн өрөөсөн шаахай шатны завсар хавчуулагдсан тул яарсан охин түүнийгээ орхиод тэр чигтээ гүйж одлоо.

Ханхүү шаахайг аван Хаан эцэгтээ очиж, энэ шаахай хөлд нь таарсан тэр хүн миний эхнэр болох болно гэлээ.

-Харин чи эзнийг нь яаж олох юм бэ хэмээн Хааныг асуухад,

Зам дээр хар давирхай түрхсэн байгаа. Тэнд охины мөр үлдсэн байх учиртай. Түүгээр хөөж олно хэмээн ханхүү хариуллаа.

Маргааш өглөө нь Ханхүү цэргүүдээ дагуулан замын давирхайн дээрх мөрөөр мөшгөсөөр Үнсгэлжингийн гэрт хүрч ирлээ. Хойд эх Ханхүүг үзэн, ямар зорилгоор ирсэнийг нь сонсоод балмагдсандаа бараг ухаан алдах шахав. Гэвч сүүлдээ үүнийг хэрхэн ашиглах вэ хэмээн арга сүвэгчилж эхэллээ.

-Эрхэм дээд ханхүү минь хэмээн тэр нялуунаар дуугараад,энд миний хоёр охин байна л даа. Тэр хоёр хоёулаа өнгөрсөн шөнийн бүжгэнд очоод хоёулаа л шаахайгаа гээчихээд ирсэн дээ гэлээ.

Ханхүү өрөөсөн шаахайг гаргаж ирэхэд ээж нь ууган охиноо дуудлаа.

Гэтэл нөгөөх нь,

-Ээж ээ энэ миний шаахай биш гэж ундууцах нь тэр. Ээж нь сандарсандаа нүдээ том болгон, хурдан өмсөөтөх наадхаа. Ханхүү чамтай гэрлэх гэж байна

гэж зандаллаа.

Охин шаахайг өмсөхийг оролдсон ч хөл нь дэндүү том байсан тул эрхий хуруу нь багтсангүй гэнэ.

Тэгэхээр нь эх нь хайч аван, ерөөсөө эрхий хурууг чинь тайрчихъя хэмээн ухасхийлээ.

Охин нь түүнийг сонсоод царай нь хувхайран үгүй ээ гэж ориллоо. Гэвч ээж нь үгнээсээ буцсангүй.

-Ганц хуруу зэрэг ч ямай байна. Чи гүнж болчих юм чинь явган явах ч хэрэг байхгүй гэж тэр хэлээд охиныхоо хөлийн эрхий хурууг хайчилж орхих нь тэр.

Охин өвдсөндөө ухаан нь балартаж байсан ч хөлөө шаахайд чихэж оруулан ханхүүд харууллаа. Ханхүү ч түүнтэй гэрлэхээр шийдэж ордон уруугаа сүйх тэргээрээ авч явлаа.

Тэднийг ийнхүү явсаар Үнсгэлжингийн ээжийн оршуулгын хажуугаар өнгөрч явтал жижигхэн цагаан шувуу

Эргэж нэг шалгаарай

Дахиад нэг үзээрэй

Хуруу нь цустай байгаа даа

Шаахай харин дэндүү жижиг шүү

Наад хүүхэн чинь эхнэр чинь биш шүү хэмээн дуулж байх юм гэнэ.

Ханхүү доош харвал бүсгүйн өмссөн шаахайнаас цус дусалж байв гэнэ. Тэгтэл бас эрхий хуруу нь тайрагдсан нь болор шаахайны цаанаас нэвт харагдав.

Чи яасаа хуурамч амьтан бэ? хэмээн ханхүү түүнд зөвүүрхэн хэлээд охиныг түлхэн буулгаад Үнсгэлжингийн гэр лүү буцаж очихыг хөтөчдөө тушаав.

Хойд эх ханхүүгийн эргэн ирэхийг хараад сандарсан ч зальтай хүн байсан тул ухаан сийлж, энэ том охин үнэхээр зальтай амьтан юм. Наад шаахай чинь үнэндээ бага охины минь юм байгаа юм гэж хэлэв.

Тэгээд бага охиноо авчран шаахайг өмсүүлбэл хөлийнх нь урд хэсэг орсон ч өсгий нь яагаад ч орсонгүй.

-Өсгий зэрэг ямай байна. Чи Хатан хаан юм чинь алхах ч хэрэг байхгүй хэмээн эх нь хэлээд хайч аван өсгийг нь хяргаж орхиод одоо өмсөөд үз гэлээ.

Охин гутлыг өмсөн ханхүүд үзүүлж, Ханхүү ч түүнтэй хуримаа хийхээр ордон уруугаа буцав. Гэвч мөнөөх модны дэргэдүүр өнгөртөл мөнөөх л шувуу дахиад л,

Эргэж нэг шалгаарай

Дахиад нэг үзээрэй

Өсгий нь цустай байгаа даа

Шаахай харин дэндүү жижиг шүү

Наад хүүхэн чинь эхнэр чинь биш шүү хэмээн дуулж байх юм гэнэ. Ханхүү доош харвал охины цагаан оймсыг даган цус урсаж байж. Бас нэг мэхлэгч гэж

ханхүү хашгираад түүнийг хөөж буулгалаа.

Тэр Үнсгэлжингийн гэрт очин ууртайгаар, энэ шаахайны жинхэнэ эзэн хаана байна. Гаргаад ир хэмээв.

-Энэ шаахай таарах хүн энд үнэхээр байхгүй хэмээн аав нь мөрөө хавчин хэллээ.

-Гэхдээ мөр энд л хөтөлж ирсэн дээ гэж дуугараад, та өөр охинтой хүн үү, үгүй юуу гэж асуулаа.

-Өөр нэг охин ч бий л дээ. Миний түрүүчийн эхнэрийн хүүхэд. Гэхдээ тэр яагаад ч шаахайны эзэн байх учиргүй. Үнс тоосон дунд унтдаг нэг навсайсан амьтан бий гэж аавыг хэлэхэд,

-Тэр хамаагүй, нааш нь аваад ир хэмээн ханхүү зарлиг болов.

Хойд эх хөмсгөө агируулан,

-Энэ боломжгүй зүйл. Тэр бол бохир завааны туйл болсон амьтан байгаа юм гэхэд, тэр хамаагүй. Тийм юм бол усанд оруулж угааж цэвэрлээд аваад ир гэж Ханхүү хэлэв.

Гэвч уур нь хүрвэл толгойг нь ч авч мэдэх ханхүүгийн тушаал бол тушаал хойно гэд аргагүйн эрхэнд Үнсгэлжингийн хувцсыг солин, угааж цэвэрлэн, үснийг нь самнаад авч ирлээ. Түүнд шаахайг өгөхөд яг таарлаа. Ханхүү ч бүжиглэж байсан охиноо мөн гэдгийг шууд танилаа.

-Энэ бол миний сүйт бүсгүй. Наймайг Хаан болохоор энэ хүн Хатан хаан болно гэж тэр догдлон хэлэв.

Хойд эх, хоёр охины хамт чарлалдан уйлсан ч ханхүү тэднийг хяламхийж ч харсангүй, сүйт бүсгүйгээ дагуулан гарч сүйхэндээ суулгаад буцан довтолгов. Тэднийг самрын модны дэргэдүүр өнгөрч явахад бяцхан цагаан шувуу

Эргэж нэг шалгаарай

Дахиад нэг үзээрэй.

Цус гэж тэнд алга

Чухам сүйт бүсгүй мөн дөө, мөн дөө хэмээн уянгалуулж байв. Тийн явахад хоёр тагтаа тэнгэрээс буун Үнсгэлжингийн хоёр мөрөн дээр суун чихэн дээр нь дуугаралдан байв.

Удалгүй хурим болоход Үнсгэлжингийн хоёр эгч хамгийн түрүүнд харайн очиж, хамгийн өмнө суучаад баяртай царай гаргаж байсныг яана. Тэгсэн мөртлөө тэр хоёр атаархсандаа мэгшүүлэн уйлж байсан билээ.

Хуримын ёслол дууссаны дараа эгч дүү хоёр дээр хоёр тагтаа нисэн ирээд тэдний нүдийг сох хатгаж орхижээ. Ийнхүү муу санаат эгч дүүс муу үйлийнхээ төлөө насаараа сохор байх шийтгэл амссан гэдэг.



Хансел Гретел хоёр

Эрт урьдын цагт өтгөн ойн захад нэгэн түлээчин эр эхнэрийн хамт амьдран суудаг байлаа. Тэр хоёр Хансел гэдэг хүүтэй, Гретел гэдэг охинтой юмсанжээ.

Түлээчин эр угийн ядуу зүдүү агаад тэднийд хоол хүнс үргэлж ховор хомс байдаг байв. Хүүхдүүд нь идэх юм асуухад элдвийн үлгэр таавар хэлэн, тэднийгээ аргацаах үе зөндөө байдаг байсан бөгөөд сардаа ганц удаа хнам идвэл дээдийн заяа болдог байж. Гэтэл нэгэн жил тэр нутагт аймшигт өлсгөлөн болж, хархнууд хүртэл турж үхэж эхэлжээ.

Түлээчин эхнэртэйгээ өдөр хоногийг арай ядан өнгөрүүлсээр байсан боловч удалгүй тэднийд хэдхэн зүсэм талхнаас өөр юу ч үлдсэнгүй гэнэ. Гэтэл нэгэн шөнө эхнэр нь орондоо хэвтэж байгаад нөхөртөө хэлж гэнэ.

-Хөөе! Сонсоч байна уу? Бид ерөөсөө хүүхдүүдээсээ салахгүй бол болохгүй нь ээ гэж тэр хэллээ.

Түлээчин хар даран зүүдэлж байна гэж бодоод,

-Хүүхдүүдээс сална гэнэ ээ? Чи юу яриад байна аа хэмээн хашгирчээ.

-Хэрэв бид тэдэнтэй хамт байх юм бол өнөөдрөөс эхлэн булшныхаа нүхийг малтацгаасан нь дээр болж байна. Харин тэд байхгүй болчихвол ядаж чи бид хоёр амь гарч магадгүй. Хансел Гретел хоёрыг маргааш ойн гүнд аваачаад орхичхоё хэмээн эхнэр өмнөөс нь тайлбарлалаа.

-Тэднийг маань чоно идчихнэ шүү дээ хэмээн түлээчин эр мэгшилээ.

-Харин ч тэр нь зовлонгүй үхэл болно доо гэж эхнэр хэллээ.

Түлээчин эрийн зүрх сэтгэл шаналан уйлж байсан ч зөвшөөрлөө.

-Дуугүй бай! Хүүхдүүд сонсчихвол яана гэж эхнэр нь уцаарлалаа.

Гэвч хүүхдүүд аав ээж хоёрынхоо яриаг аль хэдийн нэгд нэгэнгүй сонс-

чихсон байжээ. Учир нь тэд хэтэрхий их өлссөндөө болоод унтаж ч чадахгүй болсон байжээ.

Гретел уйлж эхэллээ. Маргааш биднийг ойд орхихоор чоно барьж иднэ хэмээн тэр ингэнүүллээ. Харин Хансел түүний толгойг илэн,

-Айлтгүй бяцхан дүү минь, бид хоёрыг чоно идэхгүй гэлээ.

Тэгснээ орноосоо сугаран босоч чимээгүйхэн өрөөнөөсөө гэтэн гараад шатаар уруудан гадагш гарлаа. Байшингийн эргэн тойрон дахь жижиг чулууд сарны гэрэлд зоос мэт гялбалзан үзэгдэж байв. Хансел халаснуудаа тэдгээр чулуудаар дүүргэж аваад гэртээ оров.

-Гретел минь. Санаа зоволтгүй ээ. Маргааш бид хоёр өөрсдийнхөө оронд унтагшаах болно гэж тэр дүүдээ хэлжээ.

Өглөө болж нар жаргахад ээж нь тэднийг босголоо.

-Одоо явцааж ойд очиж хоол хүнс эрье гэж тэр хэлжээ.

Хүүхдүүд босон гар нүүрээ угааж, хувцсаа өмсөөний дараа ээж нь тэдэнд зүсэмхэн талх өгөөд,

-Үүнийг аваад яв. Гэхдээ үдээс өмнө бүү идээрэй гэж хэлэв.

Нар хөөрч шувууд жиргэж эхлэхэд баргар царайлсан түлээчин сүхээ үүрэн гэр бүлээ ой уруу замчлан явлаа.

Тэднийг урагшлахад Хансел ард нь сүүлдэхийн явж байв. Тэр чулуугаа цувуулан хаяж түүнийгээ эргэн харж байв. Түүнийг нийнхүү эргэн харж явахыг ажигласан ээж нь,

-Чи юугаа хараад байгаа юм бэ? гэж асуулаа.

Тэгэхэд нь Хансел байшин уруугаа заан,

-Манай муурын зулзага дээвэр дээр гарчихсан баяртай гээд сарвуугаараа даллаж байна гэж заллаа.

-Битгий тэнэгтээд бай. Тэр чинь яндангийн таг л байна хэмээн ээж нь хэлээд түүний чихнээс татан урагш түлхэв.

Тэд нар ширэнгэ ойг зүсэн, мод мөчирт шавхуурдуулан урагшилсаар байсан бөгөөд Хансел нөгөө чулуунуудаа цувруулан хаясаар л явлаа.

Тэгж тэгж ойн гүнд хүрээд зогсогтоов.

-Хүүхдүүд минь. Аав ээж хоёр нь явж хоол хүнс бэлдэе. Та нар эндээ амарч бай. Би та нарт гал асааж өгье. Дулаацаад байж бай.

Түлээчин ийн өгүүлээд түүдэг гал асаахад ээж нь,

Эндээ биднийг ирж автал хүлээж бай гэлээ.

Хүүхдүүд аав ээжийгээ явсан хойно үд дунд хүртэл хүлээгээд үмх талх идэн Хансел охин дүүдээ Эрхийн чинээхэн Том хүүгийн тухай үлгэр ярьж байсаар нэг мэдэхэд нар жаргаж харанхуй болсон боловч ээж аав хоёр нь эргэж ирсэнгүй.

Харанхуй ойгоос чоно улих, модод шажиганах чимээ сонсогтоход Гретел айн уйлав. Тэгэхэд нь Хансел түүнийг тайвшруулан толгойг нь илбэж,

-Зүгээр зүгээр. Сар гарахаар бид гэр лүүгээ явна гэж аргадлаа.

Саран авхай мандан хорвоо дэлхийг гийгүүлэхэд Ханселийн цувуулан хаясан чулууд цох хорхой мэтгэрэлтэн харагдаж ах дүү хоёр түүгээр баримжаалан гэрийн зүг хөдлөв.

Тэднийг гэртээ ирэхэд аав нь маш баярлан угтсан бол ээж нь харааж загнан,

-Зүггүй тархинууд та нар бид хоёрыг эргээд ирэхэд алга байх чинь билээ гэж байв.

Ээж нь хэдэн хоногийн дараа хөргөгчөө онгойлгон үзвэл бараг хоосон, тоос шороонд дараастай хэдхэн зүсэм талх л үлджээ. Тэрээр толгойгоо сэгсэрч тэр шөнөө бас л хүүхдүүдээ төөрүүлэх санаагаа нөхөртөө ярилаа.

Түлээчин нударга зангидан ширээ шааж,

-Үгүй, сүүлчийн хэрчим талхаа хүүхдүүдтэйгээ хуваалцах болно хэмээн хашгирлаа.

-Хоёулаа үхсэн нь дээр үү? Дөрвүүлээ үхсэн нь дээр үү тэнэг минь хэмээн эхнэр нь ийнсаар байсанд уй гашуундаа ухаан нь балартсан нөхөр нь аргагүйдэн зөвшөөрлөө.

Хүүхдүүд энэ удаа ч аав ээжийнхээ яриаг сонсчээ. Хансел орноосоо сугаран гарч чулуу түүхээр явсан ч ээж нь байшингийн хаалгыг дангинатал түгжсэн байсан тул гадагш гарч чадсангүй.

Гретелийг уйлж эхлэхэд Хансел түүнийг тайтгаруулан,

-Тайван нойрс, дүү минь. Бурхан биднийг харахдаа л харна гэж байв.

Маргааш өглөө нь хүүхдүүд босон нүүр гараа угааж, хувцсаа өмссөний дараа хүүхдүүд ганц ганц өөдөс талх аваад тэд гэр бүлээрээ ойн зүг хөдөллөө. Замдаа Хансел талхаа эмтлэн үйрмэгийг нь зам дагуулан унагаасаар явав.

Ээж нь түүний сүүлдэж явааг үзээд,

-Чи тэнд юу хийгээд байна? гэлээ.

-Манай тагтаа дээрээ гараад биднийг баяртай гэж байна хэмээн Ханселийг өгүүлэхэд ээж нь,

-Битгий тэнэгтээд бай. Яндан дээр нар тусаад гялалзаж байна даг гээд түүний үснээс угзарлаа.

Тэд явсаар урь өмнө хэн ч очиж байгаагүй тийм хол очив.Тэнд мод маш шигүү байсан агаад нар ч харагдахгүй харанхуй газар байлаа. Түлээчин түүдэг гал асааж өглөө.

-Эндээ байж байгаарай хүүхдүүд минь. Бид нар харанхуй болохоос өмнө ирнэ хэмээн тэд хэлээд явж одоцгоов.

Хүүхдүүд галын дэргэд шөнө болтол суусан ч эцэг эх нь эргэж ирсэнгүй. Гретел айж эхэлсэн ч Хансел түүн рүү нигэмсэглэн харж,

-Би талхны өөдөс замаараа хаячихсан. Сар гарахаар харагдана. Тэгээд гэртээ харьчихна гэж тайвшрууллаа.

Сар гарч шар шувуу дуугарч эхлэхэд хүүхдүүд хөдөллөө.

-Талхны өөдөс сайн хараарай хэмээн Хансел хэлсэн ч юу ч байдаггүй гэнэ. Гэтэл тэрхүү өөдсүүдийг ойн шувууд бүтдийг нь түүгээд идчихсэн байх нь тэр.

Хүүхдүүд ийнхүү харих замаа олохоосоо өнгөрсөн тул шөнийн турш модны мөчир дор хоргодон, ойд гарсан чимээ болгоноос айн чичрэн дагжсаар өглөө болгов.

Маргааш нь тэр хоёр ой шугуй, намаг шалбааган дундуур сүлжилдэн явсаар нүүр амаа модны мөчирт уруулан өдөржин явсан ч амжилт олсонгүй. Тэд тусламж эрэн хашгиралдсан боловч хэн ч хариу өгөхгүй, харин зэрлэг амьтад үргэн зугтах ажээ. Ах дүү хоёр аав ээждээ гомдон уйлавч хэн ч тэднийг сонсох билээ. Дэлхий ертөнц дээрх хамгийн азгүй хүүхдүүд гэвэл тэд л байлаа.

Ийнхүү тэр хоёр гуравдахь өдрөө харанхуй ойд явсаар байсан бөгөөд хэрэв хоол олж идэхгүй бол өлбөрч үхэх юм байна гэж Хансел бодож байлаа.

Тэд ийн явсаар ядарч нэгэн горхины хажууд амсхийн суулаа. Горхины хөвөөнд алтан навчист мод найгах агаад тэр модон дээр мөнгөн жигүүрт шувуу сууж байх юм гэнэ. Шувуу маш сайхан жиргэх тул Хансел Гретел хоёр өлсгөлөнгөө мартаж мэт болов. Тэгтэл мөнөөх шувуу хүзүүгээ сунган толгойгоо сэжиж намайг дага гэж дохиж байх шиг байна гэнэ.

Шувууг босон нисэхэд ах дүү хоёр араас нь дагалдлаа. Удалгүй тэд нар нэгэн жимээр орж, тэр жим нь хөтөлсөөр ойн чөлөөнд гарч ирсэн бөгөөд тэнд нэгэн байшин байлаа. Тэд ухасхийн гүйж хүрвэл тэр байшингийн ханыг талхаар хийсэн байв. Тэр бүү хэл дээвэр нь бялуу, цонх нь цэвэр чихэр ажээ.

Ханселийн нүд шар шувууных мэт бүлтгэр болон гайхаж пөөх хэмээн дуу алдаад,

-Бид аврагдлаа. Би дээвэрнээс жаахан идээтэхье, харин чи цонхноос ид. Ёстой амттайхан байгаа даа гэж баяртайгаар өгүүллээ.

Хүүхдүүд талх, чихрийг амтархан идэж эхэлтэл нэгэн дуу гарав. Гэтэл хаа нэгтэйгээс

-Зажил, зажил, зажил

Хариугүй жижигхэн байшинг минь

Харин хэн иднэ вэ? гэсэн авиа сонсогдлоо.

Хүүхдүүд чимээгүй байсанд нөгөө дуу дахин гарч,

-Тог, тог, тог

Хаалгыг минь идэж байгаа

Хаанахын хүн байна аа? гэж байх юм гэнэ.

Энэ удаа Хансел хариу өглөө.

-Салхи, салхи, салхи

Сансрын ариухан салхи

Хүнгэнэн үлээж байна

Хүүгэж дүүгэж байна гэж тэр амаа арчин дууллаа.

Тэгээд хэсэг талх эмгэн ам уруугаа явуултал байшингийн хаалга онгойн нэгэн эмгэн гараад ирэв. Түүний цэнхэр нүд нь хоёр од шиг гялалзан, хацар нь зуны алим мэт улайран туяарах аж.

-Хүүе ээ. Бурхан тэнгэр минь. Энэ хоёрын байж байгааг хараач хэмээн эмгэн дуу алдлаа.

Үнэхээр нөгөө хоёр нь шавар шавхай болсон нүүрэндээ талх, чихэр наалдуулчихсан халтайсан амьтад байж байлаа. Тэр хоёр айсан ичэндээ уйлахад бэлэн байсан ч эмгэн тэдэн үрүү инээмсэглэн харлаа.

-Та хоёр янз нь ойд төөрчээ дээ. Гэвч одоо айх хэрэггүй боллоо. Миний гэрт оршоо. Би та хоёрыг харж хандана хэмээн тэрээр өгүүлэв.

Эмгэн тэднийг гэртээ оруулан нүүр гарыг нь угаалгаад боов хайран элсэн чихрээр амталж өгөв. Хоолны дараа тэнд цас мэт цагаан бүтээлэгтэй ор засч өгсөн тул Хансел Гретел хоёр диваажинд ирчихлээ хэмээн бодсон ажээ. Ах дүү хоёр залбирал үйлдээд унтахад эмгэн тэднийг үнслээ.

Гэвч хүүхдүүдийг унтмагц эмгэн лаа асаан барьсаар тэдний өрөө үрүү гэтсээр ирэн лааны сүүмэлзэх гэрэлд Хансел Гретел хоёрын дээрээс тонгойн харлаа. Түүний хоёр нүд нь од мэт цэнхэр биш махчин чоных шиг час улаанаар эргэлдэж, хацар нь алимынх шиг улайрах биш харин ялзарсан сармаг шиг зөвхий даасан байв. Эмгэн гэм зэмгүй хоёр хүүхдийн дээрээс ширтэж байснаа буцан өрөөндөө орлоо.

Тэр тэндээ дүүжин сандалдаа суун, нааш цааш хөдөлгөх зуураа хоёр ёрдгор савраа зөрүүлэн атгаж, уруулаа шилэмдэх ажгуу. Тэгэх зуур хи, хи, хи хэмээн инээж байлаа. Тэгсэн тэр эмэгтэй болбоос хөө шиг хар дотортой илбэч эм байсан байжээ. Тэр байшингаа хүүхдүүдийг ирүүлэх зорилгоор барьсан байж. Тэгээд хүүхдүүдийг ирүүлэн барьж аваад алж чанаж иддэг ажээ. Илбэч нар араатан шиг улаан нүдтэй байдаг болохоор төдийлөн холыг харж чаддаггүй ч мөн л араатан мэт үнэрч тул хэдэн өртөөгөөс үнэрийг нь авч чаддаг байна. Тийм болохоор эмгэн Хансел Гретел хоёрын үнэрийг аль холоос мэдээд мөнгөн жигүүрт шувуу болон очиж дагуулж ирсэн нь тэр байжээ. Илбэч эм ойн гүнд суудаг болохоор тэнд нэг их олон хүүхэд ирдэггүй тул нэг зэрэг хоёрын хоёр хүүхэд хараад туйлын баяртай хөл нь газар хүрэхгүй байлаа.

Эмгэн дүүжин сандалдаа шөнөжин савчиж хоноод өглөө хамгийн эхний тахиа дуугармагц ухасхийн босож унглагын өрөө үрүү очин хүүхдүүдийн дээрээс тонгойж уруул амаа долоолоо. Тэгснээ Ханселиг орноос нь тулд татан чирсээр сэрэхээс нь өмнө байшингаас гаран хашаанд байх торон цонхтой пинд хийж түгжлээ.

Илбэч эм үүндээ баясан ингээд алдсанаа Гретелийг угзчин сэрэв.

-Залхуу новш минь бос чи. Ус авчирч хамгийн сайхан хоол хийгээд орхи.

Чиний ах чинь хэтэрхий туранхай тул би одоохондоо идэхээ азналаа. Таргалаад ирэхээр нь алж иднэ дээ гэж тэр ярилаа.

Гретел айн хашгирч уйлсан ч яах ч билээ, аргагүйн эрхэнд тахианы мах чанан, боов хийлээ. Илбэч эм бараг бүгдийг нь Ханселд өгч, Гретелд тахианы хоосон яс л оногджээ.

Маргааш өглөө нь илбэч эм цоожтой пингийн зүг очин,

-Хөөе Хансел ээ. Наад торны завсраар хуруугаа гаргаад орхи, чамайг хэр таргалсаныг үзээд орхиё гэж тушаалаа.

Харин Хансел ухаантай хөвгүүн байсан тул өөрийнхөө хурууг биш харин идсэн тахианыхаа сарвууг цухуйлгалаа.

-Ай яа. Чамайг чанаж идэхэд дэндүү туранхай байна. Гэхдээ чи таргална аа гайгүй гэж илбэч сарвууг хараад хэллээ.

Түүнээс хойш Гретел өдөр бүхэн давтсан мах, котлет гэхчлэн хамгийн амттай хоол бэлтгэн түүнийг нь Хансел идэх бөгөөд харин илбэч эмд урьдын адил тахианы сарвуу харуулан аргацааж байв.

Ийнхүү дөрвөн долоо хоног өнгөрсний дараа илбэч эм тэсэхээ байв.

-Ах чинь таргалсан ч бай, туранхай хэвээрээ ч бай өнөөдөр би түүнийг иднэ гэж тэр Гретелд хэллээ.

Гретел ус авчран тогоонд дүүргэхдээ асгартал уйлж байлаа. Түүний нулимс бараг тогоо дүүрэх шахаж байв. Бурхан минь. Бид зэрлэг араатнаас аврагдсан ч түүнээс долоон дор амьтны гарт оржээ. Биднийг эндээс аварч хайрла хэмээн тэр уйлж байлаа.

Эмгэн түүний толгойг тэвшээр дэлсэн,

-Тэгэхгүй шүү хэмээн хяхтнаад янз янзын юм битгий гуншигнаад бай. Явж тэр шарах зуух шалга. Хансел гэдэг боодгийг сайхан шаргал болтол нь шарж чадахаар халж уу? үгүй юу? үзээд ир. Би хараа муутай болохоор сайн харж чадахгүй байна гэлээ.

Гэвч Гретел Ханселийн адил ухаалаг хүүхэд байсан учраас эмгэн түүнийг шарах зууханд түлхэж оруулах гэж байгааг ойлгов. Тэгээд,

-Би зуух уруу толгойгоо шургуулж харж чадахгүй байна. Таг нь хэтэрхий бага онгойсон байна гэж эмгэнд хэллээ.

-Өө Яадаг муу тэнэг вэ чи. Ингэдэг юм. Чамд харуулахаас.

Эмгэн доош тонгойн шарах зуухны тагны завсраар толгойгоо шургуулан за харав уу гэлээ. Гэвч эмгэн үгээ дуусгаж амжсангүй.

Учир нь Гретел түүний үрчлээт гүрдгэр хүзүүнээс нь татан шарах зууханд хийгээд тагийг нь түгжиж орхив. Одоо эмгэний хашгирах ээлж иржээ. Тэр шарах зуухны төмөр хаалгыг нүдсэн ч гарч эс чадаад шатан үнс боллоо.

Гретел хашаа уруу гүйж пингийн хаалгыг нээхэд Хансел торноос мултгарсан шувуу шиг дүүлэн гарч ирлээ.

-Хансел! Илбэч эм үхсэн шүү. Үхсэн гэж Гретел хашгирлаа.

Хоёр хүүхэд хэчнээн баярлаж хөөрсийг хэлээд яахав. Бас ойн бүх амьтад ч баяр хөөрт автлаа.

Хүүхдүүд байшинд орж шүүгээ савыг нь уудалбал илбэч эмгэний хуурч авчраад дээрэмдсэн хүмүүсийн алт, эрдэнэс пиг дүүрэн байв. Гретел хормогчоороо дүүрэн алмас эрдэнэ, харин Хансел халаас дүүрэн сувд авчээ.

-Энэ бол чулуу, талхны өөдөс хоёроос хавьгүй дээр хэмээн Гретел хэлээд, гэхдээ одоо явцгаая. Гэртээ очих замаа олох хэрэгтэй гэлээ.

Тэр хоёр хөтлөлцөн замд гарсан ч ой урьд урьдынхаасаа битүүлэг харагдан удалгүй төөрцгөөлөө. Тэгж хоёр цаг явсны дараа нэгэн том, гүнзгий голд тулж очлоо.

-Энэ том голыг яаж гатлах юм бэ? Завины бараа ч алга гээд Гретел уйлахад, Зүгээр зүгээр нэг арга олдож л таарна хэмээн Хансел хэлснээ, хүүе тэнд нэг цагаан нугас байна. Түүнээ тусламж хүсье гэв. Тэгээд Хансел,

-Бяцхан хөөрхөн нугасхан минь

Бядгүй хоёр жаалыг

Ус гаталгаж өгөөч гэж

Учирлан гуйя чамгаас хэмээн дуулав.

Нугас толгойгоо шомболзуулан хөвж ирснээ зөөлөн хүрэн нүдээрээ тэднийг хараад “гаага, гаага” хэмээв. Тэгснээ жигүүрээ дэлгэн тэднийг суухыг урилаа. Хансел нугасны нуруун дээр үсрэн морлоод Гретелийг мөн суухыг дохилоо. Гэтэл нугас,

-Тэгвэл бяцхан нугас надад дэндүү хүндэлнэ. Чамайг эхлээд гаргая гэж өгүүллээ.

Нугас эхлээд Ханселийг, дараа нь Гретелийг гол гаталган өгөөд нисэн одлоо. Тэгэхдээ “илбэч эм үхсэн, илбэч эм үхсэн” хэмээн баяртайгаар гагалсаар явжээ.

Ханс Гретел хоёр голын цаана гарахад өргөн уудам тал угтлаа. Удалгүй тэр хоёр гэртээ харьдаг замыг олон, дагаж явсаар ойн захад байх төрсөн байшингийнхаа барааг олж үзлээ.

Муурын бяцхан зулзага, тагтаа хоёр тэр хоёрыг угтан ирлээ. Хансел муураа, Гретел тагтаагаа тус тус тэвэрсээр гэртээ орцгоовол аав нь тэднийг таниад маш их баярлан догдоллоо.

Хоёрхий золгүй эрийн эхнэр нас барсан байсан ба ойд орхисон хүүхдүүдээ бодон гуниг зовлондоо шаналан амьдарч байж л дээ. Гретел хормогчноосоо алмас эрдэнэ гарган, Хансел халааснаасаа сувд асгахад тэдгээр эрдэнэс хурц өнгөөр гялалзан солонгорч байсан бүлгээ. Ийнхүү дахин учирсан аав, хүү, охин гурав баян чинээлэг аз жаргалтай амьдарсан ажгуу.



Цасан цагаан ба долоон одой хүн

Эрт дээр үед дүн өвлийн нам гүмд Хатан хаан цонхны дэргэд юм нэхэж суужээ. Гадаа орж буй цасан ширхгүүд цонхны тас хар модон хүрээний цаагуур зөөлхөн газардах нь харагдана. Хатан хаан түүнийг харж байгаад хуруугаа зүүгээр санамсаргүй хатгаж орхитол хундан улаан цусны гурван дусал гарч гэнэ.

Хатан хаан цасан ширхэг, цонхны хар хүрээ, гурван дусал цусыг ээлжлэн харж цас шиг цагаан, хүрээ мэт хар, цус мэт улаахан охинтой болох юм сан гэж боджээ.

Түүнээс хойш нэгэн жил өнгөрөхөд Хатан хаан охин төрүүлдэл цас шиг цагаахан арьстай, хүрээ мод мэт хав хар үстэй, цус мэт ув улаахан уруултай хүүхэд мэндлэн Хатан хааны мөрөөдөл биелжээ. Хуруугаа эгэсэн тэр нэгэн өдрийг эргэн санасан Хатан хаан охиндоо өвлийн дурсгал болгон Цасан цагаан гэдэг нэр хайрлажээ.

Харамсалтай нь хэдэн жилийн дараа Хатан хаан нас барж, Хаан дахин эхнэр авчээ. Шинэ Хатан хаан үзэсгэлэнтэй сайхан бүсгүй байсан бөгөөд түүндээ их л омог бардам явдаг байв. Тэр өөрөөсөө илүү сайхан эмэгтэй энэ дэлхий дээр байх ёсгүй гэж боддог байсан бөгөөд хэрэв тийм сайхан бүсгүй байвал шууд л мэдэх боломжтой байлаа.

Учир нь Хатан хаан ордны цамхгийн мухарт нэгэн нууц өрөөтэй, тэнд нь нэгэн толь байдаг байв. Гэхдээ тэр бол энгийн ч нэгэн толь биш байжээ.

Хатан хаан өдөр бүхэн цамхгийн мушгирсан шатаар өгсөн нууц өрөөндөө очоод толь уруугаа ширтэхэд толь нь ч түүнийг бас харах аж. Гэхдээ толинд Хатан хааны дүрс биш харин сохор хүний нүд мэт сүүдэр сүүмэлздэг байв. Тэгж байснаа Хатан хаан:

Хананд байгаа хайртай тунгалаг толь минь

Хамаг орчлон дэлхий дээрх

Хамгийн сайхан бүсгүй хэн бэ? хэмээн асуух бүлгээ.

Тэгэхэд толь булингартан усан дотор чулуу шидсэн мэт болон баралздаг байв. Энэ нь толь дэлхийн бүх хот, тосгодоос сайхан бүсгүй хайж байгаа нь тэр байжээ. Тэгж тэгж нөгөө толь ярьдаг байж. Толь Хатан хаанд хандан,

Эрхэм Хатан хаантан минь та л ганцаар

Эгнэшгүй үзэсгэлэнтэй нь хэвээр байна гэдэг ажээ. Үүнийг сонссон Хатан хааны сэтгэл машинд ханаж, баясгалантайгаар мишээгээд шатаар буун өрөө үрүүгээ явдаг заншилтай байв.

Ийнхүү таван жил өнгөрсний хойно нэгэн өдөр Хатан хаан мөнөөх толин дээрээ очоод,

Хамаг орчлон дэлхий дээрх

Хамгийн сайхан бүсгүй хэн бэ? гэж асуухад толь булингартан, баралзан түүнийг хариу ширтэж байснаа

Эрхэм Хатан хаан минь та

Энүүхэндээ үзэсгэлэнтэй ч

Энхрий Цасан цагаан гэвч танаас

Элбэг мянга дахин хөөрхөн дөө гэх нь тэр.

Гүнж толины хэлэхийг сонсоод атаархал хорсол нь буцлан,

-Би үүнийг тэвчихгүй, хэзээ ч тэвчихгүй гэж хашгирлаа.

Тэр нууц өрөөнөөс гаран, шууд анчин дээр явж очлоо.

-Чи одоо Цасан цагааныг дагуулж яваад уулын оройд аваачин алчхаад ир хэмээн тэр хэллээ.

-Юу гэнэ ээ? Цасан цагааныг алах гэж үү гэж анчин эр мэл гайхан асуув.

-Тийм ээ. Тийм гэж байна гэж Хаан хаан хорт могой мэт исгэрээд тэгэхдээ чи надад нотолгоо болгож Цасан цагааны зүрх, уушги, элгийг авчирч өг. Би чанаж иднэ гэж тушаалаа.

Анчин эр чихэндээ ч итгээгүй боловч хэрэв үгийг нь дагахгүй бол Хатан хаан түүнийг хордуулж ална гэж мэдэж байсан учраас маргааш өглөө нь Цасан цагаанд ойн гүнд нууц газарт байдаг зүр гур үзүүлднэ гэж хэлээд дагуулан явлаа.

Тэр Цасан цагааныг бүхэл өдөржин дагуулж явсаар уулын оройд хүрээд хутгаа сугалсан ч охиныг алж зүрхэлсэнгүй.

-За байз. Ийм гэмгүй хүүхдийг алж нүгэл үйлдээд явах. Тийм ээ, би яасан ч ингэж чадахгүй гэж тэр өөртөө хэлээд хутгаа хуйллаа. Тэгээд энэ охиныг энд нь орхичхье, тэртэй тэргүй энэ ойгоос гэрээ олж очиж чадахгүй, зэрлэг араатнуудад барлуулах нь мэдээж хэмээн анчин эр бодоод, түүнийг орхиод явж одов.

Тэр ордон уруу буцах замаараа нэгэн залуу буга агнажээ.

-Энэ буганы зүрх, уушги, элэг нь яг хүүхдийнх шиг юм байна. Хатан хаан ялгааг нь мэдэх ч үгүй. Анчин эр ийн өөрөө өөртөө хэллээ.

Түүний зөв байжээ. Хатан хаан бугын зүрх, уушги, элгийг авч чанаж иджээ.

Хатан хааныг ийнхүү идэж суухад Цасан цагаан ёстой л эзгүй зэлүүд гав ганцаар байв.

Тэрээр анчиг дуудан удтал хашгирсан ч шувуудын жиргэх л хариу сонсогдох бүлгээ. Охин чонын улиа, баавгайны архирааг сонсоод айсандаа гүйж гарлаа. Тэр нүүр царайгаа модонд уруулан, хөлөө чулуунд зүсүүдэн хааяа нэг амрахаар зогсох бүрдээ аймшигт араатнуудын дууг сонсон цааш дэгдэх аж. Гэвч зэрлэг баавгайнууд хүртэл нийжин сэтгэлтэй байдаг болохоор тэр араатнууд өчүүхэн бяцхан охинд үл довтлон моддын араас түүнийг сэм ширтэн байв.

Цасан цагаан үдээс хойшжин ой дундуур ийн гүйсээр үдэш харанхуй болж байхад нэгэн чөлөөнд гарч ирвэл тэр чөлөөнд байшин байж байв.

Гэхдээ тэр нь ердийн ч нэг байшин бас биш ээ. Учир нь тэр бол маш жижигхэн байшин байв. Цасан цагаан хаалгыг нь тогших гэж өвдгөн дээрээ сөхөрч суусан гээд та нар бод доо.

Цасан цагаан хаалгыг тогшин, хонхыг нь дарсан боловч хэн ч хариу өгсөнгүй. Байшин дотроос цагны чаг чаг хийх чимээ л гагцхүү сонсогдох аж.

-Замар ч гэсэн ороод үзье. Энэ байшингийн эзэн хэн ч байсан золгүй намайг оруулах байх гэж Цасан цагаан бодоод байшин уруу орлоо.

Нар жарган нарны хамгийн сүүлчийн цацрагууд цонхоор гэрэлтэн байшин доторхыг гэрэлтүүлж байсан бөгөөд Цасан цагаан эргэн тойрон харвал бүх юм нь ихэд жижигхэн байв. Гэхдээ жижигхэн боловч цэвэрхэн нямбай харагдлаа. Жижигхэн ширээн дээрх цэвэрхэн бүтээлгэн дээр долоон таваг, долоон халбага, царсны самраас томгүй долоон аяга өрөөстэй харагдана. Мөн тэнд нялх хүүхдийнх шиг жижигхэн сандал тавиастай байв. Ханын дагуу цас шиг цагаан бүтээлгээр хучсан долоон ор эгнүүлсэн байх агаад тэндхийн бүх юм өнгөлөг, алт мөнгөөр хийсэн мэт гялалзаж байв.

Тэнд таваг бүхэнд шөл байсанд Цасан цагаан хэдийгээр өлсөж явсан ч аяга тус бүрээс нэг нэг халбага идэв. Тэр хэтэрхий ховдог байхыг хүссэнгүй. Охин хоол идсэнийхээ дараа өөрийн эрхгүй унтмаар санагдлаа. Тэр эхний орон дээр унтах гэтэл дэндүү жижиг, дараагийнх нь дэндүү хатуу, нөгөөх нь дэндүү зөөлөн байсан тул ээлжлэн үзэсээр харин хамгийн сүүлчийн долоо дахь ор сэтгэлд нь таалагджээ. Цасан цагаан тэрхүү орон дээр хэвтэн таг унтлаа.

Үдэш болоход уулын зүгээс хөлийн чимээ сонсогдлоо.

Тип, тап, тип, тап

Тип тап, тип тап

Энэ бол Цасан цагааны унтаж буй байшингийн эзэд болох долоон эрийн

алхаа байлаа. Харин тэд энгийн нэг хүмүүс биш харин одой нар байв. Тэд бол урт урт сахалтай, уулын дор байх уурхайгаас эрднийн чулуу олзворлодог долоон жижигхэн эр билээ. Хүн бүхэн дэнлүүтэй тул тэд байшинд ормогцоо хэн нэгэн байгааг олж мэдэв.

-Ай яа. Хэн миний сандал дээр суудаг байна аа? гэж эхний эр дуу алдахад, хоёр дахь нь миний хоолноос хэн идчихэв ээ гэж гайхлаа.

-Миний шөлнөөс бас идчихэж гэж гурав дахь нь хэлсэн бол дөрөвдэх нь талхаа үгүйллээ.

Тав, зургаа дахь одой нар халбага, хутгыг нь хэн нэгэн хэрэглэснийг мэдсэн бол хамгийн сүүлчийн одой,

-Хүүе ээ, миний сэрээг хэн нэг нь хэрэглэчихсэн байна гэж уулга алдлаа.

Одой нар бие бие үрүүгээ айсан нүдээр харигаалаа. Яагаад гэвэл тэд жижигхэн хүмүүс билээ. Тэгээд бүгдээр дэнлүүнүүдээ дээш өргөн харвал нэг нь хүүе хараач орыг минь бусниулчихаж гэлээ. Бусад нь бүгд ухасхийн харахад орны бүтээлэг нь хөдөлж үрчийсэн харагдлаа.

Гэвч долоо дахь одой,

-Хүүе та нар нааш ир дээ. Хэн байгааг хар даа гэж уулгалаа.

Бусад одой нар гүйн ирцгээгээд орон дотор нам унтаж буй Цасан цагааныг гайхан ширтлээ.

-Бурхан минь! Бурхан минь! хэмээн одой нар шивнэлдээд,

-Яасан хөөрхөн хүүхэд вэ, хаанаас гараад ирэв гэгцгэн түүнийг өхөөрдөн ширтэж байв.

Тэд Цасан цагааныг сэрээхээс болгоомжлон өмний дээрээ гишгэн холдсон агаад өргүй болсон нэг нь бусдынхаа орон дээр нэг нэг цаг ээлжлэн унтжээ.

Одой нар маргааш өглөө нь эртлэн босоч Цасан цагааны орыг тойрон сууж, түүнийг сэрэхийг хүлээлээ. Охин үд хэвийтэл унтаад сэрлээ. Түүнийг нүдээ нээхэд сахал үс болсон олон эрчүүд тойрон харж байлаа.

Цасан цагаан эхлээд айн дуу алдсан боловч одой нар найрсаар инээмсэглэсэн тул айхаа больж, хариу инээмсэглэв. Бяцхан хүмүүс Цасан цагаанд өглөөний цай бэлдэн түүнийг цайгаа уусны дараа тус тусынхаа сандалд тухлан, харин охин нэгнийн нь орон дээр суулаа.

Одой нар түүнээс хаанаас ирснийг нь асуухад тэрээр анчин хүн хэрхэн түүнийг ойд авчирсан, түүнийг алалгүй орхиод явсан болон ой дундуур явсаар байгаад тэдний байшинд ирсэнээ тоочин ярилаа.

Цасан цагааныг ийнхүү түүхээ хүүрнэж байх зуур одой нар гаансаар тамхиа нэрж суусгаалаа. Түүнийг ярьж дуусахад,

-Эх хүн хүүхдэд яаж тэгж хандаж болдог байна аа хэмээн одой нар харамсан толгой сэгсэрлээ.

Эцэст нь хамгийн ахмад одой ам нээж,

-Цасан цагаан минь, чамд үнэхээр аймшигтай зүйл тохиолджээ. Аймшигтай юм. Би л лав ийм зүйл хэзээ ч сонсоч байгаагүй юм байна. Тэгэхээр чи одоо буцаад ордон уруу явж лав болохгүй. Яагаад гэвэл хойт эх чинь чамайг дахиад л алахыг оролдоно. Харин чамайг энд байгааг хэн ч мэдэхгүй болохоор чи аюулгүй байна гэсэн үг. Тийм болохоор чи энд үлдэж манай гэрийн үйлчлэгч болбол бид маш их баярлана. Чи эндээ байх уу? хэмээн асуулаа.

Цасан Цагаан одой нарын найрсаг царайг ширтэн,

-Тэгье, тэгье гэлээ.

Сайн байна. Биднийг уурхай уруугаа явсан хойгуур чи хоол хийж, хувцас угаан, гэр орныг цэвэрлэх хэрэгтэй. Охин минь бид нар газар дор уурхайд бүтэн өдөржингөө ажилладаг учраас чи гэртээ ганцаараа хоцорч байх болно. Юмыг яаж мэдэх вэ, ээж чинь чамайг олоод ирж мэднэ. Тийм учраас чи хэнийг ч гэртээ оруулж болохгүй шүү хэмээн одой нар Цасан цагаанд аминчлан захиллаа.

Цасан Цагаан үүнийг зөвшөөрөн гэртээ үлдсэн бөгөөд байшинг ёстой л гялалзтал цэвэрлэн ажил үүргээ нэр төртэй гүйцэтгэж байлаа.

Түүнийг ийн байхад холын хол байсан Хатан ээж нь шөнө ч унтаж чадахгүй дэгэн догон хийсээр үүр цайлгаад, нууц өрөө үрүүтээ гүйж очоод шндэт толинд хандан өөрөөс нь илүү сайхан бүсгүй хорвоо дэлхийд байгаа эсэхийг лавлав.

Толь сүүмэлзэн байснаа шивнэсэн нь:

-Эрхэм Хатан хаан минь та

Энэ өрөөнд үзэсгэлэнтэй ч

Холын хол уулын тагтад

Долоон одойгоор асруулсан

Энхрий Цасан цагаан танаас лав

Элбэг мянга дахин хөөрхөн дөө гэх нь тэр.

Хатан Хаан цээжээ дэлдэн,

-Үгүй тийм байх ёсгүй, Цасан цагаан үхсэн. Би зүрх, уушги, элгийг нь идсэн. Толь чи худлаа ярьж байна. Хэл чи. Худлаа биз дээ хэмээн хашгирлаа.

Гэвч толь урьдын хэлсэнэ давтсанд Хатан хаан аргагүй үнэмшив.

Толь үнэнийг хэлсэн бөгөөд анчин түүнийг мэхэлж, Цасан цагаан амь хэлтэрч гэдгийг Хатан хаан ойлголоо. Атаархал, хорсол нь буцалсан Хатан хаан унтаж ч чадсангүй шөнөжин ордны хонгилд өөдөө сөргөө холхиж өнгөрөөв. Тэгсээр үүрийн харанхуй үеэр Цасан цагаанаас үүрд салах хорт аргаа бодож олжээ.

Хатан хаан нүүрээ настай эмгэн болж харагдахаар будаад хуучин ноорхой хувцас эгэлдрэглэн үүргийн худалдаачин шиг болов. Зүсээ ийн хувиргасан Хатан хаан ойг сүлжин явсаар долоон одойн байшингийн гадаа хүрч ирлээ.

Тэр хаалгыг нь тогшин,

-Гоёмсог бараа зарж байна. Гоёмсог бараа шүү. Хямдхан шүү гэж дуудлаа.

Цасан цагаан цонхоор харвал нэгэн настай эмгэн үүргэвчиндээ үсний боолт,

тууз, бөгж зэрэг гял цял бараатай ирсэн байх нь харагдав.

“Энэ настай худалдаачин эмгэн надад хор хүргэхгүй нь лав” хэмээн бодсон Цасан цагаан одой нарын сануулж хэлснийг мартан хаалгаа нээлээ.

Тэрээр торгон туузыг зааж,

-Тэр ямар үнэтэй вэ? гэж асуулаа.

-Өө энэ үү гэж эмгэн дуу алдаад,

-Хямд аа хямд, чиний энэ хөөрхөн хүзүүнд чинь ч янзтай сайхан зохино доо.

Би зүүгээд өгөх үү? гэлээ.

Охин цамцныхаа захыг ярахад эмгэн хүзүүгээр нь туузаа оруулснаа чангалан татахад хөөрхий Цасан цагаан үхсэн мэт гулзайн уналаа.

-Ха Ха. Би одоо дэлхийн хамгийн сайхан хүүхэн мөн дөө гэж Хатан хаан баясан хашгираад ордон уруугаа буцаж харайлгалаа.

Хатан хааныг явсны дараахан орой болж одой нар ажлаасаа бууж ирсэн бөгөөд тэд Цасан цагаан шалан дээр ухаангүй хэвтээг олж үзээд сандралдан, хүзүүг нь ороосон туузыг суллан, нүүрийг нь хүйтэн усаар шавшлав. Охины зөвхий даасан байсан уруул аажмаар өнгө орон амьсгалж эхлэв.

Одой нар түүнийг ухаан ороход баярлалдан гурвантаа Ура хашгирсан ч юу болсныг сонсоод царайгаа барайлган толгой сэгсэрчгээлээ.

-Тэр эмгэн бол чиний хойд эх гарцаагүй мөн байна. Чи үүнээс хойш сургамж авч биднийг байхгүй үед хөндлөнгийн хүнтэй хэзээ ч юм ярьж болохгүй шүү. Тэр чамайг дахин алахыг оролдох нь дамжиггүй хэмээн ахмад одой сургамжлан хэллээ.

Цасан цагаан үүнээс хойш хэнийг ч гэртээ оруулахгүй гэж амлаад тэд унтацгаалаа.

Тэднийг унтаж байхад Хатан хаан нууц өрөөндөө очин өөрийгөө дэлхийн хамгийн сайхан хүүхэн мөн эсэхийг асуухад толь нь сүүмэлзэн байснаа шивнээсэн нь:

Эрхэм Хатан хаан минь та

Энэ өрөөнд үзэсгэлэнтэй ч

Холын хол уулын тагтад

Долоон одойгоор асруулсан

Энхрий Цасан цагаан танаас лав

Элбэг мянга дахин хөөрхөн дөө. Үүнийг сонссон Хатан хаан худлаа, худлаа, тийм байх ёсгүй хэмээн бахардан чарлалаа.

Гэвч толь өмнөхөө дахин давтсан тул Хатан хаан үнэхээр тийм гэдгийг ойлгожээ. Тэр шөнө Хатан хаан дүүжлүүрийн газарт очин илбэ жилбийн аргаар нэгэн үсний зүүлтийг хордуулж авлаа. Тэгээд өөрийгөө ядуу эмэгтэйн дүрээр хувцаслаад, явсаар одой нарын байшингийн хаалгыг тогшиход Цасан цагаан цонхоор түүнийг харлаа.

-Ёо, ёо. Би нэг муу ядарсан бэлэвсэн эхнэр байна аа. Энэ хөөрхөн зүүлтийг зарахгүй бол өнөө шөнө хоосон хонох нь ээ гэж тэр худал санаа алдан өгүүлэв.

Түүнийг өрөвдсөн Цасан цагаан хаалгаа онгойлгож үсний зүүлтийг худалдан авчээ.

-Алив охин минь. Наад зүүлт чинь чамд зохиж байгаа эсэхийг үзье хэмээн Хатан хаан хэлээд зүүлтийг Цасан цагааны үсэн дээр хүргэхэд зүүлтэнд шингээсэн хор үйлчлэн охин хордож ухаан алдан уналаа.

Хатан хаан хуруугаа араатны сарвуу мэт ёрдогонуулан,

-За чи их сайхан төрсөн юм гэл үү. Ингээд үх чи. Одоо надаас сайхан хүүхэн энэ дэлхийд байхгүй боллоо гэж хашгирлаа. Тэгээд дээлээ нөмрөн өтгөн ойг гатлан ганцаар буцаж одов.

Цасан цагааныг газарт ухаангүй хэвтэж байхад хор биенд нь улам нэвчин судсаар нь гүйж, уруул нь мөс мэт харлаад, духан дээр нь хүйтэн хөлс бурзайсан байв. Тэр үхлийн хаалганы өмнө очоод байлаа. Тэгтэл долоон одой уурхайгаасаа буцан ирээд охиныг галын өмнө хэвтэж байхыг харлаа.

Ахмад одой Цасан цагааны судсыг барилан үзээд гараа явуулан мөнөөх хорт зүүлтийг үсэн дотроос нь олж сугалан хаялаа. Тэгтэл охин алгуурхнаар нүдээ нээж өглөөний тунгалаг агаараар амьсгаллаа.

Одой нар шүүрс алдан хэчнээн халагласныг хэлээд яахав. Бяцхан охин минь, ээ дээ болгоомжтой байгаарай хэмээн тэд олонтаа давтан хэлсэн бүлгээ.

-Чи чинь яасан тэнэг юм хийчхэв ээ хэмээн отгон одойг ундууцахад ахмад одой түүнд хандан энэ чинь нялх хүүхэд шүү дээ. Гэнэн байлгүй яахав гэж Цасан цагааныг өмгөөлжээ. Тэгээд охинд хандан,

-Хонгорхон охин минь, маш болгоомжтой байна шүү. Чамайг бид алдахыг хүсэхгүй байна хэмээн дахин сайтар захилаа.

Тэгээд одой нар Цасан цагаанд сайхан унтахыг ерөөлөө.

Сар тэнгэрт нүүдэллэн, салхи ойд хүүгэн, амьд амьтан бүхэн унтаж ахуйд Хатан хаан нууц өрөө рүүгээ очин толиндоо хандан инээмсэглээд өөрийгөө дэлхийн хамгийн сайхан хүүхэн мөн эсэхийг асуулаа.

Гэвч толь нь

Эрхэм Хатан хаан минь та,

Энэ өрөөнд үзэсгэлэнтэй ч

Холын хол уулын тагтад

Долоон одойгоор асруулсан

Энхрий Цасан цагаан танаас лав

Элбэг мянга дахин хөөрхөн дөө гэж бас дахин хэлэх нь тэр. Хатан хааны нүүрнээс инээмсэглэл нь арчсан мэт алга болж халуурсан хүн шиг дагжин чичирлээ.

Түүний духнаас нь хүйтэн хөлс асгаран, толгойгоо сэргэрэн байлаа. Тэгээд

шөнийн арван хоёр цаг дөнгөж болмогц босоч ордны хамгийн дор байх газар уруу явлаа.

Тэр эхлээд нэг шатаар, дараа нь бас нэг шатаар гэхчлэн маш олон шатаар уруудан явсаар ордны хамгийн доор, газрын гүнд өөр хэн ч очоогүй бөгөөд хараагүй аймшигт газар явж хүрлээ. Тэнд Хатан хааныг эсэргүүцээд, түүний гарт амь алдсан олон арван хүний араг яс хэрзнийлдэн хэвтэж байлаа. Хатан хаан нэгэн авдрыг уудлан час улаан алим гаргаж аваад тэр үү алиманд хорт илбийн үгсийг шившихэд тэр алим туйлын хорт зүйл болон хувирав. Тэр алимыг зөвхөн харахад л хор нь үйлчилдэг агаад хүний уруулд хүрэх л юм бол шууд алах чадалтай болжээ. Хатан хаан тэрхүү хорт алимыг цүнхэлж аваад ой уруу шуударлаа. Гэвч “санаа муут яван хатна, сарьсан багваахай наранд хатна” гэж үнэн болохыг бид удалгүй мэдэх болно.

Хөгшин гуйлгачин эмгэний дүрд хувирсан Хатан хаан ой дундуур нэвт гараад байшингийн хажууд ирж, хаалганых нь өмнө газар хэвтээд худал ёолон дуу тавилаа.

-Ёо ёо, Ёох ёох. Би өвдөөд үхэх гэж байгаа хүн байна. Ганц аяга ус өгдөг хүн байдаг болоосой гэж тэр гуншиганалаа.

Цасан цагаан цонхоор түүнийг хараад,

-Уучлаарай эмээ. Би танд тус болж чадахгүй нь дээ. Яагаад гэвэл хаалга онгойлгох хориотой гэлээ.

Тэгсэн ч эмэгтэйн газарт хэвтэн болохыг хараад түүнд өрөвдөх сэтгэл төрөв. “Хөөрхий золгүй амьтанд ганц аяга ус өгчихөд юу нь болохгүй байхав” гэж тэр болжээ.

Охин цонхоо нээж, эмгэнд аягатай ус өгөхөд нөгөөх нь түүнийг нь залгилж орхиод аягыг нь буцааж өгөхдөө,

-Тусыг тусаар гэдэг юм охин минь. Алив үүнийг ав гээд алим гаргаж сарвайлаа.

Цасан цагаан толгой сэгсрээд, зүгээр, зүгээр, баярлалаа танд гэлээ.

Хатан хаан инээмсэглэн, чи хар л даа. Ёстой нэг амттайхан алим даа хэмээн хэлэхэд Цасан цагааны хорхой хүрч эхэллээ. Гэвч тэр алимыг авсангүй.

-Чи энэ алимыг хордуулсан гэж бодож байна уу? Ухаантай л охин байна. Гэхдээ айх хэрэггүй хэмээн Хатан хаан өгүүлээд хутга гарган алимыг хоёр хувааж тэгвэл би хагасыг нь идчихье гээд алимны талыг үмхлээ. Цасан цагаан ч тэссэнгүй нөгөө хагасыг нь авч хазлаа. Гэвч алимыг залгиж ч амжаагүй байтал хор үйлчлэн Цасан цагаан үхэхийн уналаа.

Хатан цааны нүд гялалзан дэвхцэн хашгирч гарлаа.

-Цонхны хүрээ шиг хар, цус шиг улаан, шас шиг цагаан гэл үү чи. Чи одоо үхсэн тэр чингээрээ үхдэл боллоо доо. Одоо муу одой нар чамд тус болж чадахгүй дээ хэмээн тэр орилж байлаа.

Хатан Хаан инээж хөхөрсөн чигээр ордондоо хүрч нууц өрөөндөө очин
Хамаг орчлон дэлхий дээрх

Хамгийн сайхан бүсгүй хэн бэ? гэлээ.

Тэгтэл толь хариуд нь:

Эрхэм Хатан хаан минь та энэ дэлхийн

Эгнэшгүй үзэсгэлэнт бүсгүй мөн байна хэмээн шивнэлээ.

Үүнийг сонссон Хатан хааны хар санаа чухам л нэг амарчээ.

Орой нь одой нар уурхайгаасаа буцан ирээд Цасан цагааныг шалан дээр
ухаангүй хэвтэж байхыг харлаа. Тэд чадах бүхнээ л хийлээ. Тэд хувисыг нь
тайчин ,үсийг нь самнаж, биеийг нь усанд бас дарсанд булхлаа. Гэвч тэд охин
чухам юунд хордсоныг мэдэхгүй учраас эмчилж чадсангүй.

-Ай яа. Бидний хөөрхөн охин үнэхээр нас баржээ хэмээн тэд мэгшицгээлээ.

Тэд нар Цасан цагааныг ширээн дээр хэвтүүлээд бүтэн гурван хоног тойрон
сууж уйлсаар байв. Хэдий түүнийг оршуулах цаг болсон боловч охин амьд
мэт үзэсгэлэнтэй сайхан хэвээрээ байсаар байсан тул тэд түүнийг газарт булж
зүрхлэхгүй л байлаа. Тэд уурхайгаасаа болор авчран хайрцаг хийж түүндээ
Цасан цагааныг хийсэн тул охин нэвт гэрэлтэн харагдаж байв.

Авсан дээр алтаар хааны охин байсан гэдгийг нь сийлэн бичжээ. Тэгээд
түүнийгээ уулын хярд аваачин, цэцгэн дунд байрлуулаад өдөр бүхэн ээлжээр
манаж байх болов. Араатан жигүүртнүүд хүртэл тэнд очин эмэгнэл илэрхийлж
байлаа. Шар шувуу, хэрээ, тагтаа ирэн гашуудлаа.

Түүнээс хойш долоон жил өнгөрөхөд Цасан цагаан тэндээ байсаар байсан
ч үхсэн биш, зөвхөн унтаж байгаа амьд хүн мэт харагдаж байлаа. Тэгтэл нэгэн
өдөр Ханхүү ан хийж яваад авсыг олж үзээд ирлээ. Тэрээр болор авс нэвт
гэрэлтэн харагдах Цасан цагааны гоо үзэсгэлэнд өвдөг сөхөрчээ.

-Та нар энэ авсаа надад өгчих. Би юу хүссэн болгоныг чинь өгье гэж тэр
хэллээ.

Харин одой нар яасан ч зөвшөөрсөнгүй.

-Бид нар хэзээ ч Цасан цагаанаасаа хагацахгүй гэж тэд толгой сэгсрэн
хэлжээ.

-Надад үүнийгээ бэлэглэчих. Би энэ гүнжийн гоо үзэсгэлэнг харахгүйгээр
амьд явж чадашгүй нь. Би амьдралынхаа эцсийн өдрийг хүртэл хамгаалж явах
болно гэж тэр гуйлаа.

Одой нар зөвлөлдөөд Ханхүүгийн сайхан сэтгэлийг бодон түүнд Цасан
цагааныг өгөхөөр боллоо. Ханхүү зарц нараа дуудан ирүүлж, тэд нар нь авсыг
авч явахаар өргөхдөө газарт санамсаргүй хүрэн доргиож орхитол Цасан цагааны
хоолойноос хорт алим мултран унаж охин нүдээ нээх нь тэр.

-Би хаа байна вэ? Зүүдэлж байна уу даа? гэж тэр асуулаа.

Ханхүү түүний дээрээс тонгойн,

-Үгүй ээ. Энэ бол зүүд биш. Чи бүтэн долоон жил үхлийн нойроор нойрлоо. Гэвч одоо зүгээр, газар дэлхийдээ тавтай морил гэлээ.

Одой нар баярлан хөөрөлдөж, араатан амьтад хүртэл догдлон баяслаа. Ханхүү тэр дороо Цасан цагаанаас эхнэрээ болохыг гуйхад охин долоон одойгоос асуун тэд ч зөвшөөрлөө. Дараа нь Ханхүү, Цасан цагаан ба долоон одой нарыг аван Хаан аавынхаа цайз уруу хөдөллөө.

Түүнээс хойш удалгүй Ханхүү, Цасан цагаан хоёрын хурим болж, газар газрын хаад, хатад уригдсаны дотор охины хойт эх Хатан хаан мөн багтжээ.

Хатан хаан хуримын бүжгэнд явахын өмнө байдгаараа гоёж аваад нууц өрөөндөө очин,

Хананд байгаа

Хайртай тунгалаг толь минь

Хамаг орчлон дээрх

Хамгийн сайхан бүсгүй хэн бэ? гэж асуулаа.

Хатан хаан хувцас хунараа засан толь уруу бардмаар харж хариулт хүлээлээ. Цасан цагаан байхгүй болсноос хойш түүнтэй эгнэх сайхан бүсгүй хаа ч байхгүй гэдгийг тэр мэдэж байлаа.

Гэтэл толь нь

Эрхэм Хатан хаан минь та

Эндээ хэдий үзэсгэлэнтэй ч

Бүжгэн дээр байгаа залуу гүнж

Танаас мянга дахин хөөрхөн байна гэх нь тэр.

Тэр уурлан занаж баахан хашгичиж, атаа, хорсол нь буцлан байсан ба эхлээд хуримын бүжгэнд очихгүй гэснээ сүүлдээ тэсч чадалгүй очтол мөнөөх гоо гүнж Цасан цагаан байсанд атаархсандаа хөдөлж ч чадахгүй хөшиж орхилоо.

Гэвч Цасан цагааны сүйт хархүүгийн аав хөгшин Хаан түүнд бүжиглэхийг тушаагаад зарц нараа дуудахад тэд нар Хатан хаанд халуун төмрөөр хийсэн цамц нөмөргөжээ. Хатан хаан тийчлэн татганасаар түлэгдэж үхжээ.

Түүнийг тийнхүү үхмэгц нөгөөх шидэт толь хагаран унаж үй түмэн хэлтэрхий болсон бөгөөд та нар хэрвээ хэзээ нэгэн цагт нууц өрөөнд очиж чадах юм бол тэр толины хэлтэрхийнүүд дээр үр хүүхдүүд болон долоон одойгоор хүрээлүүлсэн Цасан цагааны дүрс харагддаг ажээ.

Харин нэгэнт хагарч бутарсан тэр толь дахиж ярьж чадахаа байсан гэнэ билээ.



Өвгөн ба нохойн идүүр

Урьд цагт нэгэн чулуучин амьдарч байв. Тэр бол хүч чадалтай сайхан эр байсан бөгөөд бүтэн өдөржин лангуу балбасан ч эцэж цуцдаггүй байсан бөгөөд цүүц нь ямар ч хатуу чулууг бяслаг мэт зүсдэг байлаа. Гэвч тэрээр цагийн эрхээр хөгширч тамир тэнхээ нь доройтоод хүү бэр хоёртойгоо хамт амьдрах болжээ.

Гэвч хүү бэр хоёр нь түүнийг төдийлөн хайрладаггүй байв. Чулуучин эр ихэд хөгширч гар хөл нь салганах болсон тул шөл уухдаа халгиаж цалгнан сахал уруугаа асган, тэр нь урсан ширээний бүтээлэг бохирдуулж орхидог байж л дээ.

Хүү бэр хоёр нь үүнд эгдүүцэн бэр нь нэг өдөр “түүнийг харахаас дургүй байна” гэсэн тул пийшингийн ард харанхуй буланд суулгадаг болов.

Өвгөний залуудаа тэнгэр шиг цэнхэр байсан нүд муудан цайсан тул тэрээр аягаа ч муухан харах ажээ. Гэтэл нэгэн өдөр гар нь чичрэн аягаа алдаж орхисон тул хоолоо шалан дээр асгачихав.

-Ай яа. Хайран сайхан аягыг минь хагалж орхилоо. За гайгүй одоо тэгвэл дахиж хагалахгүй болгоод өгье хэмээн бэр нь уурсан хашгичаад түүнд нохойны хуучин модон идүүр өгчээ.

Эхнэр нөхөр хоёр таван настай хүүтэй юм санж. Тэгтэл нэг өдөр тэр хүү нь модны тайрдас хөрөөдөж сууна гэнэ.

-Миний хүү юу хийж байгаа юм бэ? гэж аав ээж нь түүнээс асуужээ.

Тэгэхэд хүү нь тэднийг харснаа,

-Аав аа би танд бэлэг бэлдэж байна. Таныг хөгширөхөөр идүүлэх таваг хийж байна гэсэн гэдэг.

ЭМХЭТГЭГЧИЙН ҮГ

Бид Германы ах дүү Жакоб ба Вилгельм Гримм нарын үлгэрүүдийг эртнээс нааш сонсоор ирсэн билээ.

Домог зүйн болон хэл шинжлэлийн судалгаанаас үзвэл эдгээр үлгэрийг дээрх ах дүү нар Германы тариачин ардуудаас олж мэдсэн байна. Өмнө нь хэвлэгдэж байгаагүй тэдгээр үлгэрийг ах дүү Гриммүүд 1812, 1815 ба 1822 онд гурван ботиор анхлан хэвлүүлсэн байна.

Тэр цагаас хойш энэ номууд зарим нэмэлт өөрчлөлттэйгээр, дэлхийн олон хэлээр, олон хувилбар хэмжээгээр түм бумантаа хэвлэгдсэн ажээ.

Ийн байтал дахин хэвлэх хэрэг юу гэж уншигч та асууж болох юм. Би энэ асуултанд хариулахын тулд ардын үлгэрийн тухай Жон Раскиний хэлсэн нэг үгийг иш татъя гэж бодлоо. Тэнд “Үлгэр гэгч тэнгэрт янз бүрээр хувьсан нүүдэллэж байсан ч хэвээрээ л харагдаад байдаг үүлтэй адилхан юм” гэсэн байдаг билээ. Өөрөөр хэлбэл би аль болох чөлөөтэй орчуулж, гэхдээ гол санааг нь алдуулахгүйг хичээсэн юм. Буруу бичигдэх явдал бий ч утга санаа нь устдаггүй гэдэг мэргэн үг бас бий. Би энэ үлгэрүүд тариачдын амнаас анх гарахдаа ямар байсан бол гэдгийг төсөөлөн байж орчуулсан минь үнэн юм.

Би үлгэрүүдийг сонгохдоо олонд алдартайг нь төдийгүй бас төдийлөн түгээгүй боловч маш сонирхолтой сайхан үлгэрүүдийг ч оруулахыг хичээсэн билээ. Хэрэв миний ийнхүү сонгосон байдал зарим нэг уншигчдын санаанд төдийлөн нийцэхгүй аваас энэ бол Гриммийн хоёр зуун арван үлгэрийн зөвхөн гучхан нь юм шүү гэдгийг хэлье.

Өөрөөр хэлбэл цаана нь бүхэл бүтэн нэг зуун наян үлгэр бий юм шүү.

Эцэст нь номыг бэлдэхэд надад тусалсан нэр бүхий хатагтайд талархал дэвшүүлж байна.

Петер Картер

1980 он. Сент Мартиал де Виверол

Андерсений шидэт үлгэрүүд

Нугасны муухай дэгдээхий, Цасан гүнж, Лусын бяцхан гүнж зэрэг Ханс Христиан Андерсений алдарт үлгэрүүдийн гайхамшигт баатруудтай та уулзах болно. Энэ эмхтгэлд Андерсений алдартай үлгэрүүдийг төдийгүй бас олонд төдийлөн танил болоогүй бүтээлүүд орсон нь эрт, эдүгээгийн уншигчдын сонирхлыг ижилхэн татах нь дамжиггүй юм.

Арабын мянга нэгэн шөнийн үлгэрүүд

Эмэгтэйчүүдийн хайр ганц шөнийн л настай зүйл... Шөнө бүхэн нэг шинэ эхнэрээ алдаг зантай Шахрир хаан ингэж хэлдэг байв. Харин түүний ээлжит сүйт бүсгүй Шахризад өөрийгөө аврах ухаалаг төлөвлөгөө боловсруулдаг. Түүний шөнийн үлгэрүүд болох Синдбад далайчин, Али Баба, Жиннигийн тухай түүхүүд маш их сонирхолтой байсан тул Шахрир хаан түүнийг цаазлах өдрөө хойшлуулсаар байдаг.

Арабын Шөнийн үлгэрүүдийн жинхэнэ эх хувилбарыг нэрт хэвлэн нийтлүүлэгч Гералдин Мэк Кохрен эмхтгэсэн байна.

Английн шидэт үлгэрүүд

Аймшигт аварга амьтныг даран сөнөөгч Жонни Глок, хонин толгойтой ханхүү, Мэлхий ханхүү зэрэг баатрууд нь Дик Витингтон, Эрхийн чинээ Том хүү зэрэг алдартай дүрүүдийн хамтаар энэ эмхтгэлд багтсан байна. Шуналтай харгис аварга амьтад, сайхан төрсөн ханхүү нар, муу санаат гүнж нар зэрэг нь Английн шидэт үлгэрийн энэхүү эмхтгэл хүн бүхэнд сонирхолтой байх болно.

Шотландын шидэт үлгэрүүд

Аварга биет цэргийн ноёд, шидэт Хатан Хаан Эльф, илбэчин жилбэчингүүд... Та бүхнийг эдгээр болон бусад гайхамшигт дүрүүдтэй Шотландын үлгэр, домгийн энэхүү эмхтгэл уулзуулж байна.

Эртний дуултиуд, адал явдлын ангуучид гээд хэн бүхэнд энэ эмхтгэл туйлын сонирхолтой байх болно.

INTERPRESS

Хавлэн нийтлэлийг
Интерпресс ХХК



Дэлхийн банктай хамтран хэрэгжүүлж буй
«Хөдөөгийн боловсролыг дэмжих
(READ) төсөл»-ийн хүрээнд хэвлэв.
Худалдахыг хориглоно.